

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: #INV_PUBLISH_DATE#

Тендер шалгаруулалтын төрөл: Ажил

Тендер шалгаруулалтын нэр: Геологи хайгуулын судалгааны ажил

Тендер шалгаруулалтын дугаар: УГА/20260101009

Нийт төсөвт өртөг: 21355391390 ₮

Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

Тендер шалгаруулалтын хураамж: #DOCUMENT_PRICE# [Төгрөг]

1. Үндэсний геологийн алба нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: Тийм,

3. Тендерийг 2026 оны 04 -р сарын 06 -ны өдрийн 14 цаг 00 минут-аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар ирүүлэх ба тендерийн нээлтийг 2026 оны 04 -р сарын 06 -ны өдрийн 14 цаг 30 минут -т худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулна.

4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: #IS_ALTERNATIVE#

5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: #FOREIGNER_AVAILABLE#

6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.

7. Тендерийн баталгаа шаардах эсэх: #GUARENTEE# Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичигт заасан үнийн дүн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.

8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: #IS_ADVANCE_PROCUREMENT#

9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: #PHASE#

Сонирхогч этгээд цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Монгол, Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, ҮЙЛДВЭРЧНИЙ ГУДАМЖ, ӨӨРИЙН БАЙР,
70181208

Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

#INV_PUBLISH_DATE#

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: #INV_PUBLISH_DATE#

Тендер шалгаруулалтын төрөл: Ажил

Тендер шалгаруулалтын нэр: Геологи хайгуулын судалгааны ажил

Тендер шалгаруулалтын дугаар: YGA/20260101010

Нийт төсөвт өртөг: 29744768000 ₮

Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

Тендер шалгаруулалтын хураамж: #DOCUMENT_PRICE# [Төгрөг]

1. Үндэсний геологийн алба нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: Тийм,

3. Тендерийг 2026 оны 04 -р сарын 06 -ны өдрийн 16 цаг 00 минут-аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар ирүүлэх ба тендерийн нээлтийг 2026 оны 04 -р сарын 06 -ны өдрийн 16 цаг 30 минут -т худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулна.

4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: #IS_ALTERNATIVE#

5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: #FOREIGNER_AVAILABLE#

6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.

7. Тендерийн баталгаа шаардах эсэх: #GUARENTEE# Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичигт заасан үнийн дүн бүхий тендерийн баталгаа холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.

8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: #IS_ADVANCE_PROCUREMENT#

9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: #PHASE#

Сонирхогч этгээд цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Монгол, Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, ҮЙЛДВЭРЧНИЙ ГУДАМЖ, ӨӨРИЙН БАЙР,
70181208

Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

#INV_PUBLISH_DATE#

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: #INV_PUBLISH_DATE#

Тендер шалгаруулалтын төрөл: Ажил

Тендер шалгаруулалтын нэр: Геологи хайгуулын судалгааны ажил

Тендер шалгаруулалтын дугаар: УГА/20260101009

Нийт төсөвт өртөг: 21355391390 ₮

Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

Тендер шалгаруулалтын хураамж: #DOCUMENT_PRICE# [Төгрөг]

1. Үндэсний геологийн алба нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: Тийм,

3. Тендерийг 2026 оны 05 -р сарын 12 -ны өдрийн 14 цаг 00 минут-аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар ирүүлэх ба тендерийн нээлтийг 2026 оны 05 -р сарын 12 -ны өдрийн 14 цаг 30 минут -т худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулна.

4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: #IS_ALTERNATIVE#

5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: #FOREIGNER_AVAILABLE#

6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.

7. Тендерийн баталгаа шаардах эсэх: #GUARENTEE# Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичигт заасан үнийн дүн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.

8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: #IS_ADVANCE PROCUREMENT#

9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: #PHASE#

Сонирхогч этгээд цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Монгол, Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, ҮЙЛДВЭРЧНИЙ ГУДАМЖ, ӨӨРИЙН БАЙР,
70181208

Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

#INV_PUBLISH_DATE#

БАТЛАВ
ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.МӨНХБИЛЭГ



АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын *Геологи хайгуулын судалгааны ажил*
нэр:
Тендер шалгаруулалтын *ҮГА/20260101009*
дугаар:

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	1
1. Тендерийн цар хүрээ	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	1
4. Худалдан авах ажиллагааны цахим систем	1
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх	1
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага	1
7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага	2
Б. АГУУЛГА	2
8. Тендер шалгаруулалтын баримт бичиг	2
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	2
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт	3
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах	3
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	3
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	3
13. Тендерийн иж бүрдэл	3
14. Тендерийн жишиг маягнууд	4
15. Хувилбарт санал	4
16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг	4
17. Чадавхын болон туршлагын шаардлага	4
18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	5
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт	5
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг	5
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	6
22. Тендерийн валют	6
23. Тендер хүчинтэй байх хугацаа	6
24. Тендерийн баталгаа	6
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	7
25. Тендер баталгаажуулах, илгээх	7
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	7
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	7
27. Тендерийн талаар тодруулга авах	7
28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх	7
29. Тендерийг үнэлэх	7
30. Арифметик алдааг залруулах	7
31. Давуу эрх олгох	8
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	8
33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох	8
34. Тендерийг эрэмбэлэх	8
35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах	8
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	8
36. Мэдэгдэл хүргүүлэх	8
37. Гүйцэтгэлийн баталгаа	8
38. Урьдчилгаа төлбөр	9
39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	9

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ
 - 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.
 - 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
 - 1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг
 - 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж
 - 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
4. Худалдан авах ажиллагааны цахим систем
 - 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
 - 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
 - 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
6. Сонирхогч оролцогчид ерөнхий шаардлага этгээд, тавигдах
 - 6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.
 - 6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
 - 6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
 - 6.4. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
 - 6.5. Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б. АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий

- шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;
- 13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
- 13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.
- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн жишиг маягтууд**
- 14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.
- 15. Хувилбарт санал**
- 15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.
- 16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**
- 16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:
- 16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.
- 16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
- 16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
- 17. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.
- 17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг

нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1.Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2.Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3.Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4.ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5.ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6.Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.2. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.3. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1.Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн

хүснэгтэд заана.

24.2.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2.ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт 7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2.Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1.Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1.Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1.Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

29.2.Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.3.Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

30. Арифметик алдааг залруулах

30.1.Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
- Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**
- 36. Шийдвэр хүргүүлэх**
- 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37. Гүйцэтгэлийн баталгаа**
- 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах

- ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцүүлэн гаргана.
- 38. Урьдчилгаа төлбөр**
- 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
- 38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцүүлэн гаргана.
- 38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ														
ТШЗ 1.1	Захиалагч: <i>Үндэсний геологийн алба</i> Тендер шалгаруулалтын нэр: <i>Геологи, хайгуулын судалгааны ажил</i> Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: УГА/20260101009														
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="width: 15%;">Д/д</th> <th>Багцын нэр</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Багц №1</td> <td>ТЭМЭЭТ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ</td> </tr> <tr> <td>Багц №2</td> <td>ХЭЦҮҮ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ</td> </tr> <tr> <td>Багц №3</td> <td>АЛТАН ШИРЭЭ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ</td> </tr> <tr> <td>Багц №4</td> <td>ТӨХӨЛИЙН ЭЛС ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ</td> </tr> <tr> <td>Багц №5</td> <td>ЦАХИРЫН ХЯР ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ</td> </tr> <tr> <td>Багц №6</td> <td>ХАРХОРИН ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:25000-НЫ МАСШТАБТАЙ ГЕО-ОРЧНЫ СУДАЛГАА, ЭРЛИЙН АЖИЛ</td> </tr> </tbody> </table>	Д/д	Багцын нэр	Багц №1	ТЭМЭЭТ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ	Багц №2	ХЭЦҮҮ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ	Багц №3	АЛТАН ШИРЭЭ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ	Багц №4	ТӨХӨЛИЙН ЭЛС ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ	Багц №5	ЦАХИРЫН ХЯР ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ	Багц №6	ХАРХОРИН ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:25000-НЫ МАСШТАБТАЙ ГЕО-ОРЧНЫ СУДАЛГАА, ЭРЛИЙН АЖИЛ
Д/д	Багцын нэр														
Багц №1	ТЭМЭЭТ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ														
Багц №2	ХЭЦҮҮ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ														
Багц №3	АЛТАН ШИРЭЭ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ														
Багц №4	ТӨХӨЛИЙН ЭЛС ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ														
Багц №5	ЦАХИРЫН ХЯР ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ														
Багц №6	ХАРХОРИН ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:25000-НЫ МАСШТАБТАЙ ГЕО-ОРЧНЫ СУДАЛГАА, ЭРЛИЙН АЖИЛ														
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”														
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн хөрөнгө														
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 21,653,601,389.6 төгрөг														
Б. АГУУЛГА															
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: <i>Үндэсний геологийн алба</i> Хаяг: <i>Монгол Улс, Улаанбаатар хот 18072, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрчний эвлэл-37</i> Утасны дугаар: 70171048 Цахим шуудангийн хаяг: info@ngs.gov.mn														
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”														
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ															
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: <i>Монгол хэл. Саналд хавсарган ирүүлэх материал нь гадаад хэл дээр бол түүний баталгаат орчуулгыг мөн хавсаргана. Энэ шаардлагаас зөрүүтэй бол захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно.</i>														
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”														
ТШЗ 16.1.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана” <i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн:</i> 7.1. Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ: 7.1.1. төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах шийдвэр гарсан, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлсэн, бизнесийн үйл ажиллагааг зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эдгээртэй адилтгах нөхцөлд байгаа; 7.1.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй;														

	<p>7.1.3.Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдийн оролцсон тендер шалгаруулалт, түүний багцад тендер ирүүлсэн;</p> <p>7.1.4.тухайн тендер шалгаруулалтад оролцохдоо бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцсон;</p> <p>7.1.5.энэ хуулийн 4.1.10-т заасан этгээд;</p> <p>7.1.6.дараах этгээдийн аль нэг нь авлигын, эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон:</p> <p>7.1.6.а.оролцогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд;</p> <p>7.1.6.б.оролцогчийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан эцсийн өмчлөгч;</p> <p>7.1.6.в.оролцогчийн Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан.</p> <p>7.1.7.тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахад зөвлөгөө өгсөн, оролцсон, эсхүл тухайн зөвлөгөө өгсөн, оролцсон этгээдтэй харилцан хамааралтай;</p> <p>7.1.8.тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй;</p> <p>7.1.9.энэ хуулийн 56.5.3, 56.5.4, 56.5.5-д заасан үндэслэлээр тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан, эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд,</p> <p>7.1.10.хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4-т заасан хүүхэд хамгааллын бодлого батлаагүй хуулийн этгээд.</p> <p>7.2.Оролцогч энэ хуулийн 7.1-д заасан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг бичгээр гаргана.</p> <p>7.3.Энэ хуулийн 7.1-д заасан нөхцөлийг магадлахтай холбогдох баримт бичиг ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бол оролцогч Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргуулан ирүүлнэ.</p> <p>7.4.Түншлэлийн гишүүн тус бүр ерөнхий шаардлага хангасан байх бөгөөд холбогдох мэдэгдэл, баримт бичгийг энэ хуулийн 7.2, 7.3-т зааснаар ирүүлнэ.</p>
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”</p> <p>Оролцогчид тавих доод шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> - Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын дундаж нь батлагдсан төсөвт өртгийн 10 хувиас багагүй байх. - Түргэн хөрвөх хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Батлагдсан төсөвт өртгийн 10 хувиас багагүй байх /дансны үлдэгдлийн банкны тодорхойлолт, авах боломжтой зээлийн тодорхойлолтыг гаргаж ирүүлнэ/. - Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацаа: <ol style="list-style-type: none"> 1.1. Оролцогч эсхүл түншлэлийн гишүүн нь Монгол Улсад бүртгэлтэй бол 2023, 2024, 2025 оны санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.ebalance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана. 1.2. Оролцогч нь гадаад улсад бүртгэлтэй тохиолдолд сүүлийн хоёр жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайланг тендерт ирүүлэхдээ Монгол хэл рүү орчуулан ирүүлнэ. 2. Хууль тогтоомжоор санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд 2023, 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт ирүүлнэ. 3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч тендерт хавсарган ирүүлнэ. Уг асуудлаар харилцагч банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа авч ирүүлэхгүй.

ТШЗ 19.1

Техникийн чадавх болон туршлагын доод шаардлага: **“Шаардана”**

1. Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана”

Оролцогчийн санал болгох ажилтанд шаардагдах туршлагын доод түвшин:

Төсөлд ажиллах ИТА (Улсын төсвийн санхүүжилттэй геологийн судалгааны хэрэгжиж буй төслүүдэд зөвлөхөөр ажиллаж байж болно. Инженер техникийн ажилчдын хувьд төсөл нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хяналтын хуудсаа авсан байж болно. Бусад тохиолдолд захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно)-ын бүрэлдэхүүн, тодорхойлолт. Үүнд:

1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил:

Төслийн удирдагч-1, зураглалын ахлах геологич-1, эрлийн ахлах геологич-1, геологич-4, газарзүй мэдээллийн систем хариуцсан геологи -1, нийт 8 хүн.

2. 1:25000-ны масштабтай гео-орчны судалгаа, эрлийн ажил:

Төслийн удирдагч-1, ахлах геологич-1, гео-орчны судалгаа хариуцсан ахлах-1, геологич-2, геофизикч-2, гидрогеологич-1, гидрологич-1, инженер геологич-1, геоэкологич-1, геохимич-1, газарзүй мэдээллийн систем хариуцсан ажилтан-2 нийт 14 хүн.

Багийн бүрэлдэхүүний туршлага, ур чадварын шалгуурын доод үзүүлэлт

1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил:

Албан тушаал	Мэргэжил боловсрол, туршлага	Үндсэн эсхүл гэрээт ажилтан байх
Төслийн удирдагч	-Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд 10-аас доошгүй жил ахлах геологич болон түүнээс дээш түвшинд ажилласан байх, -Мэргэшсэн эсхүл Зөвлөх геологич байх	Үндсэн
Эрлийн ахлах геологич	-Эрэл, хайгуулын чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан байх, -Мэргэшсэн эсхүл Зөвлөх геологич байх	Үндсэн
Зураглалын ахлах геологич	-Геологийн зураглалын чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан байх -Мэргэшсэн эсхүл Зөвлөх геологич байх	Үндсэн
Геологич	Геологийн зураглал, эрэл, хайгуулын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх.	50 хувь нь гэрээт байж болно.
Газарзүй мэдээллийн систем хариуцсан геологи	Газарзүй мэдээллийн системийн программ хангамж бүрэн эзэмшсэн, энэ чиглэлээр 2-оос доошгүй жил ажилласан, эсхүл ижил төсөөтэй төсөлд Газарзүй мэдээллийн системийн ажилтнаар оролцсон байх.	Гэрээт байж болно

1:25000-ны масштабтай гео-орчны судалгаа, эрлийн ажил:

Албан тушаал	Мэргэжил боловсрол, туршлага	Үндсэн эсхүл гэрээт ажилтан байх
Төслийн удирдагч	- Геологийн судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлээр 10-аас доошгүй жил ахлах геологич болон түүнээс дээш түвшинд ажилласан байх, - Мэргэшсэн эсхүл Зөвлөх геологич байх	Үндсэн
Ахлах геологич	-Геологийн зураглалын чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан байх - Мэргэшсэн эсхүл Зөвлөх геологич байх	Үндсэн
Гео-орчны судалгаа хариуцсан ахлах	- Геологи эсхүл гидрогеологийн чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан байх - Мэргэшсэн эсхүл Зөвлөх зэрэгтэй байх	Үндсэн
Геологич	Геологийн зураглал, эрэл, хайгуулын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	Үндсэн
Геофизикч	- Геофизикийн судалгааны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	Гэрээт байж болно
Гидрогеологич	Гидрогеологийн зураглал, хайгуулын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	Үндсэн
Гидрологич	Гидрологийн мэргэжилийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан эсхүл ижил төсөөтэй төсөлд ажилласан байх	Гэрээт байж болно
Инженер геологич	Инженер геологийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх	Гэрээт байж болно
Геоэкологич	Геоэкологи, байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан эсхүл ижил төсөөтэй төсөлд ажилласан байх	Гэрээт байж болно
Геохимич	Геологи эсхүл геохимийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	Гэрээт байж болно
Газарзүй мэдээллийн систем хариуцсан ажилтан	Газарзүй мэдээллийн системийн программ хангамж бүрэн эзэмшсэн, энэ чиглэлээр 2-оос доошгүй жил эсхүл ижил төсөөтэй төсөлд Газарзүй мэдээллийн системийн ажилтнаар оролцсон байх.	Гэрээт байж болно

Санал болгох ажилтнуудын боловсрол, мэргэжил, туршлагын мэдээллийг нотлох баримтын шаардлага хангаж ирүүлэх ба материалын бүрдэл дутуу, шаардлага хангахгүй (уншигдахгүй) бол захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно.

Хүний нөөцийн мэдээллийг дараах баримтаар нотолно. Үүнд:

1. Дипломын хуулбар /нотариатаар баталгаажуулсан эсхүл “ИМонголиа” цахим системээс татаж авсан лавлагаа/
2. Зөвлөх, мэргэжсэний хүчинтэй үнэмлэх
3. Нийгмийн даатгалын лавлагаа: Цахим системээс харна. /Хэрвээ цахим системд бүртгэлгүй бол тендерээс татгалзах үндэслэл болно. Үндсэн ажилтан нь сүүлийн 3 сарын нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн байна/.
4. ИТА-тай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хуулбар /нотариат/
5. Гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл /МУ-д бол судалгааны ажил хамгаалсан тайлангийн ЭБМЗ-ийн дүгнэлт, ОУ-д бол холбогдох мэдээллийг цахим орчинд танилцах холбоос/
6. Хэрэв инженер, техникийн ажилтнууд нь гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл “ИМонголиа” цахим системээс татаж авсан лавлагааг ирүүлнэ. Хөлсөөр ажиллуулах гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.

Анхааруулга: Хүний нөөцийн боловсролын мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-аар нотлох гэж байгаа бол инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн эсвэл цахим системд бүртгэл байхгүй бол тендерийн нээлтээс өмнө Боловсролын яамны Цахим боловсрол, статистик, мэдээллийн хэлтэс, Боловсролын ерөнхий газарт хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү.

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <https://e-mongolia.mn/>

2. Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн доод шаардлага: “Шаардана”

Геологийн судалгаанд ашиглагдах автомашин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл:

1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрэл болон 1:25000-ны масштабтай гео-орчны судалгаа, эрлийн ажилд:

- Туулах чадвар сайтай (4x4) хүн тээврийн хэрэгсэл – хамгийн багадаа 3
- Туулах чадвар сайтай ачаа тээврийн хэрэгсэл – хамгийн багадаа 2
- Геологийн судалгааны ажилд шаардагдах бусад тоног төхөөрөмж, техник хэрэгсэл.

Санал болгож байгаа тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээллийг V бүлгийн маягт 3-ын дагуу ирүүлэх ба тэдгээрийн гэрчилгээний хуулбар, холбогдох техникийн үзүүлэлтийг нотлох баримтын шаардлага хангаж ирүүлнэ. Түрээсээр ашиглах бол түрээсийн гэрээний хуулбарыг мөн адил нотлох баримтын шаардлага хангаж ирүүлнэ.

Ажилчдад тухайн ажлыг гүйцэтгэх орчин нөхцөл /ажлын байр, хээрийн ажил явуулах орчин, багаж хэрэгсэл, геологийн мэдээлэл боловсруулалтын программ хангамж, аюулгүй ажиллагааны хэрэгсэл, хангамж гэх мэт/-ийг бүрдүүлэх чадамж, материалын бүрдэл дутуу, шаардлага хангахгүй (уншигдахгүй) бол захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно.

3. Ижил, төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын доод шаардлага: “Шаардана”

- 3.1. Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн:

	<p>- Геологийн судалгааны ажлын хувьд 20 хувиас багагүй үнийн дүнтэй ижил, төстэй ажлыг сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд доод тал нь 1 удаа гүйцэтгэсэн байх.</p> <p>Гүйцэтгэсэн ажлын мэдээлэлд 1/ төсөвт өртөг, 2/ гэрээний хуулбар, 3/ гэрээ дүгнэсэн акт эсхүл түүнтэй ижил баримт (ЭБМЗ-ийн дүгнэлт, холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт)-ыг хавсарган ирүүлнэ.</p> <p>4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”</p> <p>4.1. Геологийн судалгааны (ижил төстэй) ажил хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсныг нотлох баримт буюу гэрээний хуулбар, эсхүл Захиалагчийн мэдээгдэл, тодорхойлолт;</p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээллийг Маягт 5-ын дагуу гаргаж ирүүлнэ. Тухайн судалгааны ажлыг захиалагчийн геологийн даалгаврын дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэхийг баталсан мэдэгдэл заавал ирүүлнэ.</p>																												
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - Шаардсан хүний нөөцийн мэдээллийг V бүлгийн маягт 2-ын дагуу ирүүлэх; - Оролцогчийн туршлагыг харуулах хэсэгт заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн маягт - 4, 5, 6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл; - Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээллийг V бүлгийн маягт 3 (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт)-ын дагуу нотлох баримтын хамт ирүүлэх; - Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт. <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичигт заасан мэдээлэл нь тус судалгааны ажлын геологийн даалгаврын шаардлагыг хангахгүй бол Захиалагч ирүүлсэн тендерээс татгалзана.</p>																												
ТШЗ 21.6	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна” .																												
ТШЗ 21.6	Оролцогч тендерийн үнийг төсөвт өртгийн 90 хувиас доош үнэ санал болгох бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ. Ирүүлсэн тайлбар нь судалгааны ажлын геологийн даалгаварт заасан шаардлагыг бүрэн биелүүлэхгүй тохиолдолд Захиалагч тендерээс татгалзана.																												
ТШЗ 21.6	Тендерийн үнийг Төгрөг -өөр илэрхийлнэ.																												
ТШЗ 24.1	Тендерийн хүчинтэй байх хугацаа тендер нээснээс хойш ажлын 30-аас доошгүй өдөр байна.																												
ТШЗ 24.1	<p>Тендерийн баталгааны дүн: Төсөвт өртгийн 0.5 хувь</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Төслийн кодын нэр</th> <th>Батлагдсан төсөвт өртөг</th> <th>Баталгаа /төсөвт өртгийн 0.5 хувь/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Багц №1</td> <td>Тэмээт уул-50</td> <td>2,694,888,750.00</td> <td>13,474,443.75</td> </tr> <tr> <td>Багц №2</td> <td>Хэцүү уул-50</td> <td>2,284,249,540.20</td> <td>11,421,247.70</td> </tr> <tr> <td>Багц №3</td> <td>Алтан ширээ уул-50</td> <td>2,856,749,564.40</td> <td>14,283,747.82</td> </tr> <tr> <td>Багц №4</td> <td>Төхөлийн элс-50</td> <td>4,533,277,410.10</td> <td>22,666,387.05</td> </tr> <tr> <td>Багц №5</td> <td>Цахирын хяр-50</td> <td>3,383,826,124.90</td> <td>16,919,130.62</td> </tr> <tr> <td>Багц №6</td> <td>Хархорин-25</td> <td>5,602,400,000.00</td> <td>28,012,000.00</td> </tr> </tbody> </table> <p>Хүчинтэй байх хугацаа: Тендерийн хүчинтэй байх хугацаа буюу тендер нээснээс хойш ажлын 29-өөс доошгүй өдөр байна.</p>	№	Төслийн кодын нэр	Батлагдсан төсөвт өртөг	Баталгаа /төсөвт өртгийн 0.5 хувь/	Багц №1	Тэмээт уул-50	2,694,888,750.00	13,474,443.75	Багц №2	Хэцүү уул-50	2,284,249,540.20	11,421,247.70	Багц №3	Алтан ширээ уул-50	2,856,749,564.40	14,283,747.82	Багц №4	Төхөлийн элс-50	4,533,277,410.10	22,666,387.05	Багц №5	Цахирын хяр-50	3,383,826,124.90	16,919,130.62	Багц №6	Хархорин-25	5,602,400,000.00	28,012,000.00
№	Төслийн кодын нэр	Батлагдсан төсөвт өртөг	Баталгаа /төсөвт өртгийн 0.5 хувь/																										
Багц №1	Тэмээт уул-50	2,694,888,750.00	13,474,443.75																										
Багц №2	Хэцүү уул-50	2,284,249,540.20	11,421,247.70																										
Багц №3	Алтан ширээ уул-50	2,856,749,564.40	14,283,747.82																										
Багц №4	Төхөлийн элс-50	4,533,277,410.10	22,666,387.05																										
Багц №5	Цахирын хяр-50	3,383,826,124.90	16,919,130.62																										
Багц №6	Хархорин-25	5,602,400,000.00	28,012,000.00																										

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: <ul style="list-style-type: none"> - ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 7 дугаар зүйлд заасан оролцогчийн ерөнхий шаардлагууд - Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл - ТБОНӨХБАҮХАТХуулийн 22.5-д заасан үндэслэлээр ил болгохгүй баримт бичиг, мэдээлэл байгаа бол түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл - Тендер шалгаруулалтын баримт бичигт ил болгохоор заасан бусад баримт бичиг (Судалгааны ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө, төсөл гэх мэт)
ТШЗ 26.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2026 оны 04 сарын 06-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут
ТШЗ 26.2	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Цаг: 11 цаг 30 минут Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 18072, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрчний эвлэл-37, Үндэсний геологийн албаны байр, 2 дугаар давхар, 219 дүгээр өрөө
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.1	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: 1. Давуу эрх тооцуулах тухай албан хүсэлт ирүүлнэ. 2. ТБОНӨХБАҮХАТХуулийн 8.7.2-д заасны дагуу давуу эрх тооцуулах нөхцөл хангаж буй талаар нотлох баримт бичиг ирүүлнэ. (Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, загвар”-ын дагуу давуу эрх олгож, үнэлнэ)
ТШЗ 32.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”
Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 37.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Туйм” <ul style="list-style-type: none"> - Гүйцэтгэлийн баталгаа нь тухайн жилд санхүүжих үнийн дүнгийн 3 хувь байна. - Гүйцэтгэгч нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 42.3 дахь заалтад заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ. - Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг Захиалагчийн тогтоосон хугацаанд ирүүлнэ.
Ё. БУСАД	
ТШЗ 38.1	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”

МОНГОЛ УЛС

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

БАТЛАВ: АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ДАШПҮРЭВ

2026 оны 05-р сарын 06-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2026/05

**ТЭМЭЭТ УУЛ-50 ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50 000-НЫ
МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖЛЫН
ГЕОЛОГИЙН ДААЛГАВАР**

Судалгааны үе шат: 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрэл

Ашигт малтмалын төрөл: Бүх төрлийн ашигт малтмал

Судалгааны талбайн нэр: Тэмээт уул

Судалгааны талбайн байршил: Дундговь аймгийн Сайнцагаан, Гурвансайхан, Өлзийт, Хулд, Луус сумдын нутаг

Судалгааны талбайн хэмжээ: 3270.72 кв.км

Координат:

№	гр	мн	сс	гр	мн	сс
1	105	45	00	45	30	00
2	106	30	00	45	30	00
3	106	30	00	45	20	00
4	107	00	00	45	20	00
5	107	00	00	45	10	00
6	106	30	00	45	10	00
7	106	30	00	45	00	00
8	106	00	00	45	00	00
9	106	00	00	45	20	00
10	105	45	00	45	20	00

Хавтгай: L-48-92-Г
L-48-93-В,Г
L-48-105-А,Б,В,Г
L-48-106-А,Б

Код: ТэУ-50

1. Геологийн даалгавар боловсруулах хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24 дэх хэсэг, “Ашигт малтмалын тухай” хуулийн 16 дугаар зүйл, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2, УИХурлын 2025 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Алт-3” аян, УИХурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ийн 3.5.2, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төсөл, төлөвлөгөө”.

2. Судалгааны ажлын үндэслэл:

Судлагдсан түвшин:

Тайлангийн дугаар	Тайлангийн нэр	Гүйцэтгэсэн он
4762	Уудам талын районд хийсэн хайгуулын ажлын тайлан	1994
2414	Зүүн Монголын галт уулын чулуулгийн бүсийн баруун урд хэсэгт хийсэн ураны эрлийн тайлан /лист L-48-А,Б,В,Г; L-49-В/	1974
4621	Дөрвөн-Дэртийн чүнчигноровын ордын эрэл-үнэлгээ, Дундговь, Дорноговийн районы цагаан хаш ба бусад төрлийн өнгөт чулууны эрлийн болон мэдээ шалгасан ажлын тайлан	1992
4797	Өмнөговь, Дундговь аймгуудын нутагт 1992 онд хийсэн пиротилитийн эрлийн ажлын тайлан	1994
1869	Мандалговийн районд хийсэн барилгын материалын түүхий эдийн эрэл, хайгуулын тайлан	1971
2196	Дундговь аймгийн баруун хэсгийн нүүрс ба шатах занарт хийсэн эрэл-үнэлгээний тайлан /№4 анги/	1973
4621	Дөрвөн-Дэртийн чүнчигноровын ордын эрэл-үнэлгээ, Дундговь, Дорноговийн районы цагаан хаш ба бусад төрлийн өнгөт чулууны эрлийн болон мэдээ шалгасан ажлын тайлан	1992
4800	Дундговь аймгийн Гурвансайхан, Өлзийт сумын нутаг Сант-Уулын талбайд 1992-1993 онуудад гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай шлих, литохимийн сорьцлолтын ажлын үр дүнгийн тайлан. Байршил. L-48-105-А,Б,В,Г, L-48-106-А,Б нэрэлбэр бүхий	1995
10415	Дундговь аймгийн Дэлгэрхангай, Луус, Хулд сумдын нутагт орших Хулд-50 талбайд 2019-2022 онд гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр	2022

	дүнгийн тайлан. Код: Хул-50. L-48-103-А,Б,В,Г; L-48-104-А,Б,В,Г /хил залгаа/	
10080	Дундговь аймгийн Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрхангай, Хулд, Луус сумдын нутаг дахь "Шүтээн улаан уул-50" төслийн талбайд 2017-2020 онд гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан Байр-зүйн хавтгай: (L-48-67-В,Г; L-48-79-А,Б,В,Г; L-48-91-А,Б,В,Г; L-48-92-А,В) /хил залгаа/	2020
7755	Дундговь аймгийн Эрдэнэдалай, Адаацаг, Луус, Дэлгэрхангай, Сайнцагаан сумдын нутаг хамарсан Сайнцагааны талбайд 2012-2014 онуудад гүйцэтгэсэн 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил:L-48-80-АБВГ, L-48-81-АБ, L-48-92-Б, L-48-93-Б /хил залгаа/	2015
7345	Дундговийн Дэлгэрцогт, Дэрэн, Гурвансайхан, Сайнцагаан, Луус сумдыг хамарсан Мандалговийн талбайд 2011-2014 онд гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан L-48-81-ВГ, L-48-82-АБВГ, L-48-93-Б, L-48-94-АБ /хил залгаа/	2014
4543	Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг Гурвансайханы талбайд хийсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, нарийвчилсан эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил: L-48-94-Б-в,г, В,Г /хил залгаа/	1991
3676	Дундговийн районд хийсэн 1:200000-ны масштабын бүлэгчилсэн геологийн зураглалын тайлан	1983
7390	Монгол Улсын 1:200000-ны масштабын геологийн иж бүрдэл зураг зохиох "УГЗ-200 Өмнөд-Монгол-VI" төслийн 2010-2013 онд гүйцэтгэсэн үр дүнгийн тайлан L-48-XVII. XIX. XX. XXI.XXII. XXIII. XXIV. XXV. XXVI. XXVII. XXVIII. XXIX. XXX. XXXIII. XXXIV. XXXV. XXXVI	2014
1779	Мандалговийн районд хийсэн 1:500000-ны масштабын геологи-гидрогеологийн зураглалын тайлан /Мандал-говийн №8 анги/	1968
4028	Зүүн өмнөд Монголд хийсэн 1:500000-ны масштабын гидрогеологийн зураглалын тайлан (L-48БГ,L-49АВ,К-48БГ,К-49АБ)	1986

Геологийн тогтоц:

Төслийн талбай нь Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургаар ялгасан Идэрмэг, Өндөршил тектоникийн бүсүүдэд хамаарч байна. Талбайд дунд

протерозойн Оорцог формац, дээд дунд девоны Бутуулхудаг формац, доод цэрдийн Тэвшийнговь формац, доод цэрдийн Манлай формац, доод цэрдийн Могойт формац, дээд цэрдийн Сайншанд формац, дээд цэрдийн Баянширээ формац, болон дөрөвдөгчийн хурдас, дунд протерозойн ангилагдаагүй габбро-диорит-боржин бүрдэл, Дунд хожуу девоны Буянт бүрдэл, дунд хожуу пермийн Мандалговь бүрдэл, Хожуу триас түрүү юрагийн Борөндөр бүрдэл зураглагдсан байна.

1. Буянт бүрдэл (D_{2-3b}? C_{1b}?). Ихбогд-Өндөршил, Идэрмэгийн бүсийн хэмжээнд маш өргөн тархалттай, анх Л.В.Заботкин (3676Ф), Г.Бөмбөрөө (4377Ф) нар ялган судалж, Б.Нямаа (7390Ф) Буянт бүрдэлд 3 фаз ялган, I фазад эвэрхуурмаг-пироксенит габбро, диорит, кварцат диорит, II фазад биотит-эвэрхуурмагт, гранодиорит, гранит, диорит, III фазад биотитот, биотит-эвэрхуурмагт заримдаа порфир маягийн гранит, лейкогранитыг ялгасан ба дэл судлын чулуулгаас микродиорит, микрогранит, аплитыг хамааруулсан. УГЗ-200 төслөөр Буянбаатар нар (6326Ф) дээрх хавтгайд дунд-хожуу девоны Буянт бүрдлийг габбро-диорит-гранитаар зурагласан бол зэргэлдээх талбайд уг бүрдлээр зураглагдсан гранитоидоос авсан дээжид үнэмлэхүй насны шинжилгээгээр 292.50±2.47 сая жил (ШУУ-50 төсөл), 333.23±1.2 сая жил (Хулд-50 төсөл) гэж тус тус тогтоосон бөгөөд Хулд-50 төслийн талбайд геологийн харьцаа, үнэмлэхүй насанд үндэслэн түрүү карбонд хамааруулсан байна.

2. Мандалговь бүрдэл (P_{1-2m})-ийг Идэрмэгийн бүсэд Сахалгол формацын вулканиттай вулкан-плутон эвшил үүсгэн тархдаг гэж үздэг. Анх Л.В.Заботкин 1982 онд ялган, түрүү пермийн цаг үед хамруулж, Дамдинжав нар (5463Ф) түрүү-дунд пермийн настай Мандалговь бүрдлээр нэрлэн, 3 фазтайгаар ялгасан. I фаз габбро, габбродиорит, II фаз кварцат монцодиорит, диорит, биотит-эвэрхуурмагт жижиг мөхлөгт гранит, кварцат сиенит, граносиенит, III фаз биотитот, амфибол-биотитот шүлтлэгдүү гранит, лейкогранит, дэл судлууд нь гранит-порфир, микродиоритоос тогтдог. Хожим УГЗ-200 төслөөр Буянбаатар нар (6326Ф) түрүү-дунд пермийн настай гранодиорит-гранитын найрлагатай гэж үзсэн бол Эрдэнэчимэг нар (8480Ф) габбро, габбродиорит, диорит, кварцат диорит, гранодиорит, лейкогранит, шүлтлэгдүү лейкогранитоос тогтоно гэж үзсэн байна.

Ашигт малтмал: Төслийн талбай нь Дундговийн минерагений бүсийн Мандалговийн хүдрийн дүүргийн Луусын хүдрийн зангилаа болон Гурвансайхан-Өлзийтийн хүдрийн дүүргийн Хөтөл ус – Билгэх – Гурвансайханы хүдрийн зангилааг дамнан байрлах бөгөөд ЗУ зах хэсгээр нь Хөхдэл-Хайрхны хүдрийн зангилааны БХ зарим хэсэг хамрагдана. Тус талбайд өмнөх судалгаагаар Хайлуур жонш-12, Хүрэн нүүрс-1, Шохойн чулуу-1 орд, Асбест-2, Төмөр-2, Вольфрам-4, Барит-1, Хайлуур жонш-14, Болор-1, Цагаан тугалга-1, Хар тугалга-1, Зэс-1, Шохойн чулуу-6, Хүрэн нүүрс-1, Бал чулуу-1, Алт-2 илрэл тогтоогдсон.

Л.В.Заботкин нарын 1:200000-ны масштабын ГЗЕЭА-аар /1983, №3676/ төслийн талбай бүрэн бүрхэгдсэн бөгөөд олон тооны хайлуур жоншны илрэл, эрдэсэжсэн цэгүүдийг илрүүлсэн бөгөөд өнөөдөр байдлаар тэдгээр илрэлүүдэд хувийн хөрөнгөөр хайгуул хийж олон тооны ордуудыг тогтоосон.

Төслийн талбай нь хайлуур жоншны хувьд хэтийн төлөв маш өндөр, өнөөдрийн хувьд Л.В.Заботкин нар /1983, №3676/-ын илрүүлсэн зарим илрэл, эрдэсэжсэн цэгүүдийн хэтийн төлөв тодорхойгүй, ямар нэг ажил хийгдээгүй байна.

Доод цэрдийн Хөхтээг, Шинэхудаг, Манлай формацуудын доор орших нүүрс болон шатдаг занарын хувьд хэтийн төлөвтэй дээд юра-доод цэрдийн Могойт формацын хурдас нь

мезозойн хотгоруудаар газрын гадаргад /Үнст худгийн хотгор/ болон Манлай формацаар хучигдсан гэж зураглагдсан байгаа тул цэрдийн хотгоруудын цаашдын хэтийн төлөвийг тодруулах шаардлагатай.

Уг талбайн 1:50000-ны масштабын номенклатурын L-48-105-А,Б,В,Г, L-48-106-А,Б хавтгайд 1992-1993 онд 1:50000-ны масштабтай шлик, литогеохимийн сорьцлолт хийгдэж үр дүнгийн тайлан бичигдсэн. /Ж.Нармандах, 1992, №4800ф/ Харин L-48-92-Г, L-48-93-А,Б хавтгайд 1:50000-ны масштабын ямар нэг ажил хийгдээгүй ч хайлуур жоншны илрэлүүд нь орд болсон байдаг.

Эдийн засгийн хувьд:

Төслийн талбай нь нутаг дэвсгэр нь говь хээрийн бүсэд орших бөгөөд уур амьсгалын хувьд эх газрын эрс тэс хуурай мужид хамрагддаг. Агаарын температурын дундаж хэмжээ өвлийн улиралд -16-19 хэмийн дундаж хүйтэн, зуны улиралд 17-21 хэм дулаан, жилд дунджаар 95-150 мм хур тунадас ордог. Эдийн засгийн хувьд төслийн талбай нь Дундговь аймгийн засаг захиргааны нэгжид хамрагдах бөгөөд тус аймаг нь 2024 оны эцсийн байдлаар 46131 мянган хүн амтай, 3,547.7 мянган толгой малтай, ДНБ-ний өсөлт 16,8% Хэрэглээний үнийн индекс 107,4 хувь хүрсэн Нүүрс, жонш, гөлтгөнө, шохойн чулуу, төмрийн хүдэр зэрэг уул уурхай олборлолт, барилгын материалын үйлдвэрлэл хөгжиж байгаа төвийн бүс нутаг юм.

Ажлын зорилго:

Төслийн үндсэн зорилго нь:

- Судалгааны талбайд тархсан тунамал, вулканоген, интрузив, метаморф чулуулаг, тэдгээрийн эвшлээс бүрдэх хурдас, чулуулгийг судлан Монголын литостратиграфын кодексийн дагуу зохих нэгжүүдэд ангилан ялгаж, зураглах, тектоник структурийн төрлүүдийг тодорхойлж, геодинамик нөхцөлийг тогтоох.

- Судалгааны талбайд ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэн эрлийн шинж тэмдэг, шалгуурыг тогтоож, ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтлыг тодорхойлон хэтийн төлөв бүхий хэсгүүдийг ялган эрлийн ажлыг гүйцэтгэн судалсны үндсэн дээр минерагений нэгжүүдийг (бүс, дүүрэг, зангилаа, талбай г.м) ялган, тэдгээрийн хэтийн төлөвийг тодорхойлон, эрдэс баялгийн үнэлгээг өгч, цаашдын судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох. Хэтийн төлөв бүхий илрэлүүдэд баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх.

- Судалгааны ажлын үр дүнд тулгуурлан гидрогеологи, геоморфологи, геоэкологийн судалгааг хийж, холбогдох зургуудыг даалгаварт заасан масштабаар зохиох, байгаль орчин дахь нөлөөллийг урьдчилан үнэлэх, уул уурхайн салбарын хөгжлийн суурь мэдээллийг бэлтгэнэ.

Зураглалын ажлыг геологийн тогтоц, нэвтрэлтийн зэрэг, хучаас хурдасны тархалт, гаршийн онцлогтой уялдуулан гүйцэтгэх бөгөөд геологийн нийлмэл тогтоц, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд торыг нягтруулан зохих шаардлага (Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:50,000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийх заавар, тавих шаардлага, 2010)-ыг хатуу мөрдөнө.

Тэмээт уул-50 төслийн талбайн хэмжээнд гүйцэтгэх геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг мөрдөж ирсэн заавар, шаардлагын дагуу гүйцэтгэн геологи, ашигт малтмалын болон холбогдох бусад зургуудыг зохиох, ашигт малтмалын тархалтын зүй

тогтол, хэтийн төлөвийн үнэлгээг өгч, тэдгээрийн тайлбар бичгийг зохиож, анхдагч материалын сан бүрдүүлнэ.

3. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх үндсэн арга аргачлал ба дэс дараалал:

А.Бэлтгэл ажлын үе:

4.1. Судалгааны ажлын төсөл, төсөв, календарьчилсан төлөвлөгөө зохионо.

4.2. Талбайн хэмжээнд өмнө нь хийсэн геологийн үе шатны судалгаа болон сэдэвчилсэн судалгааны материалуудыг бүрэн судлан танилцаж дүн шинжилгээ хийх, түүний үндсэн дээр тухайн талбайд тохирсон судалгааны арга аргачлалыг сонгоно. Үүнд:

- Өмнөх шатны судалгааны бүх төрлийн ажлын үр дүнг багтаасан мэдээллийн сан үүсгэх, мэдээллийг боловсруулан үнэлэлт, дүгнэлт өгч, өөрсдийн судалгааны ажлын суурийг бэлтгэх, арга аргачлал боловсруулах, баримтын зургийг зохиож бүртгэл үйлдэх,
- Өмнөх судалгааны материалд үндэслэн тухайн дүүргийн онцлогт тохирсон талбайн сорьцлолтын аргыг сонгож, тоо хэмжээг тооцох,
- Төслийн талбайн хэмжээнд мэдэгдэж байгаа ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, шлих, литогеохимийн сарнилын хүрээ, гажлуудыг бүртгэж, тэдгээрт дүн шинжилгээ хийх, хэтийн төлөвийн урьдчилсан зураг зохиох,
- Төслийн талбайн 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын шаардлага хангасан, өндөр нарийвчлалын агаар, сансрын болон 1:25 000, 1:50 000-ны масштабтай байрзүйн зургуудыг холбогдох мэргэжлийн байгууллагаар бэлдүүлэх, АСЗ-т геологийн тайлал хийх, тухайн талбай хамрагдсан геофизикийн судалгааны (хүндийн хүчний, соронзон зураглал гэх мэт) материалуудтай танилцан, урьдчилсан тайлал, боловсруулалт хийх,
- Өмнөх шатны судалгааны материалууд болон АСЗ-т хийсэн урьдчилсан тайллыг ашиглан төслийн геологийн болон бусад холбогдох зургийг 1:50 000-ны масштабтаар зохиож, нэгдсэн таних тэмдэг зохиох,
- Хээрийн ажилд гарахын өмнө талбайн стратиграфи, магматизм, тектоникийн мэдээлэл, урьдчилсан тайлал хийсэн зургийн хүрээнд танилцах маршрут төлөвлөх, уг асуудлаар Монголын стратиграфийн комиссоос зөвлөгөө авч, хамтран ажиллах,
- Дээрх материалууд дээр үндэслэн цаашдын судалгааны ажлыг төлөвлөсөн байх,
- Хилийн болон тал, хээрийн бүсэд ажиллахтай холбоотой хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны бэлтгэлийг хангана.

4.3. Машин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон ажиллагсдын хөдөлмөр-ахуйн нөхцөлийг хангасан хээрийн судалгааны өмнөх бэлтгэлийг бүрэн хангана.

4.4. Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрөл (орон нутаг, хилийн бүс, тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах гэх мэт), бичиг баримтыг бүрдүүлнэ.

4.5. Хээрийн судалгааны шатанд зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгэх гэрээ, геологийн даалгавар, ажлын төсөл, төсөв болон холбогдох журам, зааврыг бүрдүүлэн бэлтгэнэ.

Б. Хээрийн ажлын үе:

4.6. Ажил эхлэхээс өмнө жил бүрийн хээрийн судалгааны ажлыг хэрхэн ямар хугацаанд гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөө (ажлын хөтөлбөр) зохиосон байна.

4.7. Судалгаанд хамрагдах талбайн хэмжээнд юуны түрүүнд танилцах маршрутыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Талбайд тархсан хурдас, чулуулаг, гүний биетүүдийн тогтоц, голлох бүрдүүлэгч чулуулгийн найрлага, тогтоц, онцлог, тэдгээрийн харьцаа, хил зааг, томоохон хувирал, өөрчлөлтийн бүсүүд, тасралтад эвдрэлүүд, органик үлдэгдэл тогтоогдсон цэгүүд, өмнөх судалгаануудаар тогтоосон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, бүх төрлийн гажлуудтай танилцаж, дүгнэлт гаргах, эдгээр геологийн биетүүдээс эталон дээж бүрдүүлэх, шаардлагатай бол урьдчилан дээжилж, сорьцлох,
- Талбайн сорьцлолтын урьдчилан боловсруулсан арга, аргачлалыг бодит байдал, орчин нөхцөл, ландшафтын онцлог, орчин үеийн хурдасны тархалт, гарал үүсэл, бүс нутгийн уур амьсгал зэрэгтэй уялдуулан нягталж, шаардлагатай бол туршилт аргачлалын сорьцлолт хийх, сорьцын тоог хучаас хурдсаар дарагдаагүй үндсэн чулуулгийн гарш бүхий нийт талбайд 1 кв.км-т >1 сорьц ноогдохоор тооцож, төлөвлөх,
- Маршрутын судалгаа, талбайн сорьцлолт эхэлж явуулах талбайг сонгох,
- Дээрх ажлуудыг гүйцэтгэхэд төслийн инженер техникийн ажилчид (ИТА), зөвлөхүүд бүгд оролцож, нэгдсэн дүгнэлт өгөх,
- Танилцах маршрутын үр дүнд тулгуурлан ажлын арга, аргачлалыг хянаж, шаардлагатай тохиолдолд заавар, шаардлагад нийцүүлэн зохих өөрчлөлтийг оруулан, хээрийн ажлын төлөвлөгөөг нарийвчилна.

В. Геологийн зураглалаар:

Геологийн зураглалын ажлыг ≤500 м-ийн торын нягтралтайгаар, чанарын шаардлага хангасан маршрутын судалгаагаар гүйцэтгэх бөгөөд доорх ажлуудыг хийж, асуудлыг шийднэ. Үүнд:

- АСЗ-ийг өргөн ашиглах, түүний тайллын үр дүнг газар дээр нь баталгаажуулан шалгаж, байнга засварлаж, нарийвчлал хийх,
- Урьдчилан зохиосон ажлын зурагт үнэлэлт дүгнэлт өгөх, шалган холбох маршрутыг шат дараатай явуулах,
- Төслийн талбайн хэмжээнд тархсан бүх төрлийн магмын болон хувирмал, тунамал, вулканоген хурдас, чулуулгийн тогтоц, найрлага, тархалт, хоорондын харьцаа, ялгааг тогтоох, литологи, структурыг нарийвчлан судалж төрөлжүүлэн зураглах, насны үндэслэлийг харьцуулалтын, палеонтологийн ба үнэмлэхүй насны шинжилгээгээр баталгаажуулах, тулгуур зүсэлтүүдийг хийх, нас, геохими, петрохимийн онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн дээж, сорьцыг арга, аргачлалын дагуу авах, шинжилгээ хийлгэх, боловсруулах ба урьдчилсан байдлаар ажлын геологийн зураг зохиож, тайлбар бичиглэл хийх, анхдагч баримт материалыг зааврын дагуу бүрдүүлэх,
- Хурдас чулуулгийн хил зааг, хоорондын харьцааг тогтоох, тэдгээрийн литологи, структурыг нарийвчлан зураглаж, формац, мэмбэр, бэд болон бүрдэл, фаз, фацийн түвшинд ялгах, шаардлагатай төрлийн сорьцлолтыг хийх, ингэхдээ дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байх. Үүнд:

1. Хулд 50, Дэвийн хонгор Уул 50, Модот толгой 50, Шүтээн Улаан уул 50 төслийн. Тайлан, үр дүнтэй танилцаж, талбайн хил заагийг нийлүүлэх.

2. Неопротерозойн Оорцог формацыг нарийвчилан зураглаж, хурдасны насыг нарийвчилах, үүнд зөөгдмөл циркон, тогтвортой изотопын аргуудыг хэрэглэх.

3. Девонээр зураглагдсан хурдсанд зөөгдмөл цирконы нас, палеогеографийн судалгаанууд хийж, тектоникийн дүгнэлт гаргах.

4. Суурилаг болон хэт суурилаг биет бүрээс 3-с доошгүй дээжид геохимийн шинжилгээ хийлгэх.

5. Пермийн настай зураглагдсан интрузив, эффузив биетүүдэд геохимийн судалгаа хийх, үнэмлэхүй нас тогтоох.

6. Литологийн хувьд өмнөх судлаачдын ажлаар харилцан адилгүй, шүлтлэг гранит, сиенит, монцонит, катаклажсан болон гнейслэг лейкогранит ялгасан байдаг тул магмын чулуулагт цогц шинжилгээг /петрографи, петрохими, геохими, геохронологи/ хийлгэн, бодисын найрлага, гарал үүслийг тодруулах.

- Төслийн талбайн литостратиграфийн ангиллыг “Монголын литостратиграфийн кодекс”-ийн дагуу шинэчлэн, ангилсан хурдаснуудыг хроно ба региональ стратиграфийн номенклатуртай харьцуулах, литостратиграфийн нэгжийн бичиглэлийг кодексийн дагуу үйлдэх,
- Төслийн талбайд гүний чулуулаг, дэл судлын биетүүдийн гарал үүсэл, ангилал, бүрдлийн фаз, фацийг тодруулах, петрохими, геохими, петрографийн ба металлогений онцлогийг тодорхойлох, биетүүдийн нарийвчилсан бичиглэлийг хийх, бүрдэл, дэл судлын чулуулгийн геохими онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн сорьцыг арга, аргачлалын дагуу авч, шинжилгээ хийлгэн, үр дүнг боловсруулах,
- Шаардлагатай тохиолдолд чулуулгийн үнэмлэхүй насыг тодорхойлуулах (тухайн гүний болон вулканоген, тунамал чулуулгийн онцлог, найрлага, гарал үүсэл, бусад онцлогийг бүрэн тодорхойлж, фаз, фацийн түвшинд зурагласан тохиолдолд энэ аргыг хэрэглэнэ),
- Талбайн сорьцлолтоор авсан литогеохимийн бүх сорьцод тоон шинжилгээ (ICP-MS) хийлгэж, үр дүнг боловсруулах,
- Орчин үеийн болон сэвсгэр хурдсыг гарал үүсэл, насаар нь нарийвчлан ангилж баталгаажуулах, тэдгээрийн зузаан, литологийн бүрэлдэхүүн, бусад шинжийг тодорхойлох,
- Төслийн талбайтай хил залгаа болон ойр хийгдсэн 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлуудын үр дүнтэй уялдуулах, харьцуулж шалгах,
- Талбайн тектоник-структурын бүтцийг нарийвчлан ангилж, тэдгээрийг бүрдүүлэгч хурдаснуудын формацын хамаарлыг тогтоон, нарийвчилсан бичиглэл хийх, тектоник-структурыг ашигт малтмалын тархалтын онцлогтой уялдуулан тайлбарлах,
- Геоморфологийн ажиглалт хийж, гадаргуугийн гарал үүсэл, хэлбэр дүрсийн төрлүүдээр ангилах, рельефийн хөгжлийн онцлог, үүссэн дарааллыг судалж зураглах, тайлах, ашигт малтмалын шороон хуримтлал үүсэх боломжтой нөхцөл бүрдсэн геоморфологийн элементүүдийг судалж тогтоох, морфоструктурын анализ хийх,
- Гидрогеологийн судалгаагаар тухайн талбайд байгаа худаг, булаг, шандыг координатжуулан, усны ундарга, түвшин бууралтыг хээрийн ажиглалтаар тогтоож, тухайн талбайн уст бүрдлийг төлөөлж чадахуйц уст цэгүүдээс гидрохимийн сорьц

авч, шинжлүүлэх, уст бүрдлүүдийн онцлогийг тодруулах, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа хийх,

- Геоэкологийн судалгаагаар тухайн талбайд байгаа үржил шимт өнгөн хөрсний үеэс төрөлжилтийн сорьцлолтыг холбогдох аргачлалын дагуу хийж химийн шинжилгээнд хамруулах, тоон үзүүлэлтийг тодруулах, өмнөх байгаль орчны чиглэлээр хийгдсэн судалгааны материалуудыг ашиглах, өөрсдийн судалгааны ажлаар тухайн талбай дахь геологийн ховор тогтоц (гео-өв), улаан номд орсон амьтан, ургамал, түүхийн дурсгалт зүйлсийн байршлыг координатжуулах, геоэкологийн зураг, экологи-геологийн суурь үнэлгээний зурагт тусгах зорилгоор судалгааны ажиглалтыг зураглалын маршрутын явцад хамт хийх, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа явуулах,
- Төслийн талбайн хэмжээнд шугаман тогтоцтой дислокацид автсан чулуулгийн эрдэслэг бүрэлдэхүүн, үнэмлэхүй нас, структурийг нарийвчлан зураглах. Үүнд:
 - S0, S1, S2..., Sn хавтгай элементүүд (фолэйшн), Sn+1 тэнхлэг хавтгайг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
 - B1, B2..., Bn атирааны нугаснуудыг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
 - L1, L2..., Ln линэйшнүүдийг төрөлжүүлэн (mineral, stretching, intersection) тодорхойлж зураглах, хэмжилт хийнэ.

Г. Эрлийн ажлаар:

Өмнө хийгдсэн төрөл бүрийн геологи, геохими, геофизикийн зэрэг судалгааны ажлын материал үр дүнг бүрэн гүйцэт ашиглах, хил залгаа улсын материалтай сайтар танилцан, цугласан материалд боловсруулалт, дүн шинжилгээ хийн, төслийн талбайн хэмжээнд тогтоогдсон эрлийн шинж тэмдэг, шалгууруудын үндсэн дээр эрлийн ажлыг ашигт малтмалын төрлийг харгалзан, арга, аргачлалыг оновчтой, үр дүнтэй байхаар сонгон төлөвлөн гүйцэтгэх;

- Өмнөх судалгаануудаар илэрсэн орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүдийг хээрийн судалгааны эхний жилд шалган, үр дүнг баталгаажуулах, хяналтын сорьцлолт хийх, ялангуяа өмнөх судлаачдын гидротермаль-метасоматит хувирал харьцангуй хүчтэй илэрсэн гэж зураглаж тэмдэглэсэн талбайнуудад гүйцэтгэх зураглал-ерөнхий эрлийн маршрутын явцад ашигт малтмалын талаар онцгой анхаарал хандуулах,
- Маршрутын судалгааны үр дүнд тогтоогдсон хувирал, эрдэсэжсэн бүс, биетүүдээс ашигт малтмалын шалгуур, шинж тэмдэг тэдгээрийн тоон агуулгыг тогтоох зорилгоор авсан дээж, сорьцуудын үр дүнг нэгтгэн боловсруулсны үндсэн дээр дараагийн шатны ажлыг төлөвлөн, гүйцэтгэх,
- Талбайн шлих, литогеохимийн сорьцлолтын ажлыг 1 кв.км талбайд >1 сорьц ноогдох байдлаар зохих заавар, аргачлалын дагуу зураглалын ажлаас түрүүлүүлэн гүйцэтгэж, тогтоогдсон хэтийн төлөв бүхий сарнилын хүрээ, гажлуудын торыг нягтруулан шалгаж, үнэлгээ өгөх, өмнөх судлаачдын илрүүлсэн церусситын шлихийн хүрээ, хар тугалга, хар тугалга-цайр-зэсийн геохимийн хүрээнүүдийн хэтийн төлөвийг нарийвчлах,
- Өмнөх судалгаагаар илэрч, тухайн ажлын явцад баталгаажсан болон төслийн ажлын судалгааны үр дүнд шинээр тогтоогдсон ашигт малтмалын хүдэржилт бүхий хэсгүүдээс ашигт малтмалын төрөл, онцлог, хэтийн төлөвтэй нь уялдуулан нарийвчилсан эрэл хийх талбайнуудыг сонгох,
- Сонгосон талбайнуудад ашигт малтмалын төрөл, онцлогтой уялдуулан нарийвчилсан эрлийн ажлыг 1:5 000 - 25 000-ны масштабтаар, үе шаттайгаар, цогцолбороор гүйцэтгэх. Энэ ажлын хүрээнд дараах асуудлыг шалган шийдвэрлэх:

1.Геологийн зураглалын маршрутын үед эрлийн ажиглалтыг чанартай гүйцэтгэж, дагалдах дээжлэлт, сорьцлолтыг хийх.

2.L-48-92-Г, L-48-93-А,Б хавтгайд 1:50000-ны масштабын зураглал-ерөнхий эрлийн ажлын кондицийн шаардлага хангасан түвшинд шлих, геохимийн зураглал хийх.

3.1:200000-ны масштабын ГЗЕЭА-аар илэрсэн ба ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарахгүй орших хайлуур жоншны илрэл, эрдэсжсэн цэгүүдийн судлан, шаардлагатай тохиолдолд нарийвчилсан эрлийн ажлаар үнэлэх.

4. Цэрдийн хотгоруудын дотоод бүтэц тогтоцыг зураглал болон түүнд тохирох геофизикийн аргаар судлан тодруулж, ашигт малтмалын хэтийн төлөв /нүүрс, шатдаг занар, элсжингийн уран г.м./ -ийг үнэлэх

5. 1:50000-ны ГЗЕЭА-ын явцад шинээр илрэх ашигт малтмалын илрэл, цэгүүдийн хэтийн төлвийг үнэлэх

- Судалгааны талбайн хэмжээнд тогтоогдсон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсжсэн цэгүүдийн талбай болон биетийн хэмжээ, байрлал, хүдрийн болон дагалдагч эрдсийн найрлага, бүрэлдэхүүн, хүдэржилт, тэдгээрийн хувирлын төрөл, түүний хэмжээ, онцлогийг нарийвчлан судалж, дагалдах дээжлэлт, сорьцлолт хийх, холбогдох шинжилгээг бүрэн хийлгэх,
- Ашигт малтмалын илрэл, эрдэсжсэн цэгийг судлахын хамт талбайд тархсан хурдас, чулуулгийг эрдсийн түүхий эд болох талаас нь судлах,
- Ирээдүйн бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн бодлоготой уялдуулан зам, барилгын материалын түүхий эдийн судалгааг хийж, баялгийг үнэлнэ.

Д. Суурин боловсруулалт.

4.8. Завсрын суурин боловсруулалтаар:

- Хээрийн судалгааны явцад бүрдүүлсэн анхдагч баримт материалыг нэгтгэн боловсруулж, түүний үр дүнгээр баримт бүрдэл, геологи, шлих, геохимийн болон бусад холбогдох зургуудыг зохиох, бүх төрлийн дээж, сорьцын баримтжуулалтыг бүрдүүлэх, лабораторийн үр дүнгүүдийг зурагт буулгах, шаардлагатай тооцоолол, боловсруулалт хийж, дараагийн шатны ажлын төлөвлөлтөд ашиглах нөхцөл бүрдүүлэх,
- Хээрийн судалгаагаар шийдэж чадаагүй геологийн бүх асуудлыг шийдвэрлэх буюу дараагийн үе шатны ажлын үед шийдвэрлэх арга замыг сонгох, тодорхойлох, төлөвлөх,
- Төслийн хээрийн судалгаагаар талбайн тодорхой хэсэгт үүссэн зарчмын зөрүүтэй болон тодорхойгүй асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд дараагийн талбайд хээрийн ажлыг үргэлжлүүлэхийг хориглох,
- Судалгааны ажлын үр дүнд шаардлага хангасан мэдээлэлтэй болоогүй тохиолдолд түүнд дүн шинжилгээ хийж, тухайн асуудлыг шуурхай шийдвэрлэх арга замыг тодорхойлон шийдвэрлэх, ингэж чадаагүй тохиолдолд судалгааны арга аргачлалыг өөрчлүүлэх хүртэл саналыг тухайн үед нь захиалагчид хандаж, шуурхай шийдвэрлүүлнэ.

4.9.Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтаар:

- Мөрдөж буй заавар, шаардлагыг бүрэн хангасан анхдагч баримт, геологи, ашигт малтмал ба ашигт малтмалын тархалтын зүй тогтол, ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ, шлих болон литогеохимийн сорьцлолт, түүний үр дүнгийн зургуудыг 1:50 000-ны масштабтаар, тектоник, геоморфологи, гидрогеологи, геоэкологийн зургуудыг 1:100 000-200 000-ны масштабтаар, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий илрэл, эрлийн талбайн зургийг 1:1 000 - 25 000-ны масштабтаар тус тус зохиож, бусад төрөлжсөн зураг, бүдүүвч, график, хүснэгтийг хавсралтаар үйлдэх, зургууд нь ҮГА-ны Геомэдээллийн төвийн зурагт тавих шаардлагыг хангасан байх,
- Тухайн талбайн геологийн хөгжлийн түүхийг сэргээн босгохдоо О. Төмөртоогогийн тектоник-бүсчлэлийн, Г.Бадарчийн тектоно-стратиграфийн террейний болон Ж.Бямбын геодинамикийн ангиллаар төслийн талбай нь структур-тектоникийн ямар нэгжүүдэд хамаарч байгааг жишиж харьцуулж, дүгнэлт өгөх,
- Талбайн геологийн тогтоц, ашигт малтмалын гарал үүсэл, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, металлогений нөхцөлийг геодинамикийн хөгжилтэй уялдуулан дүгнэх,
- Төслийн талбайн ашигт малтмалын судалгааны үр дүнгээр хүдрийн талбай, потенциал талбайнуудыг шинээр ялгах,
- Талбайн хэмжээнд тогтоогдсон хэтийн төлөв бүхий ашигт малтмалын илрэлийн баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх,
- Төслийн ажлын үр дүнгээр төслийн талбайн хэтийн төлвийг А,Б,В,Г зэргээр үнэлэн цаашид хийх судалгааны ажлын чиглэлийг тодорхойлж, дараагийн шатанд нарийвчлан судлах талбайг ялган, дүгнэлт, зөвлөмж өгөх.
- Гидрогеологи, геоморфологи, геоэкологийн бүлгүүдийг өмнөх судалгааны ажил болон өөрсдийн ажлын үр дүнтэй уялдуулан тайлбарлах, дүгнэлт, зөвлөмж өгөх,
- Тайлангийн зургийг ArcGis программаар, бичвэрийг Times New Roman фондоор үйлдэх,
- Геофизикийн судалгааны ажлын үр дүнгээр зохиох ижил утгын зураг болон графикийг 1:25 000 -1 000-ны масштабтаар Geosoft Oasis Montaj программаар боловсруулах,
- Тухайн судалгааны ажлаар болон өмнөх судалгаагаар хуримтлагдсан геологи, геофизик, геохимийн зэрэг холбогдох бусад материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийснээр судалгааны талбайн ерөнхий мэдээлэл, ажлын арга, аргачлал болон геологийн тогтоц, ашигт малтмал, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, гидрогеологи, геоморфологи, геоэкологи зэргийг тусгасан тайлангийн зураг, бичвэрийг зохиож, Монголын стратиграфийн комисс болон хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гаргуулан, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Захиалагчийн шийдвэрийг гаргуулна.

5. Ажил гүйцэтгэх хугацаа:

5.1. Төсөл, төсөв зохион батлуулах:

Эхний жилд: - Шууд гэрээгээр.

5.2. Хээрийн ажил:

Эхний жилд:	2026 оны 8-р сараас 10-р сарыг дуустал
Хоёр дахь жилд:	2027 оны 5-р сараас 10-р сарыг дуустал
Гурав дахь жилд:	2028 оны 5-р сараас 10-р сарыг дуустал.

5.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт:	2026 оны 11-12-р сар дуустал
	2027 оны 1-4-р сар, 11-12-р сар.
	2028 оны 1-4-р сар дуустал

Эцсийн суурин боловсруулалт: 2028 оны 11-р сараас 2029 оны 10 сар дуустал.

5.4. Үр дүнгийн тайланг МСК-оор хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсны дараа хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэн холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийж, геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албажуулан ирүүлэх:

2029 оны 11-р сарын 30.

5.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжээр хянуулж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт, засварыг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр албажуулан хүргүүлэх:

2029 оны 12-р сарын 30.

5.6. Тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох дүгнэлт, түүнд үндэслэн эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулсны дараа Геологийн мэдээллийн төв архивд тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны
дараа ажлын 5 өдөрт

МОНГОЛ УЛС

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

БАТЛАВ: АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ДАШПҮРЭВ

2026 оны 03 сарын 06-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2026/ 04

**ХЭЦҮҮ УУЛ-50 ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50 000-НЫ
МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖЛЫН
ГЕОЛОГИЙН ДААЛГАВАР**

Судалгааны үе шат: 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрэл

Ашигт малтмалын төрөл: Бүх төрлийн ашигт малтмал

Судалгааны талбайн нэр: Хэцүү уул

Судалгааны талбайн байршил: Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг

Судалгааны талбайн хэмжээ: 3012.83 кв.км

Координат:

№	гр	мн	сс	гр	мн	сс
1	105	45	00	43	20	00
2	106	15	00	43	20	00
3	106	15	00	43	10	00
4	106	30	00	43	10	00
5	106	30	00	42	50	00
6	105	45	00	42	50	00

Хавтгай: К-48- 32-Б,Г
К-48-33-А,В,Г
К-48-44-Б
К-48-45-А,Б

Код: ХэУ-50

1. Геологийн даалгавар боловсруулах хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24 дэх хэсэг, “Ашигт малтмалын тухай” хуулийн 16 дугаар зүйл, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2, УИХурлын 2025 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Алт-3” аян, УИХурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ийн 3.5.2, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төсөл, төлөвлөгөө”.

2. Судалгааны ажлын үндэслэл:

Судлагдсан тувшин:

Тайлангийн дугаар	Тайлангийн нэр	Гүйцэтгэсэн он
4762	Уудам талын районд хийсэн хайгуулын ажлын тайлан	1994
2648	Өмнөговийн зэсийн хүдрийн районд хийсэн эрэл-үнэлгээ, шалгалтын ажлын тайлан	1978
2724	Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн нутагт хийсэн 1:200000-ны масштабын геологийн зураглалын тайлан /L-48-XXVIII, XIX-ийн хагас, L-48-XXXIV, XXXV, K-48-III-ын хагас, K-48-IV,V,VI, K-49-I-ийн хагас/ (Контракт №55-034/07000)	1978
4877	Галбын говийн талбай 1987-1989 онд K-48-VI, IX-XII, XV-XXVIII, XXI, XXII, K-49-I, VII, XIII хавтгайд хийсэн 1:200000-ны масштабын геологийн цогцолбор судалгааны тайлан	1996
5307	Өмнөговь аймгийн Ноён, Баяндалай, Хүрмэн, Ханхонгор, Номгон, Баян-Овоо сумдын нутагт 1996-98 онд Зурамтайн ангийн хийсэн 1:200000-ны масштабын геологийн бүлэгчилсэн зураглалын ажлын үр дүнгийн тайлан. Байршил: K-48-VII, VIII, IX, X, XIII, XVI, XVII, XVIII, XXI	2000
5861	Өмнөд Монгол УГЗ-200 төслийн 2005-2007 онд Дорноговь Өмнөговь аймгуудын нутагт зохиосон 1:200000-ны масштабын улсын геологийн иж бүрдэл зураг (K-49-IV, VII, VIII, IX, XIII, XIV, XV K-48-X, XI, XII, XVI, XVII, XVIII, XXII)	2008
6326	Өмнөговь, Дорноговь аймгуудын зарим нутгийг хамарсан K-48-III, IV, V, VI, VIII, IX, XIII, XIV, XV, XX, XXI хавтгайд 1:200000-ны масштабын “Улсын геологийн зураг зохиох” төслийн 2007-2010 оны ажлын үр дүнгийн тайлан.	2011

5163	Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо сумдын нутгийг хамарсан Хацавчийн талбайд 1996-1998 онд явуулсан 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил: К-48-34-В,Г, 45-В,Г, 46-А,В, 57-А-а /хил залгаа/	1998
11125	Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо, Цогтцэций сумдын нутагт орших Ямаат уул-50 талбайд 2021-2024 онд гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Код: ЯмУ-50 Хавтгай К-48-19-В,Г, К-48-20-В, К-48-31-А,Б,В,Г, К-48-32-А,В, К-48-43-А,Б, К-48-44-А /хил залгаа/	2024
4028	Зүүн өмнөт Монголд хийсэн 1:500000-ны масштабын гидрогеологийн зураглалын тайлан (L-48БГ, L-49АВ, К-48БГ, К-49АБ).	1986
4545	Монгол улсын зүүн өмнөд хэсгийн гидрогеологийн зураг 1:500000-ны масштабтай. L-49-АБВГ, L-50-АБВ, К-48-БГ, К-49-АБ.	1989
2929	Баян-Овоогийн хотгорт хийсэн газар доорх усны эрэл, хайгуулын тайлан	1979
4107	Таван толгойн үйлдвэрийн районы Зайрмагтайн хэсэгт хийсэн газар доорх усны урьдчилсан ба нарийвчилсан хайгуулын тайлан	1987
7670	Өмнөговь аймаг Манлай, Ханбогд, Дорноговь аймаг Мандах сумын зарим нутгийг хамарсан Өмнөд говийн талбайд 2012-2014 онд гүйцэтгэсэн 1:200000-ны масштабын гидрогеологи, геоэкологийн үнэлгээний тайлан. /К-48-III. IV. V. VI. IX. X. XI. XII. XV. XVI. XVII. X	2015
1762	Зүүн Монголд хийсэн 1:200000-ны масштабын агаарын соронзон зураглалын тайлан /Контракт №1495/	1968
3375	Өмнөговь аймгийн хотгор Цэцэй уулын бэлд хийсэн геофизикийн эрлийн тайлан	1982
4515	1987-88 онд явуулсан геофизикийн сэдэвчилсэн судалгааны үр дүнгийн тайлан	1989
4547	Баянхонгор, Өмнөговь аймгуудын нутагт хийсэн 1:200000-ны масштабын агаарын соронзон зураглалын тайлан	1991

Геологийн тогтоо: Өмнөд Монголын атриат мужийн Говийн атриат мега бүсэд хамаарна. Төслийн талбайд дээд девон-карбоны миссисип серийн Алаг баян формац, карбоны миссисип серийн Сайншанд худаг формац, Цохиот формац, пермийн сизурал серийн Тогоотхар формац, гваделуп серийн Дэлийншандхудаг формац, лопин серийн Ямаанусныбулаг формац, доод триасын ангилагдаагүй хурдас, дээд цэрдийн Баянширээ, олигоцен-миоцены ангилагдаагүй хурдас зураглагдсан байна.

Ашигт малтмал: Төслийн талбай нь Оюутолгой-Цагаансуваргын минерагений бүсийн Оюутолгойн хүдрийн дүүргийн Оюутолгойн хүдрийн зангилаа, Алагтолгойн хүдрийн зангилаа, Зараа-Цохиотын хүдрийн потенциал дүүргийн Зараагийн хүдрийн потенциал зангилаа, Номгоны хүдрийн потенциал дүүрэг, Цант уул-Луус худгийн нүүрст сав газрын зарим хэсгүүдийг хамрана. Талбайд өмнөх судалгаагаар Чулуун нүүрс-6, Барилгын чулуу-1 орд, Зэс-2 илрэл тогтоогдсон.

Оюутолгойн хүдрийн дүүрэгт 2 насны зэсийн хүдэржилт тогтоогдсон. Хэцүү уул-50 төслийн талбайн хөрш зэргэлдээ талбайд Оюутолгойн болон Алагтолгойн хүдрийн зангилааны хожуу девоны вулканоген хурдсыг зүссэн хожуу девоны кварцат монцониттой холбоотой порфирын зэс-алт-молибдены Оюутолгойн бүлэг ордууд, мөн Хатавчийн порфирын зэс-алт-молибдены орд оршино. Карбоны гранитоид интрузивтэй холбоотой гидротермаль зэс, зэс-алтны олон тооны илрэл, эрдэсэжсэн цэгүүд ч тогтоогдсон байдаг.

Оюутолгойн хүдрийн дүүргийн холжуу девоны кварцат монцониттой холбоотой порфирын хүдэржилт нь хэтийн төлөв өндөртэй, ордууд үүсгэсэн бөгөөд газрын гадаргад ховроор /Оюутолгойн орд, Хатавчийн орд/, голчлон гүнд, далд /Херуга, Өмнөд Хюго Даммет, Хойд Хюго Даммет, түүний хойд үргэлжлэл, Улаан худын ордууд/ оршдог бөгөөд гүний өрөмдлөг, геофизикийн хайгуулаар илэрсэн байдаг.

Оюутолгой төрлийн порфирын зэс-алт-молибдены хүдэржилтийн эрлийн шинж тэмдэг нь агуулагч болох карбоноос өмнө үүссэн хурдас чулуулаг, тухайлбал дээд девон, дунд девон, түүнээс хөгшин хурдсууд бөгөөд хүдэржилтийг дагуулагч нь хожуу девоны кварцат монцонитын интрузив биетүүд болдог онцлогтой.

Хожуу карбоны Могойт бүрдлийн гранитоидтой холбоотой олон тооны алт-зэс, зэс, зэс-молибден, молибден, алтны илрэл, эрдэсэжсэн цэгүүд нь хэмжээ жижигтэй бөгөөд гранитоид дотор болон түүнийг агуулагч миссисипийн Сайншандхудаг, миссисипи-пенсильваны Мөрөгцөг, пенсильваны вулканоген-тунамал хурдас дотор агуулагдсан нь Хэцүү уул-50 талбайн зэргэлдээ зүүн талд Н.Банзрагч, А.Батхүү /1998, 5163ф/ нарын гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай ГЗЕЭА-аар илэрсэн байна.

Цант уул-Лууст худгийн нүүрст савд миссисипийн Мөрөгцөг формац, пенсильваны вулканоген-тунамал хурдас, цэрд болон кайнозойн хурдсаар хучигдан орших пермийн гвадалупын Дэлийн шанд формацын хурдсыг нүүрсний хуримтлалтай гэж судлаачид үздэг.

Оюутолгойн ордын талбайд миссисипийн Сайншандхудаг формацын вулканоген-тунамал хурдсыг бүрэн огтолж өрөмдсөн цооногт харьцангуй чанар муутай нүүрсний үе илэрсэн байна.

Э.Бүрэнхүү, А.Готовсүрэн /1996, 4877ф/ нарын гүйцэтгэсэн 1:200000-ны масштабын ГЗЕЭА-аар алт агуулсан зэсийн судлын төрлийн 2 илрэл тогтоогдсон ба хэтийн төлөв нь тодорхойгүй байдаг.

Эдийн засгийн хувьд: Төслийн талбай нь говь, цөлийн мужид багтах бөгөөд дунджаар д.т.д. 1300-1600 м өндөрт оршино. Байгаль цаг уурын хувьд эрс тэс эх газрын уур амьсгалтай, дулааны улиралд халуун нь 30-39 градус, -20 градус хүртэл хүйтэрдэг. Салхины

хурд 5-15 м/сек, заримдаа 34-45 м/сек хүрд. Тус бүс нутаг нүүрс, зэс, алтны том ордуудтай. 2024 оны байдлаар Өмнөговь аймгийн нийт ДНБ нь 4,8 их наяд төгрөг (1.42 тэрбум ам.доллар) хүрсэн бөгөөд энэ нь Монгол Улсын хэмжээнд хамгийн өндөр ДНБ-тэй аймагт тооцогддог, эдийн засгийн хувьд эрчимтэй хөгжиж бүс нутагт хамрагдана.

Төслийн үндсэн зорилго нь:

- Судалгааны талбайд тархсан тунамал, вулканоген, интрузив, метаморф чулуулаг, тэдгээрийн эвшлээс бүрдэх хурдас, чулуулгийг судлан Монголын литостратиграфын кодексийн дагуу зохих нэгжүүдэд ангилан ялгаж, зураглах, тектоник структурийн төрлүүдийг тодорхойлж, геодинамик нөхцөлийг тогтоох.

- Судалгааны талбайд ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэн эрлийн шинж тэмдэг, шалгуурыг тогтоож, ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтлыг тодорхойлон хэтийн төлөв бүхий хэсгүүдийг ялган эрлийн ажлыг гүйцэтгэн судалсны үндсэн дээр минерагений нэгжүүдийг (бүс, дүүрэг, зангилаа, талбай г.м) ялган, тэдгээрийн хэтийн төлөвийг тодорхойлон, эрдэс баялгийн үнэлгээг өгч, цаашдын судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох. Хэтийн төлөв бүхий илрэлүүдэд баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх.

- Судалгааны ажлын үр дүнд тулгуурлан гидрогеологи, геоморфологи, геоэкологийн судалгааг хийж, холбогдох зургуудыг даалгаварт заасан масштабаар зохиох, байгаль орчин дахь нөлөөллийг урьдчилан үнэлэх, уул уурхайн салбарын хөгжлийн суурь мэдээллийг бэлтгэнэ.

Зураглалын ажлыг геологийн тогтоц, нэвтрэлтийн зэрэг, хучаас хурдасны тархалт, гаршийн онцлогтой уялдуулан гүйцэтгэх бөгөөд геологийн нийлмэл тогтоц, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд торыг нягтруулан зохих шаардлага (Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:50,000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийх заавар, тавих шаардлага, 2010)-ыг хатуу мөрдөнө.

Хэцүү уул-50 төслийн талбайн хэмжээнд гүйцэтгэх геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг мөрдөж ирсэн заавар, шаардлагын дагуу гүйцэтгэн геологи, ашигт малтмалын болон холбогдох бусад зургуудыг зохиох, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийн үнэлгээг өгч, тэдгээрийн тайлбар бичгийг зохиож, анхдагч материалын сан бүрдүүлнэ.

3. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх үндсэн арга аргачлал ба дэс дараалал:

А.Бэлтгэл ажлын үе

4.1. Судалгааны ажлын төсөл, төсөв, календарьчилсан төлөвлөгөө зохионо.

4.2. Талбайн хэмжээнд өмнө нь хийсэн геологийн үе шатны судалгаа болон сэдэвчилсэн судалгааны материалуудыг бүрэн судлан танилцаж дүн шинжилгээ хийх, түүний үндсэн дээр тухайн талбайд тохирсон судалгааны арга аргачлалыг сонгоно. Үүнд:

- Өмнөх шатны судалгааны бүх төрлийн ажлын үр дүнг багтаасан мэдээллийн сан үүсгэх, мэдээллийг боловсруулан үнэлэлт, дүгнэлт өгч, өөрсдийн судалгааны ажлын суурийг бэлтгэх, арга аргачлал боловсруулах, баримтын зургийг зохиож бүртгэл үйлдэх,
- Өмнөх судалгааны материалд үндэслэн тухайн дүүргийн онцлогт тохирсон талбайн сорьцлолтын аргыг сонгож, тоо хэмжээг тооцох,
- Төслийн талбайн хэмжээнд мэдэгдэж байгаа ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, шлих, литогеохимийн сарнилын хүрээ, гажлуудыг бүртгэж, тэдгээрт дүн шинжилгээ хийх, хэтийн төлөвийн урьдчилсан зураг зохиох,
- Төслийн талбайн 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын шаардлага хангасан, өндөр нарийвчлалын агаар, сансрын болон 1:25 000, 1 :50 000-ны масштабтай байрзүйн зургуудыг холбогдох мэргэжлийн байгууллагаар бэлдүүлэх,

АСЗ-т геологийн тайлал хийх, тухайн талбай хамрагдсан геофизикийн судалгааны (хүндийн хүчний, соронзон зураглал гэх мэт) материалуудтай танилцан, урьдчилсан тайлал, боловсруулалт хийх,

- Өмнөх шатны судалгааны материалууд болон АСЗ-т хийсэн урьдчилсан тайллыг ашиглан төслийн геологийн болон бусад холбогдох зургийг 1:50 000-ны масштабээр зохиож, нэгдсэн таних тэмдэг зохиох,
- Хээрийн ажилд гарахын өмнө талбайн стратиграфи, магматизм, тектоникийн мэдээлэл, урьдчилсан тайлал хийсэн зургийн хүрээнд танилцах маршрут төлөвлөх, уг асуудлаар Монголын стратиграфийн комиссоос зөвлөгөө авч, хамтран ажиллах,
- Дээрх материалууд дээр үндэслэн цаашдын судалгааны ажлыг төлөвлөсөн байх,
- Хилийн болон тал, хээрийн бүсэд ажиллахтай холбоотой хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны бэлтгэлийг хангана.

4.3. Машин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон ажиллагсдын хөдөлмөр-ахуйн нөхцөлийг хангасан хээрийн судалгааны өмнөх бэлтгэлийг бүрэн хангана.

4.4. Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрөл (орон нутаг, хилийн бүс, тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах гэх мэт), бичиг баримтыг бүрдүүлнэ.

4.5. Хээрийн судалгааны шатанд зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгэх гэрээ, геологийн даалгавар, ажлын төсөл, төсөв болон холбогдох журам, зааврыг бүрдүүлэн бэлтгэнэ.

Б. Хээрийн ажлын үе:

4.6. Ажил эхлэхээс өмнө жил бүрийн хээрийн судалгааны ажлыг хэрхэн ямар хугацаанд гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөө (ажлын хөтөлбөр) зохиосон байна.

4.7. Судалгаанд хамрагдах талбайн хэмжээнд юуны түрүүнд танилцах маршрутыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Талбайд тархсан хурдас, чулуулаг, гүний биетүүдийн тогтоц, голлох бүрдүүлэгч чулуулгийн найрлага, тогтоц, онцлог, тэдгээрийн харьцаа, хил зааг, томоохон хувирал, өөрчлөлтийн бүсүүд, тасралтад эвдрэлүүд, органик үлдэгдэл тогтоогдсон цэгүүд, өмнөх судалгаануудаар тогтоосон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, бүх төрлийн гажлуудтай танилцаж, дүгнэлт гаргах, эдгээр геологийн биетүүдээс эталон дээж бүрдүүлэх, шаардлагатай бол урьдчилан дээжилж, сорьцлох,
- Талбайн сорьцлолтын урьдчилан боловсруулсан арга, аргачлалыг бодит байдал, орчин нөхцөл, ландшафтын онцлог, орчин үеийн хурдасны тархалт, гарал үүсэл, бүс нутгийн уур амьсгал зэрэгтэй уялдуулан нягталж, шаардлагатай бол туршилт аргачлалын сорьцлолт хийх, сорьцын тоог хучаас хурдсаар дарагдаагүй үндсэн чулуулгийн гарш бүхий нийт талбайд 1 кв.км-т >1 сорьц ноогдохоор тооцож, төлөвлөх,
- Маршрутын судалгаа, талбайн сорьцлолт эхэлж явуулах талбайг сонгох,
- Дээрх ажлуудыг гүйцэтгэхэд төслийн инженер техникийн ажилчид (ИТА), зөвлөхүүд бүгд оролцож, нэгдсэн дүгнэлт өгөх,
- Танилцах маршрутын үр дүнд тулгуурлан ажлын арга, аргачлалыг хянаж, шаардлагатай тохиолдолд заавар, шаардлагад нийцүүлэн зохих өөрчлөлтийг оруулан, хээрийн ажлын төлөвлөгөөг нарийвчилна.

В. Геологийн зураглалаар:

Геологийн зураглалын ажлыг ≤ 500 м-ийн торын нягтралтайгаар, чанарын шаардлага хангасан маршрутын судалгаагаар гүйцэтгэх бөгөөд доорх ажлуудыг хийж, асуудлыг шийднэ. Үүнд:

- АСЗ-ийг өргөн ашиглах, түүний тайллын үр дүнг газар дээр нь баталгаажуулан шалгаж, байнга засварлаж, нарийвчлал хийх,
- Урьдчилан зохиосон ажлын зурагт үнэлэлт дүгнэлт өгөх, шалган холбох маршрутыг шат дараатай явуулах,
- Төслийн талбайн хэмжээнд тархсан бүх төрлийн магмын болон хувирмал, тунамал, вулканоген хурдас, чулуулгийн тогтоц, найрлага, тархалт, хоорондын харьцаа, ялгааг тогтоох, литологи, структурыг нарийвчлан судалж төрөлжүүлэн зураглах, насны үндэслэлийг харьцуулалтын, палеонтологийн ба үнэмлэхүй насны шинжилгээгээр баталгаажуулах, тулгуур зүсэлтүүдийг хийх, нас, геохими, петрохимийн онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн дээж, сорьцыг арга, аргачлалын дагуу авах, шинжилгээ хийлгэх, боловсруулах ба урьдчилсан байдлаар ажлын геологийн зураг зохиож, тайлбар бичиглэл хийх, анхдагч баримт материалыг зааврын дагуу бүрдүүлэх,
- Хурдас чулуулгийн хил зааг, хоорондын харьцааг тогтоох, тэдгээрийн литологи, структурыг нарийвчлан зураглаж, формац, мэмбэр, бэд болон бүрдэл, фаз, фацийн түвшинд ялгах, шаардлагатай төрлийн сорьцлолтыг хийх, ингэхдээ дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байх. Үүнд:

1.Өмнөд Монголын атриат мужийн Говийн атриат мегабүсийн Гурвансайханы бүс болон Өмнөд говийн массивын Говийн тэнгэр уулын блокийн хил заагийг тодруулах.

2.Дунд девоны Булагбаян формац нь хожуу девон-түрүү карбоны настай Алагбаян формацын нэг мэмбэр мөн эсэхийг тодруулах.

3.Карбоны миссисип серийн Мөрөгцөг формац байгаа эсэхийг тодруулах.

4.Карбоны хурдсанд ургамлын үлдэгдэл илрүүлэх.

5.Цэрдийн хурдсанд микрофауны үлдэгдэл илрүүлэх.

6.Девон, Карбоны гранитоид дээр нас тогтоох, яагаад девоны гранитоид шүлтлэг, карбон нь ердийн найрлагатай байгааг тайлбарлах.

7.Төслийн талбайд үнэмлэхүй насны судалгаа хийгдсэн Могойт бүрдлээс геохими, гарал үүслийн хувьд хэрхэн ялгагдах, Багахачиг бүрдэлийг дахин ялгах эсэх, агуулагч хурдас нь дунд девоны Булагбаян формац, эсхүл хожуу девон-түрүү карбоны Алагбаян формацын аль нь болохыг тодруулах.

- Төслийн талбайн литостратиграфийн ангиллыг “Монголын литостратиграфийн кодекс”-ийн дагуу шинэчлэн, ангилсан хурдаснуудыг хроно ба региональ стратиграфийн номенклатуртай харьцуулах, литостратиграфийн нэгжийн бичиглэлийг кодексийн дагуу үйлдэх,
- Төслийн талбайд гүний чулуулаг, дэл судлын биетүүдийн гарал үүсэл, ангилал, бүрдлийн фаз, фацийг тодруулах, петрохими, геохими, петрографийн ба металлогений онцлогийг тодорхойлох, биетүүдийн нарийвчилсан бичиглэлийг хийх, бүрдэл, дэл судлын чулуулгийн геохими онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн сорьцыг арга, аргачлалын дагуу авч, шинжилгээ хийлгэн, үр дүнг боловсруулах,
- Шаардлагатай тохиолдолд чулуулгийн үнэмлэхүй насыг тодорхойлуулах (тухайн гүний болон вулканоген, тунамал чулуулгийн онцлог, найрлага, гарал үүсэл, бусад онцлогийг бүрэн тодорхойлж, фаз, фацийн түвшинд зурагласан тохиолдолд энэ аргыг хэрэглэнэ),
- Талбайн сорьцлолтоор авсан литогеохимийн бүх сорьцод тоон шинжилгээ (ICP-MS) хийлгэж, үр дүнг боловсруулах,
- Орчин үеийн болон сэвсгэр хурдсыг гарал үүсэл, насаар нь нарийвчлан ангилж баталгаажуулах, тэдгээрийн зузаан, литологийн бүрэлдэхүүн, бусад шинжийг тодорхойлох,

- Төслийн талбайтай хил залгаа болон ойр хийгдсэн 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлуудын үр дүнтэй уялдуулах, харьцуулж шалгах,
- Талбайн тектоник-структурын бүтцийг нарийвчлан ангилж, тэдгээрийг бүрдүүлэгч хурдаснуудын формацын хамаарлыг тогтоон, нарийвчилсан бичиглэл хийх, тектоник-структурыг ашигт малтмалын тархалтын онцлогтой уялдуулан тайлбарлах,
- Геоморфологийн ажиглалт хийж, гадаргуугийн гарал үүсэл, хэлбэр дүрсийн төрлүүдээр ангилах, рельефийн хөгжлийн онцлог, үүссэн дарааллыг судалж зураглах, тайлах, ашигт малтмалын шороон хуримтлал үүсэх боломжтой нөхцөл бүрдсэн геоморфологийн элементүүдийг судалж тогтоох, морфоструктурын анализ хийх,
- Гидрогеологийн судалгаагаар тухайн талбайд байгаа худаг, булаг, шандыг координатжуулан, усны ундарга, түвшин бууралтыг хээрийн ажиглалтаар тогтоож, тухайн талбайн уст бүрдлийг төлөөлж чадахуйц уст цэгүүдээс гидрохимийн сорьц авч, шинжлүүлэх, уст бүрдлүүдийн онцлогийг тодруулах, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа хийх,
- Геоэкологийн судалгаагаар тухайн талбайд байгаа үржил шимт өнгөн хөрсний үеэс төрөлжилтийн сорьцлолтыг холбогдох аргачлалын дагуу хийж химийн шинжилгээнд хамруулах, тоон үзүүлэлтийг тодруулах, өмнөх байгаль орчны чиглэлээр хийгдсэн судалгааны материалуудыг ашиглах, өөрсдийн судалгааны ажлаар тухайн талбай дахь геологийн ховор тогтоц (гео-өв), улаан номд орсон амьтан, ургамал, түүхийн дурсгалт зүйлсийн байршлыг координатжуулах, геоэкологийн зураг, экологи-геологийн суурь үнэлгээний зурагт тусгах зорилгоор судалгааны ажиглалтыг зураглалын маршрутын явцад хамт хийх, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа явуулах,
- Төслийн талбайн хэмжээнд шугаман тогтоцтой дислокацид автсан чулуулгийн эрдэслэг бүрэлдэхүүн, үнэмлэхүй нас, стрүктүрийг нарийвчлан зураглах. Үүнд:
 - S0, S1, S2..., Sn хавтгай элементүүд (фолэйшн), Sn+1 тэнхлэг хавтгайг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
 - B1, B2..., Bn атирааны нугаснуудыг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
 - L1, L2..., Ln линэйшнүүдийг төрөлжүүлэн (mineral, stretching, intersection) тодорхойлж зураглах, хэмжилт хийнэ.

Г. Эрлийн ажлаар:

Өмнө хийгдсэн төрөл бүрийн геологи, геохими, геофизикийн зэрэг судалгааны ажлын материал үр дүнг бүрэн гүйцэт ашиглах, хил залгаа улсын материалтай сайтар танилцан, цугласан материалд боловсруулалт, дүн шинжилгээ хийн, төслийн талбайн хэмжээнд тогтоогдсон эрлийн шинж тэмдэг, шалгууруудын үндсэн дээр эрлийн ажлыг ашигт малтмалын төрлийг харгалзан, арга, аргачлалыг оновчтой, үр дүнтэй байхаар сонгон төлөвлөн гүйцэтгэх;

- Өмнөх судалгаануудаар илэрсэн орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүдийг хээрийн судалгааны эхний жилд шалган, үр дүнг баталгаажуулах, хяналтын сорьцлолт хийх, ялангуяа өмнөх судлаачдын гидротермаль-метасоматит хувирал харьцангуй хүчтэй илэрсэн гэж зураглаж тэмдэглэсэн талбайнуудад гүйцэтгэх зураглал-ерөнхий эрлийн маршрутын явцад ашигт малтмалын талаар онцгой анхаарал хандуулах,
- Маршрутын судалгааны үр дүнд тогтоогдсон хувирал, эрдэсэжсэн бүс, биетүүдээс ашигт малтмалын шалгуур, шинж тэмдэг тэдгээрийн тоон агуулгыг тогтоох зорилгоор авсан дээж, сорьцуудын үр дүнг нэгтгэн боловсруулсны үндсэн дээр дараагийн шатны ажлыг төлөвлөн, гүйцэтгэх,

- Талбайн шлих, литогеохимийн сорьцлолтын ажлыг 1 кв.км талбайд >1 сорьц ноогдох байдлаар зохих заавар, аргачлалын дагуу зураглалын ажлаас түрүүлүүлэн гүйцэтгэж, тогтоогдсон хэтийн төлөв бүхий сарнилын хүрээ, гажлуудын торыг нягтруулан шалгаж, үнэлгээ өгөх, өмнөх судлаачдын илрүүлсэн церусситын шлихийн хүрээ, хар тугалга, хар тугалга-цайр-зэсийн геохимийн хүрээнүүдийн хэтийн төлөвийг нарийвчлах,
- Өмнөх судалгаагаар илэрч, тухайн ажлын явцад баталгаажсан болон төслийн ажлын судалгааны үр дүнд шинээр тогтоогдсон ашигт малтмалын хүдэржилт бүхий хэсгүүдээс ашигт малтмалын төрөл, онцлог, хэтийн төлөвтэй нь уялдуулан нарийвчилсан эрэл хийх талбайнуудыг сонгох,
- Сонгосон талбайнуудад ашигт малтмалын төрөл, онцлогтой уялдуулан нарийвчилсан эрлийн ажлыг 1:5 000 - 25 000-ны масштабтаар, үе шаттайгаар, цогцолбороор гүйцэтгэх. Энэ ажлын хүрээнд дараах асуудлыг шалган шийдвэрлэх:

1. 1:50000-ны масштабын геологийн зураглалын маршрутын явцад ашигт малтмалын илрэл, эрдэсэжсэн цэг, гидротермаль-метасоматит хувирлын талбай, цэг, бүсүүдийг тэмдэглэн зохих сорьцолтууд хийх,

2. Төслийн талбайд Оюутолгойн төрлийн порфирын зэс-алт-молибдены хүдэржилтийн эрлийн шалгуур, шинж тэмдгүүдийг ашиглах, тухайлбал девон, түүнээс өмнөх насны хурдаснууд, девоны интрузивийг илрүүлэхэд онцгой анхаарах,

3. Төслийн талбайг бүрэн хамруулан 1:50000-ны масштабын ГЗЕЭА-ын масштабд тохирсон шлих, геохимийн урсгал сарнилын зураглал хийх, мөн зарим хэтийн төлөвтэй талбай, тухайлбал, Алагтолгойн хүдрийн зангилааны БХ хэсгийн девоны хурдас илэрсэн талбайд урсгал сарнилын зэрэгцээ талбайн геохимийн сорьцлолт хийх,

4. Алагтолгойн хүдрийн зангилааны БХ хэсэгт девоны хурдас илэрсэн байгаа бөгөөд уг хурдас дээд плейстоцен-голоцены болон доод дөрөвдөгчийн делюви-пролювийн хурдас, олигоцен-плиоцены хурдсаар хучигдан зүүн, ЗХ чигт уг хүдрийн зангилааны хойд, ЗХ хил хүртэл үргэлжлэх магадлалтай тул хучаас хурдсуудын зузааныг тодорхойлох, ул хурдасны бүтэц тогтцыг тодруулахын тулд зохих геофизикийн судалгааг хийх,

5. Э.Бүрэнхүү, А.Готовсүрэн /1996, 4877ф/ нарын илрүүлсэн алт агуулсан зэсийн судлын төрлийн 2 илрэлийг судлан хэтийн төлвийг үнэлэх,

6. Өмнөх судлаачдын гүйцэтгэсэн агаарын геофизикийн судалгааны үр дүнг эрлийн ажилд бүтээлчээр ашиглах, геофизикийн гажил, гажигийг шалгах,

7. Хэцүү уул-50 төслийн талбайтай хил залгаа Ямаат уул-50, Цогтцөций-50, Борзонгийн говь-50, Хацавчийн талбай-50 /1998, 5163ф/ ажлуудын тайлан материалтай нарийвчлан танилцаж хэтийн төлөвтэй гэж үзсэн илрэл, талбайнуудад тогтоогдсон эрлийн шалгуур, шинж тэмдгүүдийг ашиглах.

- Судалгааны талбайн хэмжээнд тогтоогдсон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүдийн талбай болон биетийн хэмжээ, байрлал, хүдрийн болон дагалдагч эрдсийн найрлага, бүрэлдэхүүн, хүдэржилт, тэдгээрийн хувирлын төрөл, түүний хэмжээ, онцлогийг нарийвчлан судалж, дагалдах дээжлэлт, сорьцлолт хийх, холбогдох шинжилгээг бүрэн хийлгэх,
- Ашигт малтмалын илрэл, эрдэсэжсэн цэгийг судлахын хамт талбайд тархсан хурдас, чулуулгийг эрдсийн түүхий эд болох талаас нь судлах,
- Ирээдүйн бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн бодлоготой уялдуулан зам, барилгын материалын түүхий эдийн судалгааг хийж, баялгийг үнэлнэ.

Д. Суурин боловсруулалт.

4.8. Завсрын суурин боловсруулалтаар:

- Хээрийн судалгааны явцад бүрдүүлсэн анхдагч баримт материалыг нэгтгэн боловсруулж, түүний үр дүнгээр баримт бүрдэл, геологи, шлих, геохимийн болон

бусад холбогдох зургуудыг зохиох, бүх төрлийн дээж, сорьцын баримтжуулалтыг бүрдүүлэх, лабораторийн үр дүнгүүдийг зурагт буулгах, шаардлагатай тооцоолол, боловсруулалт хийж, дараагийн шатны ажлын төлөвлөлтөд ашиглах нөхцөл бүрдүүлэх,

- Хээрийн судалгаагаар шийдэж чадаагүй геологийн бүх асуудлыг шийдвэрлэх буюу дараагийн үе шатны ажлын үед шийдвэрлэх арга замыг сонгох, тодорхойлох, төлөвлөх,
- Төслийн хээрийн судалгаагаар талбайн тодорхой хэсэгт үүссэн зарчмын зөрүүтэй болон тодорхойгүй асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд дараагийн талбайд хээрийн ажлыг үргэлжлүүлэхийг хориглох,
- Судалгааны ажлын үр дүнд шаардлага хангасан мэдээлэлтэй болоогүй тохиолдолд түүнд дүн шинжилгээ хийж, тухайн асуудлыг шуурхай шийдвэрлэх арга замыг тодорхойлон шийдвэрлэх, ингэж чадаагүй тохиолдолд судалгааны арга аргачлалыг өөрчлүүлэх хүртэл саналыг тухайн үед нь захиалагчид хандаж, шуурхай шийдвэрлүүлнэ.

3.9. Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтаар:

- Мөрдөж буй заавар, шаардлагыг бүрэн хангасан анхдагч баримт, геологи, ашигт малтмал ба ашигт малтмалын тархалтын зүй тогтол, ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ, шлих болон литогеохимийн сорьцлолт, түүний үр дүнгийн зургуудыг 1:50 000-ны масштабтаар, тектоник, геоморфологи, гидрогеологи, геоэкологийн зургуудыг 1:100 000-200 000-ны масштабтаар, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий илрэл, эрлийн талбайн зургийг 1:1 000 - 25 000-ны масштабтаар тус тус зохиож, бусад төрөлжсөн зураг, бүдүүвч, график, хүснэгтийг хавсралтаар үйлдэх, зургууд нь ҮГА-ны Геомэдээллийн төвийн зурагт тавих шаардлагыг хангасан байх,
- Тухайн талбайн геологийн хөгжлийн түүхийг сэргээн босгохдоо О. Төмөртоогогийн тектоник-бүсчлэлийн, Г.Бадарчийн тектоно-стратиграфийн террейний болон Ж.Бямбын геодинамикийн ангиллаар төслийн талбай нь структур-тектоникийн ямар нэгжүүдэд хамаарч байгааг жишиж харьцуулж, дүгнэлт өгөх,
- Талбайн геологийн тогтоц, ашигт малтмалын гарал үүсэл, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, металлогений нөхцөлийг геодинамикийн хөгжилтэй уялдуулан дүгнэх,
- Төслийн талбайн ашигт малтмалын судалгааны үр дүнгээр хүдрийн талбай, потенциал талбайнуудыг шинээр ялгах,
- Талбайн хэмжээнд тогтоогдсон хэтийн төлөв бүхий ашигт малтмалын илрэлийн баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх,
- Төслийн ажлын үр дүнгээр төслийн талбайн хэтийн төлвийг А,Б,В,Г зэргээр үнэлэн цаашид хийх судалгааны ажлын чиглэлийг тодорхойлж, дараагийн шатанд нарийвчлан судлах талбайг ялган, дүгнэлт, зөвлөмж өгөх.
- Гидрогеологи, геоморфологи, геоэкологийн бүлгүүдийг өмнөх судалгааны ажил болон өөрсдийн ажлын үр дүнтэй уялдуулан тайлбарлах, дүгнэлт, зөвлөмж өгөх,
- Тайлангийн зургийг ArcGis программаар, бичвэрийг Times New Roman фондоор үйлдэх,
- Геофизикийн судалгааны ажлын үр дүнгээр зохиох ижил утгын зураг болон графикийг 1:25 000 -1 000-ны масштабтаар Geosoft Oasis Montaj программаар боловсруулах,
- Тухайн судалгааны ажлаар болон өмнөх судалгаагаар хуримтлагдсан геологи, геофизик, геохимийн зэрэг холбогдох бусад материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийснээр судалгааны талбайн ерөнхий мэдээлэл, ажлын арга, аргачлал болон геологийн тогтоц, ашигт малтмал, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, гидрогеологи, геоморфологи, геоэкологи зэргийг тусгасан

тайлангийн зураг, бичвэрийг зохиож, Монголын стратиграфийн комисс болон хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гаргуулан, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Захиалагчийн шийдвэрийг гаргуулна.

1. Ажил гүйцэтгэх хугацаа:

5.1. Төсөл, төсөв зохион батлуулах:

Эхний жилд: - Шууд гэрээгээр.

5.2. Хээрийн ажил:

Эхний жилд:

2026 оны 8-р сараас 10-р сарыг дуустал

Хоёр дахь жилд:

2027 оны 5-р сараас 10-р сарыг дуустал

Гурав дахь жилд:

2028 оны 5-р сараас 10-р сарыг дуустал.

5.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт: 2026 оны 11-12-р сар дуустал

2027 оны 1-4-р сар, 11-12-р сар.

2028 оны 1-4-р сар дуустал

Эцсийн суурин боловсруулалт: 2028 оны 11-р сараас 2029 оны 10 сар дуустал.

5.4. Үр дүнгийн тайланг МСК-оор хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсны дараа хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэн холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийж, геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албажуулан ирүүлэх:

2029 оны 11-р сарын 30.

5.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжээр хянуулж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт, засварыг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр албажуулан хүргүүлэх:

2029 оны 12-р сарын 30.

5.6. Тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох дүгнэлт, түүнд үндэслэн эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулсны дараа Геологийн мэдээллийн төв архивд тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны дараа ажлын 5 өдөрт

МОНГОЛ УЛС

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

БАТЛАВ: АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА **Б.ДАШПҮРЭВ**

2026 оны 03-р сарын 26-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2026/02

**АЛТАН ШИРЭЭ УУЛ-50 ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50 000-НЫ
МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖЛЫН
ГЕОЛОГИЙН ДААЛГАВАР**

Судалгааны үе шат: *1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрэл*

Ашигт малтмалын төрөл: *Бүх төрлийн ашигт малтмал*

Судалгааны талбайн нэр: *Алтан ширээ уул*

Судалгааны талбайн байршил: *Дорноговь аймгийн Мандах, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдын нутаг*

Судалгааны талбайн хэмжээ: *3735.5 кв.км*

Координат:

№	гр	мн	сс	гр	мн	сс
1	109	00	00	44	00	00
2	109	15	00	44	00	00
3	109	15	00	43	50	00
4	109	45	00	43	50	00
5	109	45	00	43	20	00
6	109	00	00	43	20	00

Хавтгай: *К-49-3-А,В,Г*
К-49-4-В
К-49-15-А,Б,В,Г
К-49-16-А,В

Код: *АШУ-50*

1. Геологийн даалгавар боловсруулах хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24 дэх хэсэг, “Ашигт малтмалын тухай” хуулийн 16 дугаар зүйл, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2, УИХурлын 2025 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Алт-3” аян, УИХурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ийн 3.5.2, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төсөл, төлөвлөгөө”.

2. Судалгааны ажлын үндэслэл:

Судлагдсан түвшин:

Тайлангийн дугаар	Тайлангийн нэр	Гүйцэтгэсэн он
2010	Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт хийсэн эрэл-шалгалтын ажлын тайлан /№5 анги/	1973
1855	Зүүнбаянгийн районы шилний элсний ерөнхий эрлийн тайлан /Болгарын геологийн экспедици №7 анги/	1970
3049	Дорноговь аймгийн нутагт хийсэн гөлтгөний эрлийн тайлан	1979
4762	Уудам талын районд хийсэн хайгуулын ажлын тайлан	1994
2428	Дорноговь аймгийн нутагт хийсэн ураны эрэл-үнэлгээний тайлан /геологийн даалгавар МГСЭ-15/	1981
2648	Өмнөговийн зэсийн хүдрийн районд хийсэн эрэл-үнэлгээ, шалгалтын ажлын тайлан	1978
5540	Дорноговь аймгийн Хөвсгөл, Улаанбадрах сумын нутагт орших Таван Хар-Овооны талбайн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын тайлан (L-49-135-Г, L-49-136-В, К-49-3-Б, К-49-4-АВГ) /хил залгаа/	2004
8465	Дорноговь аймгийн Хөвсгөл, Улаанбадрах сумдын нутгийг хамарсан Хулгарын элс-50 төслийн талбайд 2014-2016 онуудад гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Код-ХуЭ-50. Байршил:К-49-16-БГ, К-49-17-АВГ, К-49-18-ВГ, К-49-30-АБВГа, /хил залгаа/	2016
5632	Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл сумдын нутагт орших Хутаг-Уулын талбайд 2002-2005 онуудад гүйцэтгэсэн	2006

	1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын тайлан (К-49-28-АБВГ, К-49-29-АБВГ) /хил залгаа/	
8175	Дорноговь аймгийн Хатанбулаг, Өмнөговь аймгийн Ханбогд сумдын нутаг хамарсан Эргэлийн зоо-50 төслийн талбайд 2014-2017 онуудад гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Код-Эр3-50. Байршил: К-49-25-АБ, К-49-26-АБВГ, К-49-27-АБВГ /хил залгаа/	2017
1206	Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумдын нутгийг хамарсан Чигдэн, Өлгийн нефтийн районд хийсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглалын ажлын үр дүнгийн тайлан. Байршил: L-49-134-Г-в,г, К-49-2-Б-а,б, К-49-3-А-б,г, Б-а,в, В-б, Г-а /Геологийн 32-р анги/ /хил залгаа/	1952
1198	Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумдын нутгийг хамарсан Чигдэн, Өлгийн нефтийн районд хийсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглалын ажлын үр дүнгийн тайлан. Байршил: L-49-134-Г-в,г, К-49-2-Б-а,б, К-49-3-А-б,г, Б-а,в, В-б, Г-а /Геологийн 32-р анги/	1952
1315	Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт 1953-1956 онд гүйцэтгэсэн 1:200 000-ны масштабын геологийн зураглалын ажлын тайлан. (нефтьжилтийн хэтийн төлөв) Байршил: К-48-А, К-48-Б, К-49-А. (58 анги)	1956
5384	Дорноговийн зүүн өмнөд хэсгийн геологийн тогтоц ашигт малтмал (Дорноговь аймгийн Өргөн, Сайхандулаан, Мандах, Эрдэнэ, Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах сумдын нутагт 1991-1994 онд хийсэн 1:200000-ны геологийн бүлэгчилсэн зураглал, ерөнхий эрлийн ажлын тайлан	1994
5737	Монгол улсын 1:200000-ны масштабын геологийн иж бүрдэл зураг. К-48-I-III	2005
5861	Өмнөд Монгол УГЗ-200 төслийн 2005-2007 онд Дорноговь Өмнөговь аймгуудын нутагт зохиосон 1:200000-ны масштабын улсын геологийн иж бүрдэл зураг (К-49-IV, VII, VIII, IX, XIII, XIV, XV К-48-Х, XI, XII, XVI, XVII, XVIII, XXII) /хил залгаа/	2008
5741	Монгол улсын 1:200000-ны масштабын геологийн иж бүрдэл зураг. L-49-XXXII /хил залгаа/	2005
4028	Зүүн өмнөт Монголд хийсэн 1:500000-ны масштабын гидрогеологийн зураглалын тайлан (L-48БГ, L-49АВ, К-48БГ, К-49АБ).	1986

4545	Монгол улсын зүүн өмнөд хэсгийн гидрогеологийн зураг 1:500000-ны масштабтай. L-49-АВВГ, L-50-АВВ, К-48-БГ, К-49-АБ.	1989
7075	Дорноговь аймгийн Сайншанд, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах, Сайхандулаан сумдын нутгийг хамарсан Өмнийн говь талбайд гүйцэтгэсэн 1:200000-ны гидрогеологи-геологийн иж бүрдэл зураг, геоэкологийн үнэлгээний ажлын тайлан. Байршил: L-49-XXVI. XXVI. XXVII. XXVIII. XXXI. XXXII. XXXIII. XXXIV. К-49- I. II. III. IV. VII. XIII. VIII. XIV. IX	2013
1604	Улаанбаатар-Замын-Үүдийн төмөр замын дагуух нутагт хийсэн 1:200000-ны масштабын агаарын соронзон зураглалын тайлан	1964
1229	Дорноговь, Өмнөговь аймгийн нутагт хийсэн соронзон хайгуулын тайлан /Өлгийн соронзонгийн анги/	1951
1730	Төв Монголд хийсэн 1:200000-ны масштабын агаарын соронзон зураглалын тайлан	1967
4515	1987-88 онд явуулсан геофизикийн сэдэвчилсэн судалгааны үр дүнгийн тайлан	1989
1289	Дорноговь аймагт хийсэн геофизикийн иж бүрэн судалгааны тайлан	1949
1717	Дорноговийн районд хийсэн соронзон зураглалын тайлан	1951
2453	Өндөршилийн талбайд хийсэн агаарын геофизикийн 1:200000-ны масштабын геологийн зураглалын тайлан /Өмнөд анги/	1982
2455	Манлайн талбайд хийсэн 1:200000-ны масштабын агаарын геофизикийн зураглалын тайлан. Байршил: L-48-60, 72 ,84 , 96.108. L-49-49. 50. 61. 62. 73. 74. 75. 76. 85. 86. 87. 88. 97. 98. 99. 100.	1983
4843	Дорноговийн сав газрын Эргэлийн талбайд явуулсан 1:200000-ны масштабын хүндийн хүчний судалгааны тайлан	1995
1233	Дорноговь аймгийн нутагт хийсэн 1:50000-ны масштабын агаарын соронзон зураглалын тайлан	1950
1234	Дорноговь, Өмнөговь аймгийн нутагт хийсэн хүндийн хүчний ажлын судалгааны тайлан	1952
1180	Зүүнбаян ордын районд хийсэн геофизикийн иж бүрэн ажлын тайлан /Трест № 54/	1949

2217	Дорноговь аймгийн Мандах сумын нутагт хийсэн гидрогеологи-геофизикийн судалгааны тайлан /Монгол-Унгарын цогцолбор геофизик-гидрогеологийн Үнэгтийн анги/	1976
------	--	------

Геологийн тогтоц: Өмнөд Монголын атриат мужийн Өмнөд говийн массивын Говийн тэнгэр уулын блок, Нүхэт давааны блок, Хатанбулагийн массивын Хутаг уулын блокт хамаарна.

Говийн тэнгэр уулын блокт мезопротерозойн Норовзээг формац, пермийн сизурал серийн амьтан агуулсан Харнүдэн, доод-дунд юрын Хамархөөвөр, дээд юрын Шарил формац, доод цэрдийн Хөхтээг, дээд цэрдийн Баянширээ, Баруунгоёт зэрэг формацуудыг, Нүхэтдавааны блокт карбоны пенсильван серийн Өлзийт-Уул формац, пермийн сизурал серийн Харнүдэн, гваделуп серийн Дэл-Овоот формацууд, доод-дунд юрын Хамархөөвөр, доод цэрдийн Цагаанцав, дээд цэрдийн Баянширээ, Баруунгоёт формацуудыг харин Хутаг уулын блокт мезопротерозойн Цээл формац, карбоны пенсильван серийн Өлзийт-Уул формац, пермийн сизурал серийн Харнүдэн, гваделуп серийн Дэл-Овоот формацууд, дунд-дээд юрын Эрээн-Уул формац, дээд цэрдийн Баянширээ, палеогены Эргэлийнзоо формацын Сэвхүүл, Эргэл, Хэцүүцав мэмбэрүүд зурагласан байна.

Ашигт малтмал: Төслийн талбай нь Улаан уулын минерагений бүсийн Айл харангадын хүдрийн дүүрэг, Зүүнбаянгийн газрын тос-нүүрс-гөлтгөнө-ураны сав газар, Дуутын тойрмын газрын тос-мангааны хүдрийн дүүргийн зарим хэсгүүд, Хөвсгөл-Улаанбадрахын минерагений бүсийн Хатавчийн хүдрийн потенциал дүүргийн Хөвсгөлийн хүдрийн потенциал зангилааны зарим хэсгийг хамран оршино. Тус талбайд өмнөх судалгаагаар Чулуун нүүрс-1, Гөлтгөнө-1 орд, Уран-2, Өнгөт чулуу-1, Шохойн чулуу-1, Молибден-1, Чулуун нүүрс-1, Манган-1, Гөлтгөнө-3 илрэл тогтоогдсон.

Тус талбайн ихэнх хэсэгт доод болон дээд цэрдийн хурдастай холбоотой Үнэгтийн гөлтгөнө-ураны, Дуутын тойрмын газрын тос-мангааны, Зүүнбаянгийн газрын тос-нүүрс-гөлтгөнө-ураны, Хатанбулагийн мангаан-ураны хүдэржилт тогтоогдсон хотгорууд өргөн тархсан бөгөөд салхины гаралтай элсний хуримтлалаар хучигдсан онцлогтой.

Өмнөх судалгаагаар ГХЭ-н 230, 241, 246, 249, цагаан тугалганы 232, зэсийн 230, 245, мангааны 240 гэсэн эрдэсжсэн цэгүүд, Цагаанцав формацын базальт дотор мана гартаамын 250 гэсэн цэг, ГХЭ-н шлихийн 2 хүрээ, молибден, зэсийн геохимийн цөөн тооны жижиг хүрээнүүд тогтоогдсон байдаг

Айл-Харангадын хүдрийн дүүргийн Дадын хар толгойн чулуун нүүрсний орд болон Хөвсгөл-Улаанбадрахын минерагений бүсийн Хатанбулгийн хотгор дахь гөлтгөнийн илрэлд хайгуул хийж, нөөцийг тогтоосон

Гадаргын эрлийн ажлаар хэтийн төлөвийг нь бүрэн үнэлэхэд хүндрэлтэй талбай бөгөөд үндсэн структуруудын үргэлжлэл болсон зэргэлдээ талбайнуудад тогтоогдсон ашигт малтмалуудаас харахад цэрдийн хотгоруудад гадаргад гөлтгөнө, мангааны хүдэржилт, гүнд нь элсжингийн уран, газрын тос илрүүлэх хэтийн төлөвтэй. Үнэгтийн хотгорын L-49 хавтгай дахь хэсэгт Үнэгтийн гөлтгөнийн бүлэг ордууд, Сайншанд орчмын элсжингийн ураны ордууд, Зүүнбаянгийн хотгорын ЗХ үргэлжлэлд Зүүнбаян, Цагаан элсний газрын тосны ордууд, Зөөвч-Овоо, Дулааны элсжингийн ураны ордууд, мөн олон тооны гөлтгөнийн илрэлүүд тогтоогдсон байдаг.

Тухайн районд “Элсжингийн уран”-ы ордууд, хуримтлал нь голчлон доод цэрдийн Хөхтээг горизонтын хурдсыг хучсан кайнозойн болон дээд цэрдийн хурдасын зааг орчмоор хуримталсан онцлогтой.

Эдийн засгийн хувьд: Төслийн талбайд Монголын зүүн өмнөд хэсгийн талархаг гадаргуу зонхилох бөгөөд бүхэлдээ говь, хээр хосолсон нутагтай. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд +41 хэм хүртэл халж, өвлийн улиралд -40 хэм хүртэл хүйтэрдэг. Салхины дундаж хурд 4,2-4,6 м/сек, зарим үед 35 м/сек хүрдэг. Тус аймаг нь эдийн засгийн хувьд аймгийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эцсийн байдлаар өмнөх оноос 24,7 хувиар өссөн байна. Үүнээс уул уурхайн салбарын үйлдвэрлэлт 55.1 хувиар, боловсруулах салбарын үйлдвэрлэл 27.8 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл 38.0 хувиар тус тус өссөн нь эдийн засгийн хувьд эрчимтэй хөгжиж буй бүс нутаг болохыг харуулж байна.

Ажлын зорилго:

Төслийн үндсэн зорилго нь:

- Судалгааны талбайд тархсан тунамал, вулканоген, интрузив, метаморф чулуулаг, тэдгээрийн эвслээс бүрдэх хурдас, чулуулгийг судлан Монголын литостратиграфын кодексийн дагуу зохих нэгжүүдэд ангилан ялгаж, зураглах, тектоник структурийн төрлүүдийг тодорхойлж, геодинамик нөхцөлийг тогтоох.

- Судалгааны талбайд ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэн эрлийн шинж тэмдэг, шалгуурыг тогтоож, ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтлыг тодорхойлон хэтийн төлөв бүхий хэсгүүдийг ялган эрлийн ажлыг гүйцэтгэн судалсны үндсэн дээр минерагений нэгжүүдийг (бүс, дүүрэг, зангилаа, талбай г.м) ялган, тэдгээрийн хэтийн төлөвийг тодорхойлон, эрдэс баялгийн үнэлгээг өгч, цаашдын судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох. Хэтийн төлөв бүхий илрэлүүдэд баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх.

- Судалгааны ажлын үр дүнд тулгуурлан гидрогеологи, геоморфологи, геоэкологийн судалгааг хийж, холбогдох зургуудыг даалгаварт заасан масштабаар зохиох, байгаль орчин дахь нөлөөллийг урьдчилан үнэлэх, уул уурхайн салбарын хөгжлийн суурь мэдээллийг бэлтгэнэ.

Зураглалын ажлыг геологийн тогтоц, нэвтрэлтийн зэрэг, хучаас хурдасны тархалт, гаршийн онцлогтой уялдуулан гүйцэтгэх бөгөөд геологийн нийлмэл тогтоц, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд торыг нягтруулан зохих шаардлага (Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:50,000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийх заавар, тавих шаардлага, 2010)-ыг хатуу мөрдөнө.

Алтан ширээ уул-50 төслийн талбайн хэмжээнд гүйцэтгэх геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг мөрдөж ирсэн заавар, шаардлагын дагуу гүйцэтгэн геологи, ашигт малтмалын болон холбогдох бусад зургуудыг зохиох, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийн үнэлгээг өгч, тэдгээрийн тайлбар бичгийг зохиож, анхдагч материалын сан бүрдүүлнэ.

3. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх үндсэн арга аргачлал ба дэс дараалал:

А.Бэлтгэл ажлын үе

4.1. Судалгааны ажлын төсөл, төсөв, календарьчилсан төлөвлөгөө зохионо.

4.2. Талбайн хэмжээнд өмнө нь хийсэн геологийн үе шатны судалгаа болон сэдэвчилсэн судалгааны материалуудыг бүрэн судлан танилцаж дүн шинжилгээ хийх, түүний үндсэн дээр тухайн талбайд тохирсон судалгааны арга аргачлалыг сонгоно. Үүнд:

- Өмнөх шатны судалгааны бүх төрлийн ажлын үр дүнг багтаасан мэдээллийн сан үүсгэх, мэдээллийг боловсруулан үнэлэлт, дүгнэлт өгч, өөрсдийн судалгааны ажлын суурийг бэлтгэх, арга аргачлал боловсруулах, баримтын зургийг зохиож бүртгэл үйлдэх,
- Өмнөх судалгааны материалд үндэслэн тухайн дүүргийн онцлогт тохирсон талбайн сорьцлолтын аргыг сонгож, тоо хэмжээг тооцох,
- Төслийн талбайн хэмжээнд мэдэгдэж байгаа ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, шлих, литогеохимийн сарнилын хүрээ, гажлуудыг бүртгэж, тэдгээрт дүн шинжилгээ хийх, хэтийн төлөвийн урьдчилсан зураг зохиох,
- Төслийн талбайн 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын шаардлага хангасан, өндөр нарийвчлалын агаар, сансрын болон 1:25 000, 1:50 000-ны масштабтай байрзүйн зургуудыг холбогдох мэргэжлийн байгууллагаар бэлдүүлэх, АСЗ-т геологийн тайлал хийх, тухайн талбай хамрагдсан геофизикийн судалгааны (хүндийн хүчний, соронзон зураглал гэх мэт) материалуудтай танилцан, урьдчилсан тайлал, боловсруулалт хийх,
- Өмнөх шатны судалгааны материалууд болон АСЗ-т хийсэн урьдчилсан тайллыг ашиглан төслийн геологийн болон бусад холбогдох зургийг 1:50 000-ны масштабтаар зохиож, нэгдсэн таних тэмдэг зохиох,
- Хээрийн ажилд гарахын өмнө талбайн стратиграфи, магматизм, тектоникийн мэдээлэл, урьдчилсан тайлал хийсэн зургийн хүрээнд танилцах маршрут төлөвлөх, уг асуудлаар Монголын стратиграфийн комиссоос зөвлөгөө авч, хамтран ажиллах,
- Дээрх материалууд дээр үндэслэн цаашдын судалгааны ажлыг төлөвлөсөн байх,
- Хилийн болон тал, хээрийн бүсэд ажиллахтай холбоотой хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны бэлтгэлийг хангана.

4.3. Машин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон ажиллагсдын хөдөлмөр-ахуйн нөхцөлийг хангасан хээрийн судалгааны өмнөх бэлтгэлийг бүрэн хангана.

4.4. Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрөл (орон нутаг, хилийн бүс, тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах гэх мэт), бичиг баримтыг бүрдүүлнэ.

4.5. Хээрийн судалгааны шатанд зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгэх гэрээ, геологийн даалгавар, ажлын төсөл, төсөв болон холбогдох журам, зааврыг бүрдүүлэн бэлтгэнэ.

Б. Хээрийн ажлын үе:

4.6. Ажил эхлэхээс өмнө жил бүрийн хээрийн судалгааны ажлыг хэрхэн ямар хугацаанд гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөө (ажлын хөтөлбөр) зохиосон байна.

4.7. Судалгаанд хамрагдах талбайн хэмжээнд юуны түрүүнд танилцах маршрутыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Талбайд тархсан хурдас, чулуулаг, гүний биетүүдийн тогтоц, голлох бүрдүүлэгч чулуулгийн найрлага, тогтоц, онцлог, тэдгээрийн харьцаа, хил зааг, томоохон хувирал, өөрчлөлтийн бүсүүд, тасралтад эвдрэлүүд, органик үлдэгдэл тогтоогдсон цэгүүд, өмнөх судалгаануудаар тогтоосон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, бүх төрлийн гажлуудтай танилцаж, дүгнэлт гаргах, эдгээр геологийн биетүүдээс эталон дээж бүрдүүлэх, шаардлагатай бол урьдчилан дээжилж, сорьцлох,
- Талбайн сорьцлолтын урьдчилан боловсруулсан арга, аргачлалыг бодит байдал, орчин нөхцөл, ландшафтын онцлог, орчин үеийн хурдасны тархалт, гарал үүсэл, бүс нутгийн уур амьсгал зэрэгтэй уялдуулан нягталж, шаардлагатай бол туршилт

аргачлалын сорьцлолт хийх, сорьцын тоог хучаас хурдсаар дарагдаагүй үндсэн чулуулгийн гарш бүхий нийт талбайд 1 кв.км-т >1 сорьц ноогдохоор тооцож, төлөвлөх,

- Маршрутын судалгаа, талбайн сорьцлолт эхэлж явуулах талбайг сонгох,
- Дээрх ажлуудыг гүйцэтгэхэд төслийн инженер техникийн ажилчид (ИТА), зөвлөхүүд бүгд оролцож, нэгдсэн дүгнэлт өгөх,
- Танилцах маршрутын үр дүнд тулгуурлан ажлын арга, аргачлалыг хянаж, шаардлагатай тохиолдолд заавар, шаардлагад нийцүүлэн зохих өөрчлөлтийг оруулан, хээрийн ажлын төлөвлөгөөг нарийвчилна.

В. Геологийн зураглалаар:

Геологийн зураглалын ажлыг ≤ 500 м-ийн торын нягтралтайгаар, чанарын шаардлага хангасан маршрутын судалгаагаар гүйцэтгэх бөгөөд доорх ажлуудыг хийж, асуудлыг шийднэ. Үүнд:

- АСЗ-ийг өргөн ашиглах, түүний тайллын үр дүнг газар дээр нь баталгаажуулан шалгаж, байнга засварлаж, нарийвчлал хийх,
- Урьдчилан зохиосон ажлын зурагт үнэлэлт дүгнэлт өгөх, шалган холбох маршрутыг шат дараатай явуулах,
- Төслийн талбайн хэмжээнд тархсан бүх төрлийн магмын болон хувирмал, тунамал, вулканоген хурдас, чулуулгийн тогтоц, найрлага, тархалт, хоорондын харьцаа, ялгааг тогтоох, литологи, структурыг нарийвчлан судалж төрөлжүүлэн зураглах, насны үндэслэлийг харьцуулалтын, палеонтологийн ба үнэмлэхүй насны шинжилгээгээр баталгаажуулах, тулгуур зүсэлтүүдийг хийх, нас, геохими, петрохимийн онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн дээж, сорьцыг арга, аргачлалын дагуу авах, шинжилгээ хийлгэх, боловсруулах ба урьдчилсан байдлаар ажлын геологийн зураг зохиож, тайлбар бичиглэл хийх, анхдагч баримт материалыг зааврын дагуу бүрдүүлэх,
- Хурдас чулуулгийн хил зааг, хоорондын харьцааг тогтоох, тэдгээрийн литологи, структурыг нарийвчлан зураглаж, формац, мэмбэр, бэд болон бүрдэл, фаз, фацийн түвшинд ялгах, шаардлагатай төрлийн сорьцлолтыг хийх, ингэхдээ дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байх. Үүнд:
 1. Төслийн талбайн геологийн тогтоцыг бүрдүүлж буй структур дээр анхаарах, мезо-кайнозойн хурдсыг бүсүүдийн хэмжээнд ангилах, хагарлуудын 2 талын хурдасны өөрчлөлтийг тодруулан харуулах.
 2. Норовзээг метаморф зузаалгийн литологийн харьцуулалтыг хийх, геохронологи ба геохимийн судалгаа явуулж нас ба формацын хамаарлыг тогтоох, хил заагийг тодруулах.
 3. Зүүн гашуун формацын хурдас чулуулагт хэсэгчилсэн зүсэлт хийх, шохойн чулуунд микро болон макро амьтны үлдэгдэл байгаа эсэхийг тодруулж харьцангуй нас тогтоох.
 4. Пермийн хурдаснаас амьтны үлдвэр илрүүлэх, насыг баталгаажуулах.
 5. Палеогены Эргэлийнзоо формацын Хөвсгөл, Сэвхүүл, Эргэл, Хэцүүцав мэмбэрүүдийг тулгуур зүсэлттэй харьцуулах, насыг амьтны үлдвэрээр баталгаажуулах.
 6. Хожуу карбоны Улаанбадрах бүрдлийг өмнөх судлаачид хэвээр зурагласан хэдий ч тархалт, фазыг өөр өөрөөр зурагласан тул нарийвчлан ялгаж, зэргэлдээх талбайн томоохон массивтай харьцуулан, нарийвчилсан шинжилгээнүүдээр баталгаажуулах.

7. Түүрүү пермийн Байрим-Овоо бүрдлийг бүрдлийг анх ялгаж зурагласан, 3 фаз ялгагдах эсэхийг тодруулах, сүүлийн үеийн нарийвчилсан цогц шинжилгээг хийлгэн орогены дараах нөхцөлд үүссэн геодинамик нөхцөлийг баталгаажуулах шаардлагатай.
 8. Дунд-хожуу пермийн? Замын-Үүд бүрдлийг бүрдлийг сүүлийн үеийн нарийвчилсан цогц шинжилгээг хийлгэн рифтийн нөхцөлд үүссэн геодинамик нөхцөлийг баталгаажуулах шаардлагатай.
 9. Дунд-хожуу мезопротерозойн серпентинит бүрдлийг зөвхөн Зүүн Өмнөд Монголын серийн 1:200000-ны масштабтай Улсын геологийн зурагт Бөмбөрөө нар зурагласан байдаг. Өмнөх болон сүүлийн үеийн зураглал, сэдэвчилсэн судалгааны ажлуудад огт тэмдэглэгдээгүй байдаг тул онцгой анхааран цогц шинжилгээ /петрографи, петрохими, геохими, геохронологи/-д хамааруулан судлах шаардлагатай.
- Төслийн талбайн литостратиграфийн ангиллыг “Монголын литостратиграфийн кодекс”-ийн дагуу шинэчлэн, ангилсан хурдаснуудыг хроно ба региональ стратиграфийн номенклатуртай харьцуулах, литостратиграфийн нэгжийн бичиглэлийг кодексийн дагуу үйлдэх,
 - Төслийн талбайд гүний чулуулаг, дэл судлын биетүүдийн гарал үүсэл, ангилал, бүрдлийн фаз, фацийг тодруулах, петрохими, геохими, петрографийн ба металлогений онцлогийг тодорхойлох, биетүүдийн нарийвчилсан бичиглэлийг хийх, бүрдэл, дэл судлын чулуулгийн геохими онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн сорьцыг арга, аргачлалын дагуу авч, шинжилгээ хийлгэн, үр дүнг боловсруулах,
 - Шаардлагатай тохиолдолд чулуулгийн үнэмлэхүй насыг тодорхойлуулах (тухайн гүний болон вулканоген, тунамал чулуулгийн онцлог, найрлага, гарал үүсэл, бусад онцлогийг бүрэн тодорхойлж, фаз, фацийн түвшинд зурагласан тохиолдолд энэ аргыг хэрэглэнэ),
 - Талбайн сорьцлолтоор авсан литогеохимийн бүх сорьцод тоон шинжилгээ (ICP-MS) хийлгэж, үр дүнг боловсруулах,
 - Орчин үеийн болон сэвсгэр хурдсыг гарал үүсэл, насаар нь нарийвчлан ангилж баталгаажуулах, тэдгээрийн зузаан, литологийн бүрэлдэхүүн, бусад шинжийг тодорхойлох,
 - Төслийн талбайтай хил залгаа болон ойр хийгдсэн 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлуудын үр дүнтэй уялдуулах, харьцуулж шалгах,
 - Талбайн тектоник-структурын бүтцийг нарийвчлан ангилж, тэдгээрийг бүрдүүлэгч хурдаснуудын формацын хамаарлыг тогтоон, нарийвчилсан бичиглэл хийх, тектоник-структурыг ашигт малтмалын тархалтын онцлогтой уялдуулан тайлбарлах,
 - Геоморфологийн ажиглалт хийж, гадаргуугийн гарал үүсэл, хэлбэр дүрсийн төрлүүдээр ангилах, рельефийн хөгжлийн онцлог, үүссэн дарааллыг судалж зураглах, тайлах, ашигт малтмалын шороон хуримтлал үүсэх боломжтой нөхцөл бүрдсэн геоморфологийн элементүүдийг судалж тогтоох, морфоструктурын анализ хийх,
 - Гидрогеологийн судалгаагаар тухайн талбайд байгаа худаг, булаг, шандыг координатжуулан, усны ундарга, түвшин бууралтыг хээрийн ажиглалтаар тогтоож, тухайн талбайн уст бүрдлийг төлөөлж чадахуйц уст цэгүүдээс гидрохимийн сорьц авч, шинжлүүлэх, уст бүрдлүүдийн онцлогийг тодруулах, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа хийх,
 - Геоэкологийн судалгаагаар тухайн талбайд байгаа үржил шимт өнгөн хөрсний үеэс төрөлжилтийн сорьцлолтыг холбогдох аргачлалын дагуу хийж химийн шинжилгээнд

хамруулах, тоон үзүүлэлтийг тодруулах, өмнөх байгаль орчны чиглэлээр хийгдсэн судалгааны материалуудыг ашиглах, өөрсдийн судалгааны ажлаар тухайн талбай дахь геологийн ховор тогтоц (гео-өв), улаан номд орсон амьтан, ургамал, түүхийн дурсгалт зүйлсийн байршлыг координатжуулах, геоэкологийн зураг, экологи-геологийн суурь үнэлгээний зурагт тусгах зорилгоор судалгааны ажиглалтыг зураглалын маршрутын явцад хамт хийх, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа явуулах,

- Төслийн талбайн хэмжээнд шугаман тогтоцтой дислокацид автсан чулуулгийн эрдэслэг бүрэлдэхүүн, үнэмлэхүй нас, структурийг нарийвчлан зураглах. Үүнд:
 - S0, S1, S2..., Sn хавтгай элементүүд (фолэйшн), Sn+1 тэнхлэг хавтгайг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
 - B1, B2..., Bn атирааны нугаснуудыг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
 - L1, L2..., Ln линэйшнүүдийг төрөлжүүлэн (mineral, stretching, intersection) тодорхойлж зураглах, хэмжилт хийнэ.

Г. Эрлийн ажлаар:

Өмнө хийгдсэн төрөл бүрийн геологи, геохими, геофизикийн зэрэг судалгааны ажлын материал үр дүнг бүрэн гүйцэт ашиглах, хил залгаа улсын материалтай сайтар танилцан, цугласан материалд боловсруулалт, дүн шинжилгээ хийн, төслийн талбайн хэмжээнд тогтоогдсон эрлийн шинж тэмдэг, шалгууруудын үндсэн дээр эрлийн ажлыг ашигт малтмалын төрлийг харгалзан, арга, аргачлалыг оновчтой, үр дүнтэй байхаар сонгон төлөвлөн гүйцэтгэх;

- Өмнөх судалгаануудаар илэрсэн орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүдийг хээрийн судалгааны эхний жилд шалган, үр дүнг баталгаажуулах, хяналтын сорьцлолт хийх, ялангуяа өмнөх судлаачдын гидротермаль-метасоматит хувирал харьцангуй хүчтэй илэрсэн гэж зураглаж тэмдэглэсэн талбайнуудад гүйцэтгэх зураглал-ерөнхий эрлийн маршрутын явцад ашигт малтмалын талаар онцгой анхаарал хандуулах,
- Маршрутын судалгааны үр дүнд тогтоогдсон хувирал, эрдэсэжсэн бүс, биетүүдээс ашигт малтмалын шалгуур, шинж тэмдэг тэдгээрийн тоон агуулгыг тогтоох зорилгоор авсан дээж, сорьцуудын үр дүнг нэгтгэн боловсруулсны үндсэн дээр дараагийн шатны ажлыг төлөвлөн, гүйцэтгэх,
- Талбайн шлих, литогеохимийн сорьцлолтын ажлыг 1 кв.км талбайд >1 сорьц ноогдох байдлаар зохих заавар, аргачлалын дагуу зураглалын ажлаас түрүүлүүлэн гүйцэтгэж, тогтоогдсон хэтийн төлөв бүхий сарнилын хүрээ, гажлуудын торыг нягтруулан шалгаж, үнэлгээ өгөх, өмнөх судлаачдын илрүүлсэн церусситын шлихийн хүрээ, хар тугалга, хар тугалга-цайр-зэсийн геохимийн хүрээнүүдийн хэтийн төлөвийг нарийвчлах,
- Өмнөх судалгаагаар илэрч, тухайн ажлын явцад баталгаажсан болон төслийн ажлын судалгааны үр дүнд шинээр тогтоогдсон ашигт малтмалын хүдэржилт бүхий хэсгүүдээс ашигт малтмалын төрөл, онцлог, хэтийн төлөвтэй нь уялдуулан нарийвчилсан эрэл хийх талбайнуудыг сонгох,
- Сонгосон талбайнуудад ашигт малтмалын төрөл, онцлогтой уялдуулан нарийвчилсан эрлийн ажлыг 1:5 000 - 25 000-ны масштабаар, үе шаттайгаар, цогцолбороор гүйцэтгэх. Энэ ажлын хүрээнд дараах асуудлыг шалган шийдвэрлэх:

1. 1:50000-ны масштабын геологийн зураглалын маршрутын үед ерөнхий эрлийн ажилд онцгой анхаарч, хувирал өөрчлөлт, ялангуяа ашигт малтмалын хүдэржилт байх боломжтой хувиралыг илрүүлж, судлахад анхаарах.

2. Геоморфологийн бүтэц, тогтцыг харгалзан цэрдээс өмнөх хурдас илэрсэн өргөгдлүүд болон цэрдийн хотгоруудын жалга судаг хөгжсөн хэсгүүдийг шлихийн сорьцлолт, геохимийн урсгал сарнилын сорьцлолтонд хамруулах.

3. Зүүнбаянгийн болон Хатанбулгийн хотгоруудын хэмжээнд жалга судгуудыг ашиглан цэрдийн хурдсуудын зүсэлтүүд хийхдээ зохих сорьцлолтууд хийж, ашигт малтмалын хэтийн төлөвийг үнэлэх.

4. Зүүнбаян болон Хатанбулгийн хотгоруудын дээд цэрдийн хурдсууд нь гөлтгөний хувьд хэтийн төлөвтэй тул геологийн маршрутын явцад болон жалга судгуудыг ашиглан хийх зүсэлтүүдэд гөлтгөний шинэ хуримтлал илрүүлэхэд анхаарах.

5. Алтан ширээ уул-50 төслийн талбайн өргөгдсөн хэсгүүд нь ураны үндсэн хүдэржилт, цэрдийн хотгорууд нь “элэжингийн уран”-ы хэтийн төлөвтэй тул агаарын 1:200000-ны масштабын геофизикийн цогцолбор зураглал (Ю.С.Шмелев нар, 1982, 2453ф)-н үр дүнг ашиглан эрлийн талбай ялгаж нарийвчилан судлах.

6. Я.Дагва-Очир нарын /1995, 5384ф/ -н илрүүлсэн ГХЭ-н эрдэсжсэн цэгүүд, шлихийн сарнилын хүрэнүүдийг нарийвчлан судалж, дээжлэлт сорьцлолт хийн хэтийн төлөвийг нь үнэлэх.

7. Цэрдийн хотгоруудын гүн, тэдгээрийг дүүргэсэн юра, доод цэрд, дээд цэрд, кайнозойн хурдсын бүтэц тогтоцыг тодорхойлох зорилгоор геофизикийн босоо цахилгаан бүслүүрчлэл, хүндийн хүчний зураглал хийх.

- Судалгааны талбайн хэмжээнд тогтоогдсон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсжсэн цэгүүдийн талбай болон биетийн хэмжээ, байрлал, хүдрийн болон дагалдагч эрдсийн найрлага, бүрэлдэхүүн, хүдэржилт, тэдгээрийн хувирлын төрөл, түүний хэмжээ, онцлогийг нарийвчлан судалж, дагалдах дээжлэлт, сорьцлолт хийх, холбогдох шинжилгээг бүрэн хийлгэх,
- Ашигт малтмалын илрэл, эрдэсжсэн цэгийг судлахын хамт талбайд тархсан хурдас, чулуулгийг эрдсийн түүхий эд болох талаас нь судлах,
- Ирээдүйн бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн бодлоготой уялдуулан зам, барилгын материалын түүхий эдийн судалгааг хийж, баялгийг үнэлнэ.

Д. Суурин боловсруулалт.

4.8. Завсрын суурин боловсруулалтаар:

- Хээрийн судалгааны явцад бүрдүүлсэн анхдагч баримт материалыг нэгтгэн боловсруулж, түүний үр дүнгээр баримт бүрдэл, геологи, шлих, геохимийн болон бусад холбогдох зургуудыг зохиох, бүх төрлийн дээж, сорьцын баримтжуулалтыг бүрдүүлэх, лабораторийн үр дүнгүүдийг зурагт буулгах, шаардлагатай тооцоолол, боловсруулалт хийж, дараагийн шатны ажлын төлөвлөлтөд ашиглах нөхцөл бүрдүүлэх,
- Хээрийн судалгаагаар шийдэж чадаагүй геологийн бүх асуудлыг шийдвэрлэх буюу дараагийн үе шатны ажлын үед шийдвэрлэх арга замыг сонгох, тодорхойлох, төлөвлөх,
- Төслийн хээрийн судалгаагаар талбайн тодорхой хэсэгт үүссэн зарчмын зөрүүтэй болон тодорхойгүй асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд дараагийн талбайд хээрийн ажлыг үргэлжлүүлэхийг хориглох,
- Судалгааны ажлын үр дүнд шаардлага хангасан мэдээлэлтэй болоогүй тохиолдолд түүнд дүн шинжилгээ хийж, тухайн асуудлыг шуурхай шийдвэрлэх арга замыг тодорхойлон шийдвэрлэх, ингэж чадаагүй тохиолдолд судалгааны арга аргачлалыг өөрчлүүлэх хүртэл саналыг тухайн үед нь захиалагчид хандаж, шуурхай шийдвэрлүүлнэ.

3.9. Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтаар:

- Мөрдөж буй заавар, шаардлагыг бүрэн хангасан анхдагч баримт, геологи, ашигт малтмал ба ашигт малтмалын тархалтын зүй тогтол, ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ, шлих болон литогеохимийн сорьцлолт, түүний үр дүнгийн зургуудыг 1:50 000-ны масштабтаар, тектоник, геоморфологи, гидрогеологи, геоэкологийн зургуудыг 1:100 000-200 000-ны масштабтаар, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий илрэл, эрлийн талбайн зургийг 1:1 000 - 25 000-ны масштабтаар тус тус зохиож, бусад төрөлжсөн зураг, бүдүүвч, график, хүснэгтийг хавсралтаар үйлдэх, зургууд нь ҮГА-ны Геомэдээллийн төвийн зурагт тавих шаардлагыг хангасан байх,
- Тухайн талбайн геологийн хөгжлийн түүхийг сэргээн босгохдоо О. Төмөртоогогийн тектоник-бүсчлэлийн, Г.Бадарчийн тектоно-стратиграфийн террейний болон Ж.Бямбын геодинамикийн ангиллаар төслийн талбай нь структур-тектоникийн ямар нэгжүүдэд хамаарч байгааг жишиж харьцуулж, дүгнэлт өгөх,
- Талбайн геологийн тогтоц, ашигт малтмалын гарал үүсэл, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, металлогений нөхцөлийг геодинамикийн хөгжилтэй уялдуулан дүгнэх,
- Төслийн талбайн ашигт малтмалын судалгааны үр дүнгээр хүдрийн талбай, потенциал талбайнуудыг шинээр ялгах,
- Талбайн хэмжээнд тогтоогдсон хэтийн төлөв бүхий ашигт малтмалын илрэлийн баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх,
- Төслийн ажлын үр дүнгээр төслийн талбайн хэтийн төлвийг А,Б,В,Г зэргээр үнэлэн цаашид хийх судалгааны ажлын чиглэлийг тодорхойлж, дараагийн шатанд нарийвчлан судлах талбайг ялган, дүгнэлт, зөвлөмж өгөх.
- Гидрогеологи, геоморфологи, геоэкологийн бүлгүүдийг өмнөх судалгааны ажил болон өөрсдийн ажлын үр дүнтэй уялдуулан тайлбарлах, дүгнэлт, зөвлөмж өгөх,
- Тайлангийн зургийг ArcGis программаар, бичвэрийг Times New Roman фондоор үйлдэх,
- Геофизикийн судалгааны ажлын үр дүнгээр зохиох ижил утгын зураг болон графикийг 1:25 000 -1 000-ны масштабтаар Geosoft Oasis Montaj программаар боловсруулах,
- Тухайн судалгааны ажлаар болон өмнөх судалгаагаар хуримтлагдсан геологи, геофизик, геохимийн зэрэг холбогдох бусад материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийснээр судалгааны талбайн ерөнхий мэдээлэл, ажлын арга, аргачлал болон геологийн тогтоц, ашигт малтмал, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, гидрогеологи, геоморфологи, геоэкологи зэргийг тусгасан тайлангийн зураг, бичвэрийг зохиож, Монголын стратиграфийн комисс болон хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гаргуулан, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Захиалагчийн шийдвэрийг гаргуулна.

4. Ажил гүйцэтгэх хугацаа:

5.1. Төсөл, төсөв зохион батлуулах:

Эхний жилд: - Шууд гэрээгээр.

5.2. Хээрийн ажил:

Эхний жилд:	2026 оны 8-р сараас 10-р сарыг дуустал
Хоёр дахь жилд:	2027 оны 5-р сараас 10-р сарыг дуустал
Гурав дахь жилд:	2028 оны 5-р сараас 10-р сарыг дуустал.

5.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт: 2026 оны 11-12-р сар дуустал

2027 оны 1-4-р сар, 11-12-р сар.

2028 оны 1-4-р сар дуустал

Эцсийн суурин боловсруулалт: 2028 оны 11-р сараас 2029 оны 10 сар дуустал.

5.4. Үр дүнгийн тайланг МСК-оор хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсны дараа хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэн холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийж, геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албажуулан ирүүлэх:

2029 оны 11-р сарын 30.

5.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжээр хянуулж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт, засварыг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр албажуулан хүргүүлэх:

2029 оны 12-р сарын 30.

5.6. Тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох дүгнэлт, түүнд үндэслэн эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулсны дараа Геологийн мэдээллийн төв архивд тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны дараа ажлын 5 өдөрт багтаах

МОНГОЛ УЛС

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

БАТЛАВ: АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА **Б.ДАШПҮРЭВ**

2026 оны 03-р сарын 06-ний өдөр



Дугаар 2026/ 01

**ТӨХӨЛИЙН ЭЛС-50 ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50 000-НЫ
МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖЛЫН
ГЕОЛОГИЙН ДААЛГАВАР**

Судалгааны үе шат: *1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрэл*

Ашигт малтмалын төрөл: *Бүх төрлийн ашигт малтмал*

Судалгааны талбайн нэр: *Төхөлийн элс*

Судалгааны талбайн байршил: *Дорноговь аймгийн Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумдын нутаг*

Судалгааны талбайн хэмжээ: *5523.14 кв.км*

Координат:

№	гр	мн	сс	гр	мн	сс
1	108	00	00	44	00	00
2	109	00	00	44	00	00
3	109	00	00	43	20	00
4	108	00	00	43	20	00
5	108	00	00	43	45	00
6	108	18	00	43	45	00
7	108	18	00	43	55	00
8	108	00	00	43	55	00

Хавтгай:

К-49-1-А,а,б, Б, В,в,г, Г

К-49-2-А,Б,В,Г

К-49-13-А,Б,В,Г

К-49-14-А,Б,В,Г

Код: *ТөЭ-50*

1. Геологийн даалгавар боловсруулах хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24 дэх хэсэг, “Ашигт малтмалын тухай” хуулийн 16 дугаар зүйл, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2, УИХурлын 2025 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Алт-3” аян, УИХурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ийн 3.5.2, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төсөл, төлөвлөгөө”.

2. Судалгааны ажлын үндэслэл:

Судлагдсан түвшин:

Тайлангийн дугаар	Тайлангийн нэр	Гүйцэтгэсэн он
2010	Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт хийсэн эрэл-шалгалтын ажлын тайлан /№5 анги/	1973
4180	Дорноговь аймгийн Өлгий хийдийн массивийн районд хийсэн эрлийн ажлын тайлан	1988
2583	Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын хүдрийн талбайд хийсэн эрэл-үнэлгээ ба ерөнхий эрлийн тайлан	1977
3022	Хүнгүйт, Нарийн худаг, Цагаан суваргын зэсийн хүдрийн талбайн эрэл-үнэлгээ, нарийвчилсан эрлийн тайлан	1980
4977	Цагаан суваргын ордын зэс молибдены дагалдах эрдсийн хайгуул, эрэл-үнэлгээ, дээжлэлтийн тайлан	1995
3480	Хүнгүйт-Шүтээний хүдрийн зангилаа, цохиот, Алагбаян, Нарангийн-Худаг ба бусад хүдрийн илрэлийн талбайд хийсэн эрэл-үнэлгээний тайлан /хил залгаа/	1982
4762	Уудам талын районд хийсэн хайгуулын ажлын тайлан	1994
2267	Өмнөговийн зэс-молибдены хүдрийн бүсэд хийсэн эрэл-үнэлгээний үр дүн	1976
1723	Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших зэс-молибдены Цагаансуварга ордын эрэл-үнэлгээний ажлын үр дүнгийн тайлан /Цагаансуваргын №19 анги/	1967
1773	Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших зэс-молибдены Цагаан суварга ордын эрэл, хайгуулын тайлан	1968

2347	Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын районд хийсэн геофизикийн судалгааны тайлан	1977
2772	Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших зэс молибдены Цагаан суваргын ордын урьдчилсан хайгуулын тайлан /Участок Сэрвэн сухайт/	1979
2648	Өмнөговийн зэсийн хүдрийн районд хийсэн эрэл-үнэлгээ, шалгалтын ажлын тайлан	1978
3682	Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын зэс, молибдений ордын нарийвчилсан хайгуулын ажлын тайлан	1984
8305	Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Бударын чулуу-50 төслийн талбайд 2014-2016 онуудад гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Код-БЧ-50. Байршил: L-49-133-АБВГ, L-49-134-АБВГ /хил залгаа/	2016
1205	Цантын хэсгээс авсан чулуулгийн лабораторийн шинжилгээний үр дүн /Треста № 54/	1952
3701	Дорноговь аймгийн Мандах сумын Баян-Овоо уулын районд хийсэн 1:50000-ны масштабтай геологийн эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил: L-49-134-В-в,г, Г-в, К-49-2-А-а,б, Б-а,в	1984
1667	Дорноговь аймгийн Мандах сумын нутаг Цагаан суварга Зэс-Молибдены (Си-Мо)-ны ордын районд хийсэн 1:50000-ны масштабтай эрлийн ажлын тайлан. Байршил: L-49-134-А-б, В-г, Г-в, К-49-2-А-б, К-49-1-Б-в,г, Г-а,б /Чойрын экспедицийн №19 анги/	1966
1206	Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумдын нутгийг хамарсан Чигдэн, Өлгийн нефтийн районд хийсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглалын ажлын үр дүнгийн тайлан. Байршил: L-49-134-Г-в,г, К-49-2-Б-а,б, К-49-3-А-б,г, Б-а,в, В-б, Г-а /Геологийн 32-р анги/	1952
8175	Дорноговь аймгийн Хатанбулаг, Өмнөговь аймгийн Ханбогд сумдын нутаг хамарсан Эргэлийн зоо-50 төслийн талбайд 2014-2017 онуудад гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Код-Эр3-50. Байршил: К-49-25-АБ, К-49-26-АБВГ, К-49-27-АБВГ /хил залгаа/	2017
10830	Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай сумдын нутагт орших Халзан овоо-50 талбайд 2019-2022 онд гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр	2022

	дүнгийн тайлан. Код: ХаО-50 Хавтгай: К-48-23-А,Б,В,Г, К-48-24-А,Б,В,Г, К-48-12-В-в,г, К-48-12-Г-в,г/хил залгаа/	
7340	Өмнөговийн Манлай, Цогт-Цэций, Дорноговийн Мандах сумдыг хамарсан Манлайн талбайд 2011-2014 онд гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан К-48-9-Г, К-48-10-ВГ, К-48-11-ВГ, К-48-12-АБВГ, К-49-1-АБВГ, /хил залгаа/	2014
1273	Өмнөговь ба Дорноговь аймгийн Номгоны дүүрэгт 1952 онд гүйцэтгэсэн 1:200 000-ны масштабын геологийн зураглалын ажлын тайлан. Байршил: К-49-VI, XII, К-49-I. (ГРК-ийн 40-р анги)	1952
1714	Дорноговь аймгийн Өлгийн районд хийсэн 1:200000-ны масштабын геологийн зураглалын тайлан /Геологийн №21 анги/	1951
1844	Дорноговийн Олонхүрэнгийн районд хийсэн 1:200000-ны масштабын геологийн зураглалын тайлан /Геологийн №28 анги/	1952
1948	Мандахын 4-р ангийн явуулсан L-48-XXXVI, L-49-XXXI, К-48-VI, К-49-I хавтгайд хийсэн 1:200000-ны масштабын геологийн зураглал ба эрлийн ажлын тайлан /Мандахын анги №9/	1972
2724	Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн нутагт хийсэн 1:200000-ны масштабын геологийн зураглалын тайлан /L-48-XXVIII, XIX-ийн хагас, L-48-XXXIV, XXXV, К-48-III-ын хагас, К-48-IV,V,VI, К-49-I-ийн хагас/ (Контракт №55-034/07000)	1978
1315	Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт 1953-1956 онд гүйцэтгэсэн 1:200 000-ны масштабын геологийн зураглалын ажлын тайлан. (нефтьжилтийн хэтийн төлөв) Байршил: К-48-А, К-48-Б, К-49-А. (58 анги)	1956
5384	Дорноговийн зүүн өмнөд хэсгийн геологийн тогтоц ашигт малтмал (Дорноговь аймгийн Өргөн, Сайхандулаан, Мандах, Эрдэнэ, Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах сумдын нутагт 1991-1994 онд хийсэн 1:200000-ны геологийн бүлэгчилсэн зураглал, ерөнхий эрлийн ажлын тайлан	1994
4877	Галбын говийн талбай 1987-1989 онд К-48-VI, IX-XII, XV-XVIII, XXI, XXII, К-49-I, VII, XIII хавтгайд хийсэн 1:200000-ны масштабын геологийн цогцолбор судалгааны тайлан	1996
2267	Өмнөговийн зэс-молибдены хүдрийн бүсэд хийсэн эрэл-үнэлгээний үр дүн	1976

5737	Монгол улсын 1:200000-ны масштабын геологийн иж бүрдэл зураг. К-48-I-III	2005
5860	Дорнод Монгол "УГЗ-200" төслөөр Дорноговь, Дундговь аймгуудын зарим сумдын нутагт L-49-XIX, XX, XXI, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXXI) хавтгайн хэмжээнд 2005-2007 онд зохиосон 1:200000-ны масштабын геологи, ашигт малтмал, дөрөвдөгч, экологийн зураг зохиох ажлын үр дүнгийн тайлан. /хил залгаа/	2008
6326	Өмнөговь, Дорноговь аймгуудын зарим нутгийг хамарсан К-48-III, IV, V, VI, VIII, IX, XIII, XIV, XV, XX, XXI хавтгайд 1:200000-ны масштабын "Улсын геологийн зураг зохиох" төслийн 2007-2010 оны ажлын үр дүнгийн тайлан. /хил залгаа/	2011
5861	Өмнөд Монгол УГЗ-200 төслийн 2005-2007 онд Дорноговь Өмнөговь аймгуудын нутагт зохиосон 1:200000-ны масштабын улсын геологийн иж бүрдэл зураг (К-49-IV, VII, VIII, IX, XIII, XIV, XV К-48-X, XI, XII, XVI, XVII, XVIII, XXII) /хил залгаа/	2008
4028	Зүүн өмнөт Монголд хийсэн 1:500000-ны масштабын гидрогеологийн зураглалын тайлан (L-48БГ, L-49АВ, К-48БГ, К-49АБ).	1986
4545	Монгол улсын зүүн өмнөд хэсгийн гидрогеологийн зураг 1:500000-ны масштабтай. L-49-АБВГ, L-50-АБВ, К-48-БГ, К-49-АБ.	1989
7075	Дорноговь аймгийн Сайншанд, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах, Сайхандулаан сумдын нутгийг хамарсан Өмнийн говь талбайд гүйцэтгэсэн 1:200000-ны гидрогеологи-геологийн иж бүрдэл зураг, геоэкологийн үнэлгээний ажлын тайлан. Байршил: L-49-XXVI. XXVI. XXVII. XXVIII. XXXI. XXXII. XXXIII. XXXIV. К-49-I. II. III. IV. VII. XIII. VIII. XIV. IX	2013
7670	Өмнөговь аймаг Манлай, Ханбогд, Дорноговь аймаг Мандах сумын зарим нутгийг хамарсан Өмнөд говийн талбайд 2012-2014 онд гүйцэтгэсэн 1:200000-ны масштабын гидрогеологи, геоэкологийн үнэлгээний тайлан. /К-48-III. IV. V. VI. IX. X. XI. XII. XV. XVI. XVII. X/хил залгаа/	2015
1604	Улаанбаатар-Замын-Үдийн төмөр замын дагуух нутагт хийсэн 1:200000-ны масштабын агаарын соронзон зураглалын тайлан	1964
1229	Дорноговь, Өмнөговь аймгийн нутагт хийсэн соронзон хайгуулын тайлан /Өлгийн соронзонгийн анги/	1951

1730	Төв Монголд хийсэн 1:200000-ны масштабын агаарын соронзон зураглалын тайлан	1967
4515	1987-88 онд явуулсан геофизикийн сэдэвчилсэн судалгааны үр дүнгийн тайлан	1989
1289	Дорноговь аймагт хийсэн геофизикийн иж бүрэн судалгааны тайлан	1949
1717	Дорноговийн районд хийсэн соронзон зураглалын тайлан	1951
2453	Өндөршилийн талбайд хийсэн агаарын геофизикийн 1:200000-ны масштабын геологийн зураглалын тайлан /Өмнөд анги/	1982
1719	Их Хайрхан, Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын районд хийсэн 1:50000-ны масштабын агаарын соронзон зураглалын тайлан	1967
2455	Манлайн талбайд хийсэн 1:200000-ны масштабын агаарын геофизикийн зураглалын тайлан. Байршил: L-48-60, 72 ,84 , 96.108. L-49-49. 50. 61. 62. 73. 74. 75. 76. 85. 86. 87. 88. 97. 98. 99. 100.	1983
1234	Дорноговь, Өмнөговь аймгийн нутагт хийсэн хүндийн хүчний ажлын судалгааны тайлан	1952
2217	Дорноговь аймгийн Мандах сумын нутагт хийсэн гидрогеологи-геофизикийн судалгааны тайлан /Монгол-Унгарын цогцолбор геофизик-гидрогеологийн Үнэгтийн анги/	1976

Геологийн тогтоо: Өмнөд Монголын атриат мужийн Говийн атриат мегабүсийн Мандахын бүс, Өмнөд говийн массивын Говийн тэнгэр уулын блок, Нүхэтдавааны блок, Хатанбулагийн массивын Хутаг уулын блокт хамаарна.

Мандахын бүсэд доод цэрдийн Цагаанцав, Баруунбаян формацууд, дээд цэрдийн Улаанговь, Баруунгоёт формацууд, Нүхэтдавааны блокт дээд цэрдийн Баянширээ, Баруунгоёт формацууд, Хутаг уулын блокт дээд цэрдийн Баянширээ, палеогены Эргэлийнзоо формацын Хөвсгөл, Сэвхүүл, Эргэл, Хэцүүцав мэмбэрүүд зураглагдсан байна. Говийн тэнгэр уулын блокт мезопротерозойн Норовзээг формац, силурын ангилагдаагүй хурдас, дээд девон-карбоны миссисип серийн Алагбаян формац, карбоны миссисип серийн Цагаансуврага мөн карбоны миссисип серийн Сайншандхудаг, Мөхөгцөг, Цохиот формацууд, пермийн сизурал серийн Захавчхудаг, Сухайт формацууд, амьтан агуулсан Харнүдэн, гваделуп серийн Дэл-Овоот формацууд, доод-дунд юрын Хамархөөвөр, дээд юрын Өлгий болон Шарил формацууд, доод цэрдийн Цагаанцав, Манлай, Хөхтээг формацууд, дээд цэрдийн Баруунбаян, Баянширээ, Улаанговь, Баруунгоет, эоцены Эргэлийнзоо формац зэргийг зурагласан байна.

Ашигт малтмал: Төслийн талбай нь Оюутолгой-Цагаансуваргын минерагений бүсийн Цагаансуваргын хүдрийн дүүргийн Цагаансуваргын хүдрийн зангилаа, Өлгий хийдийн хүдрийн потенциал зангилаа болон Улаан уулын минерагений бүсийн Дуутын тойрмын

хүдрийн потенциал дүүрэг, Айл-Харангадын хүдрийн дүүргийг дамнан байрлана. Тус талбайд өмнөх судалгаагаар Зэс-4, Мана-1, Никель-зэс-1, Гөлтгөнө-1, Чулуун нүүрс-4 орд, Зэс-11, Барит-1, Гөлтгөнө-4, Шатдаг занар-1, Хайлуур жонш-1, ГХЭ-2, Шавар-3, Стронций-1, Уран-4, Манган-5, Өнгөт чулуу-3, Төмөр-1 илрэл тогтоогдсон байдаг.

Тус төслийн талбайд Оюутолгой-Цагаансуваргын бүсийн Цагаансуваргын хүдрийн дүүргийн Цагаансуваргын хүдрийн зангилаанд порфирын зэс-молибдены хүдэржилттэй нь тогтоогдсон.

Цагаансуваргын ордын порфирын Cu-Mo(Au,Ag)-ны хүдэржилт нь хожуу девоны Цагаансуварга бүрдлийн гранодиорит-граносиент-гранитын массивтай холбоотой ба түүнийг хучсан миссисипийн Сайншандхудаг формацын вулканоген-тунамал хурдас дороос цухуйсан гарш үүсгэсэн байдаг.

Оюутолгойн хүдрийн дүүргийн порфирын зэс-алт-молибдены ордуудын геологийн тогтоцтой харьцуулан үзвээс Сайншандхудаг формацын хурдас нь хожуу девоны порфирын Cu-Mo(Au,Ag)-ны баян хүдэржилттэй өөр хэсгүүдийг хучсан байх тул далд хүдэржилт байх магадлалтай.

Цагаансуваргын хүдрийн талбай, тухайлбал хүдэр агуулагч хожуу девоны гранитоид массив нь агаарын геофизикийн судалгаагаар цацраг идэвхжил (K,Th,U) өндөртэй гажил үүсгэдэг нь тогтоогдсон. Цагаансуваргын хүдрийн дүүрэг дэх миссисипийн хурдас тархсан хэсгүүд, БХ сунасан цэрдийн хотгоруудын хэмжээнд гажлууд илэрсэн байдаг.

Порфирын зэс-молибдены жижиг хэмжээний илрэлүүд нь Миссисипийн Сайншандхудаг формацын вулканоген тунамал хурдас, түүнийг зүссэн хожуу карбонь Могойт гранитоид бүрдэлтэй холбоотой байдаг.

Цэрдийн хотгорууд нь гөлтгөнө, тунамал төмөр, төмөр-мангаан, мангаан, тунамал стронцийн /целестин/ хүдэржилт бүхий илрэл, цэгүүдтэй.

Цагаансуваргын хүдрийн дүүргийн Өлгий хийдийн хүдрийн потенциал зангилааны миссисипийн Сайншандхудаг формацын вулканоген-тунамал хурдсыг хучсан дээд юрын Өлгий формацын вулканоген хурдас, түүний субвулкан биетүүд нь газрын ховор металлын хүдэржилттэй.

Улаан уулын минерагений бүсийн Айл-Харангадын хүдрийн дүүргийн БУ хагаст доод-дунд юрын хурдас нь чулуун нүүрсний ордуудтай, мөн цэрдийн вулканиттай холбоотойгоор вулканоген гаралтай ураны болон тунамал гаралтай “элсжингийн уран”-ы хүдэржилттэй “Айлын бүлэг” илрэлүүд тогтоогдсон. Сүүлийн үед зарим судлаачид доод-дунд юрын хурдсаас гадна Таван толгой, Дэлийн шандын түвшний буюу пермийн гвадалупын тунамал хурдас (P_{2do}) коксждог нүүрсний орд агуулдаг болохыг тогтоосон.

Улаан уулын минерагений бүсийн Дуутын тойромын талбайг газрын тосны хэтийн төлөвтэй гэж 1950-д онд хийгдсэн 1:200000-ны масштабын зураглалаар таамагласан байдаг ба энд сүүлийн үеийн судалгаа, өрөмдлөгөөр газрын тосны илрэл тогтоогдсон байдаг.

Эдийн засгийн хувьд: Төслийн талбайд Монголын зүүн өмнөд хэсгийн талархаг гадаргуу зонхилох бөгөөд бүхэлдээ говь, хээр хосолсон нутагтай. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд +41 хэм хүртэл халж, өвлийн улиралд -40 хэм хүртэл хүйтэрдэг. Салхины дундаж хурд 4,2-4,6 м/сек, зарим үед 35 м/сек хүрдэг. Тус аймаг нь эдийн засгийн хувьд аймгийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эцсийн байдлаар өмнөх оноос 24,7 хувиар өссөн байна. Үүнээс уул уурхайн салбарын үйлдвэрлэлт 55.1 хувиар, боловсруулах салбарын үйлдвэрлэл 27.8 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл 38.0 хувиар тус тус өссөн нь эдийн засгийн хувьд эрчимтэй хөгжиж буй бүс нутаг болохыг харуулж байна.

Ажлын зорилго:

Төслийн үндсэн зорилго нь:

- Судалгааны талбайд тархсан тунамал, вулканоген, интрузив, метаморф чулуулаг, тэдгээрийн эвшлээс бүрдэх хурдас, чулуулгийг судлан Монголын литостратиграфын кодексийн дагуу зохих нэгжүүдэд ангилан ялгаж, зураглах, тектоник структурийн төрлүүдийг тодорхойлж, геодинамик нөхцөлийг тогтоох.

- Судалгааны талбайд ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэн эрлийн шинж тэмдэг, шалгуурыг тогтоож, ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтлыг тодорхойлон хэтийн төлөв бүхий хэсгүүдийг ялган эрлийн ажлыг гүйцэтгэн судалсны үндсэн дээр минерагений нэгжүүдийг (бүс, дүүрэг, зангилаа, талбай г.м) ялган, тэдгээрийн хэтийн төлөвийг тодорхойлон, эрдэс баялгийн үнэлгээг өгч, цаашдын судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох. Хэтийн төлөв бүхий илрэлүүдэд баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх.

- Судалгааны ажлын үр дүнд тулгуурлан гидрогеологи, геоморфологи, геоэкологийн судалгааг хийж, холбогдох зургуудыг даалгаварт заасан масштабаар зохиох, байгаль орчин дахь нөлөөллийг урьдчилан үнэлэх, уул уурхайн салбарын хөгжлийн суурь мэдээллийг бэлтгэнэ.

Зураглалын ажлыг геологийн тогтоц, нэвтрэлтийн зэрэг, хучаас хурдасны тархалт, гаршийн онцлогтой уялдуулан гүйцэтгэх бөгөөд геологийн нийлмэл тогтоц, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд торыг нягтруулан зохих шаардлага (Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:50,000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийх заавар, тавих шаардлага, 2010)-ыг хатуу мөрдөнө.

Төхөлийн элс-50 төслийн талбайн хэмжээнд гүйцэтгэх геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг мөрдөж ирсэн заавар, шаардлагын дагуу гүйцэтгэн геологи, ашигт малтмалын болон холбогдох бусад зургуудыг зохиох, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийн үнэлгээг өгч, тэдгээрийн тайлбар бичгийг зохиож, анхдагч материалын сан бүрдүүлнэ.

3. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх үндсэн арга аргачлал ба дээ дараалал:

А.Бэлтгэл ажлын үе

4.1. Судалгааны ажлын төсөл, төсөв, календарьчилсан төлөвлөгөө зохионо.

4.2. Талбайн хэмжээнд өмнө нь хийсэн геологийн үе шатны судалгаа болон сэдэвчилсэн судалгааны материалуудыг бүрэн судлан танилцаж дүн шинжилгээ хийх, түүний үндсэн дээр тухайн талбайд тохирсон судалгааны арга аргачлалыг сонгоно. Үүнд:

- Өмнөх шатны судалгааны бүх төрлийн ажлын үр дүнг багтаасан мэдээллийн сан үүсгэх, мэдээллийг боловсруулан үнэлэлт, дүгнэлт өгч, өөрсдийн судалгааны ажлын суурийг бэлтгэх, арга аргачлал боловсруулах, баримтын зургийг зохиож бүртгэл үйлдэх,
- Өмнөх судалгааны материалд үндэслэн тухайн дүүргийн онцлогт тохирсон талбайн сорьцлолтын аргыг сонгож, тоо хэмжээг тооцох,
- Төслийн талбайн хэмжээнд мэдэгдэж байгаа ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, шлих, литогеохимийн сарнилын хүрээ, гажлуудыг бүртгэж, тэдгээрт дүн шинжилгээ хийх, хэтийн төлөвийн урьдчилсан зураг зохиох,
- Төслийн талбайн 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын шаардлага хангасан, өндөр нарийвчлалын агаар, сансрын болон 1:25 000, 1 :50 000-ны масштабтай байрзүйн зургуудыг холбогдох мэргэжлийн байгууллагаар бэлдүүлэх, АСЗ-т геологийн тайлал хийх, тухайн талбай хамрагдсан геофизикийн

судалгааны (хүндийн хүчний, соронзон зураглал гэх мэт) материалуудтай танилцан, урьдчилсан тайлал, боловсруулалт хийх,

- Өмнөх шатны судалгааны материалууд болон АСЗ-т хийсэн урьдчилсан тайллыг ашиглан төслийн геологийн болон бусад холбогдох зургийг 1:50 000-ны масштабээр зохиож, нэгдсэн таних тэмдэг зохиох,
- Хээрийн ажилд гарахын өмнө талбайн стратиграфи, магматизм, тектоникийн мэдээлэл, урьдчилсан тайлал хийсэн зургийн хүрээнд танилцах маршрут төлөвлөх, уг асуудлаар Монголын стратиграфийн комиссоос зөвлөгөө авч, хамтран ажиллах,
- Дээрх материалууд дээр үндэслэн цаашдын судалгааны ажлыг төлөвлөсөн байх,
- Хилийн болон тал, хээрийн бүсэд ажиллахтай холбоотой хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны бэлтгэлийг хангана.

4.3. Машин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон ажиллагсдын хөдөлмөр-ахуйн нөхцөлийг хангасан хээрийн судалгааны өмнөх бэлтгэлийг бүрэн хангана.

4.4. Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрөл (орон нутаг, хилийн бүс, тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах гэх мэт), бичиг баримтыг бүрдүүлнэ.

4.5. Хээрийн судалгааны шатанд зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгэх гэрээ, геологийн даалгавар, ажлын төсөл, төсөв болон холбогдох журам, зааврыг бүрдүүлэн бэлтгэнэ.

Б. Хээрийн ажлын үе:

4.6. Ажил эхлэхээс өмнө жил бүрийн хээрийн судалгааны ажлыг хэрхэн ямар хугацаанд гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөө (ажлын хөтөлбөр) зохиосон байна.

4.7. Судалгаанд хамрагдах талбайн хэмжээнд юуны түрүүнд танилцах маршрутыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Талбайд тархсан хурдас, чулуулаг, гүний биетүүдийн тогтоц, голлох бүрдүүлэгч чулуулгийн найрлага, тогтоц, онцлог, тэдгээрийн харьцаа, хил зааг, томоохон хувирал, өөрчлөлтийн бүсүүд, тасралтад эвдрэлүүд, органик үлдэгдэл тогтоогдсон цэгүүд, өмнөх судалгаануудаар тогтоосон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, бүх төрлийн гажлуудтай танилцаж, дүгнэлт гаргах, эдгээр геологийн биетүүдээс эталон дээж бүрдүүлэх, шаардлагатай бол урьдчилан дээжилж, сорьцлох,
- Талбайн сорьцлолтын урьдчилан боловсруулсан арга, аргачлалыг бодит байдал, орчин нөхцөл, ландшафтын онцлог, орчин үеийн хурдасны тархалт, гарал үүсэл, бүс нутгийн уур амьсгал зэрэгтэй уялдуулан нягталж, шаардлагатай бол туршилт аргачлалын сорьцлолт хийх, сорьцын тоог хучаас хурдсаар дарагдаагүй үндсэн чулуулгийн гарш бүхий нийт талбайд 1 кв.км-т >1 сорьц ноогдохоор тооцож, төлөвлөх,
- Маршрутын судалгаа, талбайн сорьцлолт эхэлж явуулах талбайг сонгох,
- Дээрх ажлуудыг гүйцэтгэхэд төслийн инженер техникийн ажилчид (ИТА), зөвлөхүүд бүгд оролцож, нэгдсэн дүгнэлт өгөх,
- Танилцах маршрутын үр дүнд тулгуурлан ажлын арга, аргачлалыг хянаж, шаардлагатай тохиолдолд заавар, шаардлагад нийцүүлэн зохих өөрчлөлтийг оруулан, хээрийн ажлын төлөвлөгөөг нарийвчилна.

В. Геологийн зураглалаар:

Геологийн зураглалын ажлыг ≤ 500 м-ийн торын нягтралтайгаар, чанарын шаардлага хангасан маршрутын судалгаагаар гүйцэтгэх бөгөөд доорх ажлуудыг хийж, асуудлыг шийднэ. Үүнд:

- АСЗ-ийг өргөн ашиглах, түүний тайллын үр дүнг газар дээр нь баталгаажуулан шалгаж, байнга засварлаж, нарийвчлал хийх,
- Урьдчилан зохиосон ажлын зурагт үнэлэлт дүгнэлт өгөх, шалган холбох маршрутыг шат дараатай явуулах,
- Төслийн талбайн хэмжээнд тархсан бүх төрлийн магмын болон хувирмал, тунамал, вулканоген хурдас, чулуулгийн тогтоц, найрлага, тархалт, хоорондын харьцаа, ялгааг тогтоох, литологи, структурыг нарийвчлан судалж төрөлжүүлэн зураглах, насны үндэслэлийг харьцуулалтын, палеонтологийн ба үнэмлэхүй насны шинжилгээгээр баталгаажуулах, тулгуур зүсэлтүүдийг хийх, нас, геохими, петрохимийн онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн дээж, сорьцыг арга, аргачлалын дагуу авах, шинжилгээ хийлгэх, боловсруулах ба урьдчилсан байдлаар ажлын геологийн зураг зохиож, тайлбар бичиглэл хийх, анхдагч баримт материалыг зааврын дагуу бүрдүүлэх,
- Хурдас чулуулгийн хил зааг, хоорондын харьцааг тогтоох, тэдгээрийн литологи, структурыг нарийвчлан зураглаж, формац, мэмбэр, бэд болон бүрдэл, фаз, фацийн түвшинд ялгах, шаардлагатай төрлийн сорьцлолтыг хийх, ингэхдээ дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байх. Үүнд:

1.Төслийн талбайн геологийн тогтоцыг бүрдүүлж буй структур дээр анхаарах, мезо-кайнозойн хурдсыг бүсүүдийн хэмжээнд ангилах, хагарлуудын 2 талын хурдасны өөрчлөлтийг тодруулан харуулах.

2.“УГЗ-200-К” нэгтгэлийн зурагт дунд-дээд мезопротерозойн Норовзээг формацаар зурагласан метаморф зузаалгийн парагнейсийн протолитийн хурдас хуримтлалын насны доод хязгаар 547 с.ж-ээр, зузаалагт агуулагдах гранулитийн будины талсжилтын нас 451.6 ± 5.1 с.ж-ээр тус тус тогтоогдсон (Наранцэцэг нар., 2024). Цаашид нэмэлт геохронологи ба геохимийн судалгаа явуулж тус зузаалгийн нас ба формацын хамаарлыг тогтоох, зэргэлдээ орших эртний блокуудын судалгааны дүнгүүдтэй харьцуулах.

3. Силурын ангилаагүй хурдсын насны үндэслэлийг тодруулах. Вулканоген чулуулагт геохимийн шинжилгээ хийж гарал үүсэл, тектоник орчныг тодруулах, зэргэлдээ талбайнуудад тархалттай силурын насны формацуудтай харьцуулан судалж индексжүүлэх.

4.Девон, карбоны хурдаснуудаас амьтан ургамлын үлдэгдэл илрүүлж, насны үндэслэлийг баталгаажуулах,

5.Өлгий болон Шарил формацуудын харьцаа болон хил заагийн тодруулах.

6.Цэрдийн хурдасны ангиллыг нарийвчилж, бүсүүдийн хооронд харьцуулах, амьтан ургамлын үлдэгдэл цуглуулах.

7.Энэ талбайд тархсан вулканоген чулуулагт геохимийн судалгаа хийж, Таван харын дүүргийн чулуулагтай харьцуулах.

8. Дунд неопротерозойн настай Харангад бүрдлийн литологийн онцлог, петрохими, геохими, геохронологийн цогц судалгааг хийж, Говийн тэнгэр уулын блокт хамаарах эсэхийг тодруулах.

9. К-49-I хавтгайд өмнө гүйцэтгэсэн 1:200000-ны зураглалын 2 ажлын үр дүнд зураглагдсан карбоны Улаанбадрах, Могойт, Мандахын бүрдлүүд, хожуу триас-түрүү юрын Халзан-Уулын бүрдлүүдийг нарийвчилсан судлах.

- Төслийн талбайн литостратиграфийн ангиллыг “Монголын литостратиграфийн кодекс”-ийн дагуу шинэчлэн, ангилсан хурдаснуудыг хроно ба региональ стратиграфийн номенклатуртай харьцуулах, литостратиграфийн нэгжийн бичиглэлийг кодексийн дагуу үйлдэх,
- Төслийн талбайд гүний чулуулаг, дэл судлын биетүүдийн гарал үүсэл, ангилал, бүрдлийн фаз, фацийг тодруулах, петрохими, геохими, петрографийн ба металлогений онцлогийг тодорхойлох, биетүүдийн нарийвчилсан бичиглэлийг хийх, бүрдэл, дэл судлын чулуулгийн геохими онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн сорьцыг арга, аргачлалын дагуу авч, шинжилгээ хийлгэн, үр дүнг боловсруулах,
- Шаардлагатай тохиолдолд чулуулгийн үнэмлэхүй насыг тодорхойлуулах (тухайн гүний болон вулканоген, тунамал чулуулгийн онцлог, найрлага, гарал үүсэл, бусад онцлогийг бүрэн тодорхойлж, фаз, фацийн түвшинд зурагласан тохиолдолд энэ аргыг хэрэглэнэ),
- Талбайн сорьцлолтоор авсан литогеохимийн бүх сорьцод тоон шинжилгээ (ICP-MS) хийлгэж, үр дүнг боловсруулах,
- Орчин үеийн болон сэвсгэр хурдсыг гарал үүсэл, насаар нь нарийвчлан ангилж баталгаажуулах, тэдгээрийн зузаан, литологийн бүрэлдэхүүн, бусад шинжийг тодорхойлох,
- Төслийн талбайтай хил залгаа болон ойр хийгдсэн 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлуудын үр дүнтэй уялдуулах, харьцуулж шалгах,
- Талбайн тектоник-структурын бүтцийг нарийвчлан ангилж, тэдгээрийг бүрдүүлэгч хурдаснуудын формацын хамаарлыг тогтоон, нарийвчилсан бичиглэл хийх, тектоник-структурыг ашигт малтмалын тархалтын онцлогтой уялдуулан тайлбарлах,
- Геоморфологийн ажиглалт хийж, гадаргуугийн гарал үүсэл, хэлбэр дүрсийн төрлүүдээр ангилах, рельефийн хөгжлийн онцлог, үүссэн дарааллыг судалж зураглах, тайлах, ашигт малтмалын шороон хуримтлал үүсэх боломжтой нөхцөл бүрдсэн геоморфологийн элементүүдийг судалж тогтоох, морфоструктурын анализ хийх,
- Гидрогеологийн судалгаагаар тухайн талбайд байгаа худаг, булаг, шандыг координатжуулан, усны ундарга, түвшин бууралтыг хээрийн ажиглалтаар тогтоож, тухайн талбайн уст бүрдлийг төлөөлж чадахуйц уст цэгүүдээс гидрохимийн сорьц авч, шинжлүүлэх, уст бүрдлүүдийн онцлогийг тодруулах, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа хийх,
- Геоэкологийн судалгаагаар тухайн талбайд байгаа үржил шимт өнгөн хөрсний үеэс төрөлжилтийн сорьцлолтыг холбогдох аргачлалын дагуу хийж химийн шинжилгээнд хамруулах, тоон үзүүлэлтийг тодруулах, өмнөх байгаль орчны чиглэлээр хийгдсэн судалгааны материалуудыг ашиглах, өөрсдийн судалгааны ажлаар тухайн талбай дахь геологийн ховор тогтоц (гео-өв), улаан номд орсон амьтан, ургамал, түүхийн дурсгалт зүйлсийн байршлыг координатжуулах, геоэкологийн зураг, экологи-геологийн суурь үнэлгээний зурагт тусгах зорилгоор судалгааны ажиглалтыг зураглалын маршрутын явцад хамт хийх, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа явуулах,
- Төслийн талбайн хэмжээнд шугаман тогтоцтой дислокацид автсан чулуулгийн эрдэслэг бүрэлдэхүүн, үнэмлэхүй нас, стрүктүрийг нарийвчлан зураглах. Үүнд:

- S0, S1, S2..., Sn хавтгай элементүүд (фолэйшн), Sn+1 тэнхлэг хавтгайг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
- B1, B2..., Bn атирааны нугаснуудыг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
- L1, L2..., Ln линэйшнүүдийг төрөлжүүлэн (mineral, stretching, intersection) тодорхойлж зураглах, хэмжилт хийнэ.

Г. Эрлийн ажлаар:

Өмнө хийгдсэн төрөл бүрийн геологи, геохими, геофизикийн зэрэг судалгааны ажлын материал үр дүнг бүрэн гүйцэт ашиглах, хил залгаа улсын материалтай сайтар танилцан, цугласан материалд боловсруулалт, дүн шинжилгээ хийн, төслийн талбайн хэмжээнд тогтоогдсон эрлийн шинж тэмдэг, шалгууруудын үндсэн дээр эрлийн ажлыг ашигт малтмалын төрлийг харгалзан, арга, аргачлалыг оновчтой, үр дүнтэй байхаар сонгон төлөвлөн гүйцэтгэх;

- Өмнөх судалгаануудаар илэрсэн орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүдийг хээрийн судалгааны эхний жилд шалган, үр дүнг баталгаажуулах, хяналтын сорьцлолт хийх, ялангуяа өмнөх судлаачдын гидротермаль-метасоматит хувирал харьцангуй хүчтэй илэрсэн гэж зураглаж тэмдэглэсэн талбайнуудад гүйцэтгэх зураглал-ерөнхий эрлийн маршрутын явцад ашигт малтмалын талаар онцгой анхаарал хандуулах,
- Маршрутын судалгааны үр дүнд тогтоогдсон хувирал, эрдэсэжсэн бүс, биетүүдээс ашигт малтмалын шалгуур, шинж тэмдэг тэдгээрийн тоон агуулгыг тогтоох зорилгоор авсан дээж, сорьцуудын үр дүнг нэгтгэн боловсруулсны үндсэн дээр дараагийн шатны ажлыг төлөвлөн, гүйцэтгэх,
- Талбайн шлих, литогеохимийн сорьцлолтын ажлыг 1 кв.км талбайд >1 сорьц ноогдох байдлаар зохих заавар, аргачлалын дагуу зураглалын ажлаас түрүүлүүлэн гүйцэтгэж, тогтоогдсон хэтийн төлөв бүхий сарнилын хүрээ, гажлуудын торыг нягтруулан шалгаж, үнэлгээ өгөх, өмнөх судлаачдын илрүүлсэн церусситын шлихийн хүрээ, хар тугалга, хар тугалга-цайр-зэсийн геохимийн хүрээний гүйцэтгэх хэтийн төлөвийг нарийвчлах,
- Өмнөх судалгаагаар илэрч, тухайн ажлын явцад баталгаажсан болон төслийн ажлын судалгааны үр дүнд шинээр тогтоогдсон ашигт малтмалын хүдэржилт бүхий хэсгүүдээс ашигт малтмалын төрөл, онцлог, хэтийн төлөвтэй нь уялдуулан нарийвчилсан эрэл хийх талбайнуудыг сонгох,
- Сонгосон талбайнуудад ашигт малтмалын төрөл, онцлогтой уялдуулан нарийвчилсан эрлийн ажлыг 1:5 000 - 25 000-ны масштабтаар, үе шаттайгаар, цогцолбороор гүйцэтгэх. Энэ ажлын хүрээнд дараах асуудлыг шалган шийдвэрлэх:

1. Геологийн 1:50000-ны масштабын зураглалын маршрутын үед ерөнхий эрлийн ажилд онцгой анхаарч, хувирал өөрчлөлт, ялангуяа ашигт малтмалын хүдэржилт байх боломжтой хувиралыг илрүүлж, судлахад анхаарч, дагалдах дээжлэлт, сорьцлолтыг гүйцэтгэх.

2. Геоморфологийн бүтэц, тогтцыг харгалзан цэрдээс өмнөх хурдас илэрсэн өргөгдлүүд болон цэрдийн хотгоруудын жалга судаг хөгжсөн хэсгүүдийг шлихийн сорьцлолт, геохимийн урсгал сарнилын сорьцлолтонд хамруулах.

3. Эрлийн талбайн геологийн тогтоцыг гүн рүү нь нарийвчилан судлах, хүдэржилтийн талбайн болон гүний тархалтыг судлахад геофизикийн зоохих аргыг сонгон гүйцэтгэх, ялангуяа өмнөх судлаачдын агаарын геофизикийн судалгаагаар илэрсэн K, Th, U-ны гажлуудыг нарийвчлан судлах, хожуу девоны порфирын далд хүдэржилтийг илрүүлэх, таамаглахад анхаарал хандуулах.

4. Цагаансуваргын хүдрийн дүүргийн цэрдийн хотгоруудад тогтоогдсон гөлтгөнийн илрэлүүдийг нарийвчлан судалж, хэтийн төлөвийг тогтоох.

5. Цагаансуваргын хүдрийн дүүргийн Өлгий хийдийн хүдрийн зангилааны ГХЭ болон стронцийн хүдэржилтийн хэтийн төлөвийг үнэлэх

6. Айл-Харангадын хүдрийн дүүргийн “Айлын бүлэг” ураны хүдэржилтийн хэтийн төлөвийг үнэлэх.

7. Айл-Харангадын хүдрийн дүүргийн нүүрс хуримтлал явагдсан цаг хугацааг нарийвчилж, нүүрс хуримтлалын хэтийн төлөвийг үнэлэх.

8. Цэрдийн хотгоруудаар илэрсэн тунамал мангааны хүдэржилтийн хэтийн төлвийг үнэлэх.

- Судалгааны талбайн хэмжээнд тогтоогдсон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүдийн талбай болон биетийн хэмжээ, байрлал, хүдрийн болон дагалдагч эрдсийн найрлага, бүрэлдэхүүн, хүдэржилт, тэдгээрийн хувирлын төрөл, түүний хэмжээ, онцлогийг нарийвчлан судалж, дагалдах дээжлэлт, сорьцлолт хийх, холбогдох шинжилгээг бүрэн хийлгэх,
- Ашигт малтмалын илрэл, эрдэсэжсэн цэгийг судлахын хамт талбайд тархсан хурдас, чулуулгийг эрдсийн түүхий эд болох талаас нь судлах,
- Ирээдүйн бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн бодлоготой уялдуулан зам, барилгын материалын түүхий эдийн судалгааг хийж, баялгийг үнэлнэ.

Д. Суурин боловсруулалт.

4.8. Завсрын суурин боловсруулалтаар:

- Хээрийн судалгааны явцад бүрдүүлсэн анхдагч баримт материалыг нэгтгэн боловсруулж, түүний үр дүнгээр баримт бүрдэл, геологи, шлих, геохимийн болон бусад холбогдох зургуудыг зохиох, бүх төрлийн дээж, сорьцын баримтжуулалтыг бүрдүүлэх, лабораторийн үр дүнгүүдийг зурагт буулгах, шаардлагатай тооцоолол, боловсруулалт хийж, дараагийн шатны ажлын төлөвлөлтөд ашиглах нөхцөл бүрдүүлэх,
- Хээрийн судалгаагаар шийдэж чадаагүй геологийн бүх асуудлыг шийдвэрлэх буюу дараагийн үе шатны ажлын үед шийдвэрлэх арга замыг сонгох, тодорхойлох, төлөвлөх,
- Төслийн хээрийн судалгаагаар талбайн тодорхой хэсэгт үүссэн зарчмын зөрүүтэй болон тодорхойгүй асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд дараагийн талбайд хээрийн ажлыг үргэлжлүүлэхийг хориглох,
- Судалгааны ажлын үр дүнд шаардлага хангасан мэдээлэлтэй болоогүй тохиолдолд түүнд дүн шинжилгээ хийж, тухайн асуудлыг шуурхай шийдвэрлэх арга замыг тодорхойлон шийдвэрлэх, ингэж чадаагүй тохиолдолд судалгааны арга аргачлалыг өөрчлүүлэх хүртэл саналыг тухайн үед нь захиалагчид хандаж, шуурхай шийдвэрлүүлнэ.

4.9. Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтаар:

- Мөрдөж буй заавар, шаардлагыг бүрэн хангасан анхдагч баримт, геологи, ашигт малтмал ба ашигт малтмалын тархалтын зүй тогтол, ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ, шлих болон литогеохимийн сорьцлолт, түүний үр дүнгийн зургуудыг 1:50 000-ны масштабтаар, тектоник, геоморфологи, гидрогеологи, геоэкологийн зургуудыг 1:100 000-200 000-ны масштабтаар, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий илрэл, эрлийн талбайн зургийг 1:1 000 - 25 000-ны масштабтаар тус тус зохиож, бусад төрөлжсөн зураг, бүдүүвч, график, хүснэгтийг хавсралтаар үйлдэх, зургууд нь УГА-ны Геомэдээллийн төвийн зурагт тавих шаардлагыг хангасан байх,
- Тухайн талбайн геологийн хөгжлийн түүхийг сэргээн босгохдоо О. Төмөртоогогийн тектоник-бүсчлэлийн, Г.Бадарчийн тектоно-стратиграфийн террейний болон

Ж.Бямбын геодинамикийн ангиллаар төслийн талбай нь структур-тектоникийн ямар нэгжүүдэд хамаарч байгааг жишиж харьцуулж, дүгнэлт өгөх,

- Талбайн геологийн тогтоц, ашигт малтмалын гарал үүсэл, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, металлогений нөхцөлийг геодинамикийн хөгжилтэй уялдуулан дүгнэх,
- Төслийн талбайн ашигт малтмалын судалгааны үр дүнгээр хүдрийн талбай, потенциал талбайнуудыг шинээр ялгах,
- Талбайн хэмжээнд тогтоогдсон хэтийн төлөв бүхий ашигт малтмалын илрэлийн баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх,
- Төслийн ажлын үр дүнгээр төслийн талбайн хэтийн төлвийг А,Б,В,Г зэргээр үнэлэн цаашид хийх судалгааны ажлын чиглэлийг тодорхойлж, дараагийн шатанд нарийвчлан судлах талбайг ялган, дүгнэлт, зөвлөмж өгөх.
- Гидрогеологи, геоморфологи, геоэкологийн бүлгүүдийг өмнөх судалгааны ажил болон өөрсдийн ажлын үр дүнтэй уялдуулан тайлбарлах, дүгнэлт, зөвлөмж өгөх,
- Тайлангийн зургийг ArcGis программаар, бичвэрийг Times New Roman фондоор үйлдэх,
- Геофизикийн судалгааны ажлын үр дүнгээр зохиох ижил утгын зураг болон графикийг 1:25 000 -1 000-ны масштабтаар Geosoft Oasis Montaj программаар боловсруулах,
- Тухайн судалгааны ажлаар болон өмнөх судалгаагаар хуримтлагдсан геологи, геофизик, геохимийн зэрэг холбогдох бусад материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийснээр судалгааны талбайн ерөнхий мэдээлэл, ажлын арга, аргачлал болон геологийн тогтоц, ашигт малтмал, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, гидрогеологи, геоморфологи, геоэкологи зэргийг тусгасан тайлангийн зураг, бичвэрийг зохиож, Монголын стратиграфийн комисс болон хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гаргуулан, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Захиалагчийн шийдвэрийг гаргуулна.

5. Ажил гүйцэтгэх хугацаа:

5.1. Төсөл, төсөв зохион батлуулах:

Эхний жилд: - Шууд гэрээгээр.

5.2. Хээрийн ажил:

Эхний жилд:	2026 оны 8-р сараас 10-р сарыг дуустал
Хоёр дахь жилд:	2027 оны 5-р сараас 10-р сарыг дуустал
Гурав дахь жилд:	2028 оны 5-р сараас 10-р сарыг дуустал.

5.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт:	2026 оны 11-12-р сар дуустал
	2027 оны 1-4-р сар, 11-12-р сар.
	2028 оны 1-4-р сар дуустал

Эцсийн суурин боловсруулалт: 2028 оны 11-р сараас 2029 оны 10 сар дуустал.

5.4. Үр дүнгийн тайланг МСК-оор хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсны дараа хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэн холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийж, геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албажуулан ирүүлэх:

2029 оны 11-р сарын 30.

5.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжээр хянуулж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт, засварыг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр албажуулан хүргүүлэх:

2029 оны 12-р сарын 30.

5.6. Тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох дүгнэлт, түүнд үндэслэн эрх бүхий байгууллагын шийдвэрийг гарсаны дараа Геологийн мэдээллийн төв архивд тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны
дараа ажлын 5 өдөрт

МОНГОЛ УЛС
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

БАТЛАВ: АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ДАШПҮРЭВ

2026 оны 03-р сарын 06-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2026/03

ЦАХИРЫН ХЯР-50 ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50 000-НЫ
МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖЛЫН
ГЕОЛОГИЙН ДААЛГАВАР

Судалгааны үе шат:	1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрэл																																			
Ашигт малтмалын төрөл:	Бүх төрлийн ашигт малтмал																																			
Судалгааны талбайн нэр:	Цахирын хяр																																			
Судалгааны талбайн байршил:	Өмнөговь аймгийн Хүрмэн, Баяндалай сумдын нутаг																																			
Судалгааны талбайн хэмжээ:	3797.46 кв.км																																			
Координат:	<table><thead><tr><th>№</th><th>гр</th><th>мн</th><th>сс</th><th>гр</th><th>мн</th><th>сс</th></tr></thead><tbody><tr><td>1</td><td>103</td><td>30</td><td>00</td><td>43</td><td>00</td><td>00</td></tr><tr><td>2</td><td>104</td><td>00</td><td>00</td><td>43</td><td>00</td><td>00</td></tr><tr><td>3</td><td>104</td><td>00</td><td>00</td><td>42</td><td>10</td><td>00</td></tr><tr><td>4</td><td>103</td><td>30</td><td>00</td><td>42</td><td>10</td><td>00</td></tr></tbody></table>	№	гр	мн	сс	гр	мн	сс	1	103	30	00	43	00	00	2	104	00	00	43	00	00	3	104	00	00	42	10	00	4	103	30	00	42	10	00
№	гр	мн	сс	гр	мн	сс																														
1	103	30	00	43	00	00																														
2	104	00	00	43	00	00																														
3	104	00	00	42	10	00																														
4	103	30	00	42	10	00																														
Хавтгай:	К-48-40-А,Б,В,Г К-48-52-А,Б,В,Г К-48-64-А,Б																																			
Код:	ЦаХ-50																																			

1. Геологийн даалгавар боловсруулах хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24 дэх хэсэг, “Ашигт малтмалын тухай” хуулийн 16 дугаар зүйл, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2, УИХурлын 2025 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Алт-3” аян, УИХурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ийн 3.5.2, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төсөл, төлөвлөгөө”.

2. Судалгааны ажлын үндэслэл:

Судлагдсан түвшин:

Тайлангийн дугаар	Тайлангийн нэр	Гүйцэтгэсэн он
4762	Уудам талын районд хийсэн хайгуулын ажлын тайлан	1994
5625	Өмнөговь аймгийн Номгон, Хүрмэн, сумдын нутагт Дарцагтын ангийн гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил: К-48-64-В,Г, 65-В,Г, К-48-76-А,Б, 77-А,Б /хил залгаа/	2005
5626	Өмнөговь аймгийн Ноён, Баяндалай, Хүрмэн сумдын нутагт Цагаан-Уул ангийн гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил: К-48-62-А,Б,В-б, Г-а,б,г, К-48-63-А,Б,В,Г, К-48-75-А-б, Б-а,б,г/хил залгаа/	2005
7940	Баяндалай-50 талбайн геологийн тогтоц, ашигт малтмал: Өмнөговь аймгийн Баяндалай, Хүрмэн сумдын нутгийг хамарсан Баяндалай-50 талбайд 2013-2015 онуудад гүйцэтгэсэн 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил: К-48-27-АБВГ, К-48-28--АБВГ. Баяндалайн анги. /хил залгаа/	2015
5307	Өмнөговь аймгийн Ноён, Баяндалай, Хүрмэн, Ханхонгор, Номгон, Баян-Овоо сумдын нутагт 1996-98 онд Зурамтайн ангийн хийсэн 1:200000-ны масштабын геологийн бүлэгчилсэн зураглалын ажлын үр дүнгийн тайлан. Байршил: К-48-ҮII, YIII, IX, X, XIII, XYI. XY. XX. XXI	2000
6326	Өмнөговь, Дорноговь аймгуудын зарим нутгийг хамарсан К-48-III, IV, V, VI, VII, IX, XIII, XIV, XV, XX, XXI хавтгайд 1:200000-ны масштабын “Улсын геологийн зураг зохиох” төслийн 2007-2010 оны ажлын үр дүнгийн тайлан.	2011

4366	Оорцог ба Хадан-Ус уулын районд хийсэн газар доорх усны эрэл, Хүрмэн сумын төв, Бүгтийн хоолойн хэсгийн газар доорх усны урьдчилсан хайгуулын тайлан (1990.7.1-ны байдлаар ашиглалтын нөөц тооцсон)	1990
4702	Төвийн районы 1:500000-ны масштабын гидрогеологийн зураг зохиох ажлын тайлан	1993
7670	Өмнөговь аймаг Манлай, Ханбогд, Дорноговь аймаг Мандах сумын зарим нутгийг хамарсан Өмнөд говийн талбайд 2012-2014 онд гүйцэтгэсэн 1:200000-ны масштабын гидрогеологи, геоэкологийн үнэлгээний тайлан. /К-48-III. IV. V. VI. IX. X. XI. XII. XV. XVI. XVII. X/хил залгаа/	2015
2456	Алтайн талбайд хийсэн агаарын геофизикийн 1:1000000-ын масштабын комплекс зураглалын тайлан /геологийн даалгавар МГСЭ-32//хил залгаа/	1984
3880	Монголын нутагт хийсэн агаарын геофизикийн 1:200000-ны зураглалын тайлангийн зураглал	1984
4540	Өмнөговь аймгийн Ноён, Хүрмэн сумын нутагт хийсэн 1:200000-ны гравиметрийн ажлын тайлан	1991
4547	Баянхонгор, Өмнөговь аймгуудын нутагт хийсэн 1:200000-ны масштабын агаарын соронзон зураглалын тайлан	1991

Геологийн тогтоц:

Төслийн талбай нь Өмнөд Монголын атриат мужийн Говийн атриат мегабүсийн Гурвансайханы бүсийн урд Өмнөд говийн массивын Говийн тэнгэр уулын блок болон Хатанбулагийн массивын Цагаан уулын блокийг дамнан байрлана. Говийн тэнгэр уулын блокийн хэмжээнд ордовик-силурын Хүзүүвч-Уул формац, карбоны миссисип серийн Цохиот формац, пермийн сизурал серийн Тогоотхар формац, пермийн гваделуп серийн Дэлийншанд формац, дээд цэрдийн Баянширээ формац, дөрөвдөгчийн хурдас зураглагдсан байна..

Цагаан уулын блокийн хэмжээнд неопротерозой-түрүү кембрийн Цагаан-Уул формац, доод ордовикийн Эхэнхаяа формац, дунд-дээд ордовикийн Дундхаяа формац, силурын Хөхморьт формац, доод девоны Таванхудаг формац, карбоны миссисип серийн ангилагдаагүй хурдас, карбоны пенсильван серийн Баруунцохиот формац, карбоны пенсильван сери-пермийн сизурал серийн Их-Уул формац, пермийн сизурал серийн ангилагдаагүй хурдас, гваделуп пермийн Арсухайт формац, доод цэрдийн Цагаан-Аараг, Улаандэл формацууд, дээд цэрдийн Баянширээ формац, дээд цэрдийн базальтууд, Хатан суудлын хөндийд дөрөвдөгчийн хурдас тархана.

Хараат бүрдэл (γD_{3h})-ийг анх Э.Бүрэнхүү нар (4877Ф) К-48-XIV хавтгайн хэмжээнд Хараат ууланд ялгаж, доод девоны Эхийнгол формацтай орон зайн хамааралтай гэж үзэн, түрүү-дунд девоны настай Хараат бүрдлийг 2 фазтай, эхний фазад габбро, габбродиорит, кварцат диорит, сүүлийн фазад гранодиорит, плагиогранит, биотит-эвэрхуурмагт гранитыг ялгасан. Б.Дамдинжав нар (5307Ф) К-48-XIV хавтгайн хэмжээнд Хараат нэрийг авахад алс

зайтай гэж үзэн Хашаат уул, Хонгор морьт, Хар шивээний хэц, Сайнтооройн худаг массивуудыг дунд-дээд девоны настай Цохиот бүрдлээр, 3 фазтай, I фаз: габбро, габбродиорит, кварцат диорит, кварцат сиенит, II фаз: гранодиорит, гранит, шүлтлэгдүү гранит, III фаз: шүлтлэгдүү лейкогранит, судлын чулуулгаас риолит порфир, диорит порфирит, гранит-порфир, микрогаббро, андезит, аплитаар зурагласан. УГЗ-200 төслөөр Буянбаатар нар (6326Ф) дээрх хавтгайд Хараат бүрдлийг дунд девоны настай, 2 фазтай, I фаз: габбро, габбродиорит, кварцат диорит, кварцат сиенит, II фаз: гранодиорит, плагиогранит, биотит-эвэрхуурмагт гранит, шүлтлэгдүү гранитаас тогтоно гэжээ. К нэгтгэл төслийн ажлаар хожуу девоны настай Хараат бүрдэлд зурагласан хэдий ч Монгол Улс-БНХАУ-ын хилийн бүсийн дагуух геологийн зураг зохиох ажлын хүрээнд Хараат бүрдлээр зураглагдсан хэд хэдэн массиваас дээж авч үнэмлэхүй нас тодорхойлсон. U-Pb-ны аргаар Их хонгоржийн томоохон батолитын зүүн захын гранодиоритод 336 ± 19 сая жил, 332.2 ± 2.8 сая жил, баруун захын эвэрхуурмагт гранодиоритод 326 ± 1 сая жил (Оролмаа нар., 2019), гранитад 308 ± 4 сая жил (Guo et al., 2014), гранитад 308 ± 4 сая жил 310.6 ± 9.1 сая жил (Удаанжаргал нар, 2022)-гэсэн настай гэж тодорхойлогдсон байна.

Ашигт малтмал: Төслийн талбай нь хойноос урагш Нэмэгт-Зөөлөн-Гурвансайханы минерагений бүсийн Зөөлөнгийн хүдрийн дүүргийн Аргалантын зэс-алтны хүдрийн потенциал зангилаа, Атасбогдын минерагений бүсийн Нарийн сухайт-Ноёнгийн нүүрст сав, Наранбулгийн алтны хүдрийн дүүрэг, Цагаан уулын минерагений бүсийн Баруун цохиотын хүдрийн дүүрэг, түүний Билүүтийн хүдрийн зангилааны зарим хэсгүүдийг хамаарна. Тус талбайд өмнөх судалгаагаар Чулуун нүүрс-2 орд, Алт-1 илрэл тогтоогдсон.

Б.Дамдинжав, А.Дэлгэрсайхан, 2000, 5307ф/ нарын гүйцэтгэсэн 1:200000-ны масштабын ГЗЕЭА-аар эрлийн сонирхол шууд татах ашигт малтмал илрээгүй буюу хар тугалганы хэдэн эрдэсжсэн цэг, алтны I эрдэсжсэн цэг тогтоогдсон.

Төслийн талбайн хойд талбайд Ш.Лхүндэв, Б.Дэлгэрэхтүмэн /2015, 7940ф/ 1:50000-ны масштабын ГЗЕЭА гүйцэтгэж, Аргалантын хүдрийн потенциал зангилаанд вулканоген цул сульфидын зэс, кварцын судлын бүсийн зэс, алт, нүүрсний илрэлүүдийг тогтоосон.

Ц.Гүндсамбуу, Б.Даваасүрэн /2005, 5625ф/ нар болон Л.Бадамтулга нар /2005, 5626ф/-н гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын ГЗЕЭА-аар Баруунцохиотын хүдрийн дүүргийн Билүүтийн хүдрийн зангилаанд алтны үндсэн ба шороон илрэл, шлихийн хүрээ, цэгэн гажлууд, хар тугалганы эрдэсжсэн цэгүүд, хайлуур жоншны илрэлүүд тогтоогдсон бөгөөд хайлуур жоншны илрэлд хувийн хөрөнгөөр хайгуул хийж нөөц тогтоосон.

Төслийн талбайн урд хэсэгт илэрсэн алтны үндсэн ба шороон илрэлүүд, шлихийн хүрээ, цэгэн гажлуудыг бүрэн хамарсан бөгөөд төслийн талбайн өмнөд хэсгийг хамарсан том талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай олгогдсон байна.

Нарийнсухайт-Ноёнгийн нүүрст савын энд байрлах хэсэг нь дээд цэрдийн Баянширээ формац болон дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар бараг бүрэн хучигдсан ч захаар нь чулуун нүүрсний хэтийн төлөвтэй пермийн гвадалупын Дэлийншанд формацын хурдасны гарштай байгаа нь уг хурдастай холбоотойгоор гүнд дарагдмал орших чулуун нүүрсний хуримтлал илрэх хэтийн төлөвтэй.

Наранбулгийн булгийн алтны хүдрийн дүүргийн кварцын судлын бүсүүдтэй холбоотой алтны орд, илрэлүүд нь төслийн талбайн баруун захаас бараг 70 орчим км-ийн зайтай оршдог ч түүний үргэлжлэл гэж таамаглаж буй хэсэг нь дээд цэрдийн хурдсаар хучигдсан ба харин карбон, пермийн хурдасны гарш илэрдэг ба алтны эпитеpmаль төрөлд таамаглан хамруулсан алтны илрэл, шлихийн цэгэн гажлуудтай.

Баруун цохиотын хүдрийн дүүргийн хойд хэсэгт эдикари-доод кембрийн, доод палеозойн, доод девоны, карбоны хурдсууд, пермийн вулканит болон гранитоид тархсан бөгөөд хар тугалганы эрдэсжсэн цэг, зэс, хар тугалга, хүнцэлийн геохимийн сарнилын хүрэнүүдийг Б.Дамдинжав, А.Дэлгэрсайхан /2000, 5307ф/ нар тогтоосон байдаг.

Цахирын хяр-50 төслийн талбайд мезозой-кайнозойн хотгорууд өргөн тархалттай, Б.Дамдинжав, А.Дэлгэрсайхан /2000, 5307ф/ нарын зохиосон геологи-ашигт малтмалын зургаас үзэхэд тэдгээрийн хэмжээнд жалга, судгууд нэлээн хөгжсөн.

Эдийн засгийн хувьд: Төслийн талбай нь говь цөлийн мужид багтах бөгөөд дунджаар д.т.д. 1300-1600 м өндөрт оршино. Байгаль цаг уурын хувьд эрс тэс эх газрын уур амьсгалтай, дулааны улиралд халуун нь 30-39 градус, хүйтний улиралд -20 градус хүртэл хүйтэрдэг. Салхины хурд 5-15 м/сек, заримдаа 34-45 м/сек хүрд. Тус бүс нутаг нүүрс, зэс, алтны том ордуудтай. 2024 оны байдлаар Өмнөговь аймгийн нийт ДНБ нь 4,8 их наяд төгрөг (1.42 тэрбум ам.доллар) хүрсэн бөгөөд энэ нь Монгол Улсын хэмжээнд хамгийн өндөр ДНБ-тэй аймагт тооцогддог, эдийн засгийн хувьд эрчимтэй хөгжиж бүс нутагт хамрагдана.

Ажлын зорилго:

Төслийн үндсэн зорилго нь:

- Судалгааны талбайд тархсан тунамал, вулканоген, интрузив, метаморф чулуулаг, тэдгээрийн эвшлээс бүрдэх хурдас, чулуулгийг судлан Монголын литостратиграфын кодексийн дагуу зохих нэгжүүдэд ангилан ялгаж, зураглах, тектоник структурийн төрлүүдийг тодорхойлж, геодинамик нөхцөлийг тогтоох.

- Судалгааны талбайд ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэн эрлийн шинж тэмдэг, шалгуурыг тогтоож, ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтлыг тодорхойлон хэтийн төлөв бүхий хэсгүүдийг ялган эрлийн ажлыг гүйцэтгэн судалсны үндсэн дээр минерагений нэгжүүдийг (бүс, дүүрэг, зангилаа, талбай г.м) ялган, тэдгээрийн хэтийн төлөвийг тодорхойлон, эрдэс баялгийн үнэлгээг өгч, цаашдын судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох. Хэтийн төлөв бүхий илрэлүүдэд баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх.

- Судалгааны ажлын үр дүнд тулгуурлан гидрогеологи, геоморфологи, геоэкологийн судалгааг хийж, холбогдох зургуудыг даалгаварт заасан масштабаар зохиох, байгаль орчин дахь нөлөөллийг урьдчилан үнэлэх, уул уурхайн салбарын хөгжлийн суурь мэдээллийг бэлтгэнэ.

Зураглалын ажлыг геологийн тогтоц, нэвтрэлтийн зэрэг, хучаас хурдасны тархалт, гаршийн онцлогтой уялдуулан гүйцэтгэх бөгөөд геологийн нийлмэл тогтоц, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд торыг нягтруулан зохих шаардлага (Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:50,000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийх заавар, тавих шаардлага, 2010)-ыг хатуу мөрдөнө.

Цахирын хяр-50 төслийн талбайн хэмжээнд гүйцэтгэх геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг мөрдөж ирсэн заавар, шаардлагын дагуу гүйцэтгэн геологи, ашигт малтмалын болон холбогдох бусад зургуудыг зохиох, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийн үнэлгээг өгч, тэдгээрийн тайлбар бичгийг зохиож, анхдагч материалын сан бүрдүүлнэ.

3. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх үндсэн арга аргачлал ба дэс дараалал:

А.Бэлтгэл ажлын үе

4.1. Судалгааны ажлын төсөл, төсөв, календарьчилсан төлөвлөгөө зохионо.

4.2. Талбайн хэмжээнд өмнө нь хийсэн геологийн үе шатны судалгаа болон сэдэвчилсэн судалгааны материалуудыг бүрэн судлан танилцаж дүн шинжилгээ хийх, түүний үндсэн дээр тухайн талбайд тохирсон судалгааны арга аргачлалыг сонгоно. Үүнд:

- Өмнөх шатны судалгааны бүх төрлийн ажлын үр дүнг багтаасан мэдээллийн сан үүсгэх, мэдээллийг боловсруулан үнэлэлт, дүгнэлт өгч, өөрсдийн судалгааны ажлын суурийг бэлтгэх, арга аргачлал боловсруулах, баримтын зургийг зохиож бүртгэл үйлдэх,
- Өмнөх судалгааны материалд үндэслэн тухайн дүүргийн онцлогт тохирсон талбайн сорьцлолтын аргыг сонгож, тоо хэмжээг тооцох,
- Төслийн талбайн хэмжээнд мэдэгдэж байгаа ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, шлих, литогеохимийн сарнилын хүрээ, гажлуудыг бүртгэж, тэдгээрт дүн шинжилгээ хийх, хэтийн төлөвийн урьдчилсан зураг зохиох,
- Төслийн талбайн 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын шаардлага хангасан, өндөр нарийвчлалын агаар, сансрын болон 1:25 000, 1 :50 000-ны масштабтай байрзүйн зургуудыг холбогдох мэргэжлийн байгууллагаар бэлдүүлэх, АСЗ-т геологийн тайлал хийх, тухайн талбай хамрагдсан геофизикийн судалгааны (хүндийн хүчний, соронзон зураглал гэх мэт) материалуудтай танилцан, урьдчилсан тайлал, боловсруулалт хийх,
- Өмнөх шатны судалгааны материалууд болон АСЗ-т хийсэн урьдчилсан тайллыг ашиглан төслийн геологийн болон бусад холбогдох зургийг 1:50 000-ны масштабтаар зохиож, нэгдсэн таних тэмдэг зохиох,
- Хээрийн ажилд гарахын өмнө талбайн стратиграфи, магматизм, тектоникийн мэдээлэл, урьдчилсан тайлал хийсэн зургийн хүрээнд танилцах маршрут төлөвлөх, уг асуудлаар Монголын стратиграфийн комиссоос зөвлөгөө авч, хамтран ажиллах,
- Дээрх материалууд дээр үндэслэн цаашдын судалгааны ажлыг төлөвлөсөн байх,
- Хилийн болон тал, хээрийн бүсэд ажиллахтай холбоотой хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны бэлтгэлийг хангана.

4.3. Машин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон ажиллагсдын хөдөлмөр-ахуйн нөхцөлийг хангасан хээрийн судалгааны өмнөх бэлтгэлийг бүрэн хангана.

4.4. Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрөл (орон нутаг, хилийн бүс, тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах гэх мэт), бичиг баримтыг бүрдүүлнэ.

4.5. Хээрийн судалгааны шатанд зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгэх гэрээ, геологийн даалгавар, ажлын төсөл, төсөв болон холбогдох журам, зааврыг бүрдүүлэн бэлтгэнэ.

Б. Хээрийн ажлын үе:

4.6. Ажил эхлэхээс өмнө жил бүрийн хээрийн судалгааны ажлыг хэрхэн ямар хугацаанд гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөө (ажлын хөтөлбөр) зохиосон байна.

4.7. Судалгаанд хамрагдах талбайн хэмжээнд юуны түрүүнд танилцах маршрутыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Талбайд тархсан хурдас, чулуулаг, гүний биетүүдийн тогтоц, голлох бүрдүүлэгч чулуулгийн найрлага, тогтоц, онцлог, тэдгээрийн харьцаа, хил зааг, томоохон хувирал, өөрчлөлтийн бүсүүд, тасралтад эвдрэлүүд, органик үлдэгдэл тогтоогдсон цэгүүд, өмнөх судалгаануудаар тогтоосон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, бүх төрлийн гажлуудтай танилцаж, дүгнэлт гаргах, эдгээр геологийн биетүүдээс эталон дээж бүрдүүлэх, шаардлагатай бол урьдчилан дээжилж, сорьцлох,

- Талбайн сорьцлолтын урьдчилан боловсруулсан арга, аргачлалыг бодит байдал, орчин нөхцөл, ландшафтын онцлог, орчин үеийн хурдасны тархалт, гарал үүсэл, бүс нутгийн уур амьсгал зэрэгтэй уялдуулан нягталж, шаардлагатай бол туршилт аргачлалын сорьцлолт хийх, сорьцын тоог хучаас хурдсаар дарагдаагүй үндсэн чулуулгийн гарш бүхий нийт талбайд 1 кв.км-т >1 сорьц ноогдохоор тооцож, төлөвлөх,
- Маршрутын судалгаа, талбайн сорьцлолт эхэлж явуулах талбайг сонгох,
- Дээрх ажлуудыг гүйцэтгэхэд төслийн инженер техникийн ажилчид (ИТА), зөвлөхүүд бүгд оролцож, нэгдсэн дүгнэлт өгөх,
- Танилцах маршрутын үр дүнд тулгуурлан ажлын арга, аргачлалыг хянаж, шаардлагатай тохиолдолд заавар, шаардлагад нийцүүлэн зохих өөрчлөлтийг оруулан, хээрийн ажлын төлөвлөгөөг нарийвчилна.

В. Геологийн зураглалаар:

Геологийн зураглалын ажлыг ≤ 500 м-ийн торын нягтралтайгаар, чанарын шаардлага хангасан маршрутын судалгаагаар гүйцэтгэх бөгөөд доорх ажлуудыг хийж, асуудлыг шийднэ. Үүнд:

- АСЗ-ийг өргөн ашиглах, түүний тайллын үр дүнг газар дээр нь баталгаажуулан шалгаж, байнга засварлаж, нарийвчлал хийх,
- Урьдчилан зохиосон ажлын зурагт үнэлэлт дүгнэлт өгөх, шалган холбох маршрутыг шат дараатай явуулах,
- Төслийн талбайн хэмжээнд тархсан бүх төрлийн магмын болон хувирмал, тунамал, вулканоген хурдас, чулуулгийн тогтоц, найрлага, тархалт, хоорондын харьцаа, ялгааг тогтоох, литологи, структурыг нарийвчлан судалж төрөлжүүлэн зураглах, насны үндэслэлийг харьцуулалтын, палеонтологийн ба үнэмлэхүй насны шинжилгээгээр баталгаажуулах, тулгуур зүсэлтүүдийг хийх, нас, геохими, петрохимийн онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн дээж, сорьцыг арга, аргачлалын дагуу авах, шинжилгээ хийлгэх, боловсруулах ба урьдчилсан байдлаар ажлын геологийн зураг зохиож, тайлбар бичиглэл хийх, анхдагч баримт материалыг зааврын дагуу бүрдүүлэх,
- Хурдас чулуулгийн хил зааг, хоорондын харьцааг тогтоох, тэдгээрийн литологи, структурыг нарийвчлан зураглаж, формац, мэмбэр, бэд болон бүрдэл, фаз, фацийн түвшинд ялгах, шаардлагатай төрлийн сорьцлолтыг хийх, ингэхдээ дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байх. Үүнд:

1.Говийн тэнгэр уулын блок болон Цагаан уулын блокийн хил заагийг тогтоох, Г.Бадарчийн ялгаж байсан Хашаатын террейн байгаа эсэхийг тодотгох шаардлагатай. Ямар тектоникийн бүсэд "террейн" хамаарч байгааг тогтоох.

2. Геологийн 1:500000-ны масштабтай шинэ зурагт неопротерозой болон неопротерозой- кембрий, силур- девоноор зураглагдсан хурдасны насны үндэслэлийг тодруулж, зөөгдмөл циркониор үнэмлэхүй нас тогтоох болон палеогеографийн судалгаа хийх.

3.Офиолитын меланжийн нарийвчилсан судалгааг гүйцэтгэх.

4.Цэрд болон дөрөвдөгчөөр хучигдсан талбайн дунд хэсэгт эртний суурийн хэсэг цухуйц хэлбэрээр байдаг тул сансрын зургийн тайлал хийх болон зураглалын судалгааны үед анхаарч ажиллах.

5.Цохиот формацаас ургамал, Ордовикийн хурдаснаас амьтны үлдвэр тогтоогдсон тул сайн хадгалагдсан үлдвэрийг шинээр илрүүлэн тодорхойлж, формацын насыг нарийвчлан судлах.

6. Хараат бүрдэл нь сүүлийн судалгааны ажлаар карбоны настай болж байгааг цаашдын судалгаанд нарийвчилж, гарал үүслийг тодруулах.

- Төслийн талбайн литостратиграфийн ангиллыг “Монголын литостратиграфийн кодекс”-ийн дагуу шинэчлэн, ангилсан хурдаснуудыг хроно ба региональ стратиграфийн номенклатуртай харьцуулах, литостратиграфийн нэгжийн бичиглэлийг кодексийн дагуу үйлдэх,
- Төслийн талбайд гүний чулуулаг, дэл судлын биетүүдийн гарал үүсэл, ангилал, бүрдлийн фаз, фацийг тодруулах, петрохими, геохими, петрографийн ба металлогений онцлогийг тодорхойлох, биетүүдийн нарийвчилсан бичиглэлийг хийх, бүрдэл, дэл судлын чулуулгийн геохими онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн сорьцыг арга, аргачлалын дагуу авч, шинжилгээ хийлгэн, үр дүнг боловсруулах,
- Шаардлагатай тохиолдолд чулуулгийн үнэмлэхүй насыг тодорхойлуулах (тухайн гүний болон вулканоген, тунамал чулуулгийн онцлог, найрлага, гарал үүсэл, бусад онцлогийг бүрэн тодорхойлж, фаз, фацийн түвшинд зурагласан тохиолдолд энэ аргыг хэрэглэнэ),
- Талбайн сорьцлолтоор авсан литогеохимийн бүх сорьцод тоон шинжилгээ (ICP-MS) хийлгэж, үр дүнг боловсруулах,
- Орчин үеийн болон сэвсгэр хурдсыг гарал үүсэл, насаар нь нарийвчлан ангилж баталгаажуулах, тэдгээрийн зузаан, литологийн бүрэлдэхүүн, бусад шинжийг тодорхойлох,
- Төслийн талбайтай хил залгаа болон ойр хийгдсэн 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлуудын үр дүнтэй уялдуулах, харьцуулж шалгах,
- Талбайн тектоник-структурын бүтцийг нарийвчлан ангилж, тэдгээрийг бүрдүүлэгч хурдаснуудын формацын хамаарлыг тогтоон, нарийвчилсан бичиглэл хийх, тектоник-структурыг ашигт малтмалын тархалтын онцлогтой уялдуулан тайлбарлах,
- Геоморфологийн ажиглалт хийж, гадаргуугийн гарал үүсэл, хэлбэр дүрсийн төрлүүдээр ангилах, рельефийн хөгжлийн онцлог, үүссэн дарааллыг судалж зураглах, тайлах, ашигт малтмалын шороон хуримтлал үүсэх боломжтой нөхцөл бүрдсэн геоморфологийн элементүүдийг судалж тогтоох, морфоструктурын анализ хийх,
- Гидрогеологийн судалгаагаар тухайн талбайд байгаа худаг, булаг, шандыг координатжуулан, усны ундарга, түвшин бууралтыг хээрийн ажиглалтаар тогтоож, тухайн талбайн уст бүрдлийг төлөөлж чадахуйц уст цэгүүдээс гидрохимийн сорьц авч, шинжлүүлэх, уст бүрдлүүдийн онцлогийг тодруулах, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа хийх,
- Геоэкологийн судалгаагаар тухайн талбайд байгаа үржил шимт өнгөн хөрсний үеэс төрөлжилтийн сорьцолтыг холбогдох аргачлалын дагуу хийж химийн шинжилгээнд хамруулах, тоон үзүүлэлтийг тодруулах, өмнөх байгаль орчны чиглэлээр хийгдсэн судалгааны материалуудыг ашиглах, өөрсдийн судалгааны ажлаар тухайн талбай дахь геологийн ховор тогтоц (гео-өв), улаан номд орсон амьтан, ургамал, түүхийн дурсгалт зүйлсийн байршлыг координатжуулах, геоэкологийн зураг, экологи-геологийн суурь үнэлгээний зурагт тусгах зорилгоор судалгааны ажиглалтыг зураглалын маршрутын явцад хамт хийх, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа явуулах,
- Төслийн талбайн хэмжээнд шугаман тогтоцтой дислокацид автсан чулуулгийн эрдэслэг бүрэлдэхүүн, үнэмлэхүй нас, стрүктүрийг нарийвчлан зураглах. Үүнд:
 - S0, S1, S2..., Sn хавтгай элементүүд (фолэйшн), Sn+1 тэнхлэг хавтгайг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
 - B1, B2..., Bn атирааны нугаснуудыг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
 - L1, L2..., Ln линэйшнүүдийг төрөлжүүлэн (mineral, stretching, intersection) тодорхойлж зураглах, хэмжилт хийнэ.

Г. Эрлийн ажлаар:

Өмнө хийгдсэн төрөл бүрийн геологи, геохими, геофизикийн зэрэг судалгааны ажлын материал үр дүнг бүрэн гүйцэт ашиглах, хил залгаа улсын материалтай сайтар танилцан, цугласан материалд боловсруулалт, дүн шинжилгээ хийн, төслийн талбайн хэмжээнд тогтоогдсон эрлийн шинж тэмдэг, шалгууруудын үндсэн дээр эрлийн ажлыг ашигт малтмалын төрлийг харгалзан, арга, аргачлалыг оновчтой, үр дүнтэй байхаар сонгон төлөвлөн гүйцэтгэх;

- Өмнөх судалгаануудаар илэрсэн орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүдийг хээрийн судалгааны эхний жилд шалган, үр дүнг баталгаажуулах, хяналтын сорьцлолт хийх, ялангуяа өмнөх судлаачдын гидротермаль-метасоматит хувирал харьцангуй хүчтэй илэрсэн гэж зураглаж тэмдэглэсэн талбайнуудад гүйцэтгэх зураглал-ерөнхий эрлийн маршрутын явцад ашигт малтмалын талаар онцгой анхаарал хандуулах,
- Маршрутын судалгааны үр дүнд тогтоогдсон хувирал, эрдэсэжсэн бүс, биетүүдээс ашигт малтмалын шалгуур, шинж тэмдэг тэдгээрийн тоон агуулгыг тогтоох зорилгоор авсан дээж, сорьцуудын үр дүнг нэгтгэн боловсруулсны үндсэн дээр дараагийн шатны ажлыг төлөвлөн, гүйцэтгэх,
- Талбайн шлих, литогеохимийн сорьцлолтын ажлыг 1 кв.км талбайд >1 сорьц ноогдох байдлаар зохих заавар, аргачлалын дагуу зураглалын ажлаас түрүүлүүлэн гүйцэтгэж, тогтоогдсон хэтийн төлөв бүхий сарнилын хүрээ, гажлуудын торыг нягтруулан шалгаж, үнэлгээ өгөх, өмнөх судлаачдын илрүүлсэн церусситын шлихийн хүрээ, хар тугалга, хар тугалга-цайр-зэсийн геохимийн хүрээнүүдийн хэтийн төлөвийг нарийвчлах,
- Өмнөх судалгаагаар илэрч, тухайн ажлын явцад баталгаажсан болон төслийн ажлын судалгааны үр дүнд шинээр тогтоогдсон ашигт малтмалын хүдэржилт бүхий хэсгүүдээс ашигт малтмалын төрөл, онцлог, хэтийн төлөвтэй нь уялдуулан нарийвчилсан эрэл хийх талбайнуудыг сонгох,
- Сонгосон талбайнуудад ашигт малтмалын төрөл, онцлогтой уялдуулан нарийвчилсан эрлийн ажлыг 1:5 000 - 25 000-ны масштабаар, үе шаттайгаар, цогцолбороор гүйцэтгэх. Энэ ажлын хүрээнд дараах асуудлыг шалган шийдвэрлэх:

1. Геологийн 1:50000-ны масштабын зураглалын маршрутын үед ерөнхий эрлийн ажилд онцгой анхаарч, хувирал өөрчлөлт, ялангуяа ашигт малтмалын хүдэржилт байх боломжтой хувиралыг илрүүлж, судлахад анхаарч, дагалдах дээжлэлт, сорьцлолтыг гүйцэтгэх.

2. Цэрдийн хотгорууд тодорхой хэмжээгээр жалга судгаар хэрчигдсэн онцлогийг харгалзан төслийн бүх талбайг хамруулан 1:50000-ны масштабт тохирох шлих, геохимийн урсгал сарнилын хүрээний дээжлэлт хийх.

3. Наранбулгийн хүдрийн дүүргийн үргэлжлэлд илэрсэн эпитермаль гэж таамаглаж байгаа алтны VIII-20 илрэл, түүний орчинд орших алтны шлихийн цэгэн гажлуудыг хамруулан хэтийн төлөвтэй талбай ялган гадаргын нарийвчилсан эрэл хийх.

4. Өмнөх судлаачдын гүйцэтгэсэн агаарын геофизикийн 1:200000-ны масштабын цогцолбор судалгааны материалуудыг бүтээлчээр ашиглах.

5. Цахирын хяр-50 төслийн талбайн хойт талбайд Ш.Лхүндэв, Б.Дэлгэрэхтүмэн /2015, 7940ф/ нарын гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын ГЗЕЭА -ын тайлангаас Аргалантын хүдрийн потенциал зангилаанд илэрсэн вулканоген цул сульфидын зэс, кварцын судлын бүсийн зэс, алтны илрэлүүд, нүүрсний илрэлүүдэд тогтоосон эрлийн шалгуур, шинж тэмдгүүдийг судалсны үндсэн дээр Аргалантын хүдрийн потенциал талбайн үргэлжлэлд ижил төрлийн хүдэржилт илрүүлэх зорилгоор ашиглах.

6. Төслийн талбайн өмнөд хэсгийн Баруунцохиотын хүдрийн дүүргийн хэсэг нь алт, хар тугалга, алт-хар тугалга, хайлуур жоншны хэтийн төлөвтэй байх магадлалтай тул

талбайн урд захад Ц.Гүндсамбуу, Б.Даваасүрэн /2005, 5625ф/ нар болон Л.Бадамтулга нар /2005, 5626ф/-ын гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын ГЗЕЭА-ын тайлантай нарийвчлан танилцаж тэдгээрийн тогтоосон эрлийн шалгуур, шинж тэмдгүүдийг ашиглах.

7. Шинээр илрэх ашигт малтмалын хуримтлал бүхий талбайнуудын хэмжээнд нарийвчилсан эрэл хийх.

- Судалгааны талбайн хэмжээнд тогтоогдсон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүдийн талбай болон биетийн хэмжээ, байрлал, хүдрийн болон дагалдагч эрдсийн найрлага, бүрэлдэхүүн, хүдэржилт, тэдгээрийн хувирлын төрөл, түүний хэмжээ, онцлогийг нарийвчлан судалж, дагалдах дээжлэлт, сорьцлолт хийх, холбогдох шинжилгээг бүрэн хийлгэх,
- Ашигт малтмалын илрэл, эрдэсэжсэн цэгийг судлахын хамт талбайд тархсан хурдас, чулуулгийг эрдсийн түүхий эд болох талаас нь судлах,
- Ирээдүйн бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн бодлоготой уялдуулан зам, барилгын материалын түүхий эдийн судалгааг хийж, баялгийг үнэлнэ.

Д. Суурин боловсруулалт.

4.8. Завсрын суурин боловсруулалтаар:

- Хээрийн судалгааны явцад бүрдүүлсэн анхдагч баримт материалыг нэгтгэн боловсруулж, түүний үр дүнгээр баримт бүрдэл, геологи, шлих, геохимийн болон бусад холбогдох зургуудыг зохиох, бүх төрлийн дээж, сорьцын баримтжуулалтыг бүрдүүлэх, лабораторийн үр дүнгүүдийг зурагт буулгах, шаардлагатай тооцоолол, боловсруулалт хийж, дараагийн шатны ажлын төлөвлөлтөд ашиглах нөхцөл бүрдүүлэх,
- Хээрийн судалгаагаар шийдэж чадаагүй геологийн бүх асуудлыг шийдвэрлэх буюу дараагийн үе шатны ажлын үед шийдвэрлэх арга замыг сонгох, тодорхойлох, төлөвлөх,
- Төслийн хээрийн судалгаагаар талбайн тодорхой хэсэгт үүссэн зарчмын зөрүүтэй болон тодорхойгүй асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд дараагийн талбайд хээрийн ажлыг үргэлжлүүлэхийг хориглох,
- Судалгааны ажлын үр дүнд шаардлага хангасан мэдээлэлтэй болоогүй тохиолдолд түүнд дүн шинжилгээ хийж, тухайн асуудлыг шуурхай шийдвэрлэх арга замыг тодорхойлон шийдвэрлэх, ингэж чадаагүй тохиолдолд судалгааны арга аргачлалыг өөрчлүүлэх хүртэл саналыг тухайн үед нь захиалагчид хандаж, шуурхай шийдвэрлүүлнэ.

4.9. Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтаар:

- Мөрдөж буй заавар, шаардлагыг бүрэн хангасан анхдагч баримт, геологи, ашигт малтмал ба ашигт малтмалын тархалтын зүй тогтол, ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ, шлих болон литогеохимийн сорьцлолт, түүний үр дүнгийн зургуудыг 1:50 000-ны масштабтаар, тектоник, геоморфологи, гидрогеологи, геоэкологийн зургуудыг 1:100 000-200 000-ны масштабтаар, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий илрэл, эрлийн талбайн зургийг 1:1 000 - 25 000-ны масштабтаар тус тус зохиож, бусад төрөлжсөн зураг, бүдүүвч, график, хүснэгтийг хавсралтаар үйлдэх, зургууд нь УГА-ны Геомэдээллийн төвийн зурагт тавих шаардлагыг хангасан байх,
- Тухайн талбайн геологийн хөгжлийн түүхийг сэргээн босгохдоо О. Төмөртогоогийн тектоник-бүсчлэлийн, Г.Бадарчийн тектоно-стратиграфийн террейний болон Ж.Бямбын геодинамикийн ангиллаар төслийн талбай нь структур-тектоникийн ямар нэгжүүдэд хамаарч байгааг жишиж харьцуулж, дүгнэлт өгөх,

- Талбайн геологийн тогтоц, ашигт малтмалын гарал үүсэл, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, металлогений нөхцөлийг геодинамикийн хөгжилтэй уялдуулан дүгнэх,
- Төслийн талбайн ашигт малтмалын судалгааны үр дүнгээр хүдрийн талбай, потенциал талбайнуудыг шинээр ялгах,
- Талбайн хэмжээнд тогтоогдсон хэтийн төлөв бүхий ашигт малтмалын илрэлийн баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх,
- Төслийн ажлын үр дүнгээр төслийн талбайн хэтийн төлвийг А,Б,В,Г зэргээр үнэлэн цаашид хийх судалгааны ажлын чиглэлийг тодорхойлж, дараагийн шатанд нарийвчлан судлах талбайг ялган, дүгнэлт, зөвлөмж өгөх.
- Гидрогеологи, геоморфологи, геоэкологийн бүлгүүдийг өмнөх судалгааны ажил болон өөрсдийн ажлын үр дүнтэй уялдуулан тайлбарлах, дүгнэлт, зөвлөмж өгөх,
- Тайлангийн зургийг ArcGis программаар, бичвэрийг Times New Roman фондоор үйлдэх,
- Геофизикийн судалгааны ажлын үр дүнгээр зохиох ижил утгын зураг болон графикийг 1:25 000 -1 000-ны масштабаар Geosoft Oasis Montaj программаар боловсруулах,
- Тухайн судалгааны ажлаар болон өмнөх судалгаагаар хуримтлагдсан геологи, геофизик, геохимийн зэрэг холбогдох бусад материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийснээр судалгааны талбайн ерөнхий мэдээлэл, ажлын арга, аргачлал болон геологийн тогтоц, ашигт малтмал, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, гидрогеологи, геоморфологи, геоэкологи зэргийг тусгасан тайлангийн зураг, бичвэрийг зохиож, Монголын стратиграфийн комисс болон хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гаргуулан, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Захиалагчийн шийдвэрийг гаргуулна.

5. Ажил гүйцэтгэх хугацаа:

5.1. Төсөл, төсөв зохион батлуулах:

Эхний жилд: - Шууд гэрээгээр.

5.2. Хээрийн ажил:

Эхний жилд:	2026 оны 8-р сараас 10-р сарыг дуустал
Хоёр дахь жилд:	2027 оны 5-р сараас 10-р сарыг дуустал
Гурав дахь жилд:	2028 оны 5-р сараас 10-р сарыг дуустал.

5.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт:	2026 оны 11-12-р сар дуустал
	2027 оны 1-4-р сар, 11-12-р сар.
	2028 оны 1-4-р сар дуустал

Эцсийн суурин боловсруулалт: 2028 оны 11-р сараас 2029 оны 10 сар дуустал.

5.4. Үр дүнгийн тайланг МСК-оор хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсны дараа хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэн холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийж, геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албажуулан ирүүлэх:

2029 оны 11-р сарын 30.

5.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжээр хянуулж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт, засварыг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр албажуулан хүргүүлэх:

2029 оны 12-р сарын 30.

5.6. Тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох дүгнэлт, түүнд үндэслэн эрх бүхий байгууллагын шийдвэрийг гарсаны дараа Геологийн мэдээллийн төв архивд тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны
дараа ажлын 5 өдөрт

МОНГОЛ УЛС
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

БАТЛАВ: АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ДАШПҮРЭВ

2026 оны 03-р сарын 06-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2026/09

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН, АРХАНГАЙ АЙМГИЙН ХАШААТ,
ӨГИЙНУУР СУМДЫН НУТАГ ДЭВСГЭРТ 2026-2029 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
“1:25000-НЫ МАСШТАБЫН ГЕО-ОРЧНЫ СУДАЛГАА, ЭРЛИЙН АЖИЛ”
СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ГЕОЛОГИЙН ДААЛГАВАР

Судалгааны үе шат:	1:25000-ны масштабтай гео-орчны судалгаа, эрэл	
Судалгааны төрөл:	Сэдэвчилсэн судалгаа	
Судалгааны талбайн байршил:	Өвөрхангай аймгийн Хархорин сум, Архангай аймгийн Өгий нуур сум	
Талбайн хэмжээ:	4014.11 км ²	
Координат:	1	102° 30' 0.000" 47° 55' 0.000"
	2	103° 00' 0.000" 47° 55' 0.000"
	3	103° 00' 0.000" 47° 50' 0.000"
	4	103° 07' 30.000" 47° 50' 0.000"
	5	103° 07' 30.000" 47° 25' 0.000"
	6	103° 15' 0.000" 47° 25' 0.000"
	7	103° 15' 0.000" 47° 00' 0.000"
	8	102° 52' 30.000" 47° 00' 0.000"
	9	102° 52' 30.000" 47° 05' 0.000"
	10	102° 45' 0.000" 47° 05' 0.000"
	11	102° 45' 0.000" 47° 30' 0.000"
	12	102° 30' 0.000" 47° 30' 0.000"
Хавтгай	L-48-2-А,в,г -Б в,г,-В,-Г L-48-3-В,а,в L-48-14-А,-Б,-Г L-48-15-А,а,в-В,а,в,г L-48-26-Б,-Г,а,б,г L-48-27-А,-В	
Код:	Хархорин-25	
Төсөл хэрэгжих хугацаа	2026-2029	

1. Геологийн даалгавар боловсруулах хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ын 8.2.8, 4.2.24. “Шинэ-сэргэлтийн бодлого”-ын Хот хөдөөгийн сэргэлтийн хөтөлбөрийн 4.1.1, 4.1.5, 4.2.1-4.2.3, 4.3.1-4.3.3, Ногоон хөгжлийн сэргэлтийн хөтөлбөрийн 5.2.1, 5.4.1, “Ашигт малтмалын тухай” хуулийн 16 дугаар зүйл, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2, УИХурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ийн 3.5.2, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төсөл, төлөвлөгөө”.

2. Судалгааны ажлын үндэслэл:

Судлагдсан тувшин: ҮГА-ны баримтын төв архив дах судалгаа хийх талбай орчимд хийгдсэн геологийн судалгааны ажлуудын жагсаалт

№	Тайлан дугаар	Тайлангийн нэр	Гүйцэтгэсэн он
1	294	Дорнод, Хэнтий аймгуудын нутаг дэвсгэрт 1941 онд хийсэн 1:200 000-ны масштабын геологи-гидрогеологийн зураглалын ажлын тайлан. Байршил: L-49-VII, L-49-IV, V, L-50-VII	1941
2	395	Архангай, Өвөрхангай аймгийн нутаг дахь Өгий нуурын хотост хийсэн занарын эрэл, 1:500000, 1:200000-ны масштабын зураглалын ажлын үр дүнгийн урьдчилсан 1943 оны тайлан	1943
3	434	Өгий нуурын геологийн тогтоц, хотгорт 1944 онд гүйцэтгэсэн 1:200 000-ны масштабын геологийн зураглалын тайлан. Байршил: L-48-I-II, VII-VIII. (ГРЭ-ийн 47-р анги)	1944
4	436	Өвөрхангай, Ховд, Баян-Өлгий аймгийн нутагт хийсэн алтны эрэл, хайгуулын 1944 оны тайлан /38-р анги/	1944
5	1033	Өгий нуурын дүүрэгт 1943 онд гүйцэтгэсэн 1:200 000-ны геологийн зураглалын урьдчилсан тайлан	1943
6	1150	Өгий нуурын хотост (депрессия) хийсэн маршрутын судалгааны үр дүн /47-р анги/	1944
7	1585	Хархорины районд хийсэн тоосгоны шавар, шохойн чулууны эрлийн тайлан	1963
8	1716	Өвөрхангай аймагт хийсэн нүүрсний эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан /№340 анги/	1962
9	2034	Хангайн нурууны баруун өмнөт хэсэгт хийсэн 1:200000-ны масштабын геологийн зураглалын ажлын тайлан (L-48-VII, VIII). Хархорин №3 анги	1973
10	2215	Орхон ба Тарнайн голын сав газарт хийсэн 1:200000-ны масштабын геологийн зураглалын тайлан /L-48-14,15/ /Хашаат №3 анги/	1976
11	2432	Сэлэнгийн районд хийсэн 1:200000-ны масштабын агаарын геофизикийн судалгааны тайлан /геологийн даалгавар МГСЭ-29/	1984
12	2643	Архангай аймгийн Хашаат сумын төвийн инженер геологийн судалгааны дүгнэлт	1978
13	2668	Архангай аймгийн Өгий нуур сумын төвийн инженер геологийн судалгааны дүгнэлт	1978
14	2716	Төв, Архангай аймгуудад гүйцэтгэсэн нүүрсний эрлийн тайлан	1978
15	3172	Төв Монголын районд хийсэн 1:200000-ны масштабын агаарын соронзон зураглалын тайлан	1980

16	3384	Гоосгоны шаврын Хархорины ордын гүйцээх хайгуулын тайлан	1981
17	3454	1979-1980 онд Төв Монголд хийсэн 1:200000-ны масштабын агаарын соронзон зураглалын тайлан	1981
18	4135	Өгий нуурын районд хийсэн 1:200000-ны масштабын геологийн зураглалын ажлын үр дүнгийн тайлан. L-48-I, II Өгий нуурын 6-р анги	1987
19	4515	1987-88 онд явуулсан геофизикийн сэдэвчилсэн судалгааны үр дүнгийн тайлан	1989
20	4589	Дундговь аймгийн Сайхан-Овоо, Өвөрхангай аймгийн Онгийн голын район, Алтайн цаад говьд хийсэн нүүрс, битумын эрлийн тайлан	1990
21	4595	Өвөрхангай аймгийн Хөгшин гол, Дорноговь аймгийн Зүүнбаянгийн орчимд хийсэн битумжсан элсэн чулууны урьдчилсан хайгуулын тайлан	1990
22	4702	Төвийн районы 1:500000-ны масштабын гидрогеологийн зураг зохиох ажлын тайлан	1993
23	4772	Монголын шатдаг занар түүний хэтийн төлөв	1994
24	5091	Төв аймгийн Эрдэнэ, Өвөрхангайн Хархорины барилгын өнгөлгөөний чулуу, Налайхын элстэйн голын барилгын элсний ордын цацрагжилтын тайлан	1998
25	5190	Архангай аймгийн Хашаат сумын усан хангамжийн зориулалтаар 1998 онд явуулсан гидрогеологийн судалгааны ажлын тайлан	1998
26	5545	Өвөрхангай аймгийн Хархорин, Архангай аймгийн Хашаат, Хотонт сумдын нутагт 2001-2003 онд Хархорины ангийн хийсэн 1:50000-ны масштабтай зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил: L-48-26-А, Б, В, Г, 27-А, Б, В, Г	2004
27	5782	Архангай аймгийн Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Төвшрүүлэх, Цэнхэр сумдын нутагт Бор-Азаргын талбайн 2004-2006 онуудад гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил: L-48-1-А, Б, В, Г, L-48-2-А, В	2007
28	5862	Булган, Төв аймгийн нутаг дэвсгэр Төв монголын М-48-XXXI, XXXII L-48-I, II, III, IX, X, XI хавтгайн хэмжээнд 2005-2007 ондуудад зохиосон 1:200000-ны масштабын геологи, ашигт малтмал, дөрөвдөгчийн геологи, экологийн зураг зохиох ажлын үр дүнгийн тайлан	2008
29	6075	Архангай аймгийн Өгийнуур, Хашаат, Булган аймгийн Гурванбулаг, Могод сумдын нутаг Хангайн металлогений бүс нутаг дэх Бэрх уулын талбайд 2006-2009 онд явуулсан 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил: L-48-2-Б, Г, L-48-3-А, Б, В, Г	2009
30	6165	Архангай аймгийн Хашаат, Өгийнуур, Өвөрхангай аймгийн Хархорин Булган аймгийн Гурванбулаг сумдын нутагт 2006-2009 онд хийсэн Өгийнуурын 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан (L-48-15-AB)	2010
31	6320	Төв Монголын "УГЗ-200-III төсөл" 2007-2009 онд зохиосон 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг. М-48-XXV-XXVII L-48-VII-VIII L-48-XIII-XVI хавтгайн иж бүрдэл зураг	2011

Геологийн тогтоц: Талбайн хэмжээнд ангилагдаагүй силурын Яшил формац, ангилагдаагүй силурын Мөнгөнцээж формац, силурын Хотонт формац, девоны доод-дунд серийн Бэрх-Уул, Ханхар ба Хүрэнтогой формац, дунд-дээд серийн Улаан-Овоо формац, дээд серийн Цүүгэл формац, карбоны миссисип серийн турне стейжийн ангилагдаагүй хурдас, миссисип серийн Өрмөгтэй-Уул формац, Билүүт, Жонштолгой болон Холбоотолгой формацууд, миссисип-пенсильван серийн Артээлийнгол формац, пенсильван серийн Бугат Уул формац, пермийн сизурал серийн Өгийнуур формац, юрын дээд серийн Жарантай формац, доод цэрдийн доод серийн готерив-баррем стейжийн түвшинд ялгасан хоер мэмбэртэй Хөгшингол формац, түүний дээр Зүүнбулаг формац, аптальб стейжийн Архангай формац, палеогены олигоцен серийн Цайдам группын дээд хэсэг

Атар формац, миоцены сайрт болон Цуцахаа нэртэй хоёр мэмбэртэй Баянхошуу формац, Плиоцены шавар, Миоцены болон дөрөвдөгчийн базальтыг зурагласан байна.

Төслийн талбай нь П.Хосбаяр нар /1987, 4135ф/ болон Д.Баадай нар /1974, 2215ф/-ын гүйцэтгэсэн 1:200000-ны ГЗЕЭА-ын талбайд бүрэн хамрагддаг бөгөөд L-48-2-А,В талбайд Б.Дэлгэрэхтүмэн нар /2007, 5782ф/, Боразарга-50, -L-48-2-Б,Г болон 3-АБВГ талбайд Б.Батором нар /2009, 6075ф/, Бэрх уул-50, -L-48-14-А,Б,В,Г, 15-А,В талбайд Ч.Төмөрчөдөр нар /2010, 6165ф/, Өгий нуур-50, -L-48-26-А,Б,В,Г, 27-А,В талбайд А.Баатархуяг нар /2004, 5545ф/-ын Хархорин-50 төслөөр гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай ГЗЕЭА-аар бүрэн бүрхэгдсэн байна.

Дээр дурдсан судалгааны ажлуудыг өөр өөр цаг хугацаанд гүйцэтгэсэн тул тектоникийн бүсчлэл, геологийн формац, бүрдлүүдийн нэршил, насны хамаарал нь зөрүүтэй байна. Тухайлбал:

- Хангай-Хэнтийн атираат мегабүсэд А.Баатархуяг нар /2004/ 2004 онд Монгол-Агнуурын далайн бассейн гэж үзсэн байхад уг төслийн хойт талаас залган төсөл хэрэгжүүлсэн ба Ч.Төмөрчөдөр нар /2010/ 2010 онд Хархорин террейн, түүний зүүн талд Тарна террейн гэж үзсэн байна. Ч.Төмөрчөдөр нар /2010/ -ын Хархорин террейн ангийн Хотонт формацын урд үргэлжлэлийг А.Баатархуяг нар /2004/ доод-дунд девоны Эрдэнэцогт формацын доод ба дээд мэмбэрийг, Ч.Төмөрчөдөр нар /2010/ -ын Хархорин террейн ялгасан Мөнгөнчээж болон Яшил формацууд, мөн Тарна террейн ангийн доод-дунд девоны Хүрэнтолгой формацын үргэлжлэлийг А.Баатархуяг нар /2004/ доод-дунд девоны Эрдэнэцогт формацын дунд мэмбэр үргэлжилж байгаагаар тус тус зурагласан байна.

- Б.Батором нар /2009/ L-48-2-Г, L-48-3-В,Г хавтгайн өмнө хэсэгт цайвар ногоон кварцит, цайвар саарал элсжингийн тэмдэгт үеүдтэй хар саарал алевролит, бор ногоон элсжин, алевроэлсжингийн салаавчлалаас тогтох бөгөөд доод карбоны флор агуулсан Холбоотолгой формацын хурдсыг өргөн тархалттайгаар зурагласан байхад Ч.Төмөрчөдөр нар /2010/ урд үргэлжлэлийг нь доод нарийн үеллэг флишоид мэмбэр болон дээд элсжин-алевролит мэмбэрээс тогтох дээд девоны Цүүгэл формацад ангилан зурагласан бөгөөд хил зааг зөрсөн байна.

- А.Баатархуяг нар /2004/ын ангилсан Баянхошуу формацын доод терриген (N_1bh_1), дээд базальт мэмбэр (N_1bh_2) -ийн хойд үргэлжлэлд Ч.Төмөрчөдөр нар /2010/ доод цэрдийн Архангай формацын (K_1ah) терриген-тунамал болон трахиандезитбазальт, трахибазальт, хааяа тэдгээрийн туфээс тогтох доод цэрдийн Батцэнгэл (K_1bt) формацаар зурагласан.

- Ч.Төмөрчөдөр нар /2010/ -ын L-48-14-А хавтгайн БХ буланд доод цэрдийн Архангай (K_1ah) терриген-тунамал формацын хурдас ялгасан байхад Б.Дэлгэрэхтүмэн нар /2007/ L-48-2-В хавтгайд уг формац үргэлжлээгүй, дан ганц дунд-дээд ордовикийн Мөнгөнчээж формацын хурдас тархсанаар зурагласан байна.

- “Хархорин-25” төслийн талбайн гадна баруун талд L-48-I хавтгайд ШУА-н ГХ-н Т.Оюунчимэг нар /2022/ Хархорин террейн Мөнгөнчээж формацын элсжингийн зөөгдмөл цирконд U-Pb аргаар 368.8 ± 3.2 сая жил нас тогтоогоод Мөнгөнчээж формацын силурын базальт-төмөрт кварцитын хавчуургуудыг агуулсан терриген хурдас нь дээд девоны настай байх магадлалтайг тогтоон насыг нь силур-дээд девон, харин дунд девоны кварцитын хавчуурга бүхий Яшил формацын элсжингийн зөөгдмөл цирконд U-Pb аргаар 367.9 ± 3.2 сая жил нас тогтоон түүнийг дээд девоны цаг үед хуримталсан тул Мөнгөнчээж формацтай нэгтгэх нь зүйтэйг зөвлөсөн байна.

- УГЗ-200 /2008/ иж бүрдлийн геологийн зурагт Мөнгөнчээж формацын доод мэмбэрт метаэлсжингийн үетэй хар ногоон, хар өнгөтэй кварц-хлорит-серициттэт, кварц-эпидот-серициттэт, биотит-кварц-хлоритот, хлорит-эпидот-актинолитот занараас тогтох доод мэмбэрийг ангилсан байгаа ба түүний найрлага нь Ч.Төмөрчөдөр нар /2010/-ын дунд ордовик-силурт ангилсан Хотонт формацтай дүйж байна.

• ШУА-ийн ГХ-ийн Д.Эрдэнэчимэг нар /2022/ “Хархорин-25” төслийн талбайн зүүн талд улаан хүрэн хасын хавчуурга агуулсан Хүрэнтолгой формацын элсжингийн зөөгдмөл цирконд U-Pb аргаар 333.6+-1.1 сая жил нас тогтоон улаан хасын хавчуургууд агуулсан терриген хурдсын насны дээд хязгаарыг доод карбонд, Д.Шарав нар /2022/ төслийн талбайд Хашаат сумын нутагт орших хүрэн хасад дунд девоны эйфель-живет стейжийн радиолярууд тодорхойлсноор Хүрэнтолгойн хурдсын насыг дунд девон-доод карбон (D₂-C_{1ht})-д хамруулахыг тус тус зөвлөсөн. Хүрэнтолгой формацыг нийцлэг хучдаг, мөн хагарлаар хиллэдэг Цүүгэл формацын хувьд “Хархорин-25” төслийн гадна, зүүн талд 1:200000-ны ГЗЕЭА-аар /Д.Баадай нар, 1976, 2215ф/, Б.Бямба нар /1974, 2040ф/ доод карбоны Өрмөгтэй формацад, Ч.Алтанзул нар /2005, 5602ф/ дунд-дээд девоны Шарт формацад, Ч.Төмөрчөдөр нар /2006, 5650ф/ флорын тодорхойлолтод үндэслэн дээд девоны Цүүгэл формацад тус тус хамруулсан байдаг. Ч.Төмөрчөдөр нар /2010/ “Хархорин-25” төслийн талбайд дээд девоны Цүүгэл формацыг багаахан талбайд тархсан гэж зурагласан бөгөөд түүний хойд шууд үргэлжлэлд Б.Батором нар /2009, 6075ф/ флорын тодорхойлолтоор доод карбонд хамрах Холбоотолгой формацыг зурагласан байна.

• Монгол Улсын 1:500000-ны масштабын геологийн зураг /2017/ зохиогчид өмнөх судалгааны ажлуудыг нэгтгэн, хил зааг, формацын хамаарлыг нийцүүлэн ялгаж зураг зохиосон. Гэвч сүүлийн жилүүдэд эрдэм шинжилгээ судалгааны ажлаар зарим формацын нас өөрчлөгдсөн байна. Мөн уг зургийг ч туйлын үнэн гэж ойлгож болохгүй бөгөөд зөрүүтэй, шийдвэрлэх асуудлууд байсаар байна. Ж: Энэ зурагт Б.Батором нар /2009/-ын доод карбоны Холбоотолгой формацыг өмнө талд нь Ч.Төмөрчөдөр нарын дээд девонд ангилсан Цүүгэл формацтай нэгтгэн насыг нь дээд девон-доод карбонд хамруулсан байдаг.

• Интрузив массивуудын хувьд Б.Дэлгэрэхтүмэн нар /2007/ Орхон, Тамир голуудын уулзвар орчимд Мөнгөнчээж формацыг зүссэн гранитын штокийг дунд пермийн Тарвагатай бүрдэлд хамруулсан байдаг. Уг штокоос БУ 8.5 кмт орших гранитын штокийн цирконд (102°30'19" -47°38'54") В.Ярмолук нар (2010) U-Pb аргаар 247 сая жил буюу түрүү триасын нас тогтоосон байдаг тул түүний насыг нь үнэмлэхүй аргаар баталгаажуулах шаардлагатай.

• Ч.Төмөрчөдөр нар (2010, 6165ф) -ын дээд силурын Зэгэст бүрдэл гэж ялгасан диорит давамгайлсан массивын цирконд В.Ярмолук нар /2013/ U-Pb аргаар 218 сая жил нас тогтоосон нь дээд триасийн үед хамаарч байна.

• L-48-26-Г хавтгайд зурагласан гранодиорит-гранитаас тогтох Мойлтын массивыг А.Баатархуяг нар /2004, 5545ф/ хожуу пермийн Хангай бүрдэлд ангилсан бөгөөд уг массивын гранитын цирконд (102°46' 29" -47° 00' 56") В.Ярмолук нар (2010) U-Pb аргаар 228 сая жил нас тогтоосон бөгөөд уг массив W, Sn, Bi, Y, Nb -ийн геохимийн төрөлжилттэй нь түүнийг хожуу триас-түрүү юрийн Эгийн даваа бүрдэлд хамааруулах үндэслэл болно.

• Интрузив массив, штокуудад шинээр тогтоогдсон үнэмлэхүй насыг Монгол Улсын геологийн 1:500000-ны масштабын зурагт бүрэн тусгагдаагүй байна.

Ашигт малтмал: Төслийн талбай нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн металлогений зураг (2000 он), УГЗ-200 иж бүрдлийн L-48-I ба II хавтгайн ашигт малтмалын зураг, минерагений дүүрэгчлэлээр Тамир голын хагарлаас хойш Баянголын минерагений бүс, түүнээс урагш Хархорины минерагений бүсэд, төслийн талбайн БУ өнцөг нь Хангайн минерагений бүсэд тус тус хамаарна.

• Баянголын бүсэд Орхон голын уртрагийн чиглэлтэй хэсгийн баруун талд Жаргалант-Бодонтын голын хүдрийн дүүрэг, түүний Жаргалант-Хөнөгийн хүдрийн потенциал зангилаа, уг голоос зүүн талд нь Могод-Хишигөндөр-Бүрэгхангайн хүдрийн потенциал дүүрэг, түүний Харбухын голын хүдрийн потенциал зангилаа тус тус оршино.

• Хархорины бүсэд Тамир-Орхоны төмрийн хүдрийн дүүрэг, түүний Тамирын голын хүдрийн зангилааны хэсэг, түүнээс зүүн тийш Тамир-Орхоны бэлчирийн хүдрийн дүүргийн Хөгшин голын төмөр-мангаан-/алтны/-битум-шатдаг занарын хүдрийн потенциал зангилаа тус тус оршдог.

• Хангайн минерагений бүсэд хамаарах төслийн талбайн БУ захад Хужирт-Өлзийтийн ховор металл-/алтны/-битум-шатдаг занарын хүдрийн дүүргийн Хужиртын хүдрийн зангилаа болон Хотонтын хүдрийн дүүргийн Хотонтын хүдрийн зангилааны хэсгүүд тус тус оршдог.

• Хархорин-25” төслийн талбайн БУ хэсэгт Хангайн минерагений бүсийн болон Хархорины минерагений бүсийн заагаар Орхон-Тамирын мезозой-кайнозойн хотгорын урд, зүүн урд захаар шатдаг занар, битум агуулсан доод цэрдийн Зүүнбулаг болон Хужирт формацын терриген-тунамал хурдсын гаршууд, мөн Хархорины бүсийн Хашаат-Гурванбулагийн хүдрийн потенциал дүүрэгт Улаанбаатар-Арвайхээрийн засмал замын урд талаар битум агуулсан доод цэрдийн хурдас илэрдэг нь Орхон-Тамирын бэлчирийн мезозой-кайнозойн хотгорын гүнд шатдаг занар, магадгүй газрын тосны хуримтлал байх боломжтой гэж үзэхэд хүргэж байна. Иймд тус хотгорын гүний тогтоц, тухайлбал түүнийг дүүргэгч юра?, цэрд, палеоген, неоген, дөрөвдөгчийн хурдсын хоорондын хил зааг, зузаан, ул хурдас чулуугийн байрлах гүн, гадаргын рельеф зэргийг геофизикийн аргаар судлан, тааламжтой бүтэц, тогтоц илэрвэл шалгах шаардлагатай.

• Мөнгөнчээж формацын кварцитын хавчуурга нь магнетит, магнетит-гематит, гематит болон төмөр-мангаан, мангааны хүдэржилт агуулдаг бөгөөд төслийн талбайд төмөр, төмөр-мангаан, мангааны хүдэржилт агуулсан кварцитаас тогтох илрэл, эрдэсжсэн цэгүүд бөөгнөрсөн Овоот хөтлийн эрлийн хэсгийг (II-58, II-67, IV-140 гэх мэт илэрлүүд) хамруулан Овоот толгой -21882 хайгуулын тусгай зөвшөөрлийг 2021 онд “ММС майнинг” ХХК авч эрэл, хайгуул хийж байна. Мөнгөнчээж формацын тархалтын талбайд магнетитын жингийн агуулгатай шлихийн хүрээ, цэгэн гажлууд илэрдэг бөгөөд төмөр, төмөр-мангаан кварцитын илрэл, эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон нь уг формацын хурдас төмрийн хүдэржилтийн хувьд хэтийн төлөвтэйг харуулдаг. Хайгуулын тусгай зөвшөөрлийн гадна, Мөнгөнчээж формацын талбайд шинээр илрэх болон өмнөх судлаачдын илрүүлсэн илрэл, эрдэсжсэн цэгүүдийн хэтийн төлөвийг тодруулахад анхаарал хандуулахнт зүйтэй. Ч.Төмөрчөдөр нар /2010/-ын илрүүлэн 570 000 т төмрийн баялаг тооцоолсон хэтийн төлөвтэй Чулуутын эрлийн хэсэг хайгуулын тусгай зөвшөөрлийн гадна оршиж байна.

• Мөнгөнчээж формацын хурдас нь төмөр, төмөр-мангааны хүдэржилтээс гадна цул сульфидын зэс-цайр-алтны хүдэржилтийн хувьд хэтийн төлөвтэй байх магадлалтайг Ч.Төмөрчөдөр нар /2010/ Зүрх толгойн эрлийн хэсэгт тогтоож, нарийвчилсан эрэл хийсэн. Эрлээр 60-80 м өргөн, 5000 м урт милонитжсан, ЗХ чигт 40-70 хэмийн өнцгөөр унасан бүсд сульфидын эрдэсжилтэй хлорит-актинолит-серицитэт занарт хувирсан базальтын мэшлүүд, серпентинитжсэн гипербазит, төмрийн хүдэржилттэй кварцитын мэшил зэргийг илрүүлсэн. Хагарлын бүсэд байршсан Илрэл VI-196-ийн геологийн тогтоц нь төмрийн усан ислүүдээр түрэгдсэн халькопирит, пиритын шигтгээтэй, термолитжиж, талькжсан базальтаас үүссэн занар тархсан байна. Илрэлийн Зүрх толгойн талбайн жалга, судгуудаас авсан шлихийн болон литогеохимийн сорьцлолтоор киноварь, алтны шлихийн, Cu, Pb, As, Ba, Zn-н геохимийн сарнилын хүрээ, цэгэн гажлууд, 8 ховилон сорьцонд зэс 0.02-0.015%, цайр 0.02-0.015% агуулгатай нь тогтоогдсон тул зэс-цайр-алтны хэтийн төлөвтэй гэж үзсэн. Төмрийн гэж үзсэн VI-204 илрэлд элювийн хэмхдэс байдлаар 5-20 х 50-60 м талбайд магнетитын үеллэг хүдрийн хэмхдсүүд илэрсэн ба эндээс авсан 1 сорьцод зэс-0.015%, цайр-0.01%, суналын дагууд багц үеийн хойд төгсгөлд 10-20x100 м хэмжээтэй лимонитжсан базитаас авсан геохимийн 3 сорьц, 2.5-3x 40 м кварцитаас авсан 1 сорьцод алт 0.3-0.7г/т илэрсэн нь төмрийн хүдэржилтийг нь исэлдсэн төмөр малгай байх боломжтойг харуулдаг.

• Хархорины бүсийн Хашаат-Гурванбулагийн хүдрийн потенциал талбайд Б.Батром нар (2009)-ын ангилсан доод карбоны Холбоотолгой, Ч.Төмөрчөдөр нар (2010) -ын ангилсан дээд девоны Цүүгэл /?/, доод карбоны Билүүт формацын хурдсын талбайд механик-тунамал гаралтай (эртний тэнгисийн эргийн шижирмэг) магнетит агуулсан элсэн чулууны үе, хэвтэшүүд илрэх шууд шинж тэмдэг тогтоогдсон байгааг хэгийн төлөв талаас нь нарийвчлан судлах шаардлагатай. “Хархорин-25” төслийн талбайн гадна, зүүн талд нь Төмөрчөдөр нар /2010/ 47° 40' 06"-103° 08' 25" солбицлолд, дээд девоны Цүүгэл/?/

формацад хамруулсан том ширхэгт, ногоон саарал элсжин дотор 0.8-1 м өргөн бүсэд 1-2 см зузаантай магнетитын үенцэрүүд агуулагдсан төмрийн III-70 илрэлээс авсан геохимийн I сорьцод Ti-0.5%, Zn-0.1%, Cu-0.01%, Zr-0.07%, XIII-р Fe₂O₃-39.44%, FeO-4.1% илэрсэн. Мөн төслийн талбай дотор 47°39'09"–102°55'56", 47°38'57"–102° 56'01" цэгүүдэд (э/ц II-16) элсжин дотор магнетит агуулсан хэдэн метр урттай үеүд тэмдэглэгдсэн ба I сорьцод нийлбэр агуулгаар Fe-43.6% тогтоогдсон нь механик тунамал магнетитын эртний шижиर्मэг илрэх эрлийн шууд шинж тэмдэгүүд байгааг харуулдаг.

• Хашаат-Гурванбулагийн хүдрийн потенциал талбайд, Билүүт уулын орчимд доод карбоны Билүүт формацын терриген хурдсыг өргөрөгийн дагуу сунасан, зэрэгцээ байрлалтай хэд хэдэн хагарал зүссэн бүсэд Ч.Төмөрчөдөр нар /2010/ алтны илрэл, эрдэжсэн цэг, алтны шлихийн цэгэн гажлуудыг олон тоогоор илрүүлсэн. Хагарлууд дагасан, пиритжилт, лимонитжилтын 200-300 м өргөн бүс дотор захаараа лимонитжсан пирит агуулсан, 0.2-0.5 м зузаан, хэдэн зуун метр урт кварцын шаталсан судал судланцарын 18-20 биет байршсан байна. Эдгээрээс авсан 25 цэглэн, 11 геохимийн сорьцоос алтны 7(илрэл 48, э/ц 14,17,21,22,73,76,) хүнцэлийн 3 эрдэжсэн цэг (5,86,112) тэмдэглэгдсэн байна.

• Ч.Төмөрчөдөр нар /2010/ -ын 1680 м өндөртэй Өндөр нурамт уулын оройгоос хойш, ЗХ I -3 км-ийн зайд хувирсан бүс, кварцын судлуудтай холбоотой алтны V-160 илрэл, V-158, V-161, V-162, V-154, V-156 эрдэжсэн цэгүүд, мөн шлихийн цөөн цэгэн гажил тогтоосон. V-160 илрэлд ЗХ сунасан 3-4 м өргөн, 100 м урт хэсэгт агуулагч занар хүчтэй лимонитжсан ба 0.2 см хүрэх кварцын хэмхдсүүд, мөн 0.2-0.3x60 м кварцын судлаас авсан тус бүр I геохимийн сорьцод алт 1.5г/т ба 2г/т тогтоогдсон. Эрдэжсэн цэг V-158-н ЗХ сунасан 0.1-0.15 x2 м цагаан шаргал судалд алт-0.5г/т, V-162-н БХ сунасан 3x100-120 м хэмжээтэй занаржиж, лимонитжсан бүсээс авсан 3 сорьцод алт 0.05, 0.2, 0.15г/т, V-161-н кварцын судланцараар хэрчигдсэн кварцитаас авсан 2 сорьцод алт-0,2г/т, V-154-н гранит-аплитын дэлийг сунал дагуу нь зүссэн 5-8 см x4 м кварцын судланцарт Au-0.5г/т, Ag-0.3г/т, Pb-0.02%, Bi-0.005%, V-156-н занар нь БХ сунасан, хүчтэй лимонитжсан 10-15x150 м бүс агуулсан ба геохимийн 2 сорьцод алт 0.1г/т илэрсэн байгаа нь цаашид томоохон бүсүүдийг сувгаар нээж ховилон болон цэглэн сорьцлолт хийж, хэтийн төлөвийг үнэлэх шаардлагатайг харуулж байна.

• Баянголын бүсийн Могод-Хишигөндөр-Бүрэгхангайн хүдрийн потенциал дүүргийн Харбухын голын хүдрийн потенциал зангилаанд, Тамир голын гүний хагарлын хойд талд, Б.Батором нар (2009) илрүүлсэн ба доод карбоны Өрмөгтэй, доод-дээд карбоны Артээл формацын терриген хурдсуудыг зүссэн, мөн төслийн ажлаар шинээр илрэх кварцын судал, судал-судланцарын бүстэй холбоотой алтны илрэл, цэгүүдийн хэтийн төлөвийг тодруулах шаардлагатай. Төслийн талбайн ЗХ буланд, Тамир голын хагаралд шахан, өргөрөг дагуу сунасан байрлах Баясгалант ууланд Б.Батром нар (2009)-н илрүүлсэн эпитеpmаль алт-мөнгөний илрэл, эрдэжсэн цэгүүдийг хамруулан “Тоталмаркетинг эйженси” ХХК Баясгалант уул-22657 хайгуулын тусгай зөвшөөрлийг 2023 онд авч эрэл, хайгуул хийж байна.

• “Хархорин-25” төслийн талбайн БУ захад оршиж байгаа Хангайн минерагений бүсийн хэмжээнд А.Баатархуяг нар /2004/ хожуу пермийн гэж үзсэн, сүүлийн үеийн судлаачдын үнэмлэхүй насны тодорхойлолтоор хожуу триасын нас /228 сая жил/ тогтоогдсон гранодиорит-гранитын массивын ЗХ гадаад заагаар, гранодиорит, гранитын жижиг шток, дэл судлууд болон агуулагч доод-дунд девоны Эрдэнэцогт формацын хурдас дотор алт-висмут, алт-вольфрам-висмут, цайр-висмут, зэс-висмут, висмутын, зэс-висмут-мөнгөний илрэл, эрдэжсэн цэгүүд тогтоосон. Энэхүү Мойлтын массив нь региональ геохимийн зураглалаар W, Sn, Mo, Y, Nb, Bi, U, Th, Rb, Cs зэрэг ховор, цацраг идэвхит элементийн геохимийн төрөлжилттэй болох нь илэрсэн. Ийм геохимийн төрөлжилттэй интрузив нь бие даасан үйлдвэрлэлийн ач холбогдолгүй ч алтны шижиर्मэгийн эх үүсвэр болж чаддаг алт-шеелит-висмутин, алт-шеелит, алт-висмутын хүдэржилттэй цэгүүд тогтоогддог нь дэлхийн хэмжээнд, ялангуяа хөрш ОХУ-ын нутагт тогтоогдсон байдаг. А.Баатархуяг нар /2004/ шлихийн зураглалаар энэхүү массивын хэмжээнд шеелит, монацит,

монацит-касситерит, шеелит-касситерит-вольфрамитын баян, алтны ядуу шлихийн сарнилын хүрэнүүд тогтоосон байдгаас “Хархорин-25” төслийн талбайн БУ буланд, Хужирт-Өлзийтийн хүдрийн дүүргийн Хужиртын хүдрийн талбайд монацитын “52-mz” , алтны 1-3 тэмдэгт агуулсан “30-au” шлихийн урсгал гажлууд, Хотонтын хүдрийн дүүргийн ба Хотонтын хүдрийн зангилаа байрлах хэсгийн Өндөр Арцатын алтны хүдрийн потенциал талбайд, Орхон голын баруун нэг цутгалын доод хэсэгт алтны шижирмэг 26-Г-55 илрэл, “1-au” шлихийн хүрээ, Өндөр Арцатын алтны бүлэг илрэл, эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон.

• Төслийн талбайд социализмын үед хайгуул хийсэн Цагаантолгойн галт уулын шаарга, Хотонтын шавар, Хар хорины шавар, өнгөлгөөний чулууны Хархорины гранодиоритын орд, мөн Цайдам нуурын байгалийн буулт (соод)-ын ордууд оршдог. 1:200000 болон 1:50000-ны ГЗЕЭА-аар барилгын материалын илрэлүүдийг нэмж илрүүлсэн байна. Ж: Ч.Төмөрчөдөр нар /2010/ тоосгоны шаврын Нарийн гол, Хашаатын илрэл, Д.Баадай нар /1974/ Долоон голын шаврын илрэл, П.Хосбаяр нар /1974/ илрүүлж, Ч.Төмөрчөдөр нар /2010/ баталгаажуулсан ба барилгын шавардлагад ашиглах боломжтой элсний Манхан овооны элс, П.Хосбаяр нар /1974/ илрүүлж, Б.Батором нар /2009/-н баталгаажуулсан Баясгалантын элсэн чулуу, Мэргэншандын шаврын илрэлүүд оршдог.

Эдийн засаг дэд бүтэц:

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, түүх, соёл, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Орхоны хөндийд "Хархорум" хотыг байгуулах тухай 2023 оны 01 сарын 12 өдрийн Монгол Улсын Их Хурлын тогтоол гарсан. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Шинэ Хархорум" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай доорх судалгааны ажлууд хийгдэж байна. Үүнд:

1. Инженер-геологийн судалгааны эхний ээлжийн ажил /Архангай, Өвөрхангай/
2. Байрзүйн зураг зохиох эхний ээлжийн ажил /Архангай, Өвөрхангай/
3. Байр зүйн зураг зохиох, ортофото зураг үүсгэх ажил /Архангай, Өвөрхангай/
4. Археологийн хайгуул судалгааны ажил
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх
6. Инженерийн дэд бүтцийн эх үүсвэр тодорхойлох ТЭЗҮ боловсруулах
7. Нисэх буудлын ТЭЗҮ, зураг төсөл /Өвөрхангай, Хархорин сум/

Судалгааны ажлын үндэслэл:

Төслийн талбайн хүрээнд геологи, геохими, геофизик, геоморфологи, гидрогеологи, геоэкологи, инженер-геологи, гео-дурсгал (geoheritage), геогамшигийн өнөөгийн суурь нөхцөл байдлыг судлан тогтоож, байгалийн болон хүний хүчин зүйлийн хувьсал өөрчлөлтийн чиг, эрчимийг судлах, төвлөрсөн хот суурин байгуулахтай холбоотой дэд бүтэц, барилгын бүтээн байгуулалтад шаардагдах түүхий эдийн судалгаа хийж үнэлгээ өгөх, геотермийн потенциалыг үнэлж, ирээдүйн хот төлөвлөлтөд анхаарах зөвлөмж, дүгнэлт боловсруулж, Хархорин хотын ирээдүйн иргэдийн амьдралын чанар, тав тухтай орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хотын урт хугацааны стратеги бодлого төлөвлөлтийг суурь судалгааг хийж, Монголын геологийн салбарт хотын геологи (urban geology)-ийн судалгааг хөгжүүлэх суурь нөхцөлийг бий болгох мэргэжлийн зөвлөмж гаргахад оршино.

3. Ажлын зорилго:

Хархорин-25 төслийн талбайд хамрагдсан нутаг дэвсгэрийн хэмжээнд өмнөх судалгааны ажлуудаар хийгдсэн зорилтот судалгааны материалуудыг Үндэсний геологийн алба (ҮГА)-тай зөвшилцөн, шаардлагатай тохиолдол мэдээлэл нууцлалын гэрээн дор бүрдүүлэн дүн шинжилгээ хийж, шинээр болон өргөжүүлэн хөгжүүлэхээр төлөвлөгдсөн хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд өнөөгийн байдлаар геологийн суурь судалгаа ямар

байгаа цаашид хот төлөвлөлтөнд геологи орчин, геогамшиг, усан хангамж, бүтээн байгуулалтын төлөвлөлт хийгдэхэд ашиглагдах суурь судалгааг хийж мэдээлэл боловсруулж, геосистемд нөлөөлөх байгалийн болон антропоген (байгалийн бус гаралтай) хүчин зүйл, хүрээлэн буй орчны хувьсал өөрчлөлтүүдийг судалгааны гол объект болгон улмаар газрын гадаргуугийн хөгжлийн ойрын болон хэтийн төлөвийг тодорхойлж, геологи, геофизик, гео-экологи, гидрогеологи, геохимийн судалгааг явуулж цогц үнэлгээ өгөхөд энэхүү төслийн гол зорилго оршино.

Иймд 2026-2029 онд хэрэгжих уг төслийг үр дүнтэй гүйцэтгэх, мэдээллийн санг харилцан уялдаатай бүрдүүлэх, төслийн үр дүн нь бусад салбарт өргөн хэрэглэгдэхээр боловсруулах зорилгоор доорх үндсэн чиглэлийн дагуу ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

3.1. Геологийн судалгаа. Талбайн хэмжээнд 1:25000-ны масштабын геологи-ашигт малтмалын зураг зохиох, түгээмэл тархацтай ашигт малтмалын тархалтыг голлон судалж, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх (*хувийн хөрөнгөөр гүйцэтгэгдсэн уул уурхайн бүтээн байгуулалттай холбоотойгоор хийгдсэн судалгаануудыг нэгтгэнэ*), мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх.

3.2. Геофизикийн судалгаа. Геотерм, сэвсгэр хурдасны зузаан, газрын доорх усны гүн, цэвдэг хөрсний тархалт, байгалийн цацрагжилт, геогамшиг, ашигт малтмал, тектоник, газар хөдлөлтэй холбоотой геофизикийн судалгааны ажлыг сонгон хийх, мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх, зураг зохиох,

3.3. Геоморфологийн судалгаа. Газрын хэлбэр дүрс, геологийн үзэгдэл үйл явц буюу экзоген, эндоген процессуудыг судлах, мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх, зураг зохиох,

3.4. Геохимийн судалгаа. Өмнө хийгдсэн дунд масштабын зураглалын ажлын үр дүнгийн зургуудыг шинэчлэх, шаардлагатай талбайнуудыг ялган тороор сорьцлолт хийх, мэдээлэл нэгтгэх, сан бүрдүүлэх.

3.5. Өнөөгийн болон цаашид ашиглагдах газрын доорх ус (гидрогеологи) болон гадаргын усны (гидрологи) судалгааг хийж, мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх, зураг зохиох.

3.6. Геоэкологийн судалгаа. Хүрээлэн буй орчин, техноген өөрчлөлтөд орохоос өмнө болон орсон талбайд судалгаа хийх, хүн амын суурьшил, дэд бүтэцтэй холбоотойгоор гарч болох нөлөөллийг тогтоох, эрсдэлд үнэлгээ өгөх, мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх, зураг зохиох,

3.7. Шинээр бий болох суурьшил, дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд инженер-геологи, геотехникийн ерөнхий судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх, мужлалын зураг зохиох,

3.8. Геологийн болон бусад судалгааны ажлуудын үр дүнд анализ хийж геотермийн потенциал талбай байгаа эсэхийг тогтоож үнэлгээ өгөх,

1. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх арга зүй, аргачлал болон дэс дараалал:

А. Бэлтгэл ажлын үе:

4.1. Талбайн хэмжээнд өмнө нь хийж гүйцэтгэсэн геологийн үе шатны судалгааны болон сэдэвчилсэн судалгааны материалуудыг судлан танилцаж, дүн шинжилгээ хийх, Улсын төсвийн хөрөнгөөр Хархорин бүтээн байгуулалттай холбоотой хийгдэж буй судалгааны ажлуудын төсөлтэй уялдуулах, давхардуулахгүй байх, шаардлагатай мэдээллийг албан ёсоор авах, түүний үндсэн дээр тухайн талбайд тохирсон судалгааны арга аргачлалыг сонгох. Үүнд:

4.1.1. УГА-ны Гео-мэдээллийн төвтэй нууцлалын гэрээний үндсэн дээр бүх шатны судалгааны ажлын үр дүнг багтаасан мэдээллийн сан үүсгэх, баяжуулах, мэдээллийг боловсруулан үнэлэлт, дүгнэлт өгч, өөрсдийн судалгааны ажлын суурийг бэлтгэх, арга аргачлал боловсруулах, мэдээллийн баримт материалын зургийг зохиож, бүртгэл үйлдэх;

- 4.1.2. Өмнөх судалгааны материалд үндэслэн талбайн дээжлэлтийн арга, аргачлалыг урьдчилсан байдлаар боловсруулах;
- 4.1.3. Төслийн талбайн хэмжээнд мэдэгдэж байгаа ашигт малтмалын орд, илрэл, эрдэсжсэн цэгүүд, шлих, геохимийн сарнилын хүрээ, гажлуудын бүртгэл үйлдэн, дүн шинжилгээ хийх;
- 4.1.4. Төслийн талбайн нарийвчлал сайтай агаар, сансрын болон 1:25000-ны масштабтай байр зүйн зургуудыг бүрдүүлж, бэлтгэх, сансрын зурагт (Астер болон түүнтэй адилтгах түвшний нарийвчлал бүхий хиймэл дагуулын зураг гэж ойлгоно) геологийн тайллын зураг хийх, геофизикийн судалгааны (хүндийн хүчний, соронзон зураглал г.м) материалуудтай танилцан боловсруулалт, урьдчилсан тайлал хийх;
- 4.1.5. Хээрийн ажилд гарахын өмнө талбайн стратиграфи, магматизм, тектоникийн талаар мэдээллийг бүрэн цуглуулж, урьдчилсан тайлал хийсэн зургийн хүрээнд танилцах маршрут төлөвлөх;
- 4.1.6. Хувийн хөрөнгийн судалгааны ажлын үр дүнг төслийн бэлтгэл ажилд авч ашиглахдаа ҮГА-д хандаж түүний зөвшөөрлөөр гүйцэтгэх, мэдээллийн санд нэгтгэх ажлыг зохион байгуулах;
- 4.1.7. Хээрийн судалгааны ажилд бэлтгэх, машин техник, тоног төхөөрөмж, шаардлагатай багаж хэрэгсэл, материал, эд зүйлээр инженер-техникийн багийг бүрэн хангах;
- 4.1.8. Иж бүрэн хийгдэх судалгааны онцлогоос хамаарч олон төрлийн дээж сорьц авах шаардлага бий болох тул дээж, сорьцыг цуглуулах, тээвэрлэх, шинжилгээний явцад бүрэн бүтэн байдлыг хадгалж, баталгаажуулах, үүнтэй холбоотойгоор батлагдсан стандартыг мөрдөн ажиллах арга аргачлалыг боловсруулж, захиалагчаар хянуулах;

Б. Хээрийн ажлын үе:

4.2. Төслийн эхний жилд танилцах маршрутыг хийж, талбайн геологи, гео-орчны ерөнхий хэв-шинжтэй танилцаж, төсөлд тусгасан судалгааны арга аргачлал нийцэж буй эсэхийг тодорхойлон шаардлагатай засварыг оруулах. Хээрийн ажлыг геологийн даалгаварт тусгагдсан ажлыг чиглэл бүрээр шийдвэрлэх асуудлуудтай уялдуулан холбогдох заавар шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ. Хээрийн ажлын үед цаасан баримт ашиглахаас гадна цахим технологийн ашиглан, анхдагч материалын бүрдлийг цахимжуулах, материал бүрдүүлэлтийг хялбаршуулан хэрэглэх нь судлаач мэргэжилтнүүдэд нээлттэй ба хийгдсэн ажлын өгөгдлийг ҮГА-ны MonGeoCol геологийн мэдээллийн санд гэрээний санхүүжилтийн хуваарийн дагуу хүргүүлнэ.

4.2.1. Танилцах маршрутын ажил

- 4.2.1.1. Талбайн хэмжээнд геологи, тектоник, геоморфологи, гидрогеологи, гидрологийн маршрутын ажиглалт, уст цэг, түгээмэл тархалттай ашигт малтмалын тархалтын бүртгэл хийн структур-тектоникийн байдал, геологийн тогтоц, ландшафт, цэвдэг, гидрологи, гидрогеологийн байгалийн суурь нөхцөлтэй танилцан агаар сансрын зургийн зохих тайлал, боловсруулалтыг шалгах, анхан шатны боловсруулалтыг гүйцэтгэн тухайн геологи орчны нөхцөлийн байгалийн шинжийг тогтоох,
- 4.2.1.2. Судалгаанд хамрагдаж буй нутгийн хэмжээнд өмнөх судалгаагаар тогтоогдсон хурдас, чулуулаг, гүний биетүүдийн харьцаа, хил зааг, структур, литологи, тогтоц, голлох бүрдүүлэгч чулуулгийн насны үндэслэл, найрлага, текстур зэргийн тодорхойлсон тулгуур болон хэсэгчилсэн зүсэлт, зураглалын дээжлэлтийн цэгүүд, ашигт малтмалын орд, илрэл, эрдэсжсэн цэгүүд, бүх төрлийн гажлуудтай танилцаж, дүгнэлт гаргах, эдгээр геологийн биетүүдээс шаардлагатай гэж үзвэл хяналтын болон эталон дээжийг авах,
- 4.2.1.3. Өмнө гүйцэтгэсэн судалгааны материалуудад хийсэн дүгнэлтэд үндэслэн тулган шалгах, нэмэлт шаардлагатай баримт, мэдээллийг бүрдүүлэх, судалгааны ажлын төрөл ба

арга зүй, аргачлал дагаж мөрдөх стандартыг оновчтойгоор сонгох. ”Шинэ Хархорум” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа ажлуудтай давхцуулахгүй, тус ажилтай уялдуулан шинэ үр дүнгээр баталгаажуулан ажиллах төлөвлөгөөг гаргах, Монгол Улсад дагаж мөрдөгдөж эхлээгүй шинэлэг стандарт хэрэглэх тохиолдолд ҮГА-тай зөвшилцөн дагаж мөрдөх,

4.2.2. Геологийн судалгаа

4.2.2.1. Геологийн маршрутын судалгааг уламжлалт торлолоор заавал хийлгүй тодорхой даалгавар, хил зааг, насны үндэслэлийг тогтоох зэрэг, сэдэвчилсэн судалгааны аргачлалаар хийж, дагалдах дээж, сорьцыг авах,

4.2.2.2. 1:200 000-ны болон 1:50 000-ны масштабтай геологийн зураглалын ажлын талбайнуудын литостратиграфийн формац, бүрдлүүдийн насны хамаарал нэлээд зөрөөтэй байгаа ба Мөнгөнцээж, Яшил формацуудын насны хамаарал нь зөөгдмөл цирконы U-Pb үнэмлэхүй насаар өөрчлөгдсөн, зүүн талд Хүрэнтолгой формацын улаан хасын радиоляраар, агуулагч элсжингийн зөөгдмөл цирконд доод карбоны нас тогтоогдсон, мөн интрузив бүрдлүүдийн зарим шток, массивуудад U-Pb аргаар үнэмлэхүй нас тогтоогдсон зэрэг нь тус төслийн талбайд өмнөх судлаачдын зурагласан формац, бүрдлүүдийн хил заагийг нийлүүлэх, формац, бүрдлүүдийн нэр, насны хамаарлыг өөрчлөх үндэслэл болох бөгөөд мөн формац, бүрдлүүдийн хамаарал, насыг баталгаажуулахын тулд шинээр үнэмлэхүй насны тодорхойлолтууд хийх,

4.2.2.3. Зарим дотоодын их, дээд сургууль, ШУА-ийн хүрээлэнд радиоляр, конодонт тодорхойлдог, нас тогтоодог болсонтой холбоотой төслийн талбайн олон тооны формацад агуулагдах цахиурлаг чулуулгийн нас тодорхойлох,

4.2.2.4. Судалгаанд хамрагдаж буй талбайн хэмжээнд тектоник, неотектоникийн чиглэлээр хийгдсэн судалгааны материалуудад дүн шинжилгээ хийх тогтоогдсон хагарлууд болон шинээр бий болсон хагарал, дөт гүний хагарлын талаар судлах, бүтээн байгуулалттай холбоотойгоор хүн амын суурьшлын бүсэд геогамшиг, газар хөдлөлийн талаар судалгаа хийж, мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх,

4.2.3. Ашигт малтмалын судалгаа

4.2.3.1. Өмнөх 1:50000-ны геологийн зураглалын ажлаар тогтоогдсон (Их хавцал, Харбухын голын хүдрийн потенциал талбайн Цагаанчулуут, Өгийнуурын алтны илрэлүүд, Хашаат-Гурванбулагийн хүдрийн потенциал дүүрэг дэх алтны илрэл, Өндөр нурамт уулын орчимд тогтоосон алтны илрэл, цэгүүд, Өндөр Арцатын хүдрийн потенциал талбай) илрэл, эрдэсжсэн цэг, сарнилын хүрээ, цэгэн гажил зэргийг газар дээр шалгах эрлийн маршрут хийж, үнэлгээ өгөх,

4.2.3.2. Маршрутын судалгаа, талбайн дээжлэлт, геофизикийн судалгааны ажлаар шинээр тогтоосон ашигт малтмалын хэтийн төлөв бүхий эрдэсжсэн цэг, илрэл тогтоогдох аваас эрлийн хэсэг ялгаж, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх,

4.2.3.3. Шлихийн зураглал, түүнийг дагалдсан урсгал геохимийн сорьцлолтыг 1:25000-ны масштабын хэмжээнд уулархаг хэсгүүдэд явуулах. Ялангуяа Б.Батром нар /2009/-ын гуйцэтгэсэн 1 :50000-ны ГЗЕЭА-ын үед талбайн шлих, геохимийн зураглал хийгээгүй тул уг талбайд онцгой анхаарч, шлих, урсгал геохимийн зураглал хийж, өмнөх судалгааны ажлын үр дүнтэй нэгтгэн дүгнэлт хийх,

4.2.3.4. 1:25000-ны масштабын геофизикийн цогцолбор зураглалын үр дүнг ашиглан Орхон-Тамирын хотгорын гидрогеологийн нөхцөл, инженер геологийн нөхцөлийг тодорхойлох, ус агууламж, ашигт малтмалын /нүүрс, шатдаг занар, битум/ хэтийн төлөвийг үнэлэх.

4.2.3.5. Ирээдүйн бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн бодлоготой уялдан зам, барилгын материал, эрдсийн түүхий эдийг нарийвчлан судлах, түгээмэл тархацтай ашигт малтмалын тархалт, байршлыг тодорхойлон, тэдгээрт тодорхой хэмжээний эрлийн ажил хийж, чанарын шинжилгээний үр дүнд тулгуурлан нөөц, баялгийг тооцоолон, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх,

4.2.4. Геоморфологийн судалгаа:

4.2.4.1. Талбайн хэмжээнд газрын гадаргын хэлбэр, өөрчлөлт, эндоген, экзоген процессуудын үйл явц, хот төлөвлөлттэй уялдан гарах өөрчлөлт, байгалийн гамшигын тухайлбал үер усны зэрэг тодорхой үйл явцын чиглэл, аюул, хамгаалах арга замын талаар зөвлөмж боловсруулах, сан бүрдүүлэх, бусад судалгаатай уялдуулах,

4.2.4.2. Гадаргуугийн гарал үүсэл, хэлбэр дүрсийн төрлүүдийг тодруулан ангилах, хөгжлийн онцлог, үүссэн эрэмбэ дарааллыг судалж, ашигт малтмалын шороон орд үүсэж, хуримтлагдах боломжтой нөхцөл бүрдсэн геоморфологийн элементүүдийг судалж тогтоох, морфоструктурын анализ хийх, дөрөвдөгчийн хурдасны тархалтыг тогтоох.

4.2.5. Геофизикийн судалгаа:

4.2.5.1. Судалгааны талбайн хэмжээнд болон сэвсгэр хурдасны зузаан, газрын доорх усны гүн, ул хөрсний хөлдөлт болон цэвдэг хөрсний тархалт, геогамшиг, геотерм, ашигт малтмал, газар хөдлөлттэй холбоотой геофизикийн судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх,

4.2.5.2. Судалгааны талбайн ашигт малтмал болон георчны судалгаанд хэрэглэгдэх суурь материал болгох зорилгоор нийт талбайн хэмжээнд 1:25000 масштабтай геофизикийн соронзон зураглал болон спектрометрийн (U,Th,K,Cs) зураглалын ажил гүйцэтгэх,

4.2.5.3. Суурьшлын бүсийн хүрээнд голын хөндийн ул суурийг тодорхойлох зорилгоор хөндийн хэлбэр, хэмжээг харгалзан 3-с доошгүй шугамаар геофизикийн цогцолбор арга, тухайлбал босоо цахилгаан бүслүүрчлэл, хүндийн хүч, сейсмийн зураглалын аргаар зүсэлт хийж, геологи-геофизикийн нэгдсэн тайлал хийх,

4.2.6. Гидрогеологийн судалгаа

4.2.6.1. Талбайн хэмжээнд хийгдэж буй суурин газруудын өнөөгийн усан хангамжийн эх үүсвэр, худаг, уст цэгийн судалгааны дүнг харгалзан, чулуулгийн литологи, хагарал ан цавын гүний тархалт, газрын доорх усны гидрогеохимийн бүсчлэлийг судлан цаашдын тогтвортой хангах усан хангамжийн эх үүсвэрийн хэтийн төлөв бүхий талбай ялгах, зөв зохистой хэрэглээний талаар зөвлөмж боловсруулах,

4.2.6.2. Газрын доорх болон гадаргын усны сорьцонд усны гарал үүсэл, химийн болон хийн найрлага, усны гарал үүслийг тогтоох тогтвортой изотопын судалгаа хийн гидрогеохимийн нөхцөлийг тогтоох. Нийт талбайн уст цэгүүдэд газрын доорх усны түвшин, температур, ундарга, химийн найрлага, эрдэсжилтийг хэмжин хугацааны болон орон зайн өөрчлөлтийг тогтоон газрын доорх усны хөдөлгөөний онцлогийг хэрэгжиж буй ижил төрлийн судалгааны дүнтэй харьцуулах, тогтоох,

4.2.6.3. Гидрогеологийн объектуудад чулуулгийн усжилтын зэрэг, шинж, газрын доорх усны тархалт, тэжээмж, зөөгдөл, тэдгээрийн горим, гадаргын устай харилцан үйлчлэлцэл, усны физик шинж чанар, химийн найрлага, чанар, тэдгээрийн геологийн процессын хөгжил, чулуулагт үзүүлэх нөлөөллийг судлан тогтоох,

4.2.6.4. Талбайд байгаа байгалийн болон хүний үйл ажиллагаагаар үүссэн уст цэгүүдэд бичиглэл, усны дээжлэлт хийх, судалгааны талбай дахь худгийн ундарга, усны түвшин, өөрчлөлтийг тогтоох сорилын шавхалт хийж, бүртгэлжүүлэн баримтжуулах,

4.2.6.5. Хот суурин газрын төлөвлөлттэй уялдуулан өмнө хийгдсэн ажлын үр дүнд үндэслэн холбогдох гидрогеологийн судалгааны ажил арга аргачлалыг сонгоно.

4.2.7. Гидрологийн судалгаа:

4.2.7.1. Судалгаанд хамрагдаж буй талбайн хэмжээнд гол, горхи, гадаргын бусад ил задгай урсац, усан сан, нуур, цөөрөмд анхан шатны гидрометрийн хэмжилтийг хийж, тэдгээрийн үндсэн параметр (урсац, урсгалыг хурд, усны түвшин, усан мандалын талбай болон гүний хэмжээ г.м)-ийг тодорхойлох, химийн найрлага, тэжээгдлийн эх үүсвэр, нөөц, усан дахь биологийн төрөл зүйлд байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөлөх нөлөөллийн талаар судлах,

4.2.7.2. Гэнэтийн их хэмжээний хур тунадаснаас үүдэлтэй уруйн болон хаврын шар усны урсацыг тооцох, эрсдэлээс хамгаалах, гадаргын урсацын дахин хуваарилалтын талаар санал зөвлөмж тусгах.

4.2.8. Геоэкологийн судалгаа:

4.2.8.1. Судалгааны талбайн хэмжээнд байгалийн ландшафтын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд (газрын гадаргуугийн хэв шинж, хөрс, хөрсний геохими, ургамал, гадаргын болон газрын доорх ус, усан сүлжээ, агаарын чанар, дэгдэмхий бодис, уур амьсгалын нөхцөл, цацрагжилт, тоосжилт, дуу чимээ) -ийн өнөөгийн суурь нөхцөлийг тогтоох зорилгоор хэмжилт, ажиглалт, мониторинг ажлыг хийж, өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээний зураг зохиох,

4.2.8.2. Судалгаанд хамрагдаж буй бүс нутгийн хэмжээнд экосистем, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаар дүн шинжилгээ хийн, биологийн төрөл зүйл, ус зүйн зэрэг судалгааны төрөл бүрээр мэдээллийн сан бүрдүүлэх. Геоэкологийн аюулын үнэлгээг лабораторийн үр дүн болон судалгааны материалд тулгуурлан геологи орчинд үүсэх эрсдэлийг уламжлалт болон загварын программ хангамжийн аргыг ашиглан боловсруулалт хийнэ. Геоэкологи, гео-орчны нөхцөл хот байгуулагдсанаар хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөллийн аюулын урьдчилсан үнэлгээг 5-10 жилийн давтамжаар тооцох,

4.2.8.3. Судалгааны үр дүнд гео-орчныг үнэлэх, нөлөөллийг тогтоох, одоо байгаа болон цаашид үүсэх эрсдэлийг тооцох, эрсдэлээс хамгаалах бууруулах арга замыг боловсруулахад ашиглагдах тооцоолол хийх шаардлагатай параметрууд, мэдээллийг нэгтгэнэ,

4.2.9. Инженер геологийн судалгаа:

4.2.9.1. Судалгааны талбайн хэмжээнд хийгдсэн болон хийгдэхээр төлөвлөж буй бүтээн байгуулалт, (*хот төлөвлөлттэй уялдан төлөвлөгдөж буй барилга байгууламж*), шугаман байгууламж (*бүх төрлийн автозам, төмөр зам, гүүр, цахилгаан дамжуулах агаарын шугам, ус дамжуулах шугам, зэрэг*) инженер-геологи, геотехникийн судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулах, сан бүрдүүлэх,

4.2.9.2. Хот суурин газрын төлөвлөлттэй уялдуулан өмнө хийгдсэн ажлын үр дүнд үндэслэн холбогдох инженер геологийн судалгааны ажлын арга аргачлалыг сонгож, тэдгээр ажлуудтай давхцуулахгүйгээр судалгаа явуулах,

4.2.9.3. Олон жилийн цэвдгийн талаар судалгаа хийх, мониторингийн цэг байгуулах эсэхэд зөвлөмж өгөх, цэвдэг чулуулаг тархсан талбайд мөсний талстууд, хурдас чулуулаг дотор мөсний хуваарилагдсан байдал, мөсний зузаан, тэдгээрийн хоорондох зай, агуулагдсан мөсний хувь, гэссэний дараах усаар ханасан байдал, хурдас чулуулгийн температурыг тогтоох,

4.2.9.4. Судалгаанд хамрагдаж буй талбайн хэмжээнд ул хөрсний ангилал хийн инженер геологийн мужлалын зураг зохиох, бусад төрлийн судалгаатай уялдуулан шаардлагатай тохиолдолд чиглэсэн судалгааг явуулах, хамаарах дээжлэлт хийх. Зохих норм, стандартыг барих.

4.2.10. Геогамшгийн судалгаа

4.2.10.1. Төслийн талбайн хэмжээнд тархсан байгалийн гамшигт үзэгдлийн нэр төрөл, тархалт, байршлын онцлог, эрчим зэргээс хамаарч 1:25000-1:50000-ны масштабаас сонгон гео-аюулын нийлбэр үнэлгээний зургийг зохиох ба аюул тус бүрээр тооцсон үнэлгээний зургийг наклад байдлаар 1:100000-200000-ны масштабаар оруулна.

4.2.10.2. Газар хөдлөлийн аюулын үнэлгээг тооцохдоо тус талбайн хүрээнд өмнөх судалгааны ажлаар тогтоосон Өлзийтийн хагарлын төгсгөл байж болох Өгий нуурын сегмент, Сарт-Майхан-уул, Мөстийн цагааны хагарлуудыг нарийвчлан судлах шаардлагатай тохиолдолд нэг хагарлыг сонгон палеосейсмологийн судалгаа явуулах, талбайн гадна талд зураглагдсан Өлзийт, Дашлүн, Хужирт, Могод, Орхон, Агьт, Жаргалантын хагарлуудын талаар мэдээлэл цуглуулж, аюулын үнэлгээнд тооцох,

4.2.10.3. Үер, уруйн аюул, цөлжилт, хөрсний гулсалт, массын шилжилт, газар цөмрөлт зэрэг бусад гео-аюулын нүүрлэх боломжит хэсгүүдийг тогтоож, давтамж, түүний цар хүрээ, эрчмийг зураглах. Тооцооны аргачлалаар аюулыг үнэлэх ба хээрийн судалгааны ажлаар өмнө тохиосон гамшгийн талаар мэдээллийг цуглуулж сан үүсгэнэ.

4.2.11. Геотермийн судалгаа

4.2.11.1. Геофизикийн судалгааны аргыг сонгон бүс нутгийн Кюри гүний тогтоох хэмжилт хийх, магнето теллурийн судалгааг талбай сонгон авч, тороор хийн гурван хэмжээст модель үүсгэх,

4.2.11.2. Тухайн талбайд тархсан геологийн формаци, бүрдэлүүд ялангуяа метаморф, интрузив чулуулгуудын голлох төрлүүдийг физик-химийн шинж чанарыг судлан дулаан дамжуулах, хадгалах чадварыг тодорхойлох,

4.2.11.3. Гүн суусан хагарал, бутралын бүсүүдийг зураглаж гүний огтол, структурын загварчлал хийж, геофизикийн судалгааны үр дүнтэй уялдуулан баталгаажуулах,

4.2.11.4. Дээрх судалгаанууд болон геологийн бусад судалгааны ажлуудын үр дүнг нэгтгэн анализ хийж геотермийн потенциал талбай байгаа эсэхийг тогтоож, загварчлал хийх, потенциал талбайн хил заагийг зураглаж ялгах,

4.2.12. Гео-дурсгалын талаар

4.2.12.1. Тус талбайд тархсан палеонтологийн олдворт газруудыг тогтоон судалж тэдгээрийн дунд тус бүс нутгийг эртний газарзүй, геологийн чухал мэдээллийг агуулж буй ховор төрлийн төрөл зүйл бүхий олдворт цэгийг тусгайлан ялгах, олдворын цуглуулга хийж геологийн музей, ҮГА-нд хүлээлгэн өгөх,

4.2.12.2. Геологи, стратиграфи, структурын өвөрмөц, ховор тогтоц бүхий газар талбай байгаа эсэхийг тогтоож, тухайн газруудын координатжуулан тархалт хэмжээг гаргах, Фото зургаар баталгаажуулж, ҮГА-нд мэдэгдэх, газар дээр нь хаягжуулах.

4.2.13. Дээжлэлтийн ажил:

4.2.13.1. Судалгааны шатанд авсан бүх төрлийн сорьц, дээжид холбогдох лабораторийн шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн лабораторид чанарын шаардлага хангасан шинжилгээнд хамруулах, дээжийн тодорхой хувийг байгаль орчны итгэмжлэгдсэн

лаборатори болон нийгмийн эрүүл мэндийн газрын лабораторид шинжлүүлэх, гарсан үр дүнд боловсруулалт хийх, шаардлагатай тохиолдолд изотопийн шинжилгээ хийх,

4.2.13.2.Геологи-ашигт малтмалын судалгаатай холбоотойгоор талбайн шлих, геохимийн сорьцлолтыг үндсэн чулуулагт хөндлөн огтолсон жалга, сайрын дагуу 500-250м зайтайгаар өмнөх судалгааны дээжлэлтүүдийн үр дүнтэй уялдуулан, төлөвлөлт хийж авна. Геологийн маршрутын судалгааны үед бүх төрлийн сорьц, дээжүүдийг аргачлал, зааврын дагуу авна.

4.2.13.3.Геологи орчны янз бүрийн эвдрэлүүдтэй холбоотой техноген бохирдлын талбайг тодорхойлох зорилгоор сэвсгэр хурдаснаас хөрсний геохимийн шинжилгээнд зориулан хөрсний А үеэс дээж авна. Дээж авахдаа геохимийн бүсчлэл, байгаль-геохимийн бэлэн мэдээллийг харгалзан талбайг сонгож, торлолын дагуу авна. Тухайлбал 1:50000, 1:25000 масштабтай зураглал хийхдээ гол төлөв хүн ам суурьшсан бүс дотор 250х250 метр, үлдсэн хэсэгт 500х500 метрийн хэмжээтэй тороор сорьц авч болно.

4.2.13.4.Техноген хөрсний сорьц авах ажлыг голчлон бохирдлын эх үүсвэрээс нөлөөллийн бүсийн хил хүртэл профилийн дагуу түргэвчилсэн байдлаар явуулна. Мөн дээрх техноген объекттой зэргэлдээх газруудад торлон сорьц авахаас гадна хөндлөн огтлолын арга буюу радиаль цацрагийн аргыг хэрэглэнэ. Салхины голлох чиглэлийн дагуу техноген объектоос 0.5-1.2 км-ээр 10 км хүртэл зайд, 30 км хүртэл 2-5 км-н алхмаар, түүнээс цааш масштабаас хамаарч 100 км хүртэл 10 км алхмаар сорьцыг авна. Эсрэг чиглэл 0.5, 1, 2, 4, 10 км алхмаар мөн перпендикуляр чиглэлд сорьц авна.

4.2.13.5.Газрын доорх усны сорьцыг булаг, цооноогоос авах ба цооног, худгийн тоо ажлын цар хүрээг тухайн бүс нутгийн газар ашиглалтын онцлогоос хамааруулан гидрогеологи, геохими, геофизикийн судалгаа, одоо байгаа уст цэгийн байршилд тулгуурлан түүврийн аргаар сонгоно. Жишээлбэл 1:25000 масштабтай ажилд худгийн тоо 500 км² тутамд 1 байж болно.

4.2.13.6.Гадаргын усны сорьцыг 3.0<км хүртэл тасралтгүй үргэлжилсэн байнгын урсацтай гадаргын усан сүлжээний эх ба адгийн хэсэгт, харин бэсрэг болон харьцангуй томоохон голуудын урсцын дагуу 15.0-25.0 км тутамд гидрохимийн дээжлэлт хийнэ.

4.2.13.7.Хяналт шинжилгээний цооногт MNS ISO 5667:11 зааврын дагуу цооногт цэвэрлэгээ хийсний дараа сорьцыг авна. Сорьц авахдаа тусгай сорьц авагчдаас гадна хамгийн энгийн гар сорьц авагч, орчин үеийн жижиг оврын насос зэрэг олон төрлийн загвартай сорьц авагчийг ашиглах ба үүнийг ажлын цар хүрээ бохирдол байгаа эсэхээс хамаарч сонгоно.

В. Суурин боловсруулалтын үе:

4.3. Төслийн суурин боловсруулалтын ажил нь завсрын болон эцсийн (тайлангийн) гэсэн хоёр үе шатны дагуу гүйцэтгэнэ. Завсрын суурин боловсруулалтаар тухайн судалгааны ажлаар хуримтлагдсан анхдагч материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийж, дараагийн ажлын төлөвлөлтийг нарийвчлах бол эцсийн суурийн боловсруулалтаар өмнөх судалгааны ажлын материалууд болон төслийн ажлын үр дүнг нэгтгэн ажлын арга, аргачлал болон судалгааны үр дүн, цаашид хийх судалгааны чиглэл, хэтийн төлөв болон үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлангийн бичвэрийг боловсруулна.

4.3.1. Завсрын суурин боловсруулалт:

4.3.1.1. Хээрийн судалгааны ажлын жил бүрийн анхдагч баримт материалыг нэгтгэн боловсруулж, хэрэв ажлын үр дүн шаардлага хангаагүй тохиолдолд түүнд дүн шинжилгээ хийж, захиалагчид судалгааны ажлын арга аргачлал, ажлын хэмжээ, ажил гүйцэтгэх цаг хугацаа гэх зэрэг асуудлаар тулгамдсан асуудлуудыг танилцуулж, нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж шийдвэрлүүлэх, ирэх жилийн судалгааны ажлыг төлөвлөх,

4.3.1.2. Завсрын суурин боловсруулалтын ажлаар жил бүрийн хээрийн судалгааны ажил эхлэхийн өмнө геоорчины тулгуур судалгаа хийх талбайнууд, эрлийн ажил хийх талбай, хяналт мониторинг хийх объектууд, геофизикийн тор шугамууд, өрөмдлөг ба уулын ажлыг төлөвлөсөн тойм зураг зохиож, хээрийн ажлын дэлгэрэнгүй хөтөлбөр гаргана.

4.3.1.3. Тухайн жилийн болон улиралд хийгдсэн судалгааны ажлаар цуглуулсан баримт мэдээлэл болон тэдгээрт хийлгэсэн лабораторийн шинжилгээний үр дүнгүүдийг тусгасан улирлын болон жилийн эцсийн завсрын тайлан бичиж захиалагчид ирүүлсэн байна.

Жич: Байгууллагад ШУТ-ийн (Эрдмийн) зөвлөл байдаг тохиолдолд хурлаараа авч хэлэлцүүлсэн тухай тэмдэглэл, шийдвэрийн хамт, захиалагчид ирүүлсэн байна.

4.3.2. Эцсийн суурин боловсруулалт:

4.3.2.1. Тухайн судалгааны ажлаар болон өмнөх судалгаагаар хуримтлагдсан мэдээ, мэдээлэл, материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийж судалгааны талбайн ерөнхий мэдээлэл, ажлын арга, аргачлал болон судалгааны үр дүнг багтаасан хэтийн төлөвийн үнэлгээ, дүгнэлт гаргасан, цаашид хийх, анхаарах ажлын зөвлөмж бүхий тайлангийн бичвэрийг үйлдэнэ.

4.3.2.2. Судалгааны явцад авагдсан сорьц, дээжийн үр дүнг бусад үр дүнтэй харьцуулан төрөлжсөн зураг, зүсэлт, бүдүүвч, график, хүснэгтийг хавсралт маягаар үйлдэх, шинжилгээний үр дүнг AquaChem, HydroGeoAnalyst, Visual MODFLOW, Aquifer test, GE05 Laboratory, ioGas зэрэг программ хангамж ашиглан боловсруулалт хийх, газрын доорх усны нөөц болон геологи орчинд үүсэх эрсдэлийг үнэлэхдээ уламжлалт болон загварын аргыг ашиглан боловсруулалт хийнэ.

4.3.2.3. Тайлангийн бүх зургийг ArcGis программаар, бичвэрийг Times New Roman фондоор үйлдэнэ.

4.3.2.4. Судалгааны явцад цуглуулсан сорьц, дээжийн мэдээлэл болон холбогдох хэмжилт, туршилтын багажуудын мэдээлэл, зохиогдсон зургуудын тоон мэдээллийн санг Үндэсний геологийн албаны Геомэдээллийн төвийн загвар /template/-ын дагуу бүрдүүлэх,

4.3.2.5. Судалгааны шатанд хийгдсэн ажлын үр дүн болон өмнө хийгдсэн судалгаануудын мэдээллийг нэгтгэсэн санг судалгааны чиглэл тус бүрээр болон нэгдсэн байдлаар бүрдүүлнэ.

4.3.2.6. Судалгааны үр дүнд тулгуурлан судалгааны ажил гүйцэтгэх аргачилсан заавар, зөвлөмж боловсруулна.

4.3.2.7. Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтаар дараах зургуудыг зохиосон байна. Үүнд:

Үндсэн зураг:

- Баримт материалын зургууд Масштаб 1:25 000
- Геологийн зураг Масштаб 1:25 000
- Гео-орчны зураг Масштаб 1:25 000
- Гидрогеологийн зураг Масштаб 1:25 000
- Гео-экологийн зураг Масштаб 1:25 000
- Гео-экологийн аюулын үнэлгээний зураг Масштаб 1:25 000
- Инженер-геологийн зураг Масштаб 1:25 000
- Геофизикийн үр дүнгийн зургууд Масштаб 1:25 000

Дагалдах зураг:

- Геохимийн дан элемент болон эвшлийн зургууд Масштаб 1:25000
- Шлихийн дээжлэлтийн үр дүнгийн зураг Масштаб 1:25000
- Геоморфологийн зураг Масштаб 1:25000
- Гео-гамшгийн аюулын үнэлгээний зураг Масштаб 1:50000
- Гидрологийн зураг Масштаб 1:25000
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тархалт болон хэтийн төлөвийн үнэлгээний зураг Масштаб 1:25000

Төрөлжсөн зургууд:

- Нарийвчилсан судалгаа хийсэн талбайн зургууд Сонгосон масштабаар
- Бусад дагалдах шаардлагатай зураг, бүдүүвч, зүсэлт зэргийг зургийн ач холбогдлыг илэрхийлэх масштабаар зохиох.

5. Төслийн үр дүн:

5.1. Шинээр төлөвлөж буй Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих чиглэлээр геологийн 1:25000-ны масштабын геологи-ашигт малтмал, гео-орчны суурь мэдээллүүдийг багтаасан зураг, тайлбар бичгийн хамт зохиогдоно.

5.2. Шинээр байгуулагдах хотын бүтээн байгуулалттай холбоотойгоор эдгээр ажлууд хийгдсэнээр судалгааны талбайн өнөөгийн байдлыг үнэлэх, цаашид үүсч болох эрсдэлийг тооцох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах, хамгаалах арга хэмжээ төлөвлөхөд үнэтэй суурь мэдээлэл бий болох бөгөөд цаашид эрүүл мэнд, хот төлөвлөлт, байгаль орчин, хөдөө аж ахуй зэрэг олон салбарт ашиглагдах нарийвчилсан судалгаа хийх, менежмент, төлөвлөгөө гаргахад ашиглагдах суурь нөхцөл бүрдэнэ.

5.3. Хот байгуулагдахаас өмнө болон дараа тухайн эдэлбэр газар доорх ашигт малтмалыг хэрхэх талаар дүгнэлт зөвлөмж гарган, судалгааны талбай дахь харилцан адилгүй цаг хугацаанд хийгдсэн төрөл бүрийн геологийн судалгааны ажлын үр дүн, шинээр хийгдэх энэхүү судалгааны үр дүнтэй нэгтгэн цаашид авах арга хэмжээний талаар санал тусгагдана. Ингэснээр шинээр төлөвлөн байгуулагдах суурьшлын бүсэд энэ чиглэлийн судалгааг урьдчилан хийх, эрсдэлээс хамгаалах, зүй зохистой судалгаа, ашиглалт явуулах боломж бүрдэнэ.

5.4. Шинээр байгуулагдах хотын хэмжээнд хун амын суурьшил, бүтээн байгуулалт, газар ашиглалттай холбоотой тогтмол хяналт хийгдэх мониторингийн цэгүүдийг бүртгэлжүүлэх, шинэ мониторингийн цэг, талбай үндэслэлтэйгээр сонгогдоно.

6. Ажил гүйцэтгэх хугацаа:

6.1. Төсөл, төсөв боловсруулах:

Эхний жилд: -Шууд гэрээгээр.

6.2. Хээрийн ажил:

Эхний жилд: -2026 оны 6-р сараас 10-р сарыг дуустал
 Хоёр дахь жилд: -2027 оны 5-р сараас 10-р сарыг дуустал.
 Гурав дахь жилд: -2028 оны 5-р сараас 10-р сарыг дуустал.

6.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт: - 2026 оны 11-12-р сар дуустал
 - 2027 оны 1-4-р сар, 11-12-р сар,
 - 2028 оны 1-4-р сар, 11-12-р сар,

Эцсийн суурин боловсруулалт: - 2029 оны 1-р сараас 10 сар дуустал.

6.4. Судалгааны ажлын үр дүнд зохиосон зургууд, тайлбар бичиг, дагалдах мэдээллийн санг хөндлөнгийн шинжээчээр дүгнэлт хийлгэн, холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийж, геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албажуулан ирүүлэх:

2029 оны 11-р сарын 30.

6.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжээр хянуулж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт, засварыг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр албажуулан ирүүлэх:

2029 оны 12-р сарын 30.

6.6. Тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох дүгнэлт, түүнд үндэслэн эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулсны дараа Геологийн мэдээллийн төв архивд тайлан, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны
дараа ажлын 5 өдөрт

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Ажил дуусгах хугацаа: **“Ашиглахгүй”**
2. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: **“Ашиглахгүй”**
3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: **“Ашиглахгүй”**
4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: **“Ашиглахгүй”**

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягт 1. Тендер илгээх

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [**“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих**]. [**Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих**].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [**ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо**] өдрийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна. [**Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг**]:
Хаяг:

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгаавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгаавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж ажил гүйцэтгүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
 - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
 - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
 - 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад

нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

Захиалагчийн үүрэг	нийтлэг	2.1.	Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.
		2.2.	Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.
		2.3.	Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.

Захиалагчийн төлөөлөгч		2.4.	Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.
		2.5.	Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
		2.6.	Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Талбайд зөвшөөрөл	нэвтрэх	2.7.	Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.
		2.8.	Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

Гүйцэтгэгчийн үүрэг	нийтлэг	3.1.	Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.
		3.2.	Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.
		3.3.	Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.
		3.4.	Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
		3.5.	Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
		3.6.	Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

- 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
- Гүйцэтгэгчийн төлөөлөгч 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
- 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Техникийн болон ажлын талбайн өгөгдөл 3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
- Ажлын талбайн харуул хамгаалалт 3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.
- 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.
- Хог, хаягдал ба нөхөн сэргээлт 3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.
- 3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.
- 3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.
- Археологийн болон бусад олдвор 3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.
- 3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.
- Аюулгүй байдал 3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

- 3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

Ажил эхлэх

- 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

Хугацаа сунгах

- 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
 - 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;
 - 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
 - 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
 - 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.

Ажлын явцын тайлан

- 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар

ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- | | |
|-------------------|--|
| Гэрээний үнэ | 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална. |
| Урьдчилгаа төлбөр | 5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.
5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно. |
| Төлбөрийн нөхцөл | 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.
5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана. |

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- | | |
|-----------------------|---|
| Урьдчилгаа баталгаа | 6.1. ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | 6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.
6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:
6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; |

- 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
- 6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
- 6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
- 6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.
- Чанарын баталгаа 6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.
- 6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.
- 6.9. ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.
- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- Баталгаат хугацаа 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- Бусдад учруулсан хохирлыг арилгах 7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.
- Захиалагчийн эрсдэл хүлээх 7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;
- 7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;
- 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;

- 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.
- НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ**
- Доголдлыг арилгах, илрүүлэх, 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.
- 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.

- Далд доголдол 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Зураг төслийн доголдол 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.
- 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.
- ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**
- Захиалагч гэрээг цуцлах 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;
- 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
- 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
- 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
- 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
- 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
- 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
- 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
 - 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
 - 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
 - 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
 - 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

- Мэдэгдэл 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
 - 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- Төлөөлөгч өөрчлөгдөх 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
- Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл 10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал 10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.

- | | |
|-------------------------|--|
| Оюуны өмчийн эрх зөрчих | 10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана. |
| Алданги | <p>10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.</p> <p>10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p> <p>10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.</p> |
| Маргаан шийдвэрлэх | <p>10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p> <p>10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p> |

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 1.1.7.	Судалгааны ажлын геологийн даалгаварт заасан техникийн үзүүлэлтийг хангасан тоног төхөөрөмжийг ашиглан Захиалагчийн сонгосон талбайд гүйцэтгэх судалгаа болон бусад ажлыг чанарын өндөр түвшинд тогтоосон хугацаанд гүйцэтгэн хүлээлгэн өгнө.
ГЕН 1.1.8.	Батлагдсан геологийн даалгаварт заасан солбицол бүхий талбай
ГЕН 1.1.10.	Захиалагчаас томилсон хөндлөнгийн хяналтын багаас судалгааны ажлын гүйцэтгэл, чанарт гарсан доголдлыг арилгуулахаар Гүйцэтгэгчид тухай бүр гаргасан шаардлага, доголдлыг арилгах хугацаа
ГЕН 1.2.5.	Гэрээг Монгол хэл дээр байгуулна.
ГЕН 3.1.	Гүйцэтгэгч нь геологийн даалгаварт заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгнө.
ГЕН 3.11.	Захиалагч нь ажлын талбайд өмнө гүйцэтгэсэн бүх төрлийн геологи (геологи, геохими, геофизик, гидрогеологи, байр зүйн, агаар, сансрын зураг болон бусад сэдэвчилсэн судалгаа)-ийн мэдээллийг Гүйцэтгэгчид холбогдох хууль, журмын дагуу тогтоосон нууцлалыг хангуулж ажил эхлэхээс өмнө өгч болно.
ГЕН 3.24.	Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцах бөгөөд ХАБЭА хариуцсан ажилтанг томилно.
ГЕН 4.1.	Судалгааны ажлыг гэрээ байгуулсан өдрөөс эхлэх бөгөөд тендерт ирүүлсэн ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө), ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
ГЕН 4.1.	Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалж гэрээ цуцлагдсан бол цуцлах хүртэл хийгдсэн ажлыг Захиалагчийн өмч гэж үзнэ.
ГЕН 4.2.	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: Ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас хойш 15 хоногийн дотор
ГЕН 4.9.	Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: - Эхлэлийн тайлан: Судалгааны ажил эхлэснээс хойш 30 хоногийн дотор; - Ажил гүйцэтгэлийн тайланг: Сар бүрийн 25-ны дотор; - Ажлын хэрэгжилтийн тайлан: Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор; - Үр дүнгийн тайлан: Геологийн даалгаварт заасан хугацаанд ирүүлнэ.
ГЕН 4.10.	Ажлын явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусган ирүүлэх ба эдгээр нь санхүүжилт олгох үндэслэл болно.
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: “Тохируулахгүй тогтмол байна”.
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: “Үгүй”
ГЕН 5.6.	Төлбөр төлөх: 1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хувьд: - Судалгааны ажлын эхлэлийн тайлан ирүүлснээс хойш ажлын эхний жил 20% - 2 дах жил : гэрээний үнийн дүнгийн 35% - 3 дах жил : гэрээний үнийн дүнгийн 35% - Сүүлийн жил : гэрээний үнийн дүнгийн 10%-ийг тус тус гүйцэтгэгчид олгоно. 2. 1:25000-ны масштабтай гео-орчны судалгаа, эрлийн ажлын хувьд: - Судалгааны ажлын эхлэлийн тайлан ирүүлснээс хойш ажлын эхний жил 15%

	<ul style="list-style-type: none"> - 2 дах жил : гэрээний үнийн дүнгийн 35% - 3 дах жил : гэрээний үнийн дүнгийн 35% - Сүүлийн жил : гэрээний үнийн дүнгийн 15%-ийг тус тус гүйцэтгэгчид олгоно. <p>Төлбөр төлөх төгрөгийн данс: [банкны нэр, дугаарыг оруул]</p> <p>Судалгааны ажилд зарцуулахаар тендерт ирүүлсэн үнийн санал бүхий төсвийн нэгтгэлийг Хавсралт-1-д заасны дагуу ажлын төрөл тус бүрээр, хэмжих нэгж, нэгжийн өртөг, нийт дүнгээр гаргаж ирүүлнэ.</p>
ГЕН 5.9.	Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй бөгөөд Захиалагчийн томилсон хөндлөнгийн хяналтын багийн дүгнэлт, саналын дагуу доголдол гарсан ажлыг өөрийн зардлаар дахин гүйцэтгэнэ.
ГЕН 6.2.	<p>Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ: <i>Тухайн төсвийн жилд санхүүжих буюу гэрээний үнийн дүнгийн 3 хувь байна.</i></p> <p>Гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх хугацаа: <i>Гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн байна.</i></p> <p>Гүйцэтгэлийн баталгааг тендерийн баримт бичгийн “Гүйцэтгэлийн баталгаа”-ны маягтын дагуу гаргана.</p> <p>Судалгааны ажлын үр дүнгийн тайланг хамгаалж, Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэл гүйцэтгэлийн баталгааг цуцлахгүй.</p>
ГЕН 6.7.	Чанарын баталгаа шаардах эсэх: “Шаардахгүй”
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа: “Шаардахгүй”
ГЕН 7.5.	<p>Даатгалыг Гүйцэтгэгч бүрэн хариуцах бөгөөд даатгалд зайлшгүй хамруулах зүйл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Машин механизм, техник, тоног төхөөрөмжийн алдагдал, эсхүл гэмтлийн даатгал, 2. Гуравдагч этгээдийн хариуцлагын даатгал, 3. Мэргэжлийн хариуцлагын даатгал, 4. Гэнэтийн ослын, амь нас эрүүл мэндийн хувьд холбогдох хуулийн дагуу ажил олгогчийн хүлээх хариуцлагын даатгал. <p>Тэмдэглэл: Энд хэрэглэх шаардлагатай гэж үзсэн даатгалын заалтыг нэмэх</p>
ГЕН 8.2.	Захиалагчийн төлөөлөгч, захиалагчийн томилсон хөндлөнгийн хяналтын багаас судалгааны ажил эхлэхээс дуусах хүртэл хугацаанд хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд геологийн даалгаварт заасан шаардлагад нийцээгүй зөрчил, доголдлыг арилгуулах хугацаа, зааварчилгаа бүхий мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө.
ГЕН 8.2.	Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд, өгсөн зааварчилгааны дагуу өөрийн зардлаар арилгана.
ГЕН 10.5.	Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаяг сольсон болон Гүйцэтгэгч санхүүжилт авах банк, дансаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
ГЕН 10.20.	<p>Оюуны өмчийн тухай:</p> <ol style="list-style-type: none"> 1. Судалгааны ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол Гүйцэтгэгч хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана. 2. Судалгааны ажлын анхдагч, завсрын, эцсийн тоон мэдээлэл, үр дүн Захиалагчийн өмч байна.
ГЕН 10.21.	<p>Захиалагчийн төлөх алдангийн хувь:</p> <p>Алдангийн хувь: хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.01 хүртэл хувиар тооцож Гүйцэтгэгчид төлнө.</p>
ГЕН 10.22.	<p>Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:</p> <p>Алдангийн хувь: хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.03 хүртэл хувиар тооцож Захиалагчид төлнө.</p>

ГЕН 10.23.	Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан, авах аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх үүрэгтэй. Задруулсан, дамжуулсан, ил болгосон тохиолдолд Монгол Улсын хуулиар хариуцлага хүлээнэ.
ГЕН 10.24.	Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх нууцлалын гэрээ байгуулан, мэдэгдлийн хамт өгнө.
Бусад: (I)	Ажлын явцад УУХҮС-ын тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, үр дүнг тооцох” журмын дагуу хээрийн үйлдвэрлэлийн болон суурин боловсруулалтын явцад шуурхай хяналт хийх, хээрийн анхдагч материал хүлээн авах комиссыг Захиалагч талаас ажлын шаардлагын дагуу томилон ажиллуулна. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг танилцуулан холбогдох санал, хүсэлтийг комиссоор дамжуулан Захиалагч талд хүргүүлж шийдвэрлүүлнэ.
(II)	Хилийн бүс, зурвас газар судалгааны ажлыг гүйцэтгэхдээ “Монгол Улсын хилийн тухай тухай” хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд Гүйцэтгэгч нь холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авахад Захиалагч дэмжлэг үзүүлнэ.
(III)	Гүйцэтгэгч нь хээрийн болон суурин судалгааны ажилд Захиалагчаас зөвшөөрсөн дотоодын болон гадаадын мэргэжилтэн, оюутнуудыг орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, арга, аргачлалд сургах, дадлагажуулж ажиллана.
(IV)	Гүйцэтгэгч нь хээрийн болон суурин судалгааны ажилд Захиалагчаас зөвшөөрсөн орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, арга, аргачлалыг хэрэглэнэ.
(V)	Гүйцэтгэгч нь хээрийн болон суурин судалгааны ажилд Захиалагчаас зөвшөөрсөн Олон Улсын зөвлөх, мэргэжилтэн, судлаачийг төслийн ажилд оролцуулж болно.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэр] гэрээ.

Дугаар № УГА/2026.....

Улаанбаатар хот

Нэг талаас **Үндэсний геологийн алба** (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн нэрийг бичих]** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт (Ажлын даалгавар);
 - 3.7. Ажил гүйцэтгэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:

Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

Д/д	Ажлын төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Нийт дүн	
				тоо	дүн
0	1	2	3	4	5
	Төсөл, төсөв зохиох	%			
	АГЗ тайлалт	кв.км			
	Зураглал	кв.км			
	Эрлийн маршрут	т.км			
	Холбогдох дээжлэлт	сорьц			
	Геофизик: /ажлын төрөл, аргачлал тус бүрээр задаргаа хийнэ/	кв.км тууш км.ф.ц			
	гэх мэт				
	Хээрийн ажлын дүн				
	Зохион байгуулалт	%			
	Татан буулгалт	%			
	Суурин боловсруулалт	%			
	Өөрийн лаборатори /ажлын төрөл, аргачлал тус бүрээр задаргаа хийнэ/:	сорьц			
	Үйлд: хүн тээвэр Сонгосон тээврийн төрлийн марк	км			
	Үйлд. Ачаа тээвэр тээврийн төрлийн марк	т.км			
	Томилолтын зардал	хүн/өдөр			
	гэм мэт				
	Өөрийн хүчээр, бүгд				
	Топо суурь	төг			
	Тайлангийн зургийн зардал	төг			
	Онгоцны зардал	төг			
	гэм мэт				
	Дүн				
	Магадлашгүй зардал	%			
	гэх мэт				
	Нийт ажлын төсөвт өртөг	төг			

БАТЛАВ
ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.МӨНХБИЛЭГ



АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын *Геологи хайгуулын судалгааны ажил*
нэр:
Тендер шалгаруулалтын *ҮГА/20260101010*
дугаар:

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
1. Тендерийн цар хүрээ	2
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг	2
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	2
4. Худалдан авах ажиллагааны цахим систем	2
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх	2
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага	2
7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага	3
Б. АГУУЛГА	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичиг	3
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	3
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт	4
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах	4
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	4
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	4
13. Тендерийн иж бүрдэл	4
14. Тендерийн жишиг маягтууд	5
15. Хувилбарт санал	5
16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг	5
17. Чадавхын болон туршлагын шаардлага	5
18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	6
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт	6
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг	6
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	6
22. Тендерийн валют	7
23. Тендер хүчинтэй байх хугацаа	7
24. Тендерийн баталгаа	7
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	8
25. Тендер баталгаажуулах, илгээх	8
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	8
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	8
27. Тендерийн талаар тодруулга авах	8
28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх	8
29. Тендерийг үнэлэх	8
30. Арифметик алдааг залруулах	8
31. Давуу эрх олгох	9
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	9
33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох	9
34. Тендерийг эрэмбэлэх	9
35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах	9
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	9
36. Мэдэгдэл хүргүүлэх	9
37. Гүйцэтгэлийн баталгаа	9
38. Урьдчилгаа төлбөр	10
39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	10

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий

шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг

нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн

хөнгөлөлт

хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2.Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3.Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4.ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5.ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6.Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.2. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.3. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1.Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2.ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт 7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2.Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1.Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1.Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1.Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

29.2.Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.3.Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

30. Арифметик алдааг залруулах

30.1.Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2.ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг

- залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 36. Шийдвэр хүргүүлэх**
- 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37. Гүйцэтгэлийн баталгаа**
- 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох

- журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Урьдчилгаа төлбөр**
- 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
- 38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ								
ТШЗ 1.1	Захиалагч: <i>Үндэсний геологийн алба</i> Тендер шалгаруулалтын нэр: <i>Геологи хайгуулын судалгааны ажил</i> Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: УГА/20260101010								
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="width: 20%;">Д/д</th> <th>Багцын нэр</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Багц №1</td> <td>2026-2029 ГҮЙЦЭТГЭХ ХӨРСНИЙ ГЕОХИМИ-ЭРДЭСЛЭГ БҮРЭЛДЭХҮҮН-ГЕО ОРЧНЫ СУДАЛГААНЫ АЖИЛ</td> </tr> <tr> <td>Багц №2</td> <td>2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ МОНГОЛ УЛСЫН ХОЙД ХИЛ ОРЧМЫН НУТГИЙН ГЕОЛОГИ, ГЕОХИМИЙН ЗУРАГ ЗОХИОХ СУДАЛГААНЫ АЖИЛ</td> </tr> <tr> <td>Багц №3</td> <td>2026-2030 ОНД ГҮЙЦЭТГЭХ МОНГОЛ УЛСЫН ӨМНӨД ХИЛ ОРЧМЫН НУТГИЙН ГЕОЛОГИ, ГЕОХИМИЙН ЗУРАГ ЗОХИОХ СУДАЛГААНЫ АЖИЛ</td> </tr> </tbody> </table>	Д/д	Багцын нэр	Багц №1	2026-2029 ГҮЙЦЭТГЭХ ХӨРСНИЙ ГЕОХИМИ-ЭРДЭСЛЭГ БҮРЭЛДЭХҮҮН-ГЕО ОРЧНЫ СУДАЛГААНЫ АЖИЛ	Багц №2	2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ МОНГОЛ УЛСЫН ХОЙД ХИЛ ОРЧМЫН НУТГИЙН ГЕОЛОГИ, ГЕОХИМИЙН ЗУРАГ ЗОХИОХ СУДАЛГААНЫ АЖИЛ	Багц №3	2026-2030 ОНД ГҮЙЦЭТГЭХ МОНГОЛ УЛСЫН ӨМНӨД ХИЛ ОРЧМЫН НУТГИЙН ГЕОЛОГИ, ГЕОХИМИЙН ЗУРАГ ЗОХИОХ СУДАЛГААНЫ АЖИЛ
Д/д	Багцын нэр								
Багц №1	2026-2029 ГҮЙЦЭТГЭХ ХӨРСНИЙ ГЕОХИМИ-ЭРДЭСЛЭГ БҮРЭЛДЭХҮҮН-ГЕО ОРЧНЫ СУДАЛГААНЫ АЖИЛ								
Багц №2	2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ МОНГОЛ УЛСЫН ХОЙД ХИЛ ОРЧМЫН НУТГИЙН ГЕОЛОГИ, ГЕОХИМИЙН ЗУРАГ ЗОХИОХ СУДАЛГААНЫ АЖИЛ								
Багц №3	2026-2030 ОНД ГҮЙЦЭТГЭХ МОНГОЛ УЛСЫН ӨМНӨД ХИЛ ОРЧМЫН НУТГИЙН ГЕОЛОГИ, ГЕОХИМИЙН ЗУРАГ ЗОХИОХ СУДАЛГААНЫ АЖИЛ								
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”								
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн хөрөнгө								
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 29,744,768,000 төгрөг								
Б. АГУУЛГА									
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: <i>Үндэсний геологийн алба</i> Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 18072, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрчний эвлэл-37 Цахим шуудангийн хаяг: info@ngs.gov.mn								
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”								
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ									
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: <i>Монгол хэл. Саналд хавсарган ирүүлэх материал нь гадаад хэл дээр бол түүний баталгаат орчуулгыг мөн хавсаргана. Энэ шаардлагаас зөрүүтэй бол захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно.</i>								
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”								
ТШЗ 16.1.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана” <i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн:</i> 7.1. Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ: 7.1.1. төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах шийдвэр гарсан, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлсэн, бизнесийн үйл ажиллагааг зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эдгээртэй адилтгах нөхцөлд байгаа; 7.1.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй; 7.1.3. Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдийн оролцсон тендер шалгаруулалт, түүний багцад тендер ирүүлсэн; 7.1.4. тухайн тендер шалгаруулалтад оролцохдоо бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцсон; 7.1.5. энэ хуулийн 4.1.10-т заасан этгээд; 7.1.6. дараах этгээдийн аль нэг нь авлигын, эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон: 7.1.6.а. оролцогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд; 7.1.6.б. оролцогчийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан эцсийн өмчлөгч; 7.1.6.в. оролцогчийн Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан.								

	<p>7.1.7.тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахад зөвлөгөө өгсөн, оролцсон, эсхүл тухайн зөвлөгөө өгсөн, оролцсон этгээдтэй харилцан хамааралтай;</p> <p>7.1.8.тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй;</p> <p>7.1.9.энэ хуулийн 56.5.3, 56.5.4, 56.5.5-д заасан үндэслэлээр тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан, эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд,</p> <p>7.1.10.хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4-т заасан хүүхэд хамгааллын бодлого батлаагүй хуулийн этгээд.</p> <p>7.2.Оролцогч энэ хуулийн 7.1-д заасан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг бичгээр гаргана.</p> <p>7.3.Энэ хуулийн 7.1-д заасан нөхцөлийг магадлахтай холбогдох баримт бичиг ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бол оролцогч Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргуулан ирүүлнэ.</p> <p>7.4.Түншлэлийн гишүүн тус бүр ерөнхий шаардлага хангасан байх бөгөөд холбогдох мэдэгдэл, баримт бичгийг энэ хуулийн 7.2, 7.3-т зааснаар ирүүлнэ.</p>
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”</p> <p>Оролцогчид тавих доод шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> - Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын дундаж нь батлагдсан төсөвт өртгийн 15 хувиас багагүй байх. - Түргэн хөрвөх хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Батлагдсан төсөвт өртгийн 10 хувиас багагүй байх /дансны үлдэгдлийн банкны тодорхойлолт, авах боломжтой зээлийн тодорхойлолтыг гаргаж ирүүлнэ/. - Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p>1. Үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацаа:</p> <p>1.1. Оролцогч эсхүл түншлэлийн гишүүн нь Монгол Улсад бүртгэлтэй бол 2023, 2024, 2025 оны санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.ebalance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p>1.2. Оролцогч нь гадаад улсад бүртгэлтэй тохиолдолд сүүлийн хоёр жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайланг тендерт ирүүлэхдээ Монгол хэл рүү орчуулан ирүүлнэ.</p> <p>2. Хууль тогтоомжоор санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд 2023, 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт ирүүлнэ.</p> <p>3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч тендерт хавсарган ирүүлнэ. Уг асуудлаар харилцагч банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа авч ирүүлэхгүй.</p>
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын доод шаардлага: “Шаардана”</p> <p>1. Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана”</p> <p>Оролцогчийн санал болгох ажилтанд шаардагдах туршлагын доод түвшин:</p> <p>Төсөлд ажиллах ИТА (Улсын төсвийн санхүүжилттэй геологийн судалгааны хэрэгжиж буй төслүүдэд зөвлөхөөр ажиллаж байж болно. Инженер техникийн ажилчдын хувьд төсөл нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хяналтын хуудсаа авсан байж болно. Бусад тохиолдолд захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно)-ын бүрэлдэхүүн, тодорхойлолт. Үүнд:</p> <p>1. Хөрсний геохими-эрдэслэг бүрэлдэхүүн-гео орчины судалгааны ажилд:</p>

Төслийн удирдагч-1, ахлах геохимич-1, геологич-2, геофизикч-1, гидрогеологич-1, гидрологич-1, ахлах хөрс судлаач-1, агрономич, хөрс судлаач-1, хөрсний дижитал зураг зохиогч-1, хөрсний эрдэс судлаач-1, хөрсний химич-1, газар зохион байгуулалт, экологийн мэргэжилтэн-1 нийт 13 хүн.

2. “Монгол Улсын хойд хилийн орчмын нутгийн геологи, геохимийн зураг зохиох судалгаа”, “Монгол Улсын өмнөд хилийн орчмын нутгийн геологи, геохимийн зураг зохиох судалгаа”-ны ажилд:

Төслийн удирдагч-1, ахлах геохимич-1, ахлах геологич-1, геохимич-1, геологич-5, газарзүй мэдээллийн систем хариуцсан геологи -2, нийт 11 хүн.

Багийн бүрэлдэхүүний туршлага, ур чадварын шалгуурын доод үзүүлэлт

1. Хөрсний геохими-эрдэслэг бүрэлдэхүүн-гео орчины судалгааны ажилд

Албан тушаал	Мэргэжил боловсрол, туршлага	Үндсэн эсхүл гэрээт ажилтан байх
Төслийн удирдагч	-Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд 10-аас доошгүй жил ахлах геологич болон түүнээс дээш түвшинд ажилласан байх, -Мэргэшсэн эсхүл Зөвлөх геологич байх	Үндсэн
Ахлах геологич	-Геологийн зураглалын чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан байх -Мэргэшсэн эсхүл Зөвлөх геологич байх	Үндсэн
Ахлах хөрс судлаач	- Хөрс судлалын чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан байх Газар тариалангийн хээрийн ажил удирдаж байсан, экосистемийн загварчлал буюу тархалтын загвар хийж байсан туршлагатай байх	Гэрээт байж болно
Геологич	Геологийн зураглал, эрэл, хайгуулын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	Үндсэн
Геофизикч	-Геофизикийн судалгааны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	Гэрээт байж болно
Гидрогеологич	Гидрогеологийн мэргэжилийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	Гэрээт байж болно
Гидрологич	Гидрологийн мэргэжилийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	Гэрээт байж болно
Агрономич, хөрс судлаач	Хөрс судлалын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх - Газар тариалангийн салбарт хөрсний үнэлгээ (экологи, эдийн	Гэрээт байж болно

	засгийн) чиглэлээр ажилласан туршлагатай байх	
Хөрсний дижитал зураг зохиогч	Хөрсний эрдэс, хэмхдэсийн судалгааны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	Гэрээт байж болно
Хөрсний эрдэс судлаач	Хөрс судлалын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	Гэрээт байж болно
Хөрсний химич	Хөрсний геохими, химийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх.	Гэрээт байж болно
Газар зохион байгуулалт, экологийн мэргэжилтэн	Газар зохион байгуулалт, экологийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх. -Хөрсний хээрийн үнэлгээний дата мэдээллийн сан, лабораторийн дата өгөгдөл, датабааз, тандан судалгаа, сателитын дата дээр ажилласан туршлагатай байх	Гэрээт байж болно

2. “Монгол Улсын хойд хилийн орчмын нутгийн геологи, геохимийн зураг зохиох судалгаа”, “Монгол Улсын өмнөд хилийн орчмын нутгийн геологи, геохимийн зураг зохиох судалгаа”-ны ажилд

Албан тушаал	Мэргэжил боловсрол, туршлага	Үндсэн эсхүл гэрээт ажилтан байх
Төслийн удирдагч	- Геологийн судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлээр 10-аас доошгүй жил ахлах геологич эсхүл түүнээс дээш түвшинд гүйцэтгэж байсан, -Мэргэшсэн эсхүл Зөвлөх геологич байх.	Үндсэн
Ахлах геологич	-Геологийн зураглалын чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх -Мэргэшсэн геологич байх	Үндсэн
Ахлах геохимич	-Геохимийн чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх -Мэргэшсэн геологич байх	Гэрээт байж болно
Геологич	Геологийн зураглал, эрэл, хайгуулын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх	Үндсэн
Геохимич	Геологийн зураглал, эрэл, хайгуулын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх	Гэрээт байж болно
Газарзүй мэдээллийн систем хариуцсан	Газарзүй мэдээллийн системийн программ хангамж бүрэн эзэмшсэн, энэ чиглэлээр 2-оос доошгүй жил ажилласан, эсвэл ижил төсөөтэй төсөлд Газарзүй мэдээллийн системийн ажилтнаар оролцсон байх.	50 хувь нь гэрээт байж болно

Санал болгох ажилтнуудын боловсрол, мэргэжил, туршлагын мэдээллийг нотлох баримтын шаардлага хангаж ирүүлэх ба материалын бүрдэл дутуу, шаардлага хангахгүй (уншигдахгүй) бол захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно.

Хүний нөөцийн мэдээллийг дараах баримтаар нотолно. Үүнд:

- Дипломын хуулбар /нотариат эсхүл “ИМонголиа” цахим системээс татаж авсан лавлагаа/
- Зөвлөх, мэргэшсэний хүчинтэй үнэмлэх
- Нийгмийн даатгалын лавлагаа: Цахим системээс харна. /Хэрвээ цахим системд бүртгэлгүй бол тендерээс татгалзах үндэслэл болно. Үндсэн ажилтан нь сүүлийн 3 сарын нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн байна/.
- ИТА-тай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хуулбар /нотариат/
- Гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл /МУ-д бол судалгааны ажил хамгаалсан тайлангийн ЭБМЗ-ийн дүгнэлт, ОУ-д бол холбогдох мэдээллийг цахим орчинд танилцах холбоос/
- Хэрэв инженер, техникийн ажилтнууд нь гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбар эсвэл “ИМонголиа” цахим системээс татаж авсан лавлагааг ирүүлнэ. Хөлсөөр ажиллуулах гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгаасан байна.

Анхааруулга: Хүний нөөцийн боловсролын мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-аар нотлох гэж байгаа бол инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн эсвэл цахим системд бүртгэл байхгүй бол тендерийн нээлтээс өмнө Боловсролын яамны Цахим боловсрол, статистик, мэдээллийн хэлтэс, Боловсролын ерөнхий газарт хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү.

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <https://e-mongolia.mn/>

2. Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн доод шаардлага: “Шаардана”

Геологийн судалгаанд ашиглагдах автомашин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл:

“Хөрсний геохими-эрдэслэг бүрэлдэхүүн-гео орчины судалгаа”, “Монгол Улсын хойд хилийн орчмын нутгийн геологи, геохимийн зураг зохиох судалгаа”, “Монгол Улсын өмнөд хилийн орчмын нутгийн геологи, геохимийн зураг зохиох судалгаа”-ны ажилд:

- Туулах чадвар сайтай (4x4) хүн тээврийн автомашин – хамгийн багадаа 4
- Туулах чадвар сайтай ачаа тээврийн автомашин – хамгийн багадаа 2
- Геологийн судалгааны ажилд шаардагдах бусад тоног төхөөрөмж, техник хэрэгсэл.

Санал болгож байгаа тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээллийг V бүлгийн маягт 3-ын дагуу ирүүлэх ба тэдгээрийн гэрчилгээний хуулбар, холбогдох техникийн үзүүлэлтийг нотлох баримтын шаардлага хангаж ирүүлнэ. Түрээсээр ашиглах бол түрээсийн гэрээний хуулбарыг мөн адил нотлох баримтын шаардлага хангаж ирүүлнэ.

Ажилчдад тухайн ажлыг гүйцэтгэх орчин нөхцөл /ажлын байр, хээрийн ажил явуулах орчин, багаж хэрэгсэл, геологийн мэдээлэл боловсруулалтын программ хангамж, аюулгүй ажиллагааны хэрэгсэл, хангамж гэх мэт/-ийг бүрдүүлэх чадамж, материалын бүрдэл дутуу,

	<p>шаардлага хангахгүй (уншигдахгүй) бол захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>3. Ижил, төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын доод шаардлага: “Шаардана”</p> <p>3.1. Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн: - Сэдэвчилсэн судалгааны ажлын хувьд 10 хувиас багагүй үнийн дүнтэй геологийн судалгааны (ижил, төстэй) ажлыг сүүлийн гурван хүртэл жилийн хугацаанд доод тал нь 1 удаа гүйцэтгэсэн байх. Гүйцэтгэсэн ажлын мэдээлэлд 1/ төсөвт өртөг, 2/ гэрээний хуулбар, 3/ гэрээ дүгнэсэн акт эсхүл түүнтэй ижил баримтыг /ЭБМЗ-ийн дүгнэлт, холбогдох Төрийн захиргааны төв болон Төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт/ хавсарган ирүүлнэ.</p> <p>4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”</p> <p>4.1. Геологийн судалгааны (ижил төстэй) ажил хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсныг нотлох баримт буюу гэрээний хуулбар, эсхүл Захиалагчийн мэдээдэл, тодорхойлолт; Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээллийг Маягт 5-ын дагуу гаргаж ирүүлнэ. Тухайн судалгааны ажлыг захиалагчийн геологийн даалгаврын дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэхийг баталсан мэдээдэл заавал ирүүлнэ.</p>								
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - Шаардсан хүний нөөцийн мэдээллийг V бүлгийн маягт 2-ын дагуу ирүүлэх; - Оролцогчийн туршлагыг харуулах хэсэгт заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн маягт - 4, 5, 6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл; - Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээллийг V бүлгийн маягт 3 (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт)-ын дагуу нотлох баримтын хамт ирүүлэх; - Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт. <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичигт заасан мэдээлэл нь тус судалгааны ажлын геологийн даалгаврын шаардлагыг хангахгүй бол Захиалагч ирүүлсэн тендерээс татгалзана.</p>								
ТШЗ 21.6	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”.								
ТШЗ 21.6	Оролцогч тендерийн үнийг төсөвт өртгийн 90 хувиас доош үнэ санал болгох бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ. Ирүүлсэн тайлбар судалгааны ажлын геологийн даалгаварт заасан шаардлагыг бүрэн биелүүлэхгүй тохиолдолд Захиалагч тендерээс татгалзана.								
ТШЗ 21.6	Тендерийн үнийг Төгрөг -өөр илэрхийлнэ.								
ТШЗ 24.1	Тендерийн хүчинтэй байх хугацаа тендер нээснээс хойш ажлын 30-аас доошгүй өдөр байна.								
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: Төсөвт өртгийн 0.5 хувь								
	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Төслийн кодын нэр</th> <th>Батлагдсан төсөвт өртөг</th> <th>Баталгаа /төсөвт өртгийн 0.5 хувь/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Багц №1</td> <td>Хөрсний геохими-эрдэслэг бүрэлдэхүүн-гео орчны судалгаа /Код: Гео-Хөрс-2026/</td> <td>4,744,768,000.00</td> <td>23,723,840.00</td> </tr> </tbody> </table>	№	Төслийн кодын нэр	Батлагдсан төсөвт өртөг	Баталгаа /төсөвт өртгийн 0.5 хувь/	Багц №1	Хөрсний геохими-эрдэслэг бүрэлдэхүүн-гео орчны судалгаа /Код: Гео-Хөрс-2026/	4,744,768,000.00	23,723,840.00
№	Төслийн кодын нэр	Батлагдсан төсөвт өртөг	Баталгаа /төсөвт өртгийн 0.5 хувь/						
Багц №1	Хөрсний геохими-эрдэслэг бүрэлдэхүүн-гео орчны судалгаа /Код: Гео-Хөрс-2026/	4,744,768,000.00	23,723,840.00						

	Багц №2	Монгол Улсын хойд хилийн орчмын нутгийн геологи, геохимийн зураг /Код: Гео-Хойд-2026/	10,000,000,000.00	50,000,000.00
	Багц №3	Монгол Улсын өмнөд хилийн орчмын нутгийн геологи, геохимийн зураг /Код: Гео-Өмнөд-2026/	15,000,000,000.00	75,000,000.00
Хүчинтэй байх хугацаа: Тендерийн хүчинтэй байх хугацаа буюу тендер нээснээс хойш ажлын 29-өөс доошгүй өдөр байна.				
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ				
ТШЗ 25.5	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: <ul style="list-style-type: none"> - ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 7 дугаар зүйлд заасан оролцогчийн ерөнхий шаардлагууд - Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл - ТБОНӨХБАҮХАТХуулийн 22.5-д заасан үндэслэлээр ил болгохгүй баримт бичиг, мэдээлэл байгаа бол түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл - Тендер шалгаруулалтын баримт бичигт ил болгохоор заасан бусад баримт бичиг (Судалгааны ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө, төсөл гэх мэт) 			
ТШЗ 26.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2026 оны 04 сарын 06-ны өдөр Цаг: 14 цаг 00 минут			
ТШЗ 26.2	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Цаг: 14 цаг 30 минут Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 18072, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрчний эвлэл-37, Үндэсний геологийн албаны байр, 2 дугаар давхар, 219 дүгээр өрөө			
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ				
ТШЗ 31.1	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: 1. Давуу эрх тооцуулах тухай албан хүсэлт ирүүлнэ. 2. ТБОНӨХБАҮХАТХуулийн 8.7.2-д заасны дагуу давуу эрх тооцуулах нөхцөл хангаж буй талаар нотлох баримт бичиг ирүүлнэ. (Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, загвар”-ын дагуу давуу эрх олгож, үнэлнэ)			
ТШЗ 32.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”			
Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ				
ТШЗ 37.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Тийм” <ul style="list-style-type: none"> - Гүйцэтгэлийн баталгаа нь тухайн жилд санхүүжих үнийн дүнгийн 3 хувь байна. - Гүйцэтгэгч нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 42.3 дахь заалтад заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ. - Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг Захиалагчийн тогтоосон хугацаанд ирүүлнэ. 			
Ё. БУСАД				
ТШЗ 38.1	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”			

МОНГОЛ УЛС
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

БАТЛАВ: АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА **Б.ДАШНҮРЭВ**

2026 оны 03-р сарын 16-ний өдөр



Улаанбаатар хот

Дугаар 2026/08

МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮС НУТАГТ 2026-2029 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРСНИЙ ГЕОХИМИ-ЭРДЭСЛЭГ БҮРЭЛДЭХҮҮН-ГЕО
ОРЧНЫ СУДАЛГААНЫ АЖЛЫН ГЕОЛОГИЙН ДААЛГАВАР

Судалгааны үе шат:	<i>Региональ</i>
Судалгааны төрөл:	<i>Сэдэвчилсэн судалгаа</i>
Судалгааны талбайн нэр:	<i>Хөрсний геохими-эрдэслэг бүрэлдхүүн-гео орчин</i>
Судалгааны талбайн байршил:	<i>Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар тариалангийн бүс нутгууд</i>
Талбайн хэмжээ:	<i>Газар тариалангийн бүс нутагт хамаарах 25 000 кв.км талбай</i>
Код:	<i>Гео-Хөрс-2026</i>
Төсөл хэрэгжих хугацаа	<i>2026-2029</i>

1. Геологийн даалгавар боловсруулах хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24 дэх хэсэг, “Ашигт малтмалын тухай” хуулийн 16 дугаар зүйл, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2, Монгол улсын Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Атар-4” аяны зорилт, арга хэмжээний 1.1.3, 1.1.6, УИХурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ийн 3.5.2, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төсөл, төлөвлөгөө”.

2. Судалгааны талбайн судлагдсан тувшин:

Судалгааны талбай нь 1:200000-ны масштабтай геологийн зураглал, 1:500000-ны масштабтай гидрогеологийн зураглал, 1:200000-ны масштабтай агаарын соронзон зураглалаар бүрэн, 1:200000, 1:100000-ны масштабтай, 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизикийн комплекс судалгаа, гидрогеологийн судалгаа, геофизикийн төрөлжсөн судалгаагаар хэсэгчлэн бүрхэгдсэн байна.

Судалгааны ажлын үндэслэл

Монгол орны газар тариалангийн үйлдвэрлэл нь урт удаан хөгжлийн түүхтэй боловч 1960 оноос “Атар” -ын аянуудын хүрээнд эрчимжиж ирсэн. “Атар-2” аяны хүрээнд хөрсний үржил шимийн үзүүлэлт ихтэй нугархаг хар шороон болон ам хөндийн харшороон, хархүрэн хөрсний хэв шинжүүдийг өргөн ашиглаж ирсэн бөгөөд манай орны газар тариалангийн салбар голчлон байгаль-цаг уурын нөхцөлд тулгуурласан шинжтэй хөгжиж ирсэн тул хөрсний ялзмагийн агууламжын бууралт, физик шинж чанар, нягтшил, ус-чийг барих чадвар зэрэг үзүүлэлтүүд байга буурч ирсэн.

Газар тариалангийн бүс нутагт хөрсний шинж чанарын өөрчлөлт нь түүний хөрсний эрсдэслэг бүрэлдэхүүний өөрчлөлтөөс хэрхэн хамаарах болон хөрс үүсгэгч анхны хүчин зүйл болох геологийн хурдас, чулуулгийн тогтоц, түүний хэв шинжээс шууд хамаарах зүй тогтлыг илрүүлэх судалгааны ажил төдийлөн хийгдээгүй дутагдалтай тал байдаг.

Иймд хөрсний судалгаанд минералоги, гео-орчин, геологи-геоморфологи гэх мэт геологийн арга аргачлалуудыг хэрэглэн геологи, агрономи, газар ашиглалтын салбаруудын хамтарсан иж бүрэн судалгааны ажлыг хэрэгжүүлсэнээр газар тариалан эрхэлж буй талбайн хөрсний өөрчлөлтөөс гадна геоморфологи, ландшафтын нөхцөл байдалд гарч буй байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой хувьсал, өөрчлөлт, гамшгийн түвшнийг судлах, одоо байгаа болон ирээдүйд хөгжүүлэхээр төлөвлөж буй газар тариалангийн талбай орчимд геоэкологийн суурь үнэлгээ өгөх, гео орчин, хөрсний эрдэслэг бүрэлдэхүүний судалгаа болон хөдөө аж ахуйг нэгтгэсэн цогц судалгаа хөгжүүлэх суурь нөхцөлийг бий болгох үндэс суурийг тавих мэргэжлийн зөвлөмж гаргахад энэхүү төслийн ач холбогдол оршино.

Эдийн засаг дэд бүтэц:

Судалгааны талбайд Монгол Улсын хүнсний хангамжийн гол эх үүсвэрийн нэг болох газар тариалангийн талбай бүхий нутаг хамаарах тул хүн ам, суурьшил ихтэй, дэд бүтэц сайн хөгжсөн, өндөр хүчдэл, автозам зэрэг шугаман байгууламжтай.

3. Ажлын зорилго:

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хүнсний хувьсгал” хөтөлбөр, “Атар-4” аян, цөлжилтийг сааруулах, газрын доройтлыг бууруулах, хөрс хамгаалах

үндэсний бодлогын хүрээнд газар тариалангийн бүс нутгийн хөрсний эрдэслэг бүрэлдэхүүн, хэмхдэсийн агууламж, найрлагыг тодорхойлох, хөрсний физик, геохими-агрохимийн иж бүрэн судалгаа явуулах, гео орчны болон геоэкологийн эрсдэлийн үнэлгээ хийх цогц ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэхүү төсөл нь хөдөө аж ахуй газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих, хүн амын хүнсний хэрэгцээ болон аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино.

Төсөл нь 2026-2029 онд хэрэгжих бөгөөд төслийг үр дүнтэй гүйцэтгэх, мэдээллийн санг харилцан уялдаатай бүрдүүлэх, төслийн үр дүнг бусад салбарт өргөн хэрэглэгдэхээр боловсруулах зорилгоор хийгдэх тул гео орчин, хөрсний геохими-эрдэслэг бүрэлдэхүүн гэсэн 2 дэд төсөл хэлбэрээр хэрэгжүүлнэ. Төслийг хэрэгжүүлсэнээр тухайн бүс нутагт геоэкологийн эрсдэлийн зэрэглэл тогтоож, ирээдүйд гадаргын болон газрын доорх усны нөөц баялаг, эх үүсвэрт нөлөөлөх хүчин зүйл, түүний хэрэглээг тодорхойлох, тариалан эрхлэлттэй холбоотойгоор геосистемд нөлөөлөх байгалийн болон антропоген (хүний хүчин зүйл) хүчин зүйл, хүрээлэн буй орчны хувьсал өөрчлөлтүүдийг судалгааны гол объект болгон улмаар газрын гадаргуугийн хөгжлийн ойрын болон хэтийн төлөвийг тодорхойлж, цогц үнэлгээ өгнө.

Хөрсний эрдэслэг бүрэлдэхүүнийг тодорхойлсноор өөрийн орны дотоод нөөц бололцоог ашиглан тухайн газар тариалангийн талбайд тохирсон байгалийн гаралтай бордооны найрлагыг тодорхойлох, ашиглалт эргэлтэнд оруулах боломжийг бий болгосноор импортын химийн гаралтай бордооны хэмжээг багасгах ач холбогдолтой бөгөөд мөн түүнчлэн гео шинжлэх ухааны үр дүнг зүй зохистой ашигласнаар тухайлбал гадаргын болон газрын доорх усыг газар тариаланд зөвхөн усалгаанаас гадна хөрсний ус чийг нөөцлөх чадавхи, уснаас үүдэлтэй давсжилт, карбонат зэрэг эрдсийн шилжилтийг үнэлэх тариалангийн хэмжээнд эерэг нөлөө үзүүлэх боломж бүрдэнэ.

Төслийн үр дүнд:

3.1. Судалгааны талбайн хэмжээнд геохими, геоэкологи, геоморфологи, гидрогеологи, гидрологи, геогамшигийн судалгааны ажлыг нэгтгэж, дүн шинжилгээ хийх, зөвлөмж гаргана (өмчлөлийн болон эзэмшил бүхий тариалангийн талбайтай холбоотойгоор хийгдсэн судалгаануудыг нэгтгэнэ). Холбогдох лабораторийн шинжилгээгээр тоон мэдээллийн сан үүсгэнэ.

3.2. Геоэкологийн судалгаагаар гео орчин, техноген өөрчлөлтөнд орохоос өмнө болон орсон талбайд судалгаа хийх, хүн амын суурьшил, газар тариалантай холбоотойгоор гарч болох нөлөөлийг тогтоох, эрсдэлд үнэлгээ өгөх, мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх, зураг зохиох, тодорхой жилийн давтамжтай хэтийн төлөвийг тодорхойлоно.

3.3. Судалгааны чиглэлээр холбогдох төрөлжсөн болон нэгдсэн тоон мэдээллийн санг бүрдүүлнэ.

3.4. Газар тариалангийн үйл ажиллагаатай холбоотой үүсэж буй гео орчны нөлөөлөл, хүчин зүйлүүд, зэрэглэлийг тогтооно. Экологид ээлтэй эрчимжсэн газар тариалан эрхлэхэд байгалийн нөөц экологийн чадавхи, боломж, нөөцийг харуулсан зураг хийгдэнэ.

3.5. Геологийн суурь нөхцөлтэй уялдуулан зонхилон тархсан хөрсний хэв шинжийн тархалттай уялдуулан хөрсний онцлог, генетик, агрегат шинжүүдийг тодруулах, экологи-геохимийн зураг хийгдэнэ.

3.6. Зонхилох хөрсний хэв шинжийн судалгааны хүрээнд литогеохимийн шинжилгээгээр анхдагч болон хоёрдогч эрдсийн агууламжыг тодорхойлон, хөрсний үе давхаргыг ашиглан нөөцийг тооцоолж, судалгааны талбайн хэмжээнд шинж чанарийн үзүүлэлтүүдээр зураглал зохиох.

3.7. Судалгааны талбайн хөрс үүсвэрийн хүчин зүйлүүдийг үнэлэх, олон улсын түвшинд шинээр хөгжин туршигдаж аргачлалд тулгуурлан зайнаас тандан судлал, газарзүйн мэдээллийн систем, machine learning зэрэг загварчлалаар баяжуулан зураглалын загвар жишээ хөгжүүлэх.

3.8. Талбайн хэмжээнд тархсан хөрсний эрдэслэг бүрэлдэхүүн болон түүний тархалтыг судалж, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө. Тариалангийн талбайн хөрсний дижитал зураглалыг бий болгож тухайн талбайн түүхийн талаарх тоон мэдээллийн сан бүрдэнэ.

3.9 Тариалангийн бүс нутгуудад тохирсон сэлгээний тарималуудыг судлах, шинэчлэх, хөрсний үржил шимийг сайжруулах, ургацыг нэмэгдүүлэх санал, зөвлөмж гаргана. Хөрсний эрдсийн найрлагыг судлаж, хөнгөн ба хүнд хөрсөнд хольж хөрсний ус барих чадварыг дээшлүүлэх чиглэлд зөвлөмж гаргах, мөн импортын эрдэс бордоог орлох эрдсийн найрлагуудыг зөв ашиглах, хэрэглээнд оруулах зөвлөмж гарна.

3.10. Уур амьсгалын өөрчлөлт, дулааралд өртөж хөрснөөс ялгарах нүүрсхүчлийн хийн ялгарлыг тогтоох, тариалангийн эрсдэлийн судалгаанд үндэслэн эрсдэлийг бууруулах, уур амьсгалд дасан зохицсон технологийн талаар санал, зөвлөмж гаргана.

3.11. Усалгаатай газар тариаланд ашиглагдах усны эх үүсвэр, усыг барьж тогтоох онцлог бүхий хөрсний талаар болон хөрсний менежментийг зөвөлмжийг ургамлын эрдсийн найрлагад тулгуурлан бордох, ургацын мэдээлэлтэй уялдуулан хөрсний шим тэжээлийн хэрэглээг тооцоолох талаар санал, зөвлөмж гарна.

Энэ нь цаашид тариалангийн талбай бүхий нутагт хэтийн болон дунд, ойрын хугацааны төлөвлөлт, судалгаа, шинжилгээ, үнэлгээ, хяналт, болон бусад хэрэглээд ашиглагдах суурь мэдээлэл болно.

4. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх үндсэн арга зүй, аргачлал болон дэс дараалал:

А. Бэлтгэл ажлын үе:

4.1. Талбайн хэмжээнд өмнө нь хийж гүйцэтгэсэн геологийн үе шатны судалгааны болон сэдэвчилсэн судалгааны материалуудыг судлан танилцаж, дүн шинжилгээ хийж түүний үндсэн дээр тухайн талбайд тохирсон судалгааны арга аргачлалыг сонгоно. Үүнд:

4.1.1. УГА-ны Гео-мэдээллийн төвтэй зөвшилцөн, нууцлалын гэрээний үндсэн дээр бүх шатны судалгааны ажлын үр дүнг багтаасан мэдээллийн сан үүсгэх, баяжуулах, мэдээллийн боловсруулан үнэлэлт, дүгнэлт өгч, өөрсдийн судалгааны ажлын суурыг бэлтгэх, арга аргачлал боловсруулах, мэдээллийн баримт материалын зургийг зохиож бүртгэл үйлдэх;

4.1.2. Өмнөх судалгааны материалд үндэслэн газар тариалан бүхий талбайн дээжлэлтийн арга, аргачлалыг урьдчилсан байдлаар боловсруулах;

4.1.3. Төслийн талбайн хэмжээнд мэдэгдэж байгаа геохимийн сарнилын хүрээ, гажлуудын бүртгэл үйлдэн, дүн шинжилгээ хийх.

4.1.4. АСЗ-г хийсэн тайлалтын зургийг төслийн ажлын онцлогоос хамаарч 1:25000-ны масштаб болон түүнээс том масштабаар нэгдсэн таних тэмдгийн хамт урьдчилсан байдлаар зохиосон байх;

4.1.5. Хээрийн ажилд гарахын өмнө талбайн геологи, геоморфологи стратиграфи, магматизм, тектоникийн тодорхой мэдээлэл, урьдчилсан тайлалт хийсэн зургийн хүрээнд танилцах маршрут төлөвлөх, гүйцэтгэх;

4.1.6. Газар тариалангийн өнөөгийн өмчийн хэлбэрээс хамааран төсөлд холбогдох тайлан, мэдээг төслийн бэлтгэл ажилд авч ашиглахдаа УГАлба, ХХААХҮЯам болон бусад төрийн, төрийн бус байгууллага, хуулийн этгээдтэй хамтран ажиллана.

4.1.7. Хээрийн судалгааны ажилд бэлтгэх, машин техник, тоног төхөөрөмж, шаардлагатай багаж хэрэгсэл, материал, эд зүйлээр хангах, инженер-техникийн багийг бүрдүүлэх. Хээрийн судалгааны өмнөх бэлтгэл ажлуудыг бүрэн хангана.

4.1.8. Иж бүрэн хийгдэх судалгааны онцлогоос хамаарч олон төрлийн дээж сорьц авах шаардлага бий болох тул дээж, сорьцыг цуглуулах, тээвэрлэх, шинжилгээний явцад бүрэн бүтэн байдлыг хадгалж, баталгаажуулах, үүнтэй холбоотойгоор батлагдсан стандартыг мөрдөн ажиллах арга аргачлалыг боловсруулж захилагчаар хянуулах, бий болгох.

4.1.10. Судалгааны ажлын төсөл, төсөв, календарьчилсан төлөвлөгөө зохиох,

Б. Хээрийн ажлын үе:

Гео орчны судалгааны чиглэлд:

4.2. Танилцах маршрутыг хийж, талбайн геологи, геоморфологи, геохими гео-орчны ерөнхий хэв-шинжтэй танилцаж, төсөлд тусгасан судалгааны арга аргачлал нийцэж буй эсэхийг тодорхойлон шаардлагатай засварыг оруулах.

4.2.1. Судалгаанд хамрагдаж буй нутгийн хэмжээнд геологи, тектоник, геоморфологи, геохими, гидрогеологи, гидрологийн маршрутын ажиглалт, уст цэгийн бүртгэл хийн структур-тектоникийн байдал, геологийн тогтоц, ландшафт, цэвдэг, гидрологи, гидрогеологийн байгалийн суурь нөхцөлтэй танилцан агаар сансрын зургийн зохих тайлал, боловсруулалтыг гүйцэтгэх, анхан шатны боловсруулалтыг гүйцэтгэн тухайн геологи орчны нөхцөлийн байгалийн шинжийг тогтоох,

4.2.2. Төслийн талбайд хамрагдсан нутаг дэвсгэрийн хэмжээнд урьд өмнө гүйцэтгэсэн дотоод, гадаад судлаачдын холбогдох судалгааны материалтай нарийвчлан танилцаж дүн шинжилгээ хийх, шаардлагатай баримт, мэдээллийг бүрдүүлэх, региональ судалгааны ажлын төрөл ба арга зүй, аргачлал дагаж мөрдөх стандартыг оновчтойгоор сонгох. Монгол улсад дагаж мөрдөгдөж эхлээгүй шинэлэг стандарт хэрэглэх тохиолдолд ҮГА-тай зөвшилцөн дагаж мөрдөх,

4.3. Хээрийн судалгаагаар төлөвлөсөн талбай, хэсгүүдийн хэмжээнд маршрутын судалгаа хийж, геологи, геоморфологи, нео-тектоник, гидрогеологи, гидрологи, геоэкологи, гео-гамшигийн ажиглалт, шаардлагатай хэмжилтүүдийг хийж, ажлын зураг болон тэмдэглэлд баримтжуулан холбогдох дээж, сорьц авах,

4.3.1. Төслийн талбайн агаарын фото зураг, сансрын зураг (Астер болон түүнтэй адилтгах түвшний нарийвчлал бүхийн хиймэл дагуулын зураг гэж ойлгоно)-ын болон байр зүйн зургийг бүрдүүлж, агаар сансрын зураг (АСЗ)-г тайлал хийх, тухайн талбай хамрагдсан геофизикийн судалгааны (хүндийн хүчний, агаарын, соронзон зураглал г.м) материалуудтай танилцан боловсруулалт, дүгнэлт хийх,

4.4. Хээрийн ажлын завсрын суурин боловсруулалтаар бүрдүүлсэн анхдагч баримт материалыг нэгтгэж, төрөлжсөн зургуудыг зохиох, таних тэмдэгийг баяжуулах бөгөөд дараагийн ажлын төлөвлөлтийг нарийвчилах.

4.4.1. Хээрийн ажлын үед цаасан баримт ашиглахаас гадна цахим технологи ашиглан, анхдагч материалын бүрдэлийг цахимжуулах, материал бүрдүүлэлтийг хялбаршуулан хэрэглэх нь судлаач мэргэжилтэнүүдэд нээлттэй ба хийгдсэн ажлын өгөгдлийг ҮГА-ны MonGeoCol геологийн мэдээллийн санд гэрээний санхүүжилтийн хувиарын дагуу хүргүүлж байх.

Хөрсний судалгааны чиглэлд:

4.5. Одоо байгаа тариалангийн газар ашиглалтын мэдээлэлд тулгуурлан хэмжилтийн цэгийн тоог тогтоох Хөрсний хээрийн нөхцөлд экологийн чадавхийг үнэлж, генетикийн үе давхаргыг тодорхойлж дээжлэх,

4.6. Торлол татах, дата цуглуулах төлөвлөлт хийх (ArcGIS программд бэлтгэх).

4.7. Хээрийн үнэлгээний хэмжилт хийх болон тооцооллын аргаар тодорхойлох үзүүлэлтүүдийг олон улсын аргачлалын дагуу тогтоох;

4.8. Хөрсний экологийн үнэлгээ хийх: WRB 2022 олон улсын аргачлал, гарын авлагын дагуу давхарга тус бүрийг үзүүлэлт бүрээр хэмжилт хийх, хэмжилтэд үндэслэн тооцоолол хийх, тус аргачлалд заагдсан протокол хөтлөх;

4.9. Давхарга тус бүрээс дээж авах, савлах, зөөх үйл ажиллагааг стандартын дагуу хийж гүйцэтгэх, чанарын хяналт хийх

4.10. Хээрийн ажлын завсрын суурин боловсруулалтаар бүрдүүлсэн анхдагч баримт материалыг нэгтгэж, төрөлжсөн зургуудыг зохиох, таних тэмдэгийг баяжуулах бөгөөд дараагийн ажлын төлөвлөлтийг нарийвчилах, хөрсний зарим аж ахуйн хэрэгцээт үзүүлэлтүүдийн хангамжийн зэрэглэл болон бохирдлын зөвшөөрөгдөх зэрэглэлээр ангилж дүрслэх,

4.11. Тариалангийн бүс нутгийн хөрсний шинж чанар, хэв шинжийн тархалтын үнэлгээ эсвэл тариалангийн хөрс нь хөрс боловсруулалт ургац хураалт зэргээр байгалийн анхдагч шинж чанараа алдсан тариалангийн талбай дахь хөрсний шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлох, олон элементийн зураг хийх.

В. Суурин боловсруулалтын үе:

4.11. Завсрын суурин боловсруулалт:

- Хээрийн судалгааны ажлын жил бүрийн анхдагч баримт материалыг нэгтгэн боловсруулж, ирэх жилийн судалгаа хийх цэг талбайг тодорхойлох,
- Хээрийн ажлын үр дүн шаардлага хангаагүй тохиолдолд түүнд дүн шинжилгээ хийж, судалгааны арга аргачлалд оруулах нэмэлт өөрчлөлийг тодорхойлсон саналыг бэлтгэн захиалагчид хандаж шийдвэрлүүлэх,
- Завсрын суурин боловсруулалтын үргэлжлэх хугацаа нь хээрийн анги, хэсэг бууж ирснээс эхлээд дараа жилийн хээрийн ажил эхлэх хүртэл буюу өмнөх оны 10-р сараас дараа оны 5-р сар хүртэл үргэлжилнэ.
- Судалгааны шатанд авсан бүх төрлийн сорьц, дээжийг геологи, байгаль орчны болон нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үндэсний буюу олон улсын итгэмжлэл бүхий лабораториор шинжилгээ хийлгэх
- Завсрын суурин боловсруулалтын ажлаар шийдэж чадаагүй асуудлуудыг судлах, аргачлалыг тодорхойлох. Мөн уг ажлын төгсгөлд жил бүрийн хээрийн судалгааны ажил эхлэхийн өмнө тулгуур судалгаа хийх талбайнууд, голлох маршрут, тулгуур зүсэлтүүд, үнэлгээ өгөгдөх объектууд, малталтын ажлыг төлөвлөсөн тойм зураг зохиож, хээрийн ажлын дэлгэрэнгүй хөтөлбөр гаргана. Өмнөх жилийн хээрийн судалгааны ажлаар цуглуулсан баримт мэдээлэл болон тэдгээрт хийлгэсэн лабораторийн шинжилгээний үр дүнгүүдийг тусгасан завсрын тайлан бичиж захиалагчид ирүүлсэн байна.

Жич: Байгууллагад ШУТ-ийн (Эрдмийн) зөвлөл байдаг тохиолдолд хурлаараа авч хэлэлцүүлсэн тухай тэмдэглэл, шийдвэрийн хамт, захиалагчид ирүүлсэн байна.

4.12. Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалт:

4.12.1 Төслийн үр дүнд дараах зургуудыг зохионо. Үүнд:

- Үндсэн зураг:
 - Гео орчны зураг /масштаб 1:50 000/
 - Гео орчны эрсдлийн үнэлгээний зураг /масштаб 1:50 000/
 - Литогеохимийн зураг масштаб 1:50 000-1:25 000
 - Газар тариалангийн талбайн хэтийн төлөвийн зураг /масштаб 1:25 000-1:10000-1:5000/
 - Баримт материалын зураг /масштаб 1:50 000-25000/,
- Дагалдах зураг:
 - Гео-экологийн аюулын үнэлгээний зураг /масштаб 1:50 000-1:25 000/
 - Геологи-геоморфологийн зураг /масштаб 1:50000-25000-1:10000/,
 - Гидрогеологийн зураг /масштаб 1:50 000-1:25000/
 - Хөрсний зураг /масштаб 1:50 000-1:25000-1:10000/

- Хөрсний үнэлгээний зураг /масштаб 1:50 000-1:25000-1:10000/
- Хөрс ургамжилтын зураг /масштаб 1:100000-1:50 000-1:25 000/
- Гео-гамшгийн аюулын үнэлгээний зураг /масштаб 1:50000-1:25000/
- Неотектоникийн зураг /масштаб 1:100 000-1:50 000/
- Гидрологийн зураг /масштаб 1:100 000-1:50 000/
- Гидрогеохими, эрдэсжилт, экологи-геохимийн талбайн үнэлгээ, тархалтын зураг. /масштаб 1:50 000-1:25 000/
- Төрөлжсөн зураг:
 - Нарийвчилсан судалгаа хийсэн талбайн зургууд /масштаб 1: 50 000, 1:25 000, 1:10 000, 1:5 000, 1:2 000/.
- Бусад зураг:
 - дагалдах шаардлагатай зураг, бүдүүвч, зүсэлт зэргийг зургийн ач холбогдолыг илэрхийлэх масштабаар зохиох.

4.12.2. Тухайн судалгааны ажлаар болон өмнөх хамаарал бүхий судалгаагаар хуримтлагдсан мэдээ, мэдээлэл, материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийж судалгааны талбайн ерөнхий мэдээлэл, ажлын арга, аргачлал болон судалгааны үр дүн, цаашид хийх судалгааны чиглэл, хэтийн төлөв болон үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлангийн бичвэрийг зохионо. Үүнд:

4.12.2.1. Дээжлэлтийн үр дүнгээр төлөв байдлыг тодорхойлж төслийн судалгааны бусад үр дүнтэй харьцуулан төрөлжсөн зураг, зүсэлт, бүдүүвч, график, хүснэгтийг хавсралт маягаар үйлдэх, шинжилгээний үр дүнг тухайн судалгааны үр дүнг оновчтой харуулах программ хангамж ашиглан боловсруулалт хийх, хөрс газар тариалангийн судалгааны ажлын үр дүнгийн боловсруулалтад Дата нэгтгэл, дата цэвэрлэлт, тооцоолол (R програм ашиглан скрипт бичих, геостатистик тооцоо) хийх мөн хээрийн бичиглэл болон лаб анализад үндэслэн хөрсний төрлийн нэрийг олон улсын ангиллын нэршлийг бүрэн тодорхойлсон байх.

4.12.2.2. Тоон мэдээллийн санг судалгааны явцад хийгдсэн дээж тус бүрээр хийн зохиогдсон зургуудын сангуудтай холбогдсон байдлаар Үндэсний геологийн албаны Геомэдээллийн төвийн загвар /template/-ын дагуу бүрдүүлэх, Үүнд төсөлтэй холбоотой үүсэх бүх төрлийн зургуудыг мэдээллийн сан байдлаар бэлтгэх, мэдээллийн санг дотоодын болон олон улсын газар зүйн мэдээллийн системийн стандарт (ISO19101), Geographic information reference model Part 1,2 болон OGS <http://www.opengeospatial.org/>-ыг хангасан байх, мэдээллийн санг өгөгдлийн сангийн программ хангамж ашиглан бүрдүүлэх, мэдээллийн сангийн ашиглалтын горим нь энгийн, ойлгомжтой байна.

4.12.3. Хөдөө аж ахуйн экосистемийн хадгалах боломжтой эрдэс бодис, тэдгээрийн эргэлтэнд суурилан, хөрсний бүтээмж болох тариалан, цэцэрлэгжүүлэлт, хоол хүнсний хангамжаар дамжуулан нийгмийн эрүүл мэндтэй холбоотой асуудлуудад геологийн судалгааны үр дүнг хэрэглэх чиглэлд анхаарал хандуулах тул тайлангийн боловсруулалтад 4.12.2.-д заагдсан тайлан боловсруулалтад нэмэлтээр доорх сэдвүүдийг тусгасан байна. Үүнд:

- Хөрсний тархалт болон үржил шимийн үзүүлэлт. Хөрс үүсгэгч эх чулуулгийг тодорхойлсноор түүнд суурилан үүсэж, хөгжих боломжтой хөрсний эрдэслэг бүрэлдэхүүн, хэв шинж, хөрсний үржил шимийн үзүүлэлт, хөрсний агрегат бүтэц, ус чийг нөөцлөх чадавх зэрэг олон хүчин зүйлүүдийг тодорхойлох боломж бүрдэнэ. Хөрсний эрдэслэг бүрэлдэхүүний тархалт болон үржил шимийн үзүүлэлт нь тухайн бүс нутгийн геологийн тогтоц, суурь эх чулуулаг, литогеохимийн найрлагаас ихээхэн шалтгаалах ба геоморфологийн хэв шинжээр дамжуулан хөрсний эрдэслэг бүрэлдэхүүний тархалтын зүй тогтол болон хөрсний үржил шимийн эргэлтэнд хими шинж чанар болон чулуулгийн өгөршлөөс үүсэх анхдагч болон хоёрдогч эрдсүүдийн агууламжыг тодорхойлон, нөөцийг

үнэлнэ. Мөн ургамлын өсөлт хөгжилтөнд зарцуулагдах шим тэжээлийн эрдэс бодис (фосфор, кали, кальци, микроэлемент гэх мэт)-ын эргэлтийг судалж, байгалиас нөхөн сэргээгдэх боломжийг үнэлэх талаар дүгнэлт, зөвлөмж, санал тусгах.

- Тариалангийн шинэ технологи хөгжүүлэлт. Уур амьсгалын өөрчлөлт болон цөлжилт, газрын доройтлын нөлөөгөөр үржил шимт хөрсний нөөц буурч байгаа тул тариалангийн шинэ технологийн талаар тусгах. Тухайлбал голын татмын тунамал болон өргөжилд хүчтэй өртөж буй хувирмал чулуулгуудыг ашиглан, ургамал тариалах, фосфор болон кали зэрэг эрдсүүдийг ашиглах боломжийн талаар тусгах. Монгол орны хувьд базальт болон бусад чулуулгийг тариаланд ашиглах боломжтой талаар дүгнэлт, зөвлөмж, санал тусгах.

- Гүний усны нөөц, ашиглалт. Гүний усны нөөцийг тодорхойлж, түүний ашиглалтын боломжыг үнэлэх асуудал нь манай орны хэмжээнд өргөн хийгдэж байгаа бөгөөд тариалангийн бүсэд усны сав бүхий газруудад илүү худаг нягтаршиж байршсанаар усны түвшин буурах эрсдэл үүсэж байна. Үүний зэрэгцээ, усны эрдэсжилт, усны түвшин зэрэг нь тариалангийн ургацад нөлөөлөх эрсдэлтэй тул гүний уснаас үүдэлтэй давсжилт, карбонат зэрэг эрдсийн шилжилтийг үнэлж, тохируулах талаар дүгнэлт, зөвлөмж, санал тусгах.

- Эрдэс чулуулаг ашиглан бордоо хийх. Химийн гаралтай бордооны хэрэглээг бууруулж, байгалийн гаралтай түүхий эд ашиглан ургац нэмэгдүүлэх талаарх олон улсад ашиглагдаж буй технологийг судлах, нутагшуулах санал оруулах. Манай улсын хувьд 1980 онд цеолит ашиглан тариалангийн талбайн өнгөн хөрсний салхиар эвдрэх эвдрэлийг бууруулах туршилт тавьж байсан байна. Одоогоор энэ чиглэлийн технологид фосфорит, сапропель зэрэг эрдсүүдийг ашиглах боломжийн талаар дүгнэлт, зөвлөмж, санал тусгах.

- Геологийн нөхцөлд суурилсан тогтвортой менежмент. Геологийн орчинд хүнд металлын агууламжыг тодорхойлон, нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийг урьдчилан сэргийлэх санал зөвлөмж, мөн хөрсний эвдрэл, элэгдлийн түвшинг тодорхойлон түүнийг бууруулах, хамгаалах арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлэхд геологи орчны суурь нөхцөлийн талаар дүгнэлт, зөвлөмж, санал тусгах.

4.12.4. Тайлангийн бүх зургийг ArcGis программаар, бичвэрийг Times New Roman фондоор үйлдэнэ.

4.12.5. Судалгааны шатанд хийгдсэн ажлын үр дүн болон төслийн талбайн хэмжээнд хийгдсэн өмнөх хийгдсэн судалгаануудын мэдээллийн санг судалгааны чиглэл тус бүрээр болон нэгдсэн байдлаар бүрдүүлнэ.

4.12.6. Судалгааны үр дүнд тулгуурлан газар тариалангийн бүс нутагт гео-орчны болон хөрсний эрдэслэг бүрэлдэхүүний судалгааны ажил гүйцэтгэх аргачилсан заавар, зөвлөмж боловсруулна.

4.12.7. Монгол Улсын газар тариалангийн газрын хөрсний эрдэс бодис (анхдагч болон хоёрдогч эрдэс), геохими, агрохимийн болон физик шинж чанарыг тодорхойлох, хөрсийг олон улсын WRB ангиллын дагуу нарийвчлан судалж, хөрсний шинж чанарын үзүүлэлт бүрээр өндөр нарийвчлалтай дижитал зураг зохиох боломж бүхий өгөдлийн санг бүрдүүлнэ.

5. Ажил гүйцэтгэх хугацаа:

5.1. Төсөл, төсөв зохион батлуулах:

Эхний жилд: - Шууд гэрээгээр.

5.2. Хээрийн ажил:

Эхний жилд:

2026 оны 7-р сараас 10-р сарыг дуустал

Хоёр дахь жилд:

2027 оны 5-р сараас 10-р сарыг дуустал

Гурав дахь жилд:

2028 оны 5-р сараас 10-р сарыг дуустал.

5.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт: 2026 оны 11-12-р сар дуустал
2027 оны 1-4-р сар, 11-12-р сар.
2028 оны 1-4-р сар дуустал

Эцсийн суурин боловсруулалт: 2028 оны 11-р сараас 2029 оны 10 сар дуустал.

5.4. Үр дүнгийн тайланд ЭБМЗ-өөс томилсон шинжээчээр дүгнэлт хийлгэн холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийж, геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албажуулан ирүүлэх:

2029 оны 11-р сарын 30.

5.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжээр хянуулж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт, засварыг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр албажуулан хүргүүлэх:

2029 оны 12-р сарын 30.

5.6. Тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох дүгнэлт, түүнд үндэслэн эрх бүхий байгууллагын шийдвэрийг гарсаны дараа Геологийн мэдээллийн төв архивд тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны
дараа ажлын 5 өдөрт

МОНГОЛ УЛС
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

БАТЛАВ: АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА **Б.ДАШПҮРЭВ**

2026 оны 03-р сарын 06-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2026/ 07

**МОНГОЛ УЛСЫН ХОЙД ХИЛ ОРЧМЫН НУТГИЙН ГЕОЛОГИ, ГЕОХИМИЙН
ЗУРАГ ЗОХИОХ ТӨСЛИЙН 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ГЕОЛОГИЙН
ДААЛГАВАР**

Судалгааны үе шат: *Геологи, геохимийн судалгаа хийж, зураг зохиох*

Ашигт малтмалын төрөл: *Бүх төрлийн ашигт малтмал*

Судалгааны талбайн нэр: *Хойд нутгийн геологи, геохими*

Судалгааны талбайн байршил: *Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Сэлэнгэ, Хэнтий,
Дорнод аймгийн хил дагуух сумд*

Судалгааны талбайн хэмжээ: *234457.46 кв.км*

Координат: *Монгол Улсын Хойт хил орчмын 150 км-ийн зурвас
талбайг хамарна.*

Хавтгай: *М-45-Г
М-46-А,Б,В,Г
М-47-А,Б,В,Г
М-48-А,Б,В,Г
М-49-Б,В,Г
М-50-А,В
L-49-А,Б*

Код: *Гео-Хойд-2026*

Төсөл хэрэгжих хугацаа: *2026-2029 он*

1. Геологийн даалгавар боловсруулах хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24, “Ашигт малтмалын тухай” хуулийн 16 дугаар зүйл, УИХурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2, УИХурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ийн 3.5.2, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төсөл, төлөвлөгөө”.

Судлагдсан түвшин:

Монгол Улсын хойд хил орчмын нутгийн геологи, ашигт малтмалын судалгааны түвшин харилцан адилгүй байна. Энэ нутгийн хэмжээнд 1946-оод оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд, судалгааны онолын өөр өөр үндэслэлд тулгуурлан, түүнд нийцсэн арга аргачлалаар геологийн төрөл бүрийн судалгаануудыг гүйцэтгэж ирсэн түүхтэй.

Монголын Улсын Хойд хил орчмын нутаг нь 1:200 000-ны масштабтай геологийн зураглалд бүрэн, харин БНМАУ-ЗХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хилийн 100 км-ийн нутаг дэвсгэрт хийсэн геологийн судалгаа, 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил болон агаарын соронзон зураглал, агаарын геофизикийн цогцолбор судалгаануудад хэсэгчлэн хамрагдсан байна. Мөн түүнчлэн ОХУ, АНУ, Канадын болон бусад улсын эрдэмтэдтэй хамтарсан сэдэвчилсэн судалгаанууд хийгдэж, хамтын бүтээлүүд нь хэвлэгдсэн байдаг. Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНКазУ, БНСУ-ын геологийн албадын хамтарсан 1:2 500 000-ны масштабтай геологийн иж бүрдэл зургаас өөр Монгол Улс, ОХУ-ын хилийн хэмжээнд хийгдсэн геологийн төрөл бүрийн судалгааны үр дүнг орчин үеийн онолын үндэслэлээр нэгтгэн зангидаж, нэг түвшинд боловсруулсан бүтээл өнөөдрийг хүртэл хараахан гараагүй байна.

Дээр дурдсан судалгаануудын үр дүнд хил орчмын нутгийн хэмжээнд ашигт малтмалын орд, илрэлүүд олноор тогтоогдон, заримыг нь ашиглаж байгаагаас гадна цаашид томоохон орд, илрэлүүдийг шинээр илрүүлэх хэтийн төлөвтэй бүс нутаг юм. Харин энэ бүс нь хилийн боомтууд болон Сэлэнгийн газар тариалангийн бүс нутгийг үл тооцвол, томоохон суурин газраас алслагдсан, дэд бүтэц муу хөгжсөн бүсэд оршино.

2. Төслийг хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл

Монгол Улсын хойд хил орчмын нутаг нь геологийн 1:200000-ны масштабтай зураглалаар бүрэн бүрхсэн хэмээн үзэж байгаа боловч тухайн ажлын явцад хавсарга байдлаар хийгдсэн геохимийн судалгааг гүйцэтгэсэн байна. Тухайн үед лабораторийн шинжилгээгээр тодорхойлогдож байсан элементүүдийн тоо цөөн 17-22 элемент, зөвхөн металлогений шинж чанарыг тодорхойлоход хүрэлцэх хэмжээнд байсан ба тэдгээрийг тодорхойлж байсан шинжилгээний багажны мэдрэх чадамж сул, лабораторийн шинжилгээний анхдагч үр дүнгийн зарим хэсэг нь хадгалагдаагүй, зэрэг дутагдалтай байдлаас өнөөдрийн геохимийн судалгааны өмнө тавигдаж байгаа бусад зорилтуудыг хангаж чадахгүй байна.

Сүүлийн жилүүдэд Монгол орны нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан геохимийн зураг 1:1 000 000-ны масштабаар зохиогдсон (2019-2022 он) бөгөөд түүний үр дүнгээс үзэхэд, цаашид Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан олон талын зорилтот геохимийн зураглал явуулах зүй ёсны шаардлага урган гарч байна. Энэхүү судалгааг олон улсад нэвтэрсэн сүүлийн үеийн геохимийн судалгааны ажлын аргачлалын дагуу гүйцэтгэсэнээр

Монгол Улсын нутаг дэвсгэрийн болон бүс нутгийн олон талын зориулалттай геохимийн зураг зохиогдох бөгөөд цаашид геохимийн судалгааны ажлын тулгуур мэдээллийг агуулсан геохимийн эталон дээжийн санг бүрдүүлнэ.

Харилцан адилгүй чанар, үр дүнгээс бүрдсэн геохимийн мэдээллийн сан нь өнөөгийн шаардлагыг хангахгүй байна. Мөн сүүлийн үед Монгол Улсад нэвтэрч суурьшсан лабораторийн шинжилгээний орчин үеийн техник, технологийн дэвшлийн олгож байгаа боломж, чадавхийг бүрэн ашиглаж, түүний үр дүнг бүтээлчээр ашиглах шаардлага урган гарч байна. Сүүлийн жилүүдэд Монгол оронд болж буй байгалийн гамшигт үзэгдэл болох геогамшиг буюу экологийн сөрөг үзэгдэл, тэдгээрийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлах, эрсдлээс гарах арга замыг тодорхойлох, шийдвэрлэх арга, аргачлал байхгүй байна.

Иймд, дээр дурдсан улс, орны амьдралаас зайлшгүй урган гарч ирсэн олон талын асуудлыг шийдвэрлэх, олон салбарт ашиглах боломжтой региональ геологи, геохимийн судалгааг гүйцэтгэж, түүний үр дүнг геологи, уул уурхай, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн, байгаль орчны болон бусад хэрэгцээтэй салбарт шинжлэх ухааны үндэслэлтэй, бүтээлчээр ашиглах бодит хэрэгцээ бидний өмнө тулгарч байна.

Монгол Улсын хойт хил орчмын нутгийн хэмжээнд шийдвэрлэгдээгүй региональ геологийн дараахь асуудлууд байдаг. Үүнд:

А. Тектоникийн мужлалын талаар:

Төслийн хүрээнд тектоникийн мужлалын хувьд дараах асуудлуудыг шийдвэрлэх:

- Өлгийн бүсийг Таванбогдын бүстэй нэгтгэх, эсхүл бие даасан бүсээр ялгах.
- Цагааншувуутын бүсийг Монгол Алтайн атриат мегабүсд үлдээх үү, эсхүл Монгол-Оросын хилийг дамнан байрлах Нуур-Баруун Саяны атриат их мужид хамааруулах эсэх.
- Тува-Монголын атриат их мужийн Монголын талд байрлах Тэс-Дархадын атриат мегабүс болон Нуурын атриат мегабүсийн Ханхөхийн атриат мужийн хоорондын хил заагийг тодруулах.
- Эгийн гол - Жидийн атриат их мужийн Монголын талын Дорнод Хөвсгөлийн атриат мегабүсийн Хэвэн сарьдагийн бүс /террейн/-ийн тектоникийн байрлалын хамаарлыг тодруулах.
- Төв Монголын атриат их мужийн Орхоны атриат мегабүсийн Оорцог-Хөвсгөл нуруу, Хулж-Ерөөгийн атриат бүсүүдийг нэгтгэх эсэх.
- Төв Монголын атриат их мужийн Завханы атриат мегабүсийн Ургамал-Сонгины бүсийн хил заагийг тодруулах, Сонгины цухуйцыг Ургамлын бүстэй эсхүл Тарвагатайн блоктой нэгтгэх асуудлыг шийдэх.
- Хангай-Хэнтий-Монгол Агнуурын их мужид хамруулсан монголын талын Хараагийн дэд бүс нь Хангай-Хэнтийн атриат мегабүсд, эсхүл Төв Монголын атриат их мужийн Орхоны атриат мегабүсд хамаарах эсэхийг тодруулах.
- Хангай-Хэнтий-Монгол Агнуурын их мужид хамруулсан монголын талын Ононы бүс нь Хангай-Хэнтийн атриат мегабүсд, эсхүл Хэрлэнгийн массивт хамаарах эсэхийг тодруулах.
- Умард Монголын атриат муж болон Өмнөд Монголын атриат муж хоорондын хил заагийг тодруулах ба өөрөөр хэлбэл, тэдгээрийн хоорондын хил болгон

авсан Ононгийн гүний хагарлыг “Монголын гол линеамент” гэж нэрлэсэн маргааныг шийдвэрлэх.

- Дээрх хил заагтай уялдуулан “Хэрлэнгийн массив”, түүний Эрэндавааны блок, Өндөрхааны атриат мегабүс, Идэрмэгийн блокыг Өмнөд Монголын атриат мужид хамруулах нь зөв эсэх.
- Монголын мэдээллүүдийг ОХУ-ын талын тектоникийн мужлалтай нийцүүлэн шинэчлэл хийн тодруулж, маргаантай асуудлуудыг шийдвэрлэх.

Б. Хурдас, чулуулгийн формац, бүрдлүүдийн талаар:

Монгол Улсын геологийн 1:500000-ны масштабын геологийн зураг /2017/, “М-эгнээний УГЗ-200” зургуудын нэгтгэл /2026/” төслүүдийг хэрэгжүүлэх явцад илэрсэн дараахь асуудлуудыг шийдвэрлэх:

Монгол Алтайн атриат мегабүсийн хэмжээнд:

- Таванбогдын бүсийн хэмжээнд доод кембрийн Үзүүртолгой, Замт, Борбургас, Цэнгэл формацуудын литологийн давхцал, нэршил, насны асуудлыг цэгцлэн, баталгаажуулах, хожуу ордовикийн Цагаангол, хожуу девоны Алтай бүрдлүүдэд хамруулсан массивуудын литолог, насны асуудлыг цэгцлэх. Мөн хожуу ордовикийн Цагаангол бүрдэлийн критикал металлын чухал элемент болох литий агуулсан гялтгануур буюу лепидолитот гранитын биетүүдийг судлах.
- Өлгийн бүсийн хэмжээнд Ховдгол, Ташинт, Ёлт-Ус, Талнуур формацуудын тулгуур зүсэлтийг судалж, нас, гарал үүслийг тодруулах, Цагаангол ба Шарговь формацуудыг нэгтгэн Цагаангол формацаар зураглах асуудлыг шийдвэрлэх, Юстыдын массивыг насны асуудлыг судлан тодруулах.
- Ховдын бүсийн хэмжээнд Ачитнуур формацын тархалтын хүрээнд геохронологи ба геохимийн судалгааг явуулж шинэлэг бий болсон өгөгдлүүдтэй нэгтгэн дүгнэж, өмнөх судлаачдын үр дүнг баталгаажуулах, Хархираа бүрдлийн насыг түрүү карбон, эсхүл хожуу девон-түрүү карбонд хамааруулахыг шийдэх, улмаар түрүү карбоны “Ёл” бүрдлийг нарийвчилан судлах.
- Цагааншувуутын бүсийн зүүн хэсэгт тархалттай девоны формацуудын судалгааг нарийвчлах, дунд-хожуу ордовикийн настай Түргэн-Уул бүрдлийн литологи, насны асуудлыг тодруулах, Живэрт, Түргэний массивуудын насыг U-Pb аргаар баталгаажуулах, өмнөх ажлуудаар девон, карбоноор зураглагдаж байсан Үүрэгнуур бүрдлийн хэт суурилаг, суурилаг массив болон биетүүд “хожуу” кембри, түрүү девон, хожуу девон-түрүү карбоны г.м. 3 өөр насны үр дүнгүүд үзүүлж байгаа тул цаашид нарийвчлан судлах.

Нуурын атриат мега бүсийн хэмжээнд:

- Нуурын атриат бүсийн хэмжээнд өнөөдрийн түвшинд бий болоод байгаа бүхий л судалгааны өгөгдлүүдийг нэгтгэх, улмаар Нуурын бүсийн хэмжээнд ялгагдаж байгаа дэд бүсүүдийн асуудлыг эргэн харах, үндэслэлтэйгээр шийдвэрлэх шаардлагатай. Силурын Хулсынбулаг, доод девоны Тээл формацын зүсэлтүүдийг бүсүүдийн хэмжээнд нарийвчлан судалж, насны асуудлыг нарийвчлах, Нуурын бүсийн хэмжээнд нэлэнхүйд нь нэг бүрдэлд ялгах нь учир дутагдалтай тул кембри-түрүү ордовикийн Тогтохыншил, дунд-хожуу ордовикийн Түргэн-Уул бүрдлийг насжилт, литологиор нь ялган зураглах,

цаашид дээрх интрузив бүрдлүүд болон силур болон девоны настай ангилагдаагүй бүрдлүүдийн нарийвчилсан судалгааг хийх.

Төв монголын массив. Тэс-дархадын мегабүсийн хэмжээнд:

- Улаантайгын бүсийн суурийг бүрдүүлж буй Тэс (Баруунтуруун) метакомплекс болон Билүү формац, тэдгээрийг түрсэн Харгана бүрдлийн хэмжээнд төвлөрөн геохронологи, геохимийн нарийвчилсан судалгааг тулгуур дүүрэгт явуулж формацын насыг баталгаажуулах.
- Харин хайлуур жоншны орд, илрэлүүд өргөн тархсан Жаандайн дүүргийн вулканит болон шүлтлэг гранит бүхий хэсэгт хээрийн судалгааг хийж вулканит, шүлтлэг гранитын насыг тодруулах.
- Түрүү девон, силурын интрузив бүрдлүүд тархсан Улаантайгын бүсийн Бэрхийн массивт тогтоогдсон 410 сая жил, Хөгийн бүсийн Ёлт уулын массивд тогтоогдсон 432 сая жил, Шаргын голын бүсийн Дөшийн голын дүүрэгт 426 сая жил насыг зөвхөн K-Ar аргаар тогтоосон байдаг тул U-Pb аргаар насыг нь тодруулж, баталгаажуулах.
- Тэс-Дархадын мегабүсийн хэмжээнд тархсан түрүү пермийн шүлтлэг сиенит-шүлтлэг гранитын эвшлийн “Булнай бүрдэл” нэршлийн асуудлыг шийдэх.
- Хөг голын бүсэд өргөн тархалттай дунд-хожуу кембрийн Хялтас бүрдэлийн габбро-гранодиорит-гранитын эвшлийн гранитоидуудын насыг U-Pb аргаар баталгаажуулах.

Төв монголын массив. Цөмөрлөгийн блокийн хэмжээнд:

- Тус блокийн хэмжээнд тархалттай метакомплекс, ангилагдаагүй хурдас, формацуудыг сүүлийн үеийн мэдээллүүдээр баяжуулах, насыг тогтоох, түрүү-дунд неопротерозойн Сүмсунуур, түрүү ордовикийн ордовикийн ангилагдаагүй, дунд-хожуу девоны Тэс, түрүү-хожуу карбоны ховор металлт гранит-лейкогранитын ангилагдаагүй интрузив бүрдлүүдийн насыг баталгаажуулах.

Төв монголын массив. Завханы атриат мегабүсийн хэмжээнд:

- Завханы атриат мегабүсийн Ургамал-Сонгины болон Завханмандалын бүсүүдийн хэмжээнд түрүү-дунд неопротерозойн настай Сонгино бүрдэл нь том талбайг хамардаг, геохронологийн судалгаагаар хангалттай насжилт батлагдсан хэдий ч массивуудад ордовикийн 479.6 ± 7.0 сая жил, силурын 424.4 ± 9.1 сая жилийн насжилт тогтоогдож байгааг харгалзан нарийвчлан судлах.
- Ордовикийн настай Тэлмэн бүрдлээр зурагласан зарим массивууд нь 271.0 ± 2.7 сая жил буюу түрүү-дунд пермийн Булнай бүрдлээр болон 250.7 ± 2.1 сая жил буюу хожуу пермийн Шар-Усгол бүрдэлд шинэчлэн зурагласан байна. Иймд энэхүү бүрдлүүдээр зураглагдсан массивуудын нас цаашид шинэчлэгдэх боломжтой тул тархалтын хэмжээнд судлах, насыг баталгаажуулах.

Төв монголын массив. Тарвагатай блокийн хэмжээнд:

- Тарвагатай блокийн баруун хилээс гадагш Завханы атриат мегабүсийн Ургамал-Сонгино ба Завханмандалын бүсийн хэмжээнд (Ойгон нуурын баруун ба өмнө талд, мөн Хар нуурын хойд талд) неорархейн Идэр метакомплекс оор зураглагдсан жижиг блокуудын метаморф чулуулгуудад U-Pb геохронологи ба

геохимийн шинжилгээ хийж, Тарвагатай блокийн баруун хил заагийн асуудлыг үндэслэлтэйгээр шийдвэрлэх.

- Тарвагатай блокийн хэмжээнд ялгагддаг Мөст-Уул бүрдлийн нас ба гарал үүслийн асуудлыг тулгуур талбайд геохронологи, геохимийн судалгаа хийж шийдвэрлэх. Учир нь тус бүрдлээр зураглагдсан зарим массивуудын хэмжээнд түрүү неопротерозойн талсжилтын нас тогтоогдсон асуудлыг анхаарах.

Төв монголын массив. Орхоны атриат мегабүсийн хэмжээнд:

- Орхоны атриат мегабүсийн Бугат-Чулуутын бүсийн хэмжээнд өргөн тархалттай сүүлийн үед Ороох формацаар ялгах болсон хурдсын насыг геохронологийн болон палеонтологийн судалгааны аргаар тодорхойлох.
- Бугат-Чулуутын болон Хулж-Ерөөгийн бүсийн Баянгол бүрдэл нь дунд ордовик, хожуу пермийн настай гэж тодорхойлогож байгаа тул насны асуудлыг шийдвэрлэх, тархалтын талбай болон литологийг тодруулах.
- Хулж-Ерөөгийн бүсийн суурь формацуудыг бүрдүүлэгч голлох чулуулгуудын геохронологийн судалгааг хийж, сүүлийн жилүүдэд хийсэн палеонтологийн судалгааны өгөгдлүүдтэй харьцуулах, насны асуудлыг шийдвэрлэх.
- Хараагийн бүсийн Ихташир, Чулуут бүрдлийн гранитын бүрдлийн сүүлийн үеийн петрохими-геохимийн судалгааны үр дүнтэй уялдуулан, нас хил заагийн асуудлыг шийдэх.
- Оорцог-Хөвсгөл нуруу, Хулж-Ерөөгийн бүсд тархалттай интрузив чулуулгуудыг янз бүрийн нас, бүрдэлд хамруулан зураглах болсон тул энэ бүсүүдийн хэмжээнд интрузив магматизмын ангиллыг нь шинээр хийж баталгаажуулах.
- Төв Монголын атираат мужийн Хөвсгөл нуруу-Оорцог бүсийн Баянсант группийн хурдсын нарийвчилсан судалгааг хийж, насны асуудлыг шийдэх.

Дорнод Хөвсгөлийн атриат мегабүсийн хэмжээнд:

- Дорнод Хөвсгөлийн атриат мегабүсийн Хэвэнсарьдагийн бүсэд, Хөвсгөл нуурын зүүн талаар тархсан ба дунд-хожуу девоны Тэс бүрдэл нь өмнөх судалгаагаар зарим массивт түрүү девон, силур гэсэн нас тогтоогдсон учир насыг U-Pb аргаар тогтоох, Тэшигийн бүсийн Тавтын алтны ордын хүдрийн талбайн диоритод Японы геологичид дунд девоны /390 сая жил/ нас тогтоосон байгааг харгалзан Эгийн гол, Аригийн гол, Тэшигийн бүсүүдэд өргөн тархсан дунд-хожуу девоны Тэс бүрдэлд хамруулсан диорит-гранитын эвшлийн насыг U-Pb аргаар баталгаажуулах.
- Дорнод Хөвсгөлийн атриат мегабүсийн Эгийн гол, Наранмандал, Аригийн гол, Тэшиг, Зэлтэрийн бүсүүдэд өргөн тархсан гэж үзсэн ба дунд-хожуу кембрийн Зэд бүрдэл гэж нэрлэсэн габбро-диорит-гранодиорит-гранитын эвшлийн насны хамаарлыг тодруулах, гарал үүслийг тодорхойлох.

Хангай-Хэнтийн атриат мегабүсийн хэмжээнд:

- Хараагийн бүсэд Хараа группийн болон Заамар формацын тархалтын асуудлыг шийдвэрлэх.
- Асралтхайрханы бүсийн Хүрэн-Өндөр формацын шүлтлэгдүү базальтын петро-геохимийн судалгааг нарийвчлан далайн голч нурууны шинжтэй, нумын арын

сав газарт үүссэн эсэхийг тодруулж, баталгаажуулах, Мандал группийн Хошуут, Хүйнгол, Сөгнөгөр формацууд болон Мандал формацад ангилагдсан занаржсан тунамал чулуулгууд найрлагаараа ялгарахгүй байгаа тул тус группийн хурдсанд зөөгдмөл цирконы геохронологийн судалгаагаар нас болон дотоод ангиллыг шийдвэрлэх, өмнөх УГЗ-200-ийн судалгаагаар түрүү девоны эмс стейжийн түвшинд Аргал-Уул формацад ангилан зурагласан хурдсыг талбайн хэмжээнд мөрдөн судлах.

- Онон ба Дөчголын бүсийн геологийн зурагт силурын венлок-лудлов серийн, эсвэл силур-доод девоны Онон формацыг ялган зурагласан нь эргэлзээ төрүүлж байгаа төдийгүй Хангай-Хэнтийн Атриат мегабүсийн Онон ба Дөчголын бүсийн тогтоц, хил заагийн асуудлыг маргаантай болгож байна. Иймд цаашид нэмэлт нарийвчилсан судалгаа хийж, уг асуудлыг нэг мөр болгон шийдвэрлэх шаардлагатай. Ордовик, силурын настай зураглагдаж ирсэн Хилийн бүрдлийн дунд Төмөр нар (10060Ф), Нэргүй нар (2024Ф), Оюунчимэг нарын (2025) сүүлийн үеийн үр дүнгүүдээр Эрэндавааны блокийн хэмжээнд Хилийн офиолит меланж шинээр тогтоогдсон учир үүнтэй уялдуулан гарч буй тектоникийн асуудлыг шийдэх. Улаанбаатар, Ононы бүсүүдэд дунд ордовикийн настай арланумын гранитоидыг салгаж, шинэчлэн зураглах. Силур-доод девоны Онон формацыг анхны судлаачид доод-дунд девоны Ангирт формацд ангилсан. Чулуунхороотын талбайн 1:50000-ны зураглалаар /С.Төмөр нар, 2021, 10060Ф/ доод-дунд девоны Ангирт формац ялгасан ба хас дахь радиолярыг нь доод-дунд девонд хамарна гэж тодорхойлсон учир силур-доод девоны Онон формацын насыг баталгаажуулах, доод-дунд девоны Ангирт формацад эргүүлэн хамааруулах эсэхийг шийдвэрлэх.

Өмнөд монголын атриат мөж

Хэрлэнгийн массив. Эрэндавааны блокийн хэмжээнд:

- Хэрлэнгийн массивын Эрэндавааны блокийн суурийг бүрдүүлдэг хэмээн үздэг Хайчингол формацын сүүлийн үеийн өгөгдлүүдийг нэгтгэн дүгнэж, судалгаа хийгдээгүй хэсгүүдийг нэмэлт судалгаанд хамруулах.
- Эрэндаваа формацын эртний нас сүүлийн үеийн ихэнх судалгаагаар баталгаажаагүй тул түүний насыг дахин тодорхойлж, баталгаажуулах шаардлагатай бөгөөд мөн микрофоссилийн олдвор бүхий Ар Даргинтын гол орчимд геохронологийн судалгаа явуулах. Эдгээр судалгаагаар нас нь баталгаажаагүй тохиолдолд Эрэндавааны бүсийг “эртний блок” хэмээн үздэг тектоникийн дүүрэгчлэлийн схемийг эргэж харах нь зүйтэй.
- Эрэндавааны блокийн хэмжээнд ялгагддаг байсан Хэрлэн бүрдлийн хэмжээнд, сүүлийн үеийн судалгаагаар ордовикийн нас гол төлөв тогтоогдож байгаа бөгөөд цаашид Хэрлэн бүрдлээр зураглаж байсан массивуудыг ордовикийн Нарсанбулаг бүрдлээр зураглах санал өмнөх судлаачид дэвшүүлснийг баталгаажуулах шаардлагатай.
- Хэрвээ доод-дунд девоны Ангирт формацыг Дөчголын бүсд тархсан, түүний суурь формацуудын нэг гэж үзвэл энэхүү хурдас Эрэндавааны бүсд давхцамал байдлаар тархсан байж болохгүй тул Эрэн давааны бүсэд тархсан гэж үзсэн Ангирт формацаар зурагласан хурдсыг нарийвчилан судалж,

тодруулах.

3. Ажлын зорилго:

Төслийн хүрээнд Монгол орны нутаг дэвсгэрийн хойд хил орчмын нутгийн геологийн тогтоц болон геотектоникийн ангиллыг ОХУ-ын нутагт геологийн ижил масштабын төвшинд ангилсантай уялдуулан нийцүүлэх, ашигт малтмал, металлогенийн дүүрэгчлэлийн ангилалыг уялдуулах, эрлийн хувьд хэтийн төлөв бүхий хүдрийн дүүрэг, зангилаа, талбайн хэмжээнд геохимийн иж бүрэн судалгааны ажлыг гүйцэтгэнэ.

Геологийн тогтцын хувьд зөрүүтэй зураглагдсан хурдас чулуулгийн тархалт, насыг хамтарсан судалгаагаар уялдуулах бөгөөд геотектоникийн мужлал, бүсчлэл, тэдгээрийг ялгах үндэслэлийг тодорхой болгон олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц нэгдмэл нэг ангилалд нийцүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

Суурь судалгааны материалуудад үндэслэн ялгасан ашигт малтмал, металлогенийн ангилалд тулгуурлан хэтийн төлөв бүхий хүдрийн дүүрэг, зангилаа, талбайг ялган геохимийн зураглалын ажлыг олон улсын жишигт нийцсэн арга, аргачлалаар хийж, хөрш орнуудын геологи, геохимийн зураглалд нийцүүлэн судлах, хүрээлэн буй орчны химийн элементүүдийн тархалтын суурь мэдээллийн сан байгуулж бусад салбарын хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.

Төслийн судалгааны ажлын үр дүнд ашигт малтмалын хэтийн төлөвийн шалгуур, шинж тэмдгийг тогтоох, геологийн судалгааны түвшнийг өсгөх, дараагийн шатны ажил хийх боломжтой хэтийн төлөв бүхий талбайг ялгаж, түүгээр дамжуулан улс орны эдийн засгийн чадамжийг сайжруулахад хувь нэмэр оруулахад оршино.

4. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх арга аргачлал, дэс дараалал:

Төслийг хэрэгжүүлэхдээ дараахь дэс дарааллаар гүйцэтгэнэ.

А. Бэлтгэл үе шат:

4.1. Талбайн хэмжээнд өмнө нь хийж гүйцэтгэсэн геологи, геофизик, геохимийн болон бусад судалгааны ажлуудын үр дүн хуримтлагдсан мэдээллийг танилцаж, судлан дүн шинжилгээ хийн дүгнэж, судалгааны арга аргачлалыг сонгоно. Үүнд:

- Төслийн талбайн хэмжээнд хэрэгжсэн геологи, ашигт малтмал, геоэкологи, геохими болон геофизикийн судалгааны материал болон гадаад, дотоодын хэвлэлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдийг цуглуулах, өмнөх шатны бүх төрлийн судалгааны ажлын үр дүнг багтаасан мэдээллийн сан бүрдүүлэн. 1:1000000-1:200000 масштабын суурь бэлтгэх, төслийн талбайн материалуудтай танилцан боловсруулалт хийж, дүгнэлт гаргана. Мөн төслийн үр дүнгээр зохиох зургуудын нэгдсэн таних тэмдэгүүдийг зохионо.
- Дээрх материалуудад үндэслэн судалгааны ажлыг төлөвлөгөө гаргана. Шалгах, танилцах маршрутын зорилго, чиглэл, шийдэх асуудлыг тодорхойлох, геохимийн сорьцлолт хийх талбайг урьдчилан сонгох.
- Шаардлагатай зарим мэдээлэл, материалыг англи хэл рүү хөрвүүлэх.

4.2. Төсөлд ажиллах ажилтан, ажилчдыг сонгох, машин техник тоног төхөөрөмж ажиллагсдын хөдөлмөр, ахуйн нөхцөлийг хангахад чиглэгдсэн хээрийн судалгааны өмнөх бэлтгэл ажлуудыг бүрэн хангах.

4.3. Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрөл (орон нутаг, хилийн бүс, тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах гэх мэт), бичиг баримтыг бүрдүүлнэ.

4.4. Үндэсний геологийн албаны өгсөн чиглэлийн дагуу оросын талтай хамтран гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг зохион захиалагчид танилцуулан батлуулах, төлөвлөгөөнд тусгасан ажлыг төсөл, төсөвт тусгах, холбогдох арга хэмжээг авах, биелэлтийг хариуцан тайлагнана.

Б. Хээрийн ажлын үе:

4.5. Судалгааны талбайн хэмжээнд шийдвэрлэх асуудлуудтай уялдуулан танилцах, шалгах маршрутын судалгааг хийж, геохимийн сорьцлолт хийхээр сонгосон талбайг баталгаажуулна. Хэтийн төлөвтэй хүдрийн дүүрэг, зангилаа, талбайнуудаас сонгон 1:200000 масштабын геохимийн зураглалын ажлыг гүйцэтгэнэ.

4.6. Хээрийн судалгааны ажил эхлэхээс өмнө жил бүрийн хээрийн судалгааны ажлыг хэрхэн ямар хугацаанд гүйцэтгэхийг заасан ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө (ажлын хөтөлбөр) зохиосон байна.

4.7. Хээрийн судалгааны үед дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Танилцах, шалгах маршрутын судалгааг хурдас чулуулгийн хил зааг, насны зөрүүтэй асуудлыг шийдэх, тектоникийн муж, бүсийн ангиллыг Оросын талтай нэгтгэн баталгаажуулах зорилгоор гүйцэтгэх ба зарим хэсэгт хамтарсан маршрутын судалгаагаар шийдвэрлэнэ.
- Маршрутын судалгааны үед чулуулгийн нас, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, геохимийн онцлог, текстур болон бусад шинжийг тодорхойлох зорилгоор бүх төрлийн дээж, сорьцыг арга аргачлалын дагуу авах, шинжилгээ хийлгэх, боловсруулах, геологийн зурагт тусгаж тайлбар бичиглэл хийнэ.
- Хойд хилийн бүсийн дагуу эрлийн сонирхолтой, шалгах шаардлагатай гэж ялгасан хүдрийн зангилаа, талбайнуудын хэмжээнд шалган холбох маршрутыг гүйцэтгэн, холбогдох сорьцлолтуудыг хийх.
- Хэтийн төлөвтэй гэж ялгасан хүдрийн зангилаа, талбайнуудын хэмжээнд 1:200000-ын масштабтай геохимийн зураглалын ажил гүйцэтгэн, сорьцын баримтжуулалтын сан үүсгэх.
- Геохимийн сорьц авалтын аргачлалыг уулархаг хангай, ойт хээрийн болон хээрийн бүс зэрэг янз бүрийн ландшафт дахь усан сүлжээний хөгжил, морфологийн төрөл зэргүүдийг харгалзан сорьц авах гүн, сорьцын фракцын хэмжээ зэргийг сонгоно.
- Аргачлал хяналтын сорьцлолтыг нэг цэгт хөрсний хоёр өөр горизонтоос сорьцлон хооронд нь харьцуулалт хийнэ.
- Геохимийн сонирхолтой, хэтийн төлөвтэй гажлын бүсийн хэмжээнд бусад мэдээлэлтэй уялдуулан эрлийн хэсгүүд ялган, нарийвчилсан геохимийн сорьцлолт болон эрлийн ажил явуулна.

В. Суурин боловсруулалт:

4.8. Завсрын суурин боловсруулалт:

Завсарын суурин боловсруулалтын ажлыг дараах үе шаттайгаар гүйцэтгэнэ. Үүнд:

- Завсрын суурин боловсруулалт нь төслийн хэрэгжилтийн явцад хийгдэх ба энэ үед хээрийн судалгааны үр дүнд тулгуурлан шийдэх шаардлагатай бүхий л асуудлыг шийдвэрлэж, хүрсэн үр дүндээ тулгуурлан дараагийн үе шатны ажлаар шийдвэрлэх асуудлууд ба тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлно.
- Ажлын үр дүнд шаардлага хангасан мэдээлэл бүрдээгүй тохиолдолд түүнд дүн шинжилгээ хийж, судалгааны арга аргачлалыг өөрчлүүлэх хүртэлх саналыг тухайн үед нь захиалагчид хандаж шийдвэрлүүлнэ.

- Бүх геохимийн сорьцыг лабораторийн тоон шинжилгээнд (ICP-MS, ICP-MA, ICP-OES, ICP-AES г.м) бүрэн хамруулж, элемент, исэл нийлсэн 60-аас дээш элемент тодорхойлуулан үр дүнг боловсруулна.
- Нийт сорьцын 5%-д санамсаргүйгээр зэрэгцээ (дубликат) сорьц сонгон авч, нууц код өгч гаднын лабораторид шинжилгээнд хамруулж шинжилгээний чанарын түвшинг тогтмол хянаж, зохих тооцоолол хийж, шаардлагатай тохиолдолд засварлана.
- Хээрийн судалгааны ажлаар хуримтлагдсан анхдагч мэдээллийг боловсруулан, урьд хийгдсэн ажлуудын үр дүнтэй уялдуулан шаардлагатай зураг, бүдүүвчийг бэлтгэн зохионо.
- Бусад холбогдох ажлыг гэрээнд заасны дагуу гүйцэтгэнэ..

4.9. Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалт:

- Төслийн талбайн геологи, геохими, структур-тектоник, ашигт малтмал-металлогений болон бусад зургуудыг Оросын талтай хил нийлүүлэн, Оросын талын ирүүлсэн зураг, өгөгдөл болон бусад холбогдох суурь судалгааны мэдээлэлд үндэслэн, шинэлэг мэдээллээр баяжуулан шинэчлэн боловсруулж, энэхүү геологийн даалгаварт заасан масштабаар зохиож, дагалдах тайлбар бичвэрийг үйлдэнэ.
- Судалгааны ажлын болон өмнөх судалгаагаар хуримтлагдсан мэдээлэл, материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийж, судалгааны талбайн ерөнхий мэдээлэл, ажлын арга аргачлал болон судалгааны үр дүн, цаашид хийх судалгааны чиглэл, хэтийн төлөвийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлангийн бичвэрийг үйлдэнэ.
- Судалгааны талбайн хэмжээнд геохимийн мэдээллийн санг байгуулж, элемент, нэгдлүүдийн шинжилгээний үр дүнгийн тоон утгуудыг анхдагч, цахим хэлбэрээр хадгална. Геохимийн тоон утгуудыг Microsoft XLS форматаар, мэдээллийн санг Microsoft Excel 2010 программ хангамжаар гүйцэтгэнэ. Тоон утгуудын боловсруулалтыг iOGas, Geosoft, MapGIS, ArcGIS зэрэг программ хангамжийн тусламжтайгаар гүйцэтгэнэ.
- Боловсруулсан химийн элемент тус бүрийн тархалтын зүй тогтлыг хүдрийн дүүрэг, зангилаа, талбайн геологийн тогтоцтой харьцуулах замаар тайлал хийнэ.
- Тайлангийн бүх зургийг ArcGIS прогаммаар бэлдэх, бичвэрийн Times New Roman фонтоор үйлдэх, тоон мэдээллийг УГА-ны Гео-мэдээллийн төвөөс баталсан зураг боловсруулах темплетийн дагуу боловсруулсан байх.
- Төслийн үр дүнд дараах зургуудыг зохионо.
 - Үндсэн зураг /Оросын талтай хил нийлж, баталгаажуулсан/
 - Баримт материалын зураг Масштаб 1:200 000
 - Геологийн зураг Масштаб 1:500 000
 - Структур-тектоникийн зураг Масштаб 1:1000 000
 - Ашигт малтмал, металлогенийн зураг Масштаб 1:1000 000
 - Ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээний зураг Масштаб 1:1000 000
 - Геохимийн дан элементийн болон эвшлийн зураг Масштаб 1:200 000
 - Геохимийн үнэлгээний нэгдсэн зураг Масштаб 1:200 000
 - Дагалдах зураг
 - Эрлийн ажлын үр дүнгийн зургууд /Сонгосон масштабаар/,
 - Геохимийн дан элементийн болон эвшлийн зураг /Сонгосон масштабаар/,

5. Ажил гүйцэтгэх хугацаа:

5.1. Төсөл, төсөв зохион батлуулах:

Эхний жилд: Шууд гэрээгээр

5.2. Хээрийн ажил:

Эхний жилд: 2026 оны 08-р сараас 10-р сарыг дуустал

Хоёр дахь жилд: 2027 оны 05-р сараас 10-р сарыг дуустал

Гурав дахь жилд: 2028 оны 05-р сараас 10-р сарыг дуустал

5.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт:

2026 оны 11,12-р сарыг дуустал

2027 оны 1-4-р сар, 11,12-р сарыг дуустал

2028 оны 1-4-р сар, 11,12-р сарыг дуустал

Эцсийн суурин боловсруулалт:

2028 оны 11-р сараас 2029 оны 08-р сарыг дуустал

5.4. Монголын стратиграфийн комиссоор хэлэлцүүлж дүгнэлт гаргуулж, түүний үндсэн дээр холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийх:

2029 оны 10-р сарын 10 хүртэл

5.4. Судалгааны ажлын эцсийн үр дүнгийн тайлан зохиож хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэх, шүүмжийн дагуу холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийх:

2029 оны 11-р сарын 20 хүртэл

5.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж, мэргэжилтэнээр хянуулж шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр ирүүлэх:

2029 оны 12-р сарын 20 хүртэл

5.6. ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулсны дараа Геологийн баримтын төв архивт тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсаны дараа ажлын 5 өдөрт

МОНГОЛ УЛС
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

БАТЛАВ: АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА **Б.ДАШПҮРЭВ**

2026 оны 03-р сарын 06-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2026/06

МОНГОЛ УЛСЫН ӨМНӨД ХИЛ ОРЧМЫН НУТГИЙН ГЕОЛОГИ,
ГЕОХИМИЙН ЗУРАГ ЗОХИОХ ТӨСЛИЙН 2026-2030 ОНД ГҮЙЦЭТГЭХ
АЖЛЫН ГЕОЛОГИЙН ДААЛГАВАР

Судалгааны үе шат: *Геологи, геохимийн судалгаа хийж, зураг зохиох*

Ашигт малтмалын төрөл: *Бүх төрлийн ашигт малтмал*

Судалгааны талбайн нэр: *Өмнөд нутгийн геологи, геохими*

Судалгааны талбайн байршил: *Баян-Өлгий, Ховд, Новь-Алтай, Баянхонгор,
Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Дорнод
аймгийн хил дагуух сумд*

Координат: *Монгол Улсын Өмнөд хил орчмын 100 км-ийн
өргөнтэй талбайг хамарна*

Судалгааны талбайн хэмжээ: *289666.15 кв.км*

Байрзүйн зургийн номенклатур: *М-45-Г, М-46-В М-50-В. L-45-Б. L-46-А. В. Г,
L-47-В, L-49-Г. L-50-А. Б. В, К-46-Б. К-47-А,Б. К-
48-А. Б. В. Г. К-49-А. Б*

Код: *Гео-Өмнөд-2026*

Төсөл хэрэгжих хугацаа: *2026-2030 он*

1. Геологийн даалгавар боловсруулах хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24, “Ашигт малтмалын тухай” хуулийн 16 дугаар зүйл, УИХурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2, УИХурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ийн 3.5.2, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төсөл, төлөвлөгөө”.

Судлагдсан түвшин:

Монгол Улсын өмнөд хил орчмын нутгийн геологи, ашигт малтмалын судалгааны түвшин харилцан адилгүй байна. Энэ бүс нутгийн хэмжээнд 1936-оод оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд, судалгааны онолын өөр өөр үндэслэлд тулгуурлан, түүнд нийцсэн арга аргачлалаар геологийн төрөл бүрийн судалгаануудыг гүйцэтгэж ирсэн түүхтэй.

Өмнөд хилийн дагуух Монголын Улсын нутаг нь 1:200 000-ны масштабтай геологийн зураглал болон Монгол Улс, БНХАУ-ын хилийн дагуух 1:1 000 000-ын масштабын геохимийн зураглалаар бүрэн, 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил болон агаарын соронзон зураглал, агаарын геофизикийн цогцолбор судалгаануудад хэсэгчлэн хамрагдсан байна. Мөн түүнчлэн ОХУ, БНХАУ, Япон, АНУ, Канадын болон бусад улсын эрдэмтэдтэй хамтарсан сэдэвчилсэн судалгаанууд хийгдэж, хамтын бүтээлүүд нь хэвлэгдсэн байдаг. Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНКаЗУ, БНСУ-ын геологийн албадын хамтарсан 1:2 500 000-ны масштабтай геологийн иж бүрдэл зурагаас өөр Монгол Улс, БНХАУ-ын хилийн бүсийн хэмжээнд хийгдсэн геологийн төрөл бүрийн судалгааны үр дүнг орчин үеийн онолын үндэслэлээр нэгтгэн зангидаж, нэг түвшинд боловсруулсан бүтээл өнөөдрийг хүртэл хараахан гараагүй байна.

Дээр дурдсан судалгаануудын үр дүнд хил орчмын нутгийн хэмжээнд ашигт малтмалын орд, илрэлүүд олноор тогтоогдон, заримыг нь ашиглаж байгаагаас гадна цаашид томоохон орд, илрэлүүдийг шинээр илрүүлэх хэтийн төлөвтэй бүс нутаг юм. Харин энэ нутаг нь хилийн боомтуудыг үл тооцвол, томоохон суурин газраас алслагдсан, дэд бүтэц муу хөгжсөн бүсэд оршино.

2. Төслийг хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл

Монгол Улсын өмнөд хил орчмын нутаг нь геологийн 1:200000-ны масштабтай зураглалаар бүрэн бүрхсэн хэмээн үзэж байгаа боловч тухайн ажлын явцад хавсарга байдлаар хийгдсэн геохимийн судалгаагаар нутаг дэвсгэрийн дөнгөж 50% бүрхэгдсэн байна. Тухайн үед лабораторийн шинжилгээгээр тодорхойлогдож байсан элементүүдийн тоо цөөн 17-22 элемент, зөвхөн металлогений шинж чанарыг тодорхойлоход хүрэлцэх хэмжээнд байсан ба тэдгээрийг тодорхойлж байсан шинжилгээний багажны мэдрэх чадамж сул, лабораторийн шинжилгээний анхдагч үр дүнгийн зарим хэсэг нь хадгалагдаагүй, зэрэг дутагдалтай байдлаас өнөөдрийн геохимийн судалгааны өмнө тавигдаж байгаа бусад зорилтуудыг хангаж чадахгүй байна.

Сүүлийн жилүүдэд Монгол орны нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан геохимийн зураг 1:1 000 000-ны масштабаар зохиогдсон (2019-2022 он) бөгөөд түүний үр дүнгээс үзэхэд, цаашид Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан олон талын зорилтот геохимийн зураглал явуулах зүй ёсны шаардлага урган гарч байна. Энэхүү судалгааг олон улсад нэвтэрсэн сүүлийн үеийн геохимийн судалгааны ажлын аргачлалын дагуу гүйцэтгэсэнээр Монгол Улсын нутаг дэвсгэрийн болон бүс нутгийн олон талын зориулалттай геохимийн зураг зохиогдох бөгөөд цаашид геохимийн судалгааны ажлын тулгуур мэдээллийг агуулсан геохимийн эталон дээжийн санг бүрдүүлнэ.

Харилцан адилгүй чанар, үр дүнгээс бүрдсэн геохимийн мэдээллийн сан нь өнөөгийн шаардлагыг хангахгүй байна. Мөн сүүлийн үед Монгол Улсад нэвтэрч суурьшсан лабораторийн шинжилгээний орчин үеийн техник, технологийн дэвшлийн олгож байгаа боломж, чадавхийг бүрэн ашиглаж, түүний үр дүнг бүтээлчээр ашиглах шаардлага урган гарч байна. Сүүлийн жилүүдэд Монгол оронд болж буй байгалийн гамшигт үзэгдэл болох геогамшиг буюу экологийн сөрөг үзэгдэл, тэдгээрийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлах, эрсдлээс гарах арга замыг тодорхойлох, шийдвэрлэх арга, аргачлал байхгүй байна.

Иймд, дээр дурдсан улс, орны амьдралаас зайлшгүй урган гарч ирсэн олон талын асуудлыг шийдвэрлэх, олон салбарт ашиглах боломжтой региональ геологи, геохимийн судалгааг гүйцэтгэж, түүний үр дүнг геологи, уул уурхай, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн, байгаль орчны болон бусад хэрэгцээтэй салбарт шинжлэх ухааны үндэслэлтэй, бүтээлчээр ашиглах бодит хэрэгцээ бид бүхний өмнө тулгарч байна.

Монгол Улсын Өмнөд хил орчмын нутагт региональ геологийн судалгаанд маргаантай, шийдвэрлэгдээгүй дараах асуудлууд байна. Үүнд:

Умард Монголын атриат мужийн Монгол Алтайн атриат мегабүсийн Таванбогдын бүсийн хэмжээнд:

- Монгол Алтай группын хурдсыг доод (E2-3ma₁) ба дээд (E2-3ma₂) зузаалагт хувааж үзүүлсэн тул Монгол Алтай группын хурдсын формацуудын хамаарлыг тодруулах.
- L-46-1-Б хавтгайд Х.Далелхан нар (2004, 5524ф) дунд ордовикт хамруулсан карбонат-терриген чулуулгаас тогтох Чигэртэй формацын насны үндэслэлийг баталгаажуулах.
- Б.Доржсүрэн, Д.Гансүх нар(2014, 7275ф)-ын УГЗ-200 төслөөр палеопротерозойн Их ганга метакомплексоос тогтсон гэж үзэн Бодонч террейнд хамруулж байсан блокийн Түргэн гол, Баянгол, Харуулын давааны хагарлуудын хоорондох хойт хэсгийг 2017 оны “1:500000-ны масштабын геологийн шинэ зураг”-т Таванбогдын бүсэд оруулж, энд Монгол алтай группын доод мэмбэр (E₂-3ma₁) тархсан гэж үзүүлсэн байна. Энэхүү хурдсыг 1:200000-ны ГЗЕЭА хийсэн Б.Ф.Жилевский нар (1955, 634ф) элсжин, элсэрхэг занар, гялтгануурт элсжингээс тогтох дээд силурын хурдаст хамааруулсан байдаг нь метаморфизмд тийм ч хүчтэй автаагүй болохыг, мөн найрлагаараа Монгол алтай группын доод зузаалагтай ижил байгаа тул энэхүү блокт Монгол алтай группын доод зузаалаг тархсан гэдгийг “L” эгнээний УГЗ-200 зургийн нэгтгэлд үзүүлсэнийг шалгах.

Цээл-Бодончийн бүсийн Бодончийн дэд бүсийн хэмжээнд:

Таван Богдын бүсийн өмнөд хэсэгт дунд-дээд кембрийн Монгол алтай формацын терриген хурдас болон Бодончийн бүсийн Цээл метаморф хурдас нь адилхан хүчтэй метаморфжсан ба тэдгээрийн төрөл бүрийн гнейсийн цирконд гадаадын судлаачдын (Nakano M., Yasuhito O., et al., 2014, Jiang et al., 2012)-н U-Th-Pb болон U-Pb аргаар тогтоосон нас нь хожуу девон, карбон, пермь, триасын түвшний бүлэг үүсгэж байгаа нь энэхүү 2 хурдас ижил цаг хугацаанд олон үе шаттай метаморфизмд автсаныг гэрчилдэг тул Бодончийн дэд бүсийн метаморф хурдсыг дахин судлах.

Говийн Алтай-Баруун уртын атираат мегабүсийн хэмжээнд:

- Уг мегабүсийн Гичгэнэ-Матадын бүсийн хэмжээнд өмнөх судлаачдын ялгасан Халзан формацын литологи, насны хамаарлыг тодруулах. Матадын бүсийн хэмжээнд Шовдол-Овоо формацын литологи, насны хамаарлыг тодруулах. Учир нь L-50-VII, XIII хавтгайнуудын баруун залгаа L-49-XII, XVIII хавтгайн УГЗ-200 иж бүрдлийн геологийн зургийн анхны хэвлэлд дээд ордовикийн флиш маягийн аргиллит, алевролит, элсжингээс тогтох Шовдол-Овоо формацын хурдсын үргэлжлэлд дунд девон, доод-дунд девон гэж насыг нь өөр өөр өгсөн Шарга уул формацын хурдас үргэлжилж байгааг үзүүлсэн байна. L-49-XVIII хавтгайд 1:200000-ны ГЗЕЭА хийсэн Г.Копек нар (1973, 2026ф) дээд ордовикийн Шовдол-Овоо формацын хурдсын үргэлжлэлд доод палеозойн хүчиллэг, дундлаг найрлагын вулканит, шохойн чулууны үе, мэшил бүхий цахиурлаг, элсэрхэг алевролит, шаварлаг занар давамгайлсан хурдсыг зурагласан байдаг тул түүнийг “L-эгнээний УГЗ-200 зургуудын нэгтгэл” төслөөр дээд ордовикийн Шовдол-Овоо формацд хамруулсан.

Говийн атираат мегабүс. Баруунхуурайн бүсийн хэмжээнд:

- Уг бүсийн интрузив магматизмын бүрдлүүдийн насны хамаарал сул судлагдсан тул радиологийн аргаар тодруулах шаардлагатай. Хожуу девоны габбро-габбро-диабаз бүрдэлийн насыг радиологийн аргаар баталгаажуулах.

- Пикрит-пикритоид бүрдлийн насны хамаарлыг баталгаажуулах. Уг чулуулаг нь гранитоид дотор том хэмжээний шлirүүд маягаар илэрдэг ба А.Э.Изох нар (1990) анх ялгаж K-Ar аргаар 344-310 сая жил нас тогтоон түрүү-дунд карбонд хамруулсан. Д.Гансүх нар (2014, 7275ф) түрүү пермийн Бааран бүрдлийн 1-р фаз гэж авсан. “L - эгнээний УГЗ-200 зургуудын нэгтгэл төсөл”-р 344-310 сая жил насыг үндэслэн түрүү-хожуу карбонд хамруулжээ.

- Түрүү-хожуу карбоны Баруунхуурай бүрдлийн интрузивийн насны хамаарал маргаантай тул нарийвчлан судлах. Учир нь Х.Ёндонпунцаг нар (2010, 6078ф) 1:50000-ны ГЗЕЭА-аар болорт пегматитат Гурван хүүхэд, Өвхийдэг уулын массивуудыг хожуу карбон-түрүү пермийн Баруунхуурай бүрдэлд ангилсан. “L -эгнээний УГЗ-200 зургуудын нэгтгэл” төсөл болорт пегматитат массивуудыг түрүү пермьд хамруулсан байна.

- Энэ бүсэд 1:200000-ны ГЗЕЭА-аар түрүү-дунд (сүүлд түрүү-хожуу карбонд хамруулан) өргөн тархалттайгаар Ө.Даваа нар (1995, 4385ф)-н ангилсан Баруунхуурай бүрдлийг 1:50000-ны ГЗЕЭА -аар болон анхны УГЗ-200 төслөөр насны хувьд зөрүүтэй, эсвэл өөр өөр бүрдэлд, тухайлбал түрүү-хожуу карбоны Баянбулаг бүрдэл, хожуу карбоны Байтаг, хожуу карбоны Баян-Айраг, түрүү пермийн Бааран, түрүү-дунд пермийн Мэргэн бүрдэлд (Д.Гансүх нар, 2014, 7275ф), хожуу карбонд (Б.Бямба нар, 2009, 5950), мөн түрүү карбоны Цагаангол габбро-монцодиорит-граносиенит бүрдэл

(Х.Ёндонпунцаг нар, 2003, 5603ф)д гэж өөр өөрөөр ангилсаныг нарийвчилан судалж, ялган ангилах.

Мандахын бүсийн хэмжээнд:

- Мандахын бүсийн Өмнөд говийн массивын Нүхэтдавааны блоктой хиллэх хил заагийг тодруулах.

- Мандахын бүсийн L-50 хавтгайд түрүү-хожуу карбон, хожуу девоны порфирын интрузив биетүүдийг илрүүлж, насыг радиологийн аргаар баталгаажуулахад анхаарах.

- Мандахын бүсийн L48, L-49, L -50 хавтгайг дамнан байрлах Хармагтай-Хөнгөөт-Оюут улаан-Онгоны минерагений бүсийн хэтийн төлөвтэй порфирын Cu-Au(Mo,Ag), Cu(Mo,Au,Ag)-н хүдэржилт дагуулсан порфирын интрузив бүрдэлийн нас нь түрүү-хожуу карбон (338-323 сая жил) гэж тогтоогдсон.

- Мандахын бүсийн K-48, K-49, L-49, L-50 хавтгайг дамнан байрлах Оюутолгой-Цагаансуваргын бүсийн порфирын Cu-Au(Mo,Ag), Cu-Mo(Au-Ag), Cu-Au-Mo-ны хамгийн хэтийн төлөвтэй хүдэржилт хожуу девон /372-362 сая жил/ гэж тогтоогдсон.

- Хилийн бүсэд орших доод-дунд девоны Өндөр-Үүд болон силур-доод девоны Нөмрөг формацад хамруулсан хурдсын насны хамаарлыг баталгаажуулах.

Өмнөд говийн массивын Говийн тэнгэр уулын блокийн хэмжээнд:

- Өмнөд Говийн Массивын Говийн Тэнгэр уулын Блокийн хэмжээнд түүний эртний атриат суурийн илрэл одоогоор тогтоогдоогүй байгаа бөгөөд ийм том талбай хамарсан эртний массив зураглах хангалттай үндэслэл одоогоор байхгүй байна. Иймд эртний суурийн үлдэц байх магадлалтай талбайнуудыг шалгах, метаморф чулуулгуудыг U-Pb геохронологийн шинжилгээнд хамруулах, мөн талбайн хэмжээнд тархалттай ортогнейс, интрузив бүрдлүүд болон вулканоген формацуудын геохронологийн шинжилгээг Rb-Sr, Sm-Nd-ийн изотоп-геохимийн шинжилгээтэй хослуулан, эртний царцдас байгаа эсэхийг тодруулах, боломжтой тохиолдолд тодорхой талбайнуудад изотопийн зураглал буюу 'isotopic mapping' хийх.

- Тус блокийн баруун талд ялгагдаад байгаа Төмөртийн ба Эхийн голын дэд бүсүүдийн хил зааг сүүлийн үеийн зураглалын ажлуудаар нилээд тодорч байгаа боловч блокийн төв ба зүүн хэсэгт "K" нэгтгэлийн ажлаар ялгагдсан Тостын ба Цохиотын дэд бүсүүдийн хил зааг бүрэн тогтоогдоогүй, баримжаалсан байдалтай байгааг тодруулах.

- Атас богд уулын дүүрэгт Лхүндэв нарын мэдээлсэн палеозойгоос өмнөх насны талст суурийн метаморф чулуулгийн үлдэгдэл ангилагдах магадлалтай зузаалгийн геохронологи, геохимийн судалгааг явуулах (Лхүндэв нар., 2013). Уг зузаалаг нь Монгол улсын 1:1000000 ба 1:500000 масштабын геологийн зургуудад доод-дунд ордовик ба дээд ордовик-силүрийн ангилагдаагүй зузаалагт тус тус зураглагдсан байдаг бол "K" нэгтгэлийн зурагт силүр-девонд ангилагдсан байна.

- Баруун талд илрэх Төмөрт ба Эхийн голын дэд бүсүүдийн кембри, ордовик, силүр, девоны формацуудын давхаргазүйн ангилал харьцангуй сайн хийгдсэн боловч төсөл төслүүдийн талбайн хэмжээнд тус тусдаа хийгдсэн байх бөгөөд эдгээрийг харьцуулах, бүс тус бүрт давхаргазүйн нэгдсэн ангилалыг боловсруулах.

- Говийн Тэнгэр уулын Блокийн баруун, төв ба зүүн хэсэгт тархалттай ордовик, силүр, карбоны вулканоген формацуудын харьцуулалтыг хийх, U-Pb геохронологи ба геохимийн шинжилгээнд хамруулан насыг баталгаажуулах, гарал

үүслийн геодинамик нөхцлийг тодруулан бүсийн хамаарлыг тогтоох, мөн силур, девон болон карбоны тунамал формацуудыг амьтан, ургамлын комплексоор харьцуулах.

Өмнөд говийн массивын Нүхтдавааны блокийн хэмжээнд:

Тус блокийн хэмжээнд дараах асуудлуудыг шийдвэрлэх:

- Нүхтдавааны блок болон түүний хойно орших Говийн атираат мегабүсийн Мандахын бүсийн хоорондын хил заагийг тодруулах.

- Нүхтдавааны блокийг хойт талаараа Говийн атираат мегабүсийн Матадын бүстэй хиллэдэг гэж үзсэн хагарал дагуух Модонгийн талбайд илрэх ба гипербазитаар үүссэн лиственит гэж үзсэн метасоматит хувирлыг гипербазитаар, эсхүл магнезит уу, магнилаг шохойн чулуугаас үүссэн үү гэдгийг тодруулах.

- Нүхтдавааны блокийн хэмжээнд тархсан гэж 1:50000-ны масштабын ГЗЕЭА-аар зурагласан биетүүдийг гипербазит эсэхийг тодруулах. (гипербазитыг дагалддаг элементүүдийн сарнилын хүрэнүүд, эрдсүүдийн шлихийн хүрэнүүд тогтоогдоогүй байгаа нь эргэлзээ төрүүлдэг)

- Нүхтдавааны блокт тархсан доод палеозойд хамааруулсан массивуудын насны хамаарлыг үнэмлэхүй насны шинжилгээгээр тодруулах (силур, девон гэх мэт)..

- “L -эгнээний УГЗ-200 зургуудын нэгтгэл төслөөр Нүхтдавааны блокийн баруун хэсэгт К-49, L-49-г дамнан орших хэсгийг нь Улаан уулын дэд блокт ангилсан. Анхны тектоникийн мужлалын схемд /В.А.Амантов нар, 1973/ энэхүү хэсгийг Улаан уулын өргөрдөл гэж нэрлэсэн. Улаан уулын дэд блокийн хилийн бүсийн Норовзээг, Өргөн болон доод кембрийн Төгрөгхудаг (E₁th), Нүдэн-Уул (E₃-O₁nu) зэрэг формацууд болон тэдгээрийг зүссэн ба хожуу девонд хамруулсан интрузив бүрдлийн насны хамаарлыг U-Pb геохронологийн аргаар тодруулж баталгаажуулах.

Замын үүдийн Заадасын бүсийн хэмжээнд:

Тус бүс нь хил зэргэлдээх Өвөр Монголын нутагт орших Хөгөн Шаны офиолитот бүсийн үргэлжлэлээр ялгагддаг (Төмөртоогоо, 2002) бөгөөд гарш цөөнтэй структур, нас ба гарал үүслийн асуудлаар иж бүрэн судалгаа явуулах шаардлагатай.

1. Хатанбулаг массивын Цагаан уулын блокт дараах асуудлуудыг шийдвэрлэх:

- Тус блокийн суурийг бүрдүүлж буй Хулстай формацын литологийн найрлага, хурдас хуримтлалын насны доод хязгаар, эх үүсвэрийн нас болон түрсэн интрузив бүрдлүүдийн насжилтаараа зүүн талд байрлах Хутаг уулын блокоос эрс ялгаатай болох нь тогтоогдоод байна (Наранцэцэг нар., 2021). Иймд Цагаан уулын блокийн суурийг бүрдүүлэгч Хулстай формацын хэмжээнд нэмэлт судалгаа явуулж насыг баталгаажуулах, хурдас хуримтлалын насны дээд хязгаарыг тогтоох.

- Мөн Хөрхийн нурууны өмнө талд буюу Хужиртын толгодоос зүүн урагшаа Өндөр Богд уул хүртэл 4-5 км өргөнтэй, 40 гаруй км урттай блок байдлаар тархсан метаморф зузаалгийн нас, формацын хамаарлын асуудлыг шийдвэрлэж блокийн суурийн бүрэлдэхүүнд хамаарагдах эсэхийг тогтоох.

- Зарим судлаачид Цагаан уулын блокийг эртний кратоны террейн гэж үздэг бөгөөд түүний хойд талд Хашаатын арлан нумын террейнийг ялгасан байдаг (Badarch et al., 2002). Харин энэхүү ялгаатай 2 структур нь Монгол орны нутаг дэвсгэрийн тектоник дүүрэгчлэлийн хамгийн сүүлийн үеийн схемд (Төмөртоогоо, 2017) нэгтгэгдэн Хатанбулгийн эртний массивын Цагаан уулын блокод ангилсан байдаг. Иймд эдгээр

2 структурыг бүрдүүлэгч формац ба бүрдлүүдийн геохронологи ба геохимийн харьцуулсан судалгааг хийх.

- Сүүлийн үеийн судалгаагаар табулят шүрийн тодорхойлолтод тулгуурлан силурын венлокийн түвшинд ялгаж байсан Хөхморьт формацын хурдасаас силурын лудловын настай (S₁₋₃) мөрхөлтөн илэрсэн (Эрдэнэжаргал нар., 2021) тул цаашид тус дүүрэгт үнэмлэхүй насны болон микропалеонтологийн нэмэлт судалгаа явуулах, стейжүүдийн түвшинд насыг нарийвчлах.

- Цагаан уулын блокийн хэмжээнд тархалттай интрузив бүрдлүүдийг өмнөх зураглалын ажлаар хожуу девоны Хашаат, түрүү пермийн Төгрөг, хожуу карбоны Могойт бүрдлүүд ялгаж байсан бол “К” нэгтгэлийн ажлаар эдгээр бүрдлүүдийг түрүү ба хожуу карбоны ангилагдаагүй бүрдэлд ангилан зурагласан байна. Иймээс эдгээр бүрдлүүдийн U-Pb геохронологийн судалгааг геохимийн судалгааны хамтаар явуулж бүрдлийн хамаарал ба гарал үүслийн нөхцлийг тогтоох шаардлагатай. Мөн насжилт, гарал үүслийн нөхцлөөрөө ялгаатай бүрдлүүдийн изотопи-геохимийн судалгаа хийх.

- Онъч хайрхан уул орчимд хожуу юра-түрүү цэрдийн Онъчхайрхан цөм бүрдлийг агуулагч эдиакари-доод кембрид ангилагдаж байсан занаржсан зузаалаг болон түүнээс зүүн тийш дунд пермийн Лугийнгол формацаар зураглагдаж байсан зузаалгуудыг “К” нэгтгэлийн зурагт дээд карбон-доод пермийн ангилагдаагүй зузаалагт ялгасан үндэслэлийг баталгаажуулах, U-Pb геохронологийн шинжилгээг хийж нас, давхаргагүйн ангилалыг үндэслэлтэй боловсруулах.

- Номгон Хашаат уул орчимд зураглагдсан дээд карбоны Баруунцохиот формацын вулканоген зузаалаг ба дээд карбон-доод пермийн ангилагдаагүй зузаалгийн хил заагийн харьцааг шалгах, вулканоген ба тунамал зузаалгийн геохронологи, геохимийн судалгааг хийж нас, гарал үүслийн нөхцлийг тодруулах, хойд талд нь илрэх Говийн Тэнгэр уулын блокийн Тост ба Цохиотын бүсийн ижил насны вулканоген формацуудтай харьцуулан судлах.

Хатанбулгийн массивын Хутаг уулын блокийн хэмжээнд:

- Хутаг-Уул метакомплексын бүрэлдэхүүнд хамаардаг ортогнейсүүд ба Холбоонуур бүрдэлд ангилагдсан гранитоидын геохимийн харьцуулсан судалгааг хийх, гарал үүслийн геодинамик нөхцлийг тодруулах шаардлагатай. Эдгээр ортогнейсүүд нь цөөхөн тооны геохимийн шинжилгээний дүнгээр коллизийн дараах тэлэлтийн процессын явцад үүссэн байх магадлалтай (Наранцэцэг нар., 2024). Иймд цаашид нарийвчлан судлах.

- Хутаг уулын блокийн хэмжээнд Цагаан Уулын блокийн адилаар доод неопротерозойн хурдас хуримтлал явагдаагүй, харин энэ цаг үед гранитын интрузивүүдийн түрэлт явагдаж, хурдас хуримтлалын тасалдал илэрч байгаа нь тогтоогдсон. Иймээс судалгааны өнөөгийн түвшинд тус хоёр блокийг нэгэн эртний массивын хэсгүүд гэж үзэх найдвартай үндэслэл бий болоогүй учир харьцуулсан судалгаа хийх.

- Судлаачдын Дуулгантын террейн, Сулинхээрийн бүс гэх зэргээр ангилж ирсэн бүсийн суурийг бүрдүүлэгч Даргиат формацын литологи, нас, гарал үүслийн асуудлыг шийдвэрлэх.

Сулинхээрийн заадасын бүсийн хэмжээнд:

Сулинхээрийн офиолит эвшлийн Монголын талд тархалттай хэт суурьлаг ба суурьлаг чулуулгуудын геохронологи, геохимийн судалгааг хийх.

Геологийн тогтоц, тектоник дүүрэгчлэл :

Монгол Улсын нутаг дэвсгэрийн тектоник дүүрэгчлэлийн хамгийн сүүлийн үеийн схемын (Төмөртогоо, 2017) дагуу төслийн талбайн хэмжээнд Умард Монголын атриат мужийн Монгол Алтайн Атриат Мегабүсийн Таванбогдын бүс, Бодонч-Цээлийн бүс, Өмнөд Монголын атриат мужийн Өмнөд Говийн Массивын Говийн Тэнгэр уулын ба Нүхтдавааны блок, Хатанбулгийн эртний массивын Цагаан уулын ба Хутаг уулын блок, Замын үүдийн болон Сулинхээрийн заадасын бүсүүд, Говийн Атриат Мегабүсийн Баруунхуурай, Мандахын бүсүүд, Хэрлэнгийн массивын Эрээндаваа ба Идэрмэгийн блок, мөн Говийн Алтай-Баруун Уртын Атриат Мегабүсийн Гичгэнэ-Матадын бүсийн хэсэг тус тус хамрагдана.

3. Ажлын зорилго:

Монгол Улсын хил орчмын нутагт олон жилийн хугацаанд хийгдсэн геологийн судалгааны ажлуудын үр дүнг орчин үеийн онолын үндэслэлээр нэгтгэн зангидаж, тогтоогдсон болон шинэ тогтоогдож болох ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг геологи-геохимийн судалгаатай уялдуулж, геохимийн үр дүнд тулгуурлан хэтийн төлвийн үнэлгээ өгөх нь энэхүү ажлын зорилго болно.

Тухайн судалгааны үр дүнд Монгол орны нутаг дэвсгэрийн өмнөд хилийн хэмжээнд геологийн геологийн тогтоцыг өмнөд хөршийн нутаг дахь геологийн тогтоцтой харьцуулан судалж, нэгтгэх, хурдас, чулуулгийн химийн элементүүдийн тархалтын онцлог, зүй тогтлыг тогтоох, геохимийн зураглалын ажлыг олон улсын жишигт нийцсэн арга, аргачлалаар хийж, хөрш орны геохимитэй нийцүүлэн судлах, хүрээлэн буй орчны химийн элементүүдийн тархалтын суурь мэдээллийн сан бүрдүүлж бусад салбарын хэрэглэх боломжийг хангах, ашигт малтмалын хэтийн төлвийн шалгуур, шинж тэмдгийг тогтоох, геологийн судалгааны түвшинг дээшлүүлэх ба геологийн судалгааны үр дүнгээр дамжуулан улс орны эдийн засгийн чадамжийг сайжруулна.

Улмаар улс орны хөгжлийн эрч хүч улам эрчимжиж, үйлдвэржихийн хирээр манай орны бүхий л салбар түүний дотор уул уурхай, хөдөө аж ахуй, хөнгөн хүнсний үйлдвэрлэл, хотжилтийн улмаас цаашид бий болох бохирдлын эрсдлийн магадлалд урьдчилсан үнэлгээ өгч, түүний нөлөөллийг бууруулах арга хэмжээний санал боловсруулахад оршино.

4. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх үндсэн арга аргачлал, дэс дараалал:

Төслийг хэрэгжүүлэхдээ дараахь дэс дарааллаар гүйцэтгэнэ.

А. Бэлтгэл үе шат:

4.1. Талбайн хэмжээнд өмнө нь хийж гүйцэтгэсэн геологи, геофизик, геохимийн болон бусад судалгааны ажлуудын үр дүн хуримтлагдсан мэдээлэлтэй танилцаж судлан, дүн шинжилгээ хийн дүгнэж, судалгааны арга аргачлалыг сонгоно. Үүнд:

- Өмнөх судалгааны бүх төрлийн ажлын үр дүн багтаасан баримт материал зургийг 1:200000-ын масштабтай топо суурь дээр бэлтгэх, төслийн талбайн ажлын байр зүйн зургуудыг зохих масштабаар бэлтгэн бүрдүүлж, тухайн талбайг бүрэн болон хэсэгчилэн хамарсан судалгааны материалуудтай танилцан боловсруулалт хийж, үнэлгээ өгөн дүгнэх, зохиох зургуудын нэгдсэн таних тэмдэгүүдийг зохиох.
- АСЗ-т геологийн тайлал хийх, түүнд тухайн талбайг бүрэн болон хэсэгчилэн хамарсан судалгааны материалуудыг ашиглан боловсруулалт хийх.
- Дээрхи материалуудад үндэслэн судалгааны ажлыг төлөвлөсөн байх.
- Шаардлагатай зарим мэдээлэл, материалыг англи хэл рүү хөрвүүлэх.

4.2. Төсөлд ажиллах ажилтан, ажилчдыг сонгох, машин техник тоног төхөөрмж, ажиллагсдын хөдөлмөр, ахуйн нөхцлийг хангахад чиглэгдсэн хээрийн судалгааны өмнөх бэлтгэл ажлуудыг бүрэн хангана.

4.3. Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрөл (орон нутаг, хилийн бүс, тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах гэх мэт), бичиг баримтыг бүрдүүлнэ.

4.4. Төслийн талбайн хэмжээнд хэрэгжсэн геологи, ашигт малтмал, геоэкологи, геохими болон геофизикийн судалгааны материал болон гадаад, дотоодын хэвлэлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны материалуудыг цуглуулж бүрдүүлэх, өмнөх шатны бүх төрлийн судалгааны ажлын үр дүнг багтаасан мэдээллийн сан үүсгэх, бүртгэл үйлдэх, баримт материалын зураг зохионо.

4.5. Үндэсний геологийн албаны өгсөн чиглэлийн дагуу хятадын талтай хамтран гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг зохион захиалагчид танилцуулан батлуулах, төлөвлөгөөнд тусгасан ажлыг төсөл, төсөвт тусгах, холбогдох арга хэмжээг авах, биелэлтийг хариуцан тайлагнана.

Б. Хээрийн ажлын үе:

Хээрийн судалгааны ажил эхлэхээс өмнө жил бүрийн хээрийн судалгааны ажлыг хэрхэн ямар хугацаанд гүйцэтгэхийг заасан ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө (ажлын хөтөлбөр) зохиосон байна.

4.6. Судалгаанд хамрагдах талбайн хэмжээнд төлөвлөсөн талбай хэсгүүдэд шалгах маршрутын судалгааг хийж, дагалдах дээжлэлт, сорьцлолтыг гүйцэтгэнэ.

4.7. Геохимийн талбайн сорьцлолтоос өмнө сорил-туршилтын ажлыг гүйцэтгэнэ. Энэ ажлын үндсэн зорилго нь бүс нутгийн ландшафтын онцлог, чулуулгийн өгөршлийн онцлог, хөрсний элэгдлийн эрчим, газрын гүний түвшний хэлбэлзэл болон усан сүлжээний хөгжил, морфологийн төрлүүд зэргүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр сорьц авах гүн, сорьцын фракцын хэмжээ зэргийг сонгоход оршино.

4.8. Хээрийн судалгааны үед дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Геологийн шалгах маршрут. Хээрийн маршрутын судалгаагаар танилцах, хил зааг зөрүүтэй болон бусад маргаантай болон бусад шалгах шаардлагатай талбай, хэсгүүдэд судалгааг явуулж, дагалдах дээж, сорьцыг авах.
- Шаардлагатай тохиолдолд чулуулгийн үнэмлэхүй нас тодорхойлох цогц дээж авах, хурдасны зүсэлт хийх.

- Чулуулгийн эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, геохимийн онцлог, текстур болон бусад шинжийг тодорхойлох зорилгоор бүх төрлийн дээж, сорьцыг арга, аргачлалын дагуу авах, шинжилгээ хийлгэх, боловсруулах, геологийн зурагт тусгаж, тайлбар бичиглэл хийх,
- 1:200 000-ын масштабтай сорьц авалтын аргачлалыг говь цөл, хээр тал, уулархаг нутаг зэрэг янз бүрийн ландшафтад тохируулан боловсруулах.
- Нэг цэгт хөрсний өнгөн хэсгээс болон 1 м орчим гүнээс 2 сорьц авах,
- Шаардлагатай тохиолдолд геохимийн гажил бүхий талбайд нарийвчилсан геохимийн сорьцлолт хийх.
- Төслийн талбайн 1:200 000-ын масштабтай геохимийн сорьцолтыг сонгосон аргачлалаар гүйцэтгэх.
- Хяналт хийх зорилгоор зэрэгцээ сорьцолтыг нийт сорьцын 5%-д хийх ба сорьцын жин нь 2 кг-аас багагүй байх
- Төслийн талбайгаас авсан сорьц, дээжийг баримтжуулан сан үүсгэх.

В. Суурин боловсруулалт:

4.9. Завсрын суурин боловсруулалт:

Монгол Улсын Өмнөд хил орчмын нутагт геологи, геохимийн зураг анх удаагаа зохиогдож байгаа тул тухайн зургуудыг зохиоход ашиглагдах мэдээллийн төрөл, хэмжээ, чанар, судалгааны жигд байдал зэргийг харгалзан үзэж суурин боловсруулалтын ажлыг дараах үе шаттайгаар гүйцэтгэнэ. Үүнд:

- Завсрын суурин боловсруулалт нь төслийн хэрэгжилтийн явцад хийгдэх ба энэ үед хээрийн судалгааны үр дүнд тулгуурлан шийдэх шаардлагатай бүхий л асуудлыг шийдвэрлэж, хүрсэн үр дүндээ тулгуурлан дараагийн үе шатны ажлаар шийдвэрлэх асуудлууд ба тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлно.
- Ажлын үр дүнд шаардлага хангасан мэдээлэл бүрдээгүй тохиолдолд түүнд дүн шинжилгээ хийж, судалгааны арга аргачлалыг өөрчлүүлэх хүртэлх саналыг тухайн үед нь захиалагчид тавьж шийдвэрлүүлнэ.
- Хээрийн судалгааны ажлаар хуримтлагдсан анхдагч мэдээлийг боловсруулан, урьд хийгдсэн ажлуудын үр дүнтэй уялдуулан шаардлагатай зураг, бүдүүвчийг бэлтгэн зохиох ба судалгааны үр дүнгээр нэгдсэн таних тэмдгийг баяжуулна.
- Зохиогдсон зургууд дахь элемент тус бүрийн тархалтын зүй тогтолыг Монгол орны геологийн региональ тогтоцууд болон металлогений мужлалтай харьцуулах замаар тайлал хийнэ.
- Бүх сорьц, дээжийг лабораторийн шинжилгээнд бүрэн хамруулж, үр дүнг боловсруулна.
- Нийт сорьцын 5%-д санамсаргүйгээр зэрэгцээ (дубликат) сорьц сонгон авч, нууц код өгч гадны лабораторид шинжилгээнд хамруулж шинжилгээний чанарын түвшинг тогтмол хянаж, зохих тооцоолол хийж, шаардлагатай тохиолдолд засварлана.
- Бусад холбогдох ажлыг гэрээнд заасны дагуу гүйцэтгэнэ..

4.10. Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалт:

- Төслийн талбайн геологи, геохими, структур-тектоник, ашигт малтмал-металлогений болон бусад зургуудыг Хятадын талтай хил нийлүүлэн, Хятадын талын ирүүлсэн зураг, өгөгдөл болон бусад холбогдох суурь судалгааны мэдээлэлд үндэслэн, шинэлэг мэдээллээр баяжуулан шинэчлэн боловсруулж, энэхүү геологийн даалгаварт заасан масштабаар зохиож, дагалдах тайлбар бичвэрийг үйлдэнэ.
- Судалгааны ажлын болон өмнөх судалгаагаар хуримтлагдсан мэдээлэл, материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийж, судалгааны талбайн ерөнхий мэдээлэл, ажлын арга аргачлал болон судалгааны үр дүн, цаашид хийх судалгааны чиглэл, хэтийн төлөвийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлангийн бичвэрийг үйлдэнэ.
- Судалгааны талбайн хэмжээнд геохимийн мэдээллийн санг үүсгэн бүрдүүлж, элемент, нэгдлүүдийн шинжилгээний үр дүнгийн тоон утгуудыг анхдагч, цахим хэлбэрээр хадгална. Геохимийн тоон утгуудыг Microsoft XLS форматаар, мэдээллийн санг Microsoft Excel 2010 программ хангамжаар гүйцэтгэнэ. Тоон утгуудын боловсруулалтыг iOGas, Geosoft, MapGIS, ArcGIS зэрэг программ хангамжийн тусламжтайгаар гүйцэтгэнэ.
- Төслийн үр дүнгийн тайланд Монгол Улс, БНХАУ-ын хилийн бүсийн дагуу хийгдсэн 1:1,000,000 масштабтай геохимийн зураглал, Монгол орны нутаг дэвсгэрт хийгдсэн 1:1,000,000 масштабтай геохимийн зураглалын ажлуудын анхдагч үр дүнг төслийн ажлын үр дүнтэй уялдуулан нэгтгэн тусгана.
- Боловсруулсан химийн элемент тус бүрийн тархалтын зүй тогтлыг хүдрийн дүүрэг, зангилаа, талбайн геологийн тогтоцтой харьцуулах замаар тайлал хийнэ.
- Тайлангийн бүх зургийг ArcGIS програмаар бэлдэх, бичвэрийн Times New Roman фонтоор үйлдэх, тоон мэдээллийг УГА-ны Гео-мэдээллийн төвөөс баталсан зураг боловсруулах темплетийн дагуу боловсруулсан байна.
- Төслийн үр дүнд дараах зургуудыг зохионо:
 - Үндсэн зураг /Оросын талтай хил нийлж, баталгаажуулсан/
 - Баримт материалын зураг Масштаб 1:200 000
 - Геологийн зураг Масштаб 1:500 000
 - Структур-тектоникийн зураг Масштаб 1:1000 000
 - Ашигт малтмал, металлогенийн зураг Масштаб 1:1000 000
 - Ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээний зураг Масштаб 1:1000 000
 - Геохимийн дан элементийн болон эвшлийн зураг Масштаб 1:200 000
 - Геохимийн үнэлгээний нэгдсэн зураг Масштаб 1:200 000
 - Дагалдах зураг
 - Эрлийн ажлын үр дүнгийн зургууд /Сонгосон масштабаар/,
 - Геохимийн дан элементийн болон эвшлийн зураг /Сонгосон масштабаар/,

5. Ажил гүйцэтгэх хугацаа:

5.1. Төсөл, төсөв зохион батлуулах:

Эхний жилд: Шууд гэрээгээр

5.2. Хээрийн ажил:

Эхний жилд: 2026 оны 08-р сараас 10-р сарыг дуустал
Хоёр дахь жилд: 2027 оны 05-р сараас 10-р сарыг дуустал
Гурав дахь жилд: 2028 оны 05-р сараас 10-р сарыг дуустал
Дөрөв дэхь жилд: 2029 оны 05-р сараас 10-р сарыг дуустал

5.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт:

2026 оны 11,12-р сарыг дуустал

2027 оны 1-4-р сар, 11,12-р сарыг дуустал

2028 оны 1-4-р сар, 11,12-р сарыг дуустал

2029 оны 1-4-р сарыг дуустал

Эцсийн суурин боловсруулалт:

2029 оны 11-р сараас 2030 оны 08-р сарын 30 хүртэл

5.4. Монголын стратиграфийн комиссоор хэлэлцүүлж дүгнэлт гаргуулж, түүний үндсэн дээр холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийх:

2030 оны 10-р сарын 10 дотор

5.4. Судалгааны ажлын эцсийн үр дүнгийн тайлан зохиож хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэх, шүүмжийн дагуу холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийх:

2030 оны 11-р сарын 20 хүртэл

5.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж, мэргэжилтэнээр хянуулж шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр ирүүлэх:

2030 оны 12-р сарын 20 хүртэл

5.6. ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулсны дараа Геологийн баримтын төв архивт тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсаны
дараа ажлын 5 өдөрт

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Ажил дуусгах хугацаа: **“Ашиглахгүй”**
2. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: **“Ашиглахгүй”**
3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: **“Ашиглахгүй”**
4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: **“Ашиглахгүй”**

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягт 1. Тендер илгээх

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [**“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих**]. [**Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих**].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [**ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо**] өдрийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна. [**Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг**]:
Хаяг:

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж ажил гүйцэтгүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
 - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
 - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
 - 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад

нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

Захиалагчийн үүрэг	нийтлэг	2.1.	Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.
		2.2.	Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.
		2.3.	Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.

Захиалагчийн төлөөлөгч		2.4.	Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.
		2.5.	Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
		2.6.	Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Талбайд зөвшөөрөл	нэвтрэх	2.7.	Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.
		2.8.	Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

Гүйцэтгэгчийн үүрэг	нийтлэг	3.1.	Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.
		3.2.	Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.
		3.3.	Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.
		3.4.	Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
		3.5.	Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
		3.6.	Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

- 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
- Гүйцэтгэгчийн төлөөлөгч 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
- 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Техникийн болон ажлын талбайн өгөгдөл 3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
- Ажлын талбайн харуул хамгаалалт 3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.
- 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.
- Хог, хаягдал ба нөхөн сэргээлт 3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.
- 3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.
- 3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.
- Археологийн болон бусад олдвор 3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.
- 3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.
- Аюулгүй байдал 3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

- 3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

Ажил эхлэх

- 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.

Хугацаа сунгах

- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
- 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
 - 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;
 - 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
 - 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
 - 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.

Ажлын явцын тайлан

- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар

ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- | | |
|-------------------|--|
| Гэрээний үнэ | 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална. |
| Урьдчилгаа төлбөр | 5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.
5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно. |
| Төлбөрийн нөхцөл | 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.
5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана. |

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- | | |
|-----------------------|---|
| Урьдчилгаа баталгаа | 6.1. ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | 6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.
6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:
6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; |

- 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
- 6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
- 6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
- 6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.
- Чанарын баталгаа 6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.
- 6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.
- 6.9. ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.
- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- Баталгаат хугацаа 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- Бусдад учруулсан хохирлыг арилгах 7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.
- Захиалагчийн эрсдэл хүлээх 7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;
- 7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;
- 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;

- 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.
- НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ**
- Доголдлыг арилгах илрүүлэх, 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.
- 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.

- Далд доголдол 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Зураг төслийн доголдол 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.
- 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.
- ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**
- Захиалагч гэрээг цуцлах 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;
- 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
- 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
- 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
- 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
- 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
- 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
- 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
 - 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
 - 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
 - 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
 - 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

- Мэдэгдэл 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
 - 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- Төлөөлөгч өөрчлөгдөх 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
- Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл 10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал 10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.

- Оюуны өмчийн эрх зөрчих 10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
- Маргаан шийдвэрлэх 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 1.1.7.	Судалгааны ажлын геологийн даалгаварт заасан техникийн үзүүлэлтийг хангасан тоног төхөөрөмжийг ашиглан Захиалагчийн сонгосон талбайд гүйцэтгэх судалгаа болон бусад ажлыг чанарын өндөр түвшинд тогтоосон хугацаанд гүйцэтгэн хүлээлгэн өгнө.
ГЕН 1.1.8.	Батлагдсан геологийн даалгаварт заасан солбицол бүхий талбай
ГЕН 1.1.10.	Захиалагчаас томилсон хөндлөнгийн хяналтын багаас судалгааны ажлын гүйцэтгэл, чанарт гарсан доголдлыг арилгуулахаар Гүйцэтгэгчид тухай бүр гаргасан шаардлага, доголдлыг арилгах хугацаа
ГЕН 1.2.5.	Гэрээг Монгол хэл дээр байгуулна.
ГЕН 3.1.	Гүйцэтгэгч нь геологийн даалгаварт заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгнө.
ГЕН 3.11.	Захиалагч нь ажлын талбайд өмнө гүйцэтгэсэн бүх төрлийн геологи (геологи, геохими, геофизик, гидрогеологи, байр зүйн, агаар, сансрын зураг болон бусад сэдэвчилсэн судалгаа)-ийн мэдээллийг Гүйцэтгэгчид холбогдох хууль, журмын дагуу тогтоосон нууцлалыг хангуулж ажил эхлэхээс өмнө өгч болно.
ГЕН 3.24.	Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцах бөгөөд ХАБЭА хариуцсан ажилтанг томилно.
ГЕН 4.1.	Судалгааны ажлыг гэрээ байгуулсан өдрөөс эхлэх бөгөөд тендерт ирүүлсэн ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө), ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
ГЕН 4.1.	Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалж гэрээ цуцлагдсан бол цуцлах хүртэл хийгдсэн ажлыг Захиалагчийн өмч гэж үзнэ.
ГЕН 4.2.	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: Ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас хойш 15 хоногийн дотор
ГЕН 4.9.	Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: - Эхлэлийн тайлан: Судалгааны ажил эхлэснээс хойш 30 хоногийн дотор; - Ажил гүйцэтгэлийн тайланг: Сар бүрийн 25-ны дотор; - Ажлын хэрэгжилтийн тайлан: Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор; - Үр дүнгийн тайлан: Геологийн даалгаварт заасан хугацаанд ирүүлнэ.
ГЕН 4.10.	Ажлын явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусган ирүүлэх ба эдгээр нь санхүүжилт олгох үндэслэл болно.
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: “Тохируулахгүй тогтмол байна”.
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: “Үгүй”
ГЕН 5.6.	Төлбөр төлөх: 1. Хөрсний геохими-эрдэслэг бүрэлдэхүүн-гео орчины судалгааны ажлын хувьд: - Судалгааны ажлын эхлэлийн тайлан ирүүлснээс хойш ажлын эхний жил 20% - 2 дах жил : гэрээний үнийн дүнгийн 35% - 3 дах жил : гэрээний үнийн дүнгийн 35% - Сүүлийн жил : гэрээний үнийн дүнгийн 10%-ийг тус тус гүйцэтгэгчид олгоно. 2. Монгол Улсын хойд хилийн орчмын нутгийн геологи, геохимийн зураг зохиох судалгааны ажлын хувьд - Судалгааны ажлын эхлэлийн тайлан ирүүлснээс хойш ажлын эхний жил 15%

	<ul style="list-style-type: none"> - 2 дах жил : гэрээний үнийн дүнгийн 35% - 3 дах жил : гэрээний үнийн дүнгийн 35% - Сүүлийн жил : гэрээний үнийн дүнгийн 15%-ийг тус тус гүйцэтгэгчид олгоно. <p style="text-align: center;">3. Монгол Улсын өмнөд хилийн орчмын нутгийн геологи, геохимийн зураг зохиох судалгааны ажлын хувьд</p> <ul style="list-style-type: none"> - Судалгааны ажлын эхлэлийн тайлан ирүүлснээс хойш ажлын эхний жил 16% - 2 дах жил : гэрээний үнийн дүнгийн 24% - 3 дах жил : гэрээний үнийн дүнгийн 24% - 4 дэх жил : гэрээний үнийн дүнгийн 24% - Сүүлийн жил : гэрээний үнийн дүнгийн 12%-ийг тус тус гүйцэтгэгчид олгоно. <p>Төлбөр төлөх төгрөгийн данс: [банкны нэр, дугаарыг оруул]</p> <p>Судалгааны ажилд зарцуулахаар тендерт ирүүлсэн үнийн санал бүхий төсвийн нэгтгэлийг Хавсралт-1-д заасны дагуу ажлын төрөл тус бүрээр, хэмжих нэгж, нэгжийн өртөг, нийт дүнгээр гаргаж ирүүлнэ.</p>
ГЕН 5.9.	Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй бөгөөд Захиалагчийн томилсон хөндлөнгийн хяналтын багийн дүгнэлт, саналын дагуу доголдол гарсан ажлыг өөрийн зардлаар дахин гүйцэтгэнэ.
ГЕН 6.2.	Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ: <i>Тухайн төсвийн жилд санхүүжих буюу гэрээний үнийн дүнгийн 3 хувь байна.</i> Гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх хугацаа: <i>Гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн байна.</i> Гүйцэтгэлийн баталгааг тендерийн баримт бичгийн "Гүйцэтгэлийн баталгаа"-ны маягтын дагуу гаргана. Судалгааны ажлын үр дүнгийн тайланг хамгаалж, Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэл гүйцэтгэлийн баталгааг цуцлахгүй.
ГЕН 6.7.	Чанарын баталгаа шаардах эсэх: "Шаардахгүй"
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа: "Шаардахгүй"
ГЕН 7.5.	Даатгалыг Гүйцэтгэгч бүрэн хариуцах бөгөөд даатгалд зайлшгүй хамруулах зүйл: <ol style="list-style-type: none"> 1. Машин механизм, техник, тоног төхөөрөмжийн алдагдал, эсхүл гэмтлийн даатгал, 2. Гуравдагч этгээдийн хариуцлагын даатгал, 3. Мэргэжлийн хариуцлагын даатгал, 4. Гэнэтийн ослын, амь нас эрүүл мэндийн хувьд холбогдох хуулийн дагуу ажил олгогчийн хүлээх хариуцлагын даатгал. <p>Тэмдэглэл: Энд хэрэглэх шаардлагатай гэж үзсэн даатгалын заалтыг нэмэх</p>
ГЕН 8.2.	Захиалагчийн төлөөлөгч, захиалагчийн томилсон хөндлөнгийн хяналтын багаас судалгааны ажил эхлэхээс дуусах хүртэл хугацаанд хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд геологийн даалгаварт заасан шаардлагад нийцээгүй зөрчил, доголдлыг арилгуулах хугацаа, зааварчилгаа бүхий мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө.
ГЕН 8.2.	Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд, өгсөн зааварчилгааны дагуу өөрийн зардлаар арилгана.
ГЕН 10.5.	Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаяг сольсон болон Гүйцэтгэгч санхүүжилт авах банк, дансаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
ГЕН 10.20.	Оюуны өмчийн тухай: <ol style="list-style-type: none"> 1. Судалгааны ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх

	<p>бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол Гүйцэтгэгч хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p> <p>2. Судалгааны ажлын анхдагч, завсрын, эцсийн тоон мэдээлэл, үр дүн Захиалагчийн өмч байна.</p>
ГЕН 10.21.	<p>Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.01 хүртэл хувиар тооцож Гүйцэтгэгчид төлнө.</p>
ГЕН 10.22.	<p>Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.03 хүртэл хувиар тооцож Захиалагчид төлнө.</p>
ГЕН 10.23.	<p>Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан, авах аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх үүрэгтэй. Задруулсан, дамжуулсан, ил болгосон тохиолдолд Монгол Улсын хуулиар хариуцлага хүлээнэ.</p>
ГЕН 10.24.	<p>Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх нууцлалын гэрээ байгуулан, мэдэгдлийн хамт өгнө.</p>
Бусад: (I)	<p>Ажлын явцад УУХҮС-ын тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, үр дүнг тооцох” журмын дагуу хээрийн үйлдвэрлэлийн болон суурин боловсруулалтын явцад шуурхай хяналт хийх, хээрийн анхдагч материал хүлээн авах комиссыг Захиалагч талаас ажлын шаардлагын дагуу томилон ажиллуулна. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг танилцуулан холбогдох санал, хүсэлтийг комиссоор дамжуулан Захиалагч талд хүргүүлж шийдвэрлүүлнэ.</p>
(II)	<p>Хилийн бүс, зурвас газар судалгааны ажлыг гүйцэтгэхдээ “Монгол Улсын хилийн тухай тухай” хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд Гүйцэтгэгч нь холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авахад Захиалагч дэмжлэг үзүүлнэ.</p>
(III)	<p>Гүйцэтгэгч нь хээрийн болон суурин судалгааны ажилд Захиалагчаас зөвшөөрсөн Монголын мэргэжилтэн, оюутнуудыг орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, арга, аргачлалд сургах, дадлагажуулж ажиллана.</p>
(IV)	<p>Гүйцэтгэгч нь хээрийн болон суурин судалгааны ажилд Захиалагчаас зөвшөөрсөн орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, арга, аргачлалыг хэрэглэнэ.</p>
(V)	<p>Гүйцэтгэгч нь хээрийн болон суурин судалгааны ажилд Захиалагчаас зөвшөөрсөн Олон Улсын зөвлөх, мэргэжилтэн, судлаачийг төслийн ажилд оролцуулж болно.</p>

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэр] гэрээ.

Дугаар № УГА/2026.....

Улаанбаатар хот

Нэг талаас **Үндэсний геологийн алба** (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн нэрийг бичих]** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт (Ажлын даалгавар);
 - 3.7. Ажил гүйцэтгэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:

Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА


ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

Хавсралт-1

Д/д	Ажлын төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Нийт дүн	
				тоо	дүн
0	1	2	3	4	5
	Төсөл, төсөв зохиох	%			
	АГЗ тайлалт	кв.км			
	Зураглал	кв.км			
	Эрлийн маршрут	т.км			
	Холбогдох дээжлэлт	сорьц			
	Геофизик: /ажлын төрөл, аргачлал тус бүрээр задаргаа хийнэ/	кв.км тууш км.ф.ц			
	гэм мэт				
	Хээрийн ажлын дүн				
	Зохион байгуулалт	%			
	Татан буулгалт	%			
	Сүүрин боловсруулалт	%			
	Өөрийн лаборатори /ажлын төрөл, аргачлал тус бүрээр задаргаа хийнэ/:	сорьц			
	Үйлд: хүн тээвэр Сонгосон тээврийн төрлийн марк	км			
	Үйлд: Ачаа тээвэр тээврийн төрлийн марк	т.км			
	Томилолтын зардал	хүн/өдөр			
	гэм мэт				
	Өөрийн хүчээр, бүгд				
	Топо суурь	төг			
	Тайлангийн зургийн зардал	төг			
	Онгоцны зардал	төг			
	гэм мэт				
	Дүн				
	Магадлашгүй зардал	%			
	гэх мэт				
	Нийт ажлын төсөвт өртөг	төг			

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.МӨНХБИЛЭГ



АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын *Геологи хайгуулын судалгааны ажил*
нэр:
Тендер шалгаруулалтын *ҮГА/20260101009/02*
дугаар:

2026 он

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	1
1. Тендерийн цар хүрээ	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	1
4. Худалдан авах ажиллагааны цахим систем	1
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх	1
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага	1
7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага	2
Б.АГУУЛГА	2
8. Тендер шалгаруулалтын баримт бичиг	2
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	2
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	3
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах	3
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	3
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	3
13. Тендерийн иж бүрдэл.....	3
14. Тендерийн жишиг маягтууд	4
15. Хувилбарт санал	4
16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг	4
17. Чадавхын болон туршлагын шаардлага	4
18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	5
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт	5
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	5
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	6
22. Тендерийн валют.....	6
23. Тендер хүчинтэй байх хугацаа	6
24. Тендерийн баталгаа.....	6
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ.....	7
25. Тендер баталгаажуулах, илгээх	7
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	7
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	7
27. Тендерийн талаар тодруулга авах.....	7
28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	7
29. Тендерийг үнэлэх	7
30. Арифметик алдааг залруулах.....	7
31. Давуу эрх олгох	8
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	8
33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	8
34. Тендерийг эрэмбэлэх	8
35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах	8
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	8
36. Мэдэгдэл хүргүүлэх.....	8
37. Гүйцэтгэлийн баталгаа.....	8
38. Урьдчилгаа төлбөр.....	9
39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	9

**7. Туслан гүйцэтгэгч,
түншлэлд тавигдах
шаардлага**

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б. АГУУЛГА

**8. Тендер шалгаруулалтын
баримт бичиг**

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

**9. Тендер шалгаруулалтын
баримт бичгийг тодруулах**

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий

шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг

нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1.Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2.Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3.Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4.ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5.ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6.Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.2. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.3. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1.Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн

хүснэгтэд заана.

24.2.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2.ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт 7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2.Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1.Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1.Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1.Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

29.2.Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.3.Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

30. Арифметик алдааг залруулах

30.1.Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
- Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**
- 36. Шийдвэр хүргүүлэх**
- 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37. Гүйцэтгэлийн баталгаа**
- 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах

- ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцүүлэн гаргана.
- 38. Урьдчилгаа төлбөр**
- 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
- 38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцүүлэн гаргана.
- 38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ				
ТШЗ 1.1	Захиалагч: <i>Үндэсний геологийн алба</i> Тендер шалгаруулалтын нэр: <i>Геологи, хайгуулын судалгааны ажил</i> Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: УГА/20260101009/02				
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 20%; text-align: center;">Д/д</td> <td style="text-align: center;">Багцын нэр</td> </tr> <tr> <td style="text-align: center;">Багц №1</td> <td>ТЭМЭЭТ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ</td> </tr> </table>	Д/д	Багцын нэр	Багц №1	ТЭМЭЭТ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ
Д/д	Багцын нэр				
Багц №1	ТЭМЭЭТ УУЛ ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50000-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ				
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”				
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн хөрөнгө				
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 2,694,888,750.00 төгрөг				
Б. АГУУЛГА					
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: <i>Үндэсний геологийн алба</i> Хаяг: <i>Монгол Улс, Улаанбаатар хот 18072, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрчний эвлэл-37</i> Утасны дугаар: 70171048 Цахим шуудангийн хаяг: info@ngs.gov.mn				
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”				
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ					
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: <i>Монгол хэл. Саналд хавсарган ирүүлэх материал нь гадаад хэл дээр бол түүний баталгаат орчуулгыг мөн хавсаргана. Энэ шаардлагаас зөрүүтэй бол захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно.</i>				
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”				
ТШЗ 16.1.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана” <i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн:</i> 7.1. Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ: 7.1.1. төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах шийдвэр гарсан, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлсэн, бизнесийн үйл ажиллагааг зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эдгээртэй адилтгах нөхцөлд байгаа; 7.1.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй; 7.1.3. Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдийн оролцсон тендер шалгаруулалт, түүний багцад тендер ирүүлсэн; 7.1.4. тухайн тендер шалгаруулалтад оролцохдоо бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцсон; 7.1.5. энэ хуулийн 4.1.10-т заасан этгээд; 7.1.6. дараах этгээдийн аль нэг нь авлигын, эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон: 7.1.6.а. оролцогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд; 7.1.6.б. оролцогчийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан эцсийн өмчлөгч; 7.1.6.в. оролцогчийн Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан. 7.1.7. тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахад зөвлөгөө өгсөн, оролцсон, эсхүл тухайн зөвлөгөө өгсөн, оролцсон этгээдтэй харилцан хамааралтай;				

	<p>7.1.8.тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй;</p> <p>7.1.9.энэ хуулийн 56.5.3, 56.5.4, 56.5.5-д заасан үндэслэлээр тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан, эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд,</p> <p>7.1.10.хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4-т заасан хүүхэд хамгааллын бодлого батлаагүй хуулийн этгээд.</p> <p>7.2.Оролцогч энэ хуулийн 7.1-д заасан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг бичгээр гаргана.</p> <p>7.3.Энэ хуулийн 7.1-д заасан нөхцөлийг магадлахтай холбогдох баримт бичиг ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бол оролцогч Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргуулан ирүүлнэ.</p> <p>7.4.Түншлэлийн гишүүн тус бүр ерөнхий шаардлага хангасан байх бөгөөд холбогдох мэдэгдэл, баримт бичгийг энэ хуулийн 7.2, 7.3-т зааснаар ирүүлнэ.</p>
<p>ТШЗ 18.1</p>	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”</p> <p>Оролцогчид тавих доод шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> - Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын дундаж нь батлагдсан төсөвт өртгийн 10 хувиас багагүй байх. - Түргэн хөрвөх хөрөнгө эсхүл авах боломжтой зээлийн нийт дүн: Батлагдсан төсөвт өртгийн 10 хувиас багагүй байх /дансны үлдэгдлийн банкны тодорхойлолт, авах боломжтой зээлийн тодорхойлолтыг гаргаж ирүүлнэ/. - Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.
<p>ТШЗ 18.2</p>	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p>1. Үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацаа:</p> <p>1.1. Оролцогч эсхүл түншлэлийн гишүүн нь Монгол Улсад бүртгэлтэй бол 2023, 2024, 2025 оны санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.ebalance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p>1.2. Оролцогч нь гадаад улсад бүртгэлтэй тохиолдолд сүүлийн хоёр жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайланг тендерт ирүүлэхдээ Монгол хэл рүү орчуулан ирүүлнэ.</p> <p>2. Хууль тогтоомжоор санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд 2023, 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт ирүүлнэ.</p> <p>3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч тендерт хавсарган ирүүлнэ. Уг асуудлаар харилцагч банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа авч ирүүлэхгүй.</p>
<p>ТШЗ 19.1</p>	<p>Техникийн чадавх болон туршлагын доод шаардлага: “Шаардана”</p> <p>1. Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана”</p> <p>Оролцогчийн санал болгох ажилтанд шаардагдах туршлагын доод түвшин:</p> <p>Төсөлд ажиллах ИТА (Улсын төсвийн санхүүжилттэй геологийн судалгааны хэрэгжиж буй төслүүдэд зөвлөхөөр ажиллаж байж болно. Инженер техникийн ажилчдын хувьд төсөл нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хяналтын хуудсаа авсан байж болно. Бусад тохиолдолд захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно)-ын бүрэлдэхүүн, тодорхойлолт. Үүнд:</p> <p>1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил:</p>

Төслийн удирдагч-1, зураглалын ахлах геологич-1, эрлийн ахлах геологич-1, геологич-4, газарзүй мэдээллийн систем хариуцсан геологич -1, нийт 8 хүн.

Багийн бүрэлдэхүүний туршлага, ур чадварын шалгуурын доод үзүүлэлт
1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил:

Албан тушаал	Мэргэжил боловсрол, туршлага	Үндсэн эсхүл гэрээт ажилтан байх
Төслийн удирдагч	-Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд 10-аас доошгүй жил ахлах геологич болон түүнээс дээш түвшинд ажилласан байх, -Мэргэшсэн эсхүл Зөвлөх геологич байх	Үндсэн
Эрлийн ахлах геологич	-Эрэл, хайгуулын чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан байх, -Мэргэшсэн эсхүл Зөвлөх геологич байх	Үндсэн
Зураглалын ахлах геологич	-Геологийн зураглалын чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан байх -Мэргэшсэн эсхүл Зөвлөх геологич байх	Үндсэн
Геологич	Геологийн зураглал, эрэл, хайгуулын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх.	50 хувь нь гэрээт байж болно.
Газарзүй мэдээллийн систем хариуцсан геологи	Газарзүй мэдээллийн системийн программ хангамж бүрэн эзэмшсэн, энэ чиглэлээр 2-оос доошгүй жил ажилласан, эсхүл ижил төсөөтэй төсөлд Газарзүй мэдээллийн системийн ажилтнаар оролцсон байх.	Гэрээт байж болно

Санал болгох ажилтнуудын боловсрол, мэргэжил, туршлагын мэдээллийг нотлох баримтын шаардлага хангаж ирүүлэх ба материалын бүрдэл дутуу, шаардлага хангахгүй (уншигдахгүй) бол захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно.

Хүний нөөцийн мэдээллийг дараах баримтаар нотолно. Үүнд:

1. Дипломын хуулбар /нотариатаар баталгаажуулсан эсхүл “ИМонголиа” цахим системээс татаж авсан лавлагаа/
2. Зөвлөх, мэргэшсэний хүчинтэй үнэмлэх
3. Нийгмийн даатгалын лавлагаа: Цахим системээс харна. /Хэрвээ цахим системд бүртгэлгүй бол тендерээс татгалзах үндэслэл болно. Үндсэн ажилтан нь сүүлийн 3 сарын нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн байна/.
4. ИТА-тай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хуулбар /нотариат/
5. Гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл /МУ-д бол судалгааны ажил хамгаалсан тайлангийн ЭБМЗ-ийн дүгнэлт, ОУ-д бол холбогдох мэдээллийг цахим орчинд танилцах холбоос/
6. Хэрэв инженер, техникийн ажилтнууд нь гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл “ИМонголиа” цахим

системээс татаж авсан лавлагааг ирүүлнэ. Хөлсөөр ажиллуулах гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.

Анхааруулга: Хүний нөөцийн боловсролын мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-аар нотлох гэж байгаа бол инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн эсвэл цахим системд бүртгэл байхгүй бол тендерийн нээлтээс өмнө Боловсролын яамны Цахим боловсрол, статистик, мэдээллийн хэлтэс, Боловсролын ерөнхий газарт хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү.

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <https://e-mongolia.mn/>

2. Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн доод шаардлага: “Шаардана”

Геологийн судалгаанд ашиглагдах автомашин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл:

1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд:

- Туулах чадвар сайтай (4x4) хүн тээврийн хэрэгсэл – хамгийн багадаа 3
- Туулах чадвар сайтай ачаа тээврийн хэрэгсэл – хамгийн багадаа 2
- Геологийн судалгааны ажилд шаардагдах бусад тоног төхөөрөмж, техник хэрэгсэл.

Санал болгож байгаа тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээллийг V бүлгийн маягт 3-ын дагуу ирүүлэх ба тэдгээрийн гэрчилгээний хуулбар, холбогдох техникийн үзүүлэлтийг нотлох баримтын шаардлага хангаж ирүүлнэ. Түрээсээр ашиглах бол түрээсийн гэрээний хуулбарыг мөн адил нотлох баримтын шаардлага хангаж ирүүлнэ.

Ажилчдад тухайн ажлыг гүйцэтгэх орчин нөхцөл /ажлын байр, хээрийн ажил явуулах орчин, багаж хэрэгсэл, геологийн мэдээлэл боловсруулалтын программ хангамж, аюулгүй ажиллагааны хэрэгсэл, хангамж гэх мэт/-ийг бүрдүүлэх чадамж, материалын бүрдэл дутуу, шаардлага хангахгүй (уншигдахгүй) бол захиалагч тендерээс татгалзах үндэслэл болно.

3. Ижил, төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын доод шаардлага: “Шаардана”

3.1. Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн:

- Геологийн судалгааны ажлын хувьд 20 хувиас багагүй үнийн дүнтэй ижил, төстэй ажлыг сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд доод тал нь 1 удаа гүйцэтгэсэн байх.

Гүйцэтгэсэн ажлын мэдээлэлд 1/ төсөвт өртөг, 2/ гэрээний хуулбар, 3/ гэрээ дүгнэсэн акт эсхүл түүнтэй ижил баримт (ЭБМЗ-ийн дүгнэлт, холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт)-ыг хавсарган ирүүлнэ.

4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”

4.1. Геологийн судалгааны (ижил төстэй) ажил хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсныг нотлох баримт буюу гэрээний хуулбар, эсхүл Захиалагчийн мэдээгдэл, тодорхойлолт;

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээллийг Маягт 5-ын дагуу гаргаж ирүүлнэ. Тухайн судалгааны ажлыг захиалагчийн геологийн даалгаврын дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэхийг баталсан мэдэгдэл заавал ирүүлнэ.

ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Шаардсан хүний нөөцийн мэдээллийг V бүлгийн маягт 2-ын дагуу ирүүлэх;</i> - <i>Оролцогчийн туршлагыг харуулах хэсэгт заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн маягт - 4, 5, 6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</i> - <i>Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээллийг V бүлгийн маягт 3 (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт)-ын дагуу нотлох баримтын хамт ирүүлэх;</i> - <i>Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт.</i> <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичигт заасан мэдээлэл нь тус судалгааны ажлын геологийн даалгаврын шаардлагыг хангахгүй бол Захиалагч ирүүлсэн тендерээс татгалзана.</p>								
ТШЗ 21.6	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна” .								
ТШЗ 21.6	Оролцогч тендерийн үнийг төсөвт өртгийн 90 хувиас доош үнэ санал болгох бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ. Ирүүлсэн тайлбар нь судалгааны ажлын геологийн даалгаварт заасан шаардлагыг бүрэн биелүүлэхгүй тохиолдолд Захиалагч тендерээс татгалзана.								
ТШЗ 21.6	Тендерийн үнийг Төгрөг -өөр илэрхийлнэ.								
ТШЗ 24.1	Тендерийн хүчинтэй байх хугацаа тендер нээснээс хойш ажлын 30-аас доошгүй өдөр байна.								
ТШЗ 24.1	<p>Тендерийн баталгааны дүн: Төсөвт өртгийн 0.5 хувь</p> <table border="1" data-bbox="448 1046 1461 1189"> <thead> <tr> <th data-bbox="448 1046 608 1137">№</th> <th data-bbox="608 1046 874 1137">Төслийн кодын нэр</th> <th data-bbox="874 1046 1137 1137">Батлагдсан төсөвт өртөг</th> <th data-bbox="1137 1046 1461 1137">Баталгаа /төсөвт өртгийн 0.5 хувь/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="448 1137 608 1189">Багц №1</td> <td data-bbox="608 1137 874 1189">Тэмээт уул-50</td> <td data-bbox="874 1137 1137 1189">2,694,888,750.00</td> <td data-bbox="1137 1137 1461 1189">13,474,443.75</td> </tr> </tbody> </table> <p>Хүчинтэй байх хугацаа: Тендерийн хүчинтэй байх хугацаа буюу тендер нээснээс хойш ажлын 29-өөс доошгүй өдөр байна.</p>	№	Төслийн кодын нэр	Батлагдсан төсөвт өртөг	Баталгаа /төсөвт өртгийн 0.5 хувь/	Багц №1	Тэмээт уул-50	2,694,888,750.00	13,474,443.75
№	Төслийн кодын нэр	Батлагдсан төсөвт өртөг	Баталгаа /төсөвт өртгийн 0.5 хувь/						
Багц №1	Тэмээт уул-50	2,694,888,750.00	13,474,443.75						
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ									
ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ul style="list-style-type: none"> - ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 7 дугаар зүйлд заасан оролцогчийн ерөнхий шаардлагууд - Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл - ТБОНӨХБАҮХАТХуулийн 22.5-д заасан үндэслэлээр ил болгохгүй баримт бичиг, мэдээлэл байгаа бол түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл - Тендер шалгаруулалтын баримт бичигт ил болгохоор заасан бусад баримт бичиг (Судалгааны ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө, төсөл гэх мэт) 								
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2026 оны 05 сарын 12-ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 00 минут</p>								
ТШЗ 26.2	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 30 минут</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 18072, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрчний эвлэл-37, Үндэсний геологийн албаны байр, 2 дугаар давхар, 219 дүгээр өрөө</p>								
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ									

ТШЗ 31.1	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: 1. Давуу эрх тооцуулах тухай албан хүсэлт ирүүлнэ. 2. ТБОНӨХБАҮХАТХуулийн 8.7.2-д заасны дагуу давуу эрх тооцуулах нөхцөл хангаж буй талаар нотлох баримт бичиг ирүүлнэ. (Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, загвар”-ын дагуу давуу эрх олгож, үнэлнэ)
ТШЗ 32.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”
Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 37.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “ Тийм ” - Гүйцэтгэлийн баталгаа нь тухайн жилд санхүүжих үнийн дүнгийн 3 хувь байна. - Гүйцэтгэгч нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 42.3 дахь заалтад заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ. - Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг Захиалагчийн тогтоосон хугацаанд ирүүлнэ.
Ё. БУСАД	
ТШЗ 38.1	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”

МОНГОЛ УЛС

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

БАТЛАВ: АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ДАШПҮРЭВ

2026 оны 05-р сарын 06-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2026/05

**ТЭМЭЭТ УУЛ-50 ТАЛБАЙД 2026-2029 ОНД ГҮЙЦЭТГЭХ 1:50 000-НЫ
МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖЛЫН
ГЕОЛОГИЙН ДААЛГАВАР**

Судалгааны үе шат:	<i>1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрэл</i>						
Ашигт малтмалын төрөл:	<i>Бүх төрлийн ашигт малтмал</i>						
Судалгааны талбайн нэр:	<i>Тэмээт уул</i>						
Судалгааны талбайн байршил:	<i>Дундговь аймгийн Сайнцагаан, Гурвансайхан, Өлзийт, Хулд, Луус сумдын нутаг</i>						
Судалгааны талбайн хэмжээ:	<i>3270.72 кв.км</i>						
Координат:	<i>№</i>	<i>гр</i>	<i>мн</i>	<i>сс</i>	<i>гр</i>	<i>мн</i>	<i>сс</i>
	<i>1</i>	<i>105</i>	<i>45</i>	<i>00</i>	<i>45</i>	<i>30</i>	<i>00</i>
	<i>2</i>	<i>106</i>	<i>30</i>	<i>00</i>	<i>45</i>	<i>30</i>	<i>00</i>
	<i>3</i>	<i>106</i>	<i>30</i>	<i>00</i>	<i>45</i>	<i>20</i>	<i>00</i>
	<i>4</i>	<i>107</i>	<i>00</i>	<i>00</i>	<i>45</i>	<i>20</i>	<i>00</i>
	<i>5</i>	<i>107</i>	<i>00</i>	<i>00</i>	<i>45</i>	<i>10</i>	<i>00</i>
	<i>6</i>	<i>106</i>	<i>30</i>	<i>00</i>	<i>45</i>	<i>10</i>	<i>00</i>
	<i>7</i>	<i>106</i>	<i>30</i>	<i>00</i>	<i>45</i>	<i>00</i>	<i>00</i>
	<i>8</i>	<i>106</i>	<i>00</i>	<i>00</i>	<i>45</i>	<i>00</i>	<i>00</i>
	<i>9</i>	<i>106</i>	<i>00</i>	<i>00</i>	<i>45</i>	<i>20</i>	<i>00</i>
	<i>10</i>	<i>105</i>	<i>45</i>	<i>00</i>	<i>45</i>	<i>20</i>	<i>00</i>
Хавтгай:	<i>L-48-92-Г</i>						
	<i>L-48-93-В,Г</i>						
	<i>L-48-105-А,Б,В,Г</i>						
	<i>L-48-106-А,Б</i>						
Код:	<i>ТэУ-50</i>						

1. Геологийн даалгавар боловсруулах хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24 дэх хэсэг, “Ашигт малтмалын тухай” хуулийн 16 дугаар зүйл, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2, УИХурлын 2025 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Алт-3” аян, УИХурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ийн 3.5.2, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төсөл, төлөвлөгөө”.

2. Судалгааны ажлын үндэслэл:

Судлагдсан түвшин:

Тайлангийн дугаар	Тайлангийн нэр	Гүйцэтгэсэн он
4762	Уудам талын районд хийсэн хайгуулын ажлын тайлан	1994
2414	Зүүн Монголын галт уулын чулуулгийн бүсийн баруун урд хэсэгт хийсэн ураны эрлийн тайлан /лист L-48-А,Б,В,Г; L-49-В/	1974
4621	Дөрвөн-Дэртийн чүнчигноровын ордын эрэл-үнэлгээ, Дундговь, Дорноговийн районы цагаан хаш ба бусад төрлийн өнгөт чулууны эрлийн болон мэдээ шалгасан ажлын тайлан	1992
4797	Өмнөговь, Дундговь аймгуудын нутагт 1992 онд хийсэн пиротилитийн эрлийн ажлын тайлан	1994
1869	Мандалговийн районд хийсэн барилгын материалын түүхий эдийн эрэл, хайгуулын тайлан	1971
2196	Дундговь аймгийн баруун хэсгийн нүүрс ба шатах занарт хийсэн эрэл-үнэлгээний тайлан /№4 анги/	1973
4621	Дөрвөн-Дэртийн чүнчигноровын ордын эрэл-үнэлгээ, Дундговь, Дорноговийн районы цагаан хаш ба бусад төрлийн өнгөт чулууны эрлийн болон мэдээ шалгасан ажлын тайлан	1992
4800	Дундговь аймгийн Гурвансайхан, Өлзийт сумын нутаг Сант-Уулын талбайд 1992-1993 онуудад гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай шлих, литохимийн сорьцлолтын ажлын үр дүнгийн тайлан. Байршил. L-48-105-А,Б,В,Г, L-48-106-А,Б нэрэлбэр бүхий	1995
10415	Дундговь аймгийн Дэлгэрхангай, Луус, Хулд сумдын нутагт орших Хулд-50 талбайд 2019-2022 онд гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр	2022

	дүнгийн тайлан. Код: Хул-50. L-48-103-А,Б,В,Г; L-48-104-А,Б,В,Г /хил залгаа/	
10080	Дундговь аймгийн Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрхангай, Хулд, Луус сумдын нутаг дахь "Шүтээн улаан уул-50" төслийн талбайд 2017-2020 онд гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан Байр-зүйн хавтгай: (L-48-67-В,Г; L-48-79-А,Б,В,Г; L-48-91-А,Б,В,Г; L-48-92-А,В) /хил залгаа/	2020
7755	Дундговь аймгийн Эрдэнэдалай, Адаацаг, Луус, Дэлгэрхангай, Сайнцагаан сумдын нутаг хамарсан Сайнцагааны талбайд 2012-2014 онуудад гүйцэтгэсэн 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил:L-48-80-АБВГ, L-48-81-АБ, L-48-92-Б, L-48-93-Б /хил залгаа/	2015
7345	Дундговийн Дэлгэрцогт, Дэрэн, Гурвансайхан, Сайнцагаан, Луус сумдыг хамарсан Мандалговийн талбайд 2011-2014 онд гүйцэтгэсэн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлан L-48-81-ВГ, L-48-82-АБВГ, L-48-93-Б, L-48-94-АБ /хил залгаа/	2014
4543	Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг Гурвансайханы талбайд хийсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, нарийвчилсан эрлийн ажлын үр дүнгийн тайлан. Байршил: L-48-94-Б-в,г, В,Г /хил залгаа/	1991
3676	Дундговийн районд хийсэн 1:200000-ны масштабын бүлэгчилсэн геологийн зураглалын тайлан	1983
7390	Монгол Улсын 1:200000-ны масштабын геологийн иж бүрдэл зураг зохиох "УГЗ-200 Өмнөд-Монгол-VI" төслийн 2010-2013 онд гүйцэтгэсэн үр дүнгийн тайлан L-48-XVII. XIX. XX. XXI.XXII. XXIII. XXIV. XXV. XXVI. XXVII. XXVIII. XXIX. XXX. XXXIII. XXXIV. XXXV. XXXVI	2014
1779	Мандалговийн районд хийсэн 1:500000-ны масштабын геологи-гидрогеологийн зураглалын тайлан /Мандал-говийн №8 анги/	1968
4028	Зүүн өмнөд Монголд хийсэн 1:500000-ны масштабын гидрогеологийн зураглалын тайлан (L-48БГ,L-49АВ,К-48БГ,К-49АБ)	1986

Геологийн тогтоц:

Төслийн талбай нь Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургаар ялгасан Идэрмэг, Өндөршил тектоникийн бүсүүдэд хамаарч байна. Талбайд дунд

протерозойн Оорцог формац, дээд дунд девоны Бутуулхудаг формац, доод цэрдийн Тэвшийнговь формац, доод цэрдийн Манлай формац, доод цэрдийн Могойт формац, дээд цэрдийн Сайншанд формац, дээд цэрдийн Баянширээ формац, болон дөрөвдөгчийн хурдас, дунд протерозойн ангилагдаагүй габбро-диорит-боржин бүрдэл, Дунд хожуу девоны Буянт бүрдэл, дунд хожуу пермийн Мандалговь бүрдэл, Хожуу триас түрүү юрагийн Борөндөр бүрдэл зураглагдсан байна.

1. Буянт бүрдэл ($D_2-3b?$ $C_1b?$). Ихбогд-Өндөршил, Идэрмэгийн бүсийн хэмжээнд маш өргөн тархалттай, анх Л.В.Заботкин (3676Ф), Г.Бөмбөрөө (4377Ф) нар ялган судалж, Б.Нямаа (7390Ф) Буянт бүрдэлд 3 фаз ялган, I фазад эвэрхуурмаг-пироксенит габбро, диорит, кварцат диорит, II фазад биотит-эвэрхуурмагт, гранодиорит, гранит, диорит, III фазад биотитот, биотит-эвэрхуурмагт заримдаа порфир маягийн гранит, лейкогранитыг ялгасан ба дэл судлын чулуулгаас микродиорит, микрогранит, аплитыг хамааруулсан. УГЗ-200 төслөөр Буянбаатар нар (6326Ф) дээрх хавтгайд дунд-хожуу девоны Буянт бүрдлийг габбро-диорит-гранитаар зурагласан бол зэргэлдээх талбайд уг бүрдлээр зураглагдсан гранитоидоос авсан дээжид үнэмлэхүй насны шинжилгээгээр 292.50 ± 2.47 сая жил (ШУУ-50 төсөл), 333.23 ± 1.2 сая жил (Хулд-50 төсөл) гэж тус тус тогтоосон бөгөөд Хулд-50 төслийн талбайд геологийн харьцаа, үнэмлэхүй насанд үндэслэн түрүү карбонд хамааруулсан байна.

2. Мандалговь бүрдэл (P_1-2m)-ийг Идэрмэгийн бүсэд Сахалгол формацын вулканиттай вулкан-плутон эвшил үүсгэн тархдаг гэж үздэг. Анх Л.В.Заботкин 1982 онд ялган, түрүү пермийн цаг үед хамруулж, Дамдинжав нар (5463Ф) түрүү-дунд пермийн настай Мандалговь бүрдлээр нэрлэн, 3 фазтайгаар ялгасан. I фаз габбро, габбродиорит, II фаз кварцат монцодиорит, диорит, биотит-эвэрхуурмагт жижиг мөхлөгт гранит, кварцат сиенит, граносиенит, III фаз биотитот, амфибол-биотитот шүлтлэгдүү гранит, лейкогранит, дэл судлууд нь гранит-порфир, микродиоритоос тогтдог. Хожим УГЗ-200 төслөөр Буянбаатар нар (6326Ф) түрүү-дунд пермийн настай гранодиорит-гранитын найрлагатай гэж үзсэн бол Эрдэнэчимэг нар (8480Ф) габбро, габбродиорит, диорит, кварцат диорит, гранодиорит, лейкогранит, шүлтлэгдүү лейкогранитоос тогтоно гэж үзсэн байна.

Ашигт малтмал: Төслийн талбай нь Дундговийн минерагений бүсийн Мандалговийн хүдрийн дүүргийн Луусын хүдрийн зангилаа болон Гурвансайхан-Өлзийтийн хүдрийн дүүргийн Хөтөл ус – Билгэх – Гурвансайханы хүдрийн зангилааг дамнан байрлах бөгөөд ЗУ зах хэсгээр нь Хөхдэл-Хайрхны хүдрийн зангилааны БХ зарим хэсэг хамрагдана. Тус талбайд өмнөх судалгаагаар Хайлуур жонш-12, Хүрэн нүүрс-1, Шохойн чулуу-1 орд, Асбест-2, Төмөр-2, Вольфрам-4, Барит-1, Хайлуур жонш-14, Болор-1, Цагаан тугалга-1, Хар тугалга-1, Зэс-1, Шохойн чулуу-6, Хүрэн нүүрс-1, Бал чулуу-1, Алт-2 илрэл тогтоогдсон.

Л.В.Заботкин нарын 1:200000-ны масштабын ГЗЕЭА-аар /1983, №3676/ төслийн талбай бүрэн бүрхэгдсэн бөгөөд олон тооны хайлуур жоншны илрэл, эрдэсэжсэн цэгүүдийг илрүүлсэн бөгөөд өнөөдөр байдлаар тэдгээр илрэлүүдэд хувийн хөрөнгөөр хайгуул хийж олон тооны ордуудыг тогтоосон.

Төслийн талбай нь хайлуур жоншны хувьд хэтийн төлөв маш өндөр, өнөөдрийн хувьд Л.В.Заботкин нар /1983, №3676/-ын илрүүлсэн зарим илрэл, эрдэсэжсэн цэгүүдийн хэтийн төлөв тодорхойгүй, ямар нэг ажил хийгдээгүй байна.

Доод цэрдийн Хөхтээг, Шинэхудаг, Манлай формацуудын доор орших нүүрс болон шатдаг занарын хувьд хэтийн төлөвтэй дээд юра-доод цэрдийн Могойт формацын хурдас нь

мезозойн хотгоруудаар газрын гадаргад /Үнст худгийн хотгор/ болон Манлай формацаар хучигдсан гэж зураглагдсан байгаа тул цэрдийн хотгоруудын цаашдын хэтийн төлөвийг тодруулах шаардлагатай.

Уг талбайн 1:50000-ны масштабын номенклатурын L-48-105-А,Б,В,Г, L-48-106-А,Б хавтгайд 1992-1993 онд 1:50000-ны масштабтай шлик, литогеохимийн сорьцлолт хийгдэж үр дүнгийн тайлан бичигдсэн. /Ж.Нармандах, 1992, №4800ф/ Харин L-48-92-Г, L-48-93-А,Б хавтгайд 1:50000-ны масштабын ямар нэг ажил хийгдээгүй ч хайлуур жоншны илрэлүүд нь орд болсон байдаг.

Эдийн засгийн хувьд:

Төслийн талбай нь нутаг дэвсгэр нь говь хээрийн бүсэд орших бөгөөд уур амьсгалын хувьд эх газрын эрс тэс хуурай мужид хамрагддаг. Агаарын температурын дундаж хэмжээ өвлийн улиралд -16-19 хэмийн дундаж хүйтэн, зуны улиралд 17-21 хэм дулаан, жилд дунджаар 95-150 мм хур тунадас ордог. Эдийн засгийн хувьд төслийн талбай нь Дундговь аймгийн засаг захиргааны нэгжид хамрагдах бөгөөд тус аймаг нь 2024 оны эцсийн байдлаар 46131 мянган хүн амтай, 3,547.7 мянган толгой малтай, ДНБ-ний өсөлт 16,8% Хэрэглээний үнийн индекс 107,4 хувь хүрсэн Нүүрс, жонш, гөлтгөнө, шохойн чулуу, төмрийн хүдэр зэрэг уул уурхай олборлолт, барилгын материалын үйлдвэрлэл хөгжиж байгаа төвийн бүс нутаг юм.

Ажлын зорилго:

Төслийн үндсэн зорилго нь:

- Судалгааны талбайд тархсан тунамал, вулканоген, интрузив, метаморф чулуулаг, тэдгээрийн эвшлээс бүрдэх хурдас, чулуулгийг судлан Монголын литостратиграфын кодексийн дагуу зохих нэгжүүдэд ангилан ялгаж, зураглах, тектоник структурийн төрлүүдийг тодорхойлж, геодинамик нөхцөлийг тогтоох.

- Судалгааны талбайд ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэн эрлийн шинж тэмдэг, шалгуурыг тогтоож, ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтлыг тодорхойлон хэтийн төлөв бүхий хэсгүүдийг ялган эрлийн ажлыг гүйцэтгэн судалсны үндсэн дээр минерагений нэгжүүдийг (бүс, дүүрэг, зангилаа, талбай г.м) ялган, тэдгээрийн хэтийн төлөвийг тодорхойлон, эрдэс баялгийн үнэлгээг өгч, цаашдын судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох. Хэтийн төлөв бүхий илрэлүүдэд баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх.

- Судалгааны ажлын үр дүнд тулгуурлан гидрогеологи, геоморфологи, геоэкологийн судалгааг хийж, холбогдох зургуудыг даалгаварт заасан масштабаар зохиох, байгаль орчин дахь нөлөөллийг урьдчилан үнэлэх, уул уурхайн салбарын хөгжлийн суурь мэдээллийг бэлтгэнэ.

Зураглалын ажлыг геологийн тогтоц, нэвтрэлтийн зэрэг, хучаас хурдасны тархалт, гаршийн онцлогтой уялдуулан гүйцэтгэх бөгөөд геологийн нийлмэл тогтоц, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд торыг нягтруулан зохих шаардлага (Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:50,000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийх заавар, тавих шаардлага, 2010)-ыг хатуу мөрдөнө.

Тэмээт уул-50 төслийн талбайн хэмжээнд гүйцэтгэх геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг мөрдөж ирсэн заавар, шаардлагын дагуу гүйцэтгэн геологи, ашигт малтмалын болон холбогдох бусад зургуудыг зохиох, ашигт малтмалын тархалтын зүй

тогтол, хэтийн төлөвийн үнэлгээг өгч, тэдгээрийн тайлбар бичгийг зохиож, анхдагч материалын сан бүрдүүлнэ.

3. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх үндсэн арга аргачлал ба дэс дараалал:

А.Бэлтгэл ажлын үе:

4.1. Судалгааны ажлын төсөл, төсөв, календарьчилсан төлөвлөгөө зохионо.

4.2. Талбайн хэмжээнд өмнө нь хийсэн геологийн үе шатны судалгаа болон сэдэвчилсэн судалгааны материалуудыг бүрэн судлан танилцаж дүн шинжилгээ хийх, түүний үндсэн дээр тухайн талбайд тохирсон судалгааны арга аргачлалыг сонгоно. Үүнд:

- Өмнөх шатны судалгааны бүх төрлийн ажлын үр дүнг багтаасан мэдээллийн сан үүсгэх, мэдээллийг боловсруулан үнэлэлт, дүгнэлт өгч, өөрсдийн судалгааны ажлын суурийг бэлтгэх, арга аргачлал боловсруулах, баримтын зургийг зохиож бүртгэл үйлдэх,
- Өмнөх судалгааны материалд үндэслэн тухайн дүүргийн онцлогт тохирсон талбайн сорьцлолтын аргыг сонгож, тоо хэмжээг тооцох,
- Төслийн талбайн хэмжээнд мэдэгдэж байгаа ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, шлих, литогеохимийн сарнилын хүрээ, гажлуудыг бүртгэж, тэдгээрт дүн шинжилгээ хийх, хэтийн төлөвийн урьдчилсан зураг зохиох,
- Төслийн талбайн 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын шаардлага хангасан, өндөр нарийвчлалын агаар, сансрын болон 1:25 000, 1:50 000-ны масштабтай байрзүйн зургуудыг холбогдох мэргэжлийн байгууллагаар бэлдүүлэх, АСЗ-т геологийн тайлал хийх, тухайн талбай хамрагдсан геофизикийн судалгааны (хүндийн хүчний, соронзон зураглал гэх мэт) материалуудтай танилцан, урьдчилсан тайлал, боловсруулалт хийх,
- Өмнөх шатны судалгааны материалууд болон АСЗ-т хийсэн урьдчилсан тайллыг ашиглан төслийн геологийн болон бусад холбогдох зургийг 1:50 000-ны масштабтаар зохиож, нэгдсэн таних тэмдэг зохиох,
- Хээрийн ажилд гарахын өмнө талбайн стратиграфи, магматизм, тектоникийн мэдээлэл, урьдчилсан тайлал хийсэн зургийн хүрээнд танилцах маршрут төлөвлөх, уг асуудлаар Монголын стратиграфийн комиссоос зөвлөгөө авч, хамтран ажиллах,
- Дээрх материалууд дээр үндэслэн цаашдын судалгааны ажлыг төлөвлөсөн байх,
- Хилийн болон тал, хээрийн бүсэд ажиллахтай холбоотой хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны бэлтгэлийг хангана.

4.3. Машин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон ажиллагсдын хөдөлмөр-ахуйн нөхцөлийг хангасан хээрийн судалгааны өмнөх бэлтгэлийг бүрэн хангана.

4.4. Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрөл (орон нутаг, хилийн бүс, тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах гэх мэт), бичиг баримтыг бүрдүүлнэ.

4.5. Хээрийн судалгааны шатанд зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгэх гэрээ, геологийн даалгавар, ажлын төсөл, төсөв болон холбогдох журам, зааврыг бүрдүүлэн бэлтгэнэ.

Б. Хээрийн ажлын үе:

4.6. Ажил эхлэхээс өмнө жил бүрийн хээрийн судалгааны ажлыг хэрхэн ямар хугацаанд гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөө (ажлын хөтөлбөр) зохиосон байна.

4.7. Судалгаанд хамрагдах талбайн хэмжээнд юуны түрүүнд танилцах маршрутыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Талбайд тархсан хурдас, чулуулаг, гүний биетүүдийн тогтоц, голлох бүрдүүлэгч чулуулгийн найрлага, тогтоц, онцлог, тэдгээрийн харьцаа, хил зааг, томоохон хувирал, өөрчлөлтийн бүсүүд, тасралтад эвдрэлүүд, органик үлдэгдэл тогтоогдсон цэгүүд, өмнөх судалгаануудаар тогтоосон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүд, бүх төрлийн гажлуудтай танилцаж, дүгнэлт гаргах, эдгээр геологийн биетүүдээс эталон дээж бүрдүүлэх, шаардлагатай бол урьдчилан дээжилж, сорьцлох,
- Талбайн сорьцлолтын урьдчилан боловсруулсан арга, аргачлалыг бодит байдал, орчин нөхцөл, ландшафтын онцлог, орчин үеийн хурдасны тархалт, гарал үүсэл, бүс нутгийн уур амьсгал зэрэгтэй уялдуулан нягталж, шаардлагатай бол туршилт аргачлалын сорьцлолт хийх, сорьцын тоог хучаас хурдсаар дарагдаагүй үндсэн чулуулгийн гарш бүхий нийт талбайд 1 кв.км-т >1 сорьц ноогдохоор тооцож, төлөвлөх,
- Маршрутын судалгаа, талбайн сорьцлолт эхэлж явуулах талбайг сонгох,
- Дээрх ажлуудыг гүйцэтгэхэд төслийн инженер техникийн ажилчид (ИТА), зөвлөхүүд бүгд оролцож, нэгдсэн дүгнэлт өгөх,
- Танилцах маршрутын үр дүнд тулгуурлан ажлын арга, аргачлалыг хянаж, шаардлагатай тохиолдолд заавар, шаардлагад нийцүүлэн зохих өөрчлөлтийг оруулан, хээрийн ажлын төлөвлөгөөг нарийвчилна.

В. Геологийн зураглалаар:

Геологийн зураглалын ажлыг ≤500 м-ийн торын нягтралтайгаар, чанарын шаардлага хангасан маршрутын судалгаагаар гүйцэтгэх бөгөөд доорх ажлуудыг хийж, асуудлыг шийднэ. Үүнд:

- АСЗ-ийг өргөн ашиглах, түүний тайллын үр дүнг газар дээр нь баталгаажуулан шалгаж, байнга засварлаж, нарийвчлал хийх,
- Урьдчилан зохиосон ажлын зурагт үнэлэлт дүгнэлт өгөх, шалган холбох маршрутыг шат дараатай явуулах,
- Төслийн талбайн хэмжээнд тархсан бүх төрлийн магмын болон хувирмал, тунамал, вулканоген хурдас, чулуулгийн тогтоц, найрлага, тархалт, хоорондын харьцаа, ялгааг тогтоох, литологи, структурыг нарийвчлан судалж төрөлжүүлэн зураглах, насны үндэслэлийг харьцуулалтын, палеонтологийн ба үнэмлэхүй насны шинжилгээгээр баталгаажуулах, тулгуур зүсэлтүүдийг хийх, нас, геохими, петрохимийн онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн дээж, сорьцыг арга, аргачлалын дагуу авах, шинжилгээ хийлгэх, боловсруулах ба урьдчилсан байдлаар ажлын геологийн зураг зохиож, тайлбар бичиглэл хийх, анхдагч баримт материалыг зааврын дагуу бүрдүүлэх,
- Хурдас чулуулгийн хил зааг, хоорондын харьцааг тогтоох, тэдгээрийн литологи, структурыг нарийвчлан зураглаж, формац, мэмбэр, бэд болон бүрдэл, фаз, фацийн түвшинд ялгах, шаардлагатай төрлийн сорьцлолтыг хийх, ингэхдээ дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байх. Үүнд:

1. Хулд 50, Дэвийн хонгор Уул 50, Модот толгой 50, Шүтээн Улаан уул 50 төслийн. Тайлан, үр дүнтэй танилцаж, талбайн хил заагийг нийлүүлэх.

2. Неопротерозойн Оорцог формацыг нарийвчилан зураглаж, хурдасны насыг нарийвчилах, үүнд зөөгдмөл циркон, тогтвортой изотопын аргуудыг хэрэглэх.

3. Девонгоор зураглагдсан хурдсанд зөөгдмөл цирконы нас, палеогеографийн судалгаанууд хийж, тектоникийн дүгнэлт гаргах.

4. Суурилаг болон хэт суурилаг биет бүрээс 3-с доошгүй дээжид геохимийн шинжилгээ хийлгэх.

5. Пермийн настай зураглагдсан интрузив, эффузив биетүүдэд геохимийн судалгаа хийх, үнэмлэхүй нас тогтоох.

6. Литологийн хувьд өмнөх судлаачдын ажлаар харилцан адилгүй, шүлтлэг гранит, сиенит, монцонит, катаклажсан болон гнейслэг лейкогранит ялгасан байдаг тул магмын чулуулагт цогц шинжилгээг /петрографи, петрохими, геохими, геохронологи/ хийлгэн, бодисын найрлага, гарал үүслийг тодруулах.

- Төслийн талбайн литостратиграфийн ангиллыг “Монголын литостратиграфийн кодекс”-ийн дагуу шинэчлэн, ангилсан хурдаснуудыг хроно ба региональ стратиграфийн номенклатуртай харьцуулах, литостратиграфийн нэгжийн бичиглэлийг кодексийн дагуу үйлдэх,
- Төслийн талбайд гүний чулуулаг, дэл судлын биетүүдийн гарал үүсэл, ангилал, бүрдлийн фаз, фацийг тодруулах, петрохими, геохими, петрографийн ба металлогений онцлогийг тодорхойлох, биетүүдийн нарийвчилсан бичиглэлийг хийх, бүрдэл, дэл судлын чулуулгийн геохими онцлог, эрдэслэг бүрэлдэхүүн, найрлага, структур, текстурыг тодорхойлох зорилгоор бүх төрлийн сорьцыг арга, аргачлалын дагуу авч, шинжилгээ хийлгэн, үр дүнг боловсруулах,
- Шаардлагатай тохиолдолд чулуулгийн үнэмлэхүй насыг тодорхойлуулах (тухайн гүний болон вулканоген, тунамал чулуулгийн онцлог, найрлага, гарал үүсэл, бусад онцлогийг бүрэн тодорхойлж, фаз, фацийн түвшинд зурагласан тохиолдолд энэ аргыг хэрэглэнэ),
- Талбайн сорьцлолтоор авсан литогеохимийн бүх сорьцод тоон шинжилгээ (ICP-MS) хийлгэж, үр дүнг боловсруулах,
- Орчин үеийн болон сэвсгэр хурдсыг гарал үүсэл, насаар нь нарийвчлан ангилж баталгаажуулах, тэдгээрийн зузаан, литологийн бүрэлдэхүүн, бусад шинжийг тодорхойлох,
- Төслийн талбайтай хил залгаа болон ойр хийгдсэн 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлуудын үр дүнтэй уялдуулах, харьцуулж шалгах,
- Талбайн тектоник-структурын бүтцийг нарийвчлан ангилж, тэдгээрийг бүрдүүлэгч хурдаснуудын формацын хамаарлыг тогтоон, нарийвчилсан бичиглэл хийх, тектоник-структурыг ашигт малтмалын тархалтын онцлогтой уялдуулан тайлбарлах,
- Геоморфологийн ажиглалт хийж, гадаргуугийн гарал үүсэл, хэлбэр дүрсийн төрлүүдээр ангилах, рельефийн хөгжлийн онцлог, үүссэн дарааллыг судалж зураглах, тайлах, ашигт малтмалын шороон хуримтлал үүсэх боломжтой нөхцөл бүрдсэн геоморфологийн элементүүдийг судалж тогтоох, морфоструктурын анализ хийх,
- Гидрогеологийн судалгаагаар тухайн талбайд байгаа худаг, булаг, шандыг координатжуулан, усны ундарга, түвшин бууралтыг хээрийн ажиглалтаар тогтоож, тухайн талбайн уст бүрдлийг төлөөлж чадахуйц уст цэгүүдээс гидрохимийн сорьц

авч, шинжлүүлэх, уст бүрдлүүдийн онцлогийг тодруулах, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа хийх,

- Геоэкологийн судалгаагаар тухайн талбайд байгаа үржил шимт өнгөн хөрсний үеэс төрөлжилтийн сорьцлолтыг холбогдох аргачлалын дагуу хийж химийн шинжилгээнд хамруулах, тоон үзүүлэлтийг тодруулах, өмнөх байгаль орчны чиглэлээр хийгдсэн судалгааны материалуудыг ашиглах, өөрсдийн судалгааны ажлаар тухайн талбай дахь геологийн ховор тогтоц (гео-өв), улаан номд орсон амьтан, ургамал, түүхийн дурсгалт зүйлсийн байршлыг координатжуулах, геоэкологийн зураг, экологи-геологийн суурь үнэлгээний зурагт тусгах зорилгоор судалгааны ажиглалтыг зураглалын маршрутын явцад хамт хийх, онцгой тохиолдолд чиглэсэн судалгаа явуулах,
- Төслийн талбайн хэмжээнд шугаман тогтоцтой дислокацид автсан чулуулгийн эрдэслэг бүрэлдэхүүн, үнэмлэхүй нас, структурийг нарийвчлан зураглах. Үүнд:
 - S0, S1, S2..., Sn хавтгай элементүүд (фолэйшн), Sn+1 тэнхлэг хавтгайг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
 - B1, B2..., Bn атирааны нугаснуудыг тодорхойлж зураглах, хэмжилт хийх,
 - L1, L2..., Ln линэйшнүүдийг төрөлжүүлэн (mineral, stretching, intersection) тодорхойлж зураглах, хэмжилт хийнэ.

Г. Эрлийн ажлаар:

Өмнө хийгдсэн төрөл бүрийн геологи, геохими, геофизикийн зэрэг судалгааны ажлын материал үр дүнг бүрэн гүйцэт ашиглах, хил залгаа улсын материалтай сайтар танилцан, цугласан материалд боловсруулалт, дүн шинжилгээ хийн, төслийн талбайн хэмжээнд тогтоогдсон эрлийн шинж тэмдэг, шалгууруудын үндсэн дээр эрлийн ажлыг ашигт малтмалын төрлийг харгалзан, арга, аргачлалыг оновчтой, үр дүнтэй байхаар сонгон төлөвлөн гүйцэтгэх;

- Өмнөх судалгаануудаар илэрсэн орд, илрэл, эрдэсэжсэн цэгүүдийг хээрийн судалгааны эхний жилд шалган, үр дүнг баталгаажуулах, хяналтын сорьцлолт хийх, ялангуяа өмнөх судлаачдын гидротермаль-метасоматит хувирал харьцангуй хүчтэй илэрсэн гэж зураглаж тэмдэглэсэн талбайнуудад гүйцэтгэх зураглал-ерөнхий эрлийн маршрутын явцад ашигт малтмалын талаар онцгой анхаарал хандуулах,
- Маршрутын судалгааны үр дүнд тогтоогдсон хувирал, эрдэсэжсэн бүс, биетүүдээс ашигт малтмалын шалгуур, шинж тэмдэг тэдгээрийн тоон агуулгыг тогтоох зорилгоор авсан дээж, сорьцуудын үр дүнг нэгтгэн боловсруулсны үндсэн дээр дараагийн шатны ажлыг төлөвлөн, гүйцэтгэх,
- Талбайн шлих, литогеохимийн сорьцлолтын ажлыг 1 кв.км талбайд >1 сорьц ноогдох байдлаар зохих заавар, аргачлалын дагуу зураглалын ажлаас түрүүлүүлэн гүйцэтгэж, тогтоогдсон хэтийн төлөв бүхий сарнилын хүрээ, гажлуудын торыг нягтруулан шалгаж, үнэлгээ өгөх, өмнөх судлаачдын илрүүлсэн церусситын шлихийн хүрээ, хар тугалга, хар тугалга-цайр-зэсийн геохимийн хүрээнүүдийн хэтийн төлөвийг нарийвчлах,
- Өмнөх судалгаагаар илэрч, тухайн ажлын явцад баталгаажсан болон төслийн ажлын судалгааны үр дүнд шинээр тогтоогдсон ашигт малтмалын хүдэржилт бүхий хэсгүүдээс ашигт малтмалын төрөл, онцлог, хэтийн төлөвтэй нь уялдуулан нарийвчилсан эрэл хийх талбайнуудыг сонгох,
- Сонгосон талбайнуудад ашигт малтмалын төрөл, онцлогтой уялдуулан нарийвчилсан эрлийн ажлыг 1:5 000 - 25 000-ны масштабаар, үе шаттайгаар, цогцолбороор гүйцэтгэх. Энэ ажлын хүрээнд дараах асуудлыг шалган шийдвэрлэх:

1.Геологийн зураглалын маршрутын үед эрлийн ажиглалтыг чанартай гүйцэтгэж, дагалдах дээжлэлт, сорьцлолтыг хийх.

2.L-48-92-Г, L-48-93-А,Б хавтгайд 1:50000-ны масштабын зураглал-ерөнхий эрлийн ажлын кондицийн шаардлага хангасан түвшинд шлих, геохимийн зураглал хийх.

3.1:200000-ны масштабын ГЗЕЭА-аар илэрсэн ба ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарахгүй орших хайлуур жоншны илрэл, эрдэсжсэн цэгүүдийн судлан, шаардлагатай тохиолдолд нарийвчилсан эрлийн ажлаар үнэлэх.

4. Цэрдийн хотгоруудын дотоод бүтэц тогтоцыг зураглал болон түүнд тохирох геофизикийн аргаар судлан тодруулж, ашигт малтмалын хэтийн төлөв /нүүрс, шатдаг занар, элсжингийн уран г.м./ -ийг үнэлэх

5. 1:50000-ны ГЗЕЭА-ын явцад шинээр илрэх ашигт малтмалын илрэл, цэгүүдийн хэтийн төлвийг үнэлэх

- Судалгааны талбайн хэмжээнд тогтоогдсон ашигт малтмалын орд, илрэл, эрдэсжсэн цэгүүдийн талбай болон биетийн хэмжээ, байрлал, хүдрийн болон дагалдагч эрдсийн найрлага, бүрэлдэхүүн, хүдэржилт, тэдгээрийн хувирлын төрөл, түүний хэмжээ, онцлогийг нарийвчлан судалж, дагалдах дээжлэлт, сорьцлолт хийх, холбогдох шинжилгээг бүрэн хийлгэх,
- Ашигт малтмалын илрэл, эрдэсжсэн цэгийг судлахын хамт талбайд тархсан хурдас, чулуулгийг эрдсийн түүхий эд болох талаас нь судлах,
- Ирээдүйн бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн бодлоготой уялдуулан зам, барилгын материалын түүхий эдийн судалгааг хийж, баялгийг үнэлнэ.

Д. Суурин боловсруулалт.

4.8. Завсрын суурин боловсруулалтаар:

- Хээрийн судалгааны явцад бүрдүүлсэн анхдагч баримт материалыг нэгтгэн боловсруулж, түүний үр дүнгээр баримт бүрдэл, геологи, шлих, геохимийн болон бусад холбогдох зургуудыг зохиох, бүх төрлийн дээж, сорьцын баримтжуулалтыг бүрдүүлэх, лабораторийн үр дүнгүүдийг зурагт буулгах, шаардлагатай тооцоолол, боловсруулалт хийж, дараагийн шатны ажлын төлөвлөлтөд ашиглах нөхцөл бүрдүүлэх,
- Хээрийн судалгаагаар шийдэж чадаагүй геологийн бүх асуудлыг шийдвэрлэх буюу дараагийн үе шатны ажлын үед шийдвэрлэх арга замыг сонгох, тодорхойлох, төлөвлөх,
- Төслийн хээрийн судалгаагаар талбайн тодорхой хэсэгт үүссэн зарчмын зөрүүтэй болон тодорхойгүй асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд дараагийн талбайд хээрийн ажлыг үргэлжлүүлэхийг хориглох,
- Судалгааны ажлын үр дүнд шаардлага хангасан мэдээлэлтэй болоогүй тохиолдолд түүнд дүн шинжилгээ хийж, тухайн асуудлыг шуурхай шийдвэрлэх арга замыг тодорхойлон шийдвэрлэх, ингэж чадаагүй тохиолдолд судалгааны арга аргачлалыг өөрчлүүлэх хүртэл саналыг тухайн үед нь захиалагчид хандаж, шуурхай шийдвэрлүүлнэ.

4.9.Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтаар:

- Мөрдөж буй заавар, шаардлагыг бүрэн хангасан анхдагч баримт, геологи, ашигт малтмал ба ашигт малтмалын тархалтын зүй тогтол, ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ, шлих болон литогеохимийн сорьцлолт, түүний үр дүнгийн зургуудыг 1:50 000-ны масштабтаар, тектоник, геоморфологи, гидрогеологи, геоэкологийн зургуудыг 1:100 000-200 000-ны масштабтаар, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий илрэл, эрлийн талбайн зургийг 1:1 000 - 25 000-ны масштабтаар тус тус зохиож, бусад төрөлжсөн зураг, бүдүүвч, график, хүснэгтийг хавсралтаар үйлдэх, зургууд нь ҮГА-ны Геомэдээллийн төвийн зурагт тавих шаардлагыг хангасан байх,
- Тухайн талбайн геологийн хөгжлийн түүхийг сэргээн босгохдоо О.Төмөртоогогийн тектоник-бүсчлэлийн, Г.Бадарчийн тектоно-стратиграфийн террейний болон Ж.Бямбын геодинамикийн ангиллаар төслийн талбай нь структур-тектоникийн ямар нэгжүүдэд хамаарч байгааг жишиж харьцуулж, дүгнэлт өгөх,
- Талбайн геологийн тогтоц, ашигт малтмалын гарал үүсэл, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, металлогений нөхцөлийг геодинамикийн хөгжилтэй уялдуулан дүгнэх,
- Төслийн талбайн ашигт малтмалын судалгааны үр дүнгээр хүдрийн талбай, потенциал талбайнуудыг шинээр ялгах,
- Талбайн хэмжээнд тогтоогдсон хэтийн төлөв бүхий ашигт малтмалын илрэлийн баялгийн үнэлгээг Р зэргээр өгөх,
- Төслийн ажлын үр дүнгээр төслийн талбайн хэтийн төлвийг А,Б,В,Г зэргээр үнэлэн цаашид хийх судалгааны ажлын чиглэлийг тодорхойлж, дараагийн шатанд нарийвчлан судлах талбайг ялган, дүгнэлт, зөвлөмж өгөх.
- Гидрогеологи, геоморфологи, геоэкологийн бүлгүүдийг өмнөх судалгааны ажил болон өөрсдийн ажлын үр дүнтэй уялдуулан тайлбарлах, дүгнэлт, зөвлөмж өгөх,
- Тайлангийн зургийг ArcGis программаар, бичвэрийг Times New Roman фондоор үйлдэх,
- Геофизикийн судалгааны ажлын үр дүнгээр зохиох ижил утгын зураг болон графикийг 1:25 000 -1 000-ны масштабтаар Geosoft Oasis Montaj программаар боловсруулах,
- Тухайн судалгааны ажлаар болон өмнөх судалгаагаар хуримтлагдсан геологи, геофизик, геохимийн зэрэг холбогдох бусад материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийснээр судалгааны талбайн ерөнхий мэдээлэл, ажлын арга, аргачлал болон геологийн тогтоц, ашигт малтмал, тэдгээрийн байршил, тархалтын зүй тогтол, хэтийн төлөв, тектоник, гидрогеологи, геоморфологи, геоэкологи зэргийг тусгасан тайлангийн зураг, бичвэрийг зохиож, Монголын стратиграфийн комисс болон хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гаргуулан, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Захиалагчийн шийдвэрийг гаргуулна.

5. Ажил гүйцэтгэх хугацаа:

5.1. Төсөл, төсөв зохион батлуулах:

Эхний жилд: - Шууд гэрээгээр.

5.2. Хээрийн ажил:

Эхний жилд:	2026 оны 8-р сараас 10-р сарыг дуустал
Хоёр дахь жилд:	2027 оны 5-р сараас 10-р сарыг дуустал
Гурав дахь жилд:	2028 оны 5-р сараас 10-р сарыг дуустал.

5.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт:	2026 оны 11-12-р сар дуустал
	2027 оны 1-4-р сар, 11-12-р сар.
	2028 оны 1-4-р сар дуустал

Эцсийн суурин боловсруулалт: 2028 оны 11-р сараас 2029 оны 10 сар дуустал.

5.4. Үр дүнгийн тайланг МСК-оор хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсны дараа хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэн холбогдох нэмэлт өөрчлөлт, засварыг хийж, геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албажуулан ирүүлэх:

2029 оны 11-р сарын 30.

5.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжээр хянуулж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт, засварыг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр албажуулан хүргүүлэх:

2029 оны 12-р сарын 30.

5.6. Тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох дүгнэлт, түүнд үндэслэн эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулсны дараа Геологийн мэдээллийн төв архивд тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны
дараа ажлын 5 өдөрт

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Ажил дуусгах хугацаа: **“Ашиглахгүй”**
2. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: **“Ашиглахгүй”**
3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: **“Ашиглахгүй”**
4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: **“Ашиглахгүй”**

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягт 1. Тендер илгээх

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].**
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо]** өдрийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.
[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:
Хаяг:

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж ажил гүйцэтгүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
 - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
 - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
 - 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад

нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

Захиалагчийн үүрэг	нийтлэг	2.1.	Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.
		2.2.	Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.
		2.3.	Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.

Захиалагчийн төлөөлөгч		2.4.	Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.
		2.5.	Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
		2.6.	Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Талбайд зөвшөөрөл	нэвтрэх	2.7.	Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.
		2.8.	Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

Гүйцэтгэгчийн үүрэг	нийтлэг	3.1.	Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.
		3.2.	Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.
		3.3.	Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.
		3.4.	Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
		3.5.	Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
		3.6.	Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

- 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
- Гүйцэтгэгчийн төлөөлөгч 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
- 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Техникийн болон ажлын талбайн өгөгдөл 3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
- Ажлын талбайн харуул хамгаалалт 3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.
- 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.
- Хог, хаягдал ба нөхөн сэргээлт 3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.
- 3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.
- 3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.
- Археологийн болон бусад олдвор 3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.
- 3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.
- Аюулгүй байдал 3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

- 3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

Ажил эхлэх

- 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

Хугацаа сунгах

- 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
 - 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;
 - 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
 - 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
 - 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.

Ажлын явцын тайлан

- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар

ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- | | |
|-------------------|--|
| Гэрээний үнэ | 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална. |
| Урьдчилгаа төлбөр | 5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.
5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно. |
| Төлбөрийн нөхцөл | 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.
5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана. |

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- | | |
|-----------------------|---|
| Урьдчилгаа баталгаа | 6.1. ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | 6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.
6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:
6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; |

- 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
- 6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
- 6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
- 6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.
- Чанарын баталгаа 6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.
- 6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.
- 6.9. ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.
- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- Баталгаат хугацаа 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- Бусдад учруулсан хохирлыг арилгах 7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.
- Захиалагчийн эрсдэл хүлээх 7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;
- 7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;
- 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;

- 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.
- НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ**
- Доголдлыг арилгах, илрүүлэх, 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.
- 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.

- Далд доголдол 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Зураг төслийн доголдол 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.
- 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.
- ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**
- Захиалагч гэрээг цуцлах 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;
- 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
- 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
- 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
- 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
- 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
- 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
- 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
 - 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
 - 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
 - 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
 - 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

- Мэдэгдэл 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
 - 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- Төлөөлөгч өөрчлөгдөх 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
- Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл 10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал 10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.

- Оюуны өмчийн эрх зөрчих 10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
- Маргаан шийдвэрлэх 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 1.1.7.	Судалгааны ажлын геологийн даалгаварт заасан техникийн үзүүлэлтийг хангасан тоног төхөөрөмжийг ашиглан Захиалагчийн сонгосон талбайд гүйцэтгэх судалгаа болон бусад ажлыг чанарын өндөр түвшинд тогтоосон хугацаанд гүйцэтгэн хүлээлгэн өгнө.
ГЕН 1.1.8.	Батлагдсан геологийн даалгаварт заасан солбицол бүхий талбай
ГЕН 1.1.10.	Захиалагчаас томилсон хөндлөнгийн хяналтын багаас судалгааны ажлын гүйцэтгэл, чанарт гарсан доголдлыг арилгуулахаар Гүйцэтгэгчид тухай бүр гаргасан шаардлага, доголдлыг арилгах хугацаа
ГЕН 1.2.5.	Гэрээг Монгол хэл дээр байгуулна.
ГЕН 3.1.	Гүйцэтгэгч нь геологийн даалгаварт заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгнө.
ГЕН 3.11.	Захиалагч нь ажлын талбайд өмнө гүйцэтгэсэн бүх төрлийн геологи (геологи, геохими, геофизик, гидрогеологи, байр зүйн, агаар, сансрын зураг болон бусад сэдэвчилсэн судалгаа)-ийн мэдээллийг Гүйцэтгэгчид холбогдох хууль, журмын дагуу тогтоосон нууцлалыг хангуулж ажил эхлэхээс өмнө өгч болно.
ГЕН 3.24.	Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцах бөгөөд ХАБЭА хариуцсан ажилтанг томилно.
ГЕН 4.1.	Судалгааны ажлыг гэрээ байгуулсан өдрөөс эхлэх бөгөөд тендерт ирүүлсэн ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө), ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
ГЕН 4.1.	Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалж гэрээ цуцлагдсан бол цуцлах хүртэл хийгдсэн ажлыг Захиалагчийн өмч гэж үзнэ.
ГЕН 4.2.	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: Ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас хойш 15 хоногийн дотор
ГЕН 4.9.	Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: - Эхлэлийн тайлан: Судалгааны ажил эхлэснээс хойш 30 хоногийн дотор; - Ажил гүйцэтгэлийн тайланг: Сар бүрийн 25-ны дотор; - Ажлын хэрэгжилтийн тайлан: Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор; - Үр дүнгийн тайлан: Геологийн даалгаварт заасан хугацаанд ирүүлнэ.
ГЕН 4.10.	Ажлын явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусган ирүүлэх ба эдгээр нь санхүүжилт олгох үндэслэл болно.
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: “Тохируулахгүй тогтмол байна” .
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: “Үгүй”
ГЕН 5.6.	Төлбөр төлөх: - Судалгааны ажлын эхлэлийн тайлан ирүүлснээс хойш ажлын эхний жил 20% - 2 дах жил : гэрээний үнийн дүнгийн 35% - 3 дах жил : гэрээний үнийн дүнгийн 35% - Сүүлийн жил : гэрээний үнийн дүнгийн 10%-ийг тус тус гүйцэтгэгчид олгоно. Төлбөр төлөх төгрөгийн данс: [банкны нэр, дугаарыг оруул] Судалгааны ажилд зарцуулахаар тендерт ирүүлсэн үнийн санал бүхий төсвийн нэгтгэлийг Хавсралт-1-д заасны дагуу ажлын төрөл тус бүрээр, хэмжих нэгж, нэгжийн өртөг, нийт дүнгээр гаргаж ирүүлнэ.
ГЕН 5.9.	Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй бөгөөд

	Захиалагчийн томилсон хөндлөнгийн хяналтын багийн дүгнэлт, саналын дагуу доголдол гарсан ажлыг өөрийн зардлаар дахин гүйцэтгэнэ.
ГЕН 6.2.	Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ: <i>Тухайн төсвийн жилд санхүүжих буюу гэрээний үнийн дүнгийн 3 хувь байна.</i> Гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх хугацаа: <i>Гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн байна.</i> Гүйцэтгэлийн баталгааг тендерийн баримт бичгийн “Гүйцэтгэлийн баталгаа”-ны маягтын дагуу гаргана. Судалгааны ажлын үр дүнгийн тайланг хамгаалж, Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэл гүйцэтгэлийн баталгааг цуцлахгүй.
ГЕН 6.7.	Чанарын баталгаа шаардах эсэх: “Шаардахгүй”
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа: “Шаардахгүй”
ГЕН 7.5.	Даатгалыг Гүйцэтгэгч бүрэн хариуцах бөгөөд даатгалд зайлшгүй хамруулах зүйл: 1. Машин механизм, техник, тоног төхөөрөмжийн алдагдал, эсхүл гэмтлийн даатгал, 2. Гуравдагч этгээдийн хариуцлагын даатгал, 3. Мэргэжлийн хариуцлагын даатгал, 4. Гэнэтийн ослын, амь нас эрүүл мэндийн хувьд холбогдох хуулийн дагуу ажил олгогчийн хүлээх хариуцлагын даатгал. Тэмдэглэл: Энд хэрэглэх шаардлагатай гэж үзсэн даатгалын заалтыг нэмэх
ГЕН 8.2.	Захиалагчийн төлөөлөгч, захиалагчийн томилсон хөндлөнгийн хяналтын багаас судалгааны ажил эхлэхээс дуусах хүртэл хугацаанд хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд геологийн даалгаварт заасан шаардлагад нийцээгүй зөрчил, доголдлыг арилгуулах хугацаа, зааварчилгаа бүхий мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө.
ГЕН 8.2.	Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд, өгсөн зааварчилгааны дагуу өөрийн зардлаар арилгана.
ГЕН 10.5.	Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаяг сольсон болон Гүйцэтгэгч санхүүжилт авах банк, дансаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
ГЕН 10.20.	Оюуны өмчийн тухай: 1. Судалгааны ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол Гүйцэтгэгч хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана. 2. Судалгааны ажлын анхдагч, завсрын, эцсийн тоон мэдээлэл, үр дүн Захиалагчийн өмч байна.
ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.01 хүртэл хувиар тооцож Гүйцэтгэгчид төлнө.
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.03 хүртэл хувиар тооцож Захиалагчид төлнө.
ГЕН 10.23.	Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан, авах аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх үүрэгтэй. Задруулсан, дамжуулсан, ил болгосон тохиолдолд Монгол Улсын хуулиар хариуцлага хүлээнэ.
ГЕН 10.24.	Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх нууцлалын гэрээ байгуулан, мэдэгдлийн хамт өгнө.

Бусад: (I)	Ажлын явцад УУХҮС-ын тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, үр дүнг тооцох” журмын дагуу хээрийн үйлдвэрлэлийн болон суурин боловсруулалтын явцад шуурхай хяналт хийх, хээрийн анхдагч материал хүлээн авах комиссыг Захиалагч талаас ажлын шаардлагын дагуу томилон ажиллуулна. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг танилцуулан холбогдох санал, хүсэлтийг комиссоор дамжуулан Захиалагч талд хүргүүлж шийдвэрлүүлнэ.
(II)	Хилийн бүс, зурвас газар судалгааны ажлыг гүйцэтгэхдээ “Монгол Улсын хилийн тухай тухай” хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд Гүйцэтгэгч нь холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авахад Захиалагч дэмжлэг үзүүлнэ.
(III)	Гүйцэтгэгч нь хээрийн болон суурин судалгааны ажилд Захиалагчаас зөвшөөрсөн дотоодын болон гадаадын мэргэжилтэн, оюутнуудыг орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, арга, аргачлалд сургах, дадлагажуулж ажиллана.
(IV)	Гүйцэтгэгч нь хээрийн болон суурин судалгааны ажилд Захиалагчаас зөвшөөрсөн орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, арга, аргачлалыг хэрэглэнэ.
(V)	Гүйцэтгэгч нь хээрийн болон суурин судалгааны ажилд Захиалагчаас зөвшөөрсөн Олон Улсын зөвлөх, мэргэжилтэн, судлаачийг төслийн ажилд оролцуулж болно.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэр] гэрээ.

Дугаар № УГА/2026.....

Улаанбаатар хот

Нэг талаас **Үндэсний геологийн алба** (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн нэрийг бичих]** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт (Ажлын даалгавар);
 - 3.7. Ажил гүйцэтгэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:

Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

Д/д	Ажлын төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Нийт дүн	
				тоо	дүн
0	1	2	3	4	5
	Төсөл, төсөв зохиох	%			
	АГЗ тайлалт	кв.км			
	Зураглал	кв.км			
	Эрлийн маршрут	т.км			
	Холбогдох дээжлэлт	сорьц			
	Геофизик: /ажлын төрөл, аргачлал тус бүрээр задаргаа хийнэ/ гэх мэт	кв.км тууш км.ф.ц			
	Хээрийн ажлын дүн				
	Зохион байгуулалт	%			
	Татан буулгалт	%			
	Суурин боловсруулалт	%			
	Өөрийн лаборатори /ажлын төрөл, аргачлал тус бүрээр задаргаа хийнэ/:	сорьц			
	Үйлд: хүн тээвэр Сонгосон тээврийн төрлийн марк	км			
	Үйлд. Ачаа тээвэр тээврийн төрлийн марк	т.км			
	Томилолтын зардал гэм мэт	хүн/өдөр			
	Өөрийн хүчээр, бүгд				
	Топо суурь	төг			
	Тайлангийн зургийн зардал	төг			
	Онгоцны зардал гэм мэт	төг			
	Дүн				
	Магадлашгүй зардал гэх мэт	%			
	Нийт ажлын төсөвт өртөг	төг			

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/248 дугаар тушаалын хавсралт
ЦАХИМ СИСТЕМЭЭР ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ ТАСРАЛТГҮЙ,
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн 9.1-д заасны дагуу худалдан авах ажиллагааг цахим систем (цаашид "цахим систем" гэх)-ээр зохион байгуулахтай холбоотой нөхцөл, шаардлагыг тодорхойлох, цахим системийн тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах, тендер шалгаруулалттай холбоотойгоор цахим системд хандах, мэдээлэл авах эрх бүхий этгээдийг тогтооход энэ журмын зорилго оршино.

1.2.Цахим систем нь www.tender.gov.mn гэсэн хаягтай байх ба цахим системийн тасралтгүй, аюулгүй ажиллагааг худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид "мэргэжлийн байгууллага" гэх) хангаж ажиллана.

1.3.Захиалагч, аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, оролцогч болон холбогдох бусад этгээд хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн байгууллагаас гаргасан журам, аргачлал, зааварчилгааны дагуу цахим системийг хэрэглэнэ.

Хоёр.Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах

2.1.Захиалагч Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам"-ын дагуу цахим системд бүртгэгдсэнээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулна.

2.2.Захиалагч тендер шалгаруулалтыг хуульд зааснаар зохион байгуулахад дараахыг баримтална. Үүнд:

2.2.1.үнэлгээний хороог цахим систем дэх худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны мэдээллийн санд бүртгэлтэй этгээдээс сонгож байгуулах;

2.2.2.үнэлгээний хороо байгуулсан шийдвэрийг цахим системд бүртгэх;

/Энэ заалтад СС-ын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/98 дугаар тушаалаар өөрчлөлт оруулсан/

2.2.3.үнэлгээний хороо тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, захиалагчаар батлуулсны дараа тендер шалгаруулалтын зарлал, урилга, тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим системд нийтлэх;

2.2.4.хуулийн 19.1-д заасны дагуу тодруулга авах хүсэлт сонирхогч этгээдээс гаргасан бол түүний нэрийг дурдалгүйгээр хүсэлтийг тодруулгын хамт албан бичгээр цахим систем дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн "тодруулга" хэсэгт нийтэлж, тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлтийг захиалагчаар батлуулж нийтлэх;

2.2.5.үнэлгээний хороо захиалагчийн шийдвэр, тендертэй холбоотой тодруулгыг цахим системд бүрэн нийтэлснээр тендер шалгаруулалтын үр дүн нийтлэгдэх бөгөөд шалгарсан оролцогчийн тендерийн хүний эмзэг мэдээлэлд хамаарахгүй хэсэг, тендерийн талаар оролцогчоос өгсөн тодруулгыг гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын таван өдрийн хугацаанд цахим системээр бусад оролцогчид ил болгох;

2.2.6.тендерийн нээлтэд зарласан үнийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан нөхцөлөөр үнийн задаргааны нийт нийлбэр дүнгээр өөрчилж тооцсон, эсхүл арифметик алдааг залруулсан залруулгыг оролцогч хүлээн зөвшөөрч хариу ирүүлсэн бол энэ тухай тэмдэглэл үйлдэж, тендерийн нээлтэд зарлагдсан цахим системийн мэдээллийг залруулах;

2.2.7.худалдан авах гэрээг цахим системд байршуулах ба хуульд зааснаар давуу эрх тооцсон, дотоодын үйлдвэрээс худалдан авах нөхцөлтэй гэрээний мэдээллийг цахим системд бүртгэх;

2.2.8.худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх.

2.3.Аж ахуй эрхлэгч Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам"-ын дагуу цахим системд бүртгэгдсэнээр тендер шалгаруулалтад дараах байдлаар оролцоно. Үүнд:

2.3.1.тендер шалгаруулалтад түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй оролцох бол холбогдох гэрээг цахим системээр баталгаажуулсан байх;

2.3.2.хуулийн 19.1-д заасны дагуу тодруулга авах хүсэлтийг тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар гаргах;

2.3.3.тендерийн баталгаа шаардсан нөхцөлд хуулийн 22.7-д заасны дагуу тендерийн баталгааг цахим системээр дамжуулан хүргүүлэх;

2.3.4. Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам"-ын дагуу цахим системд баталгаажсан чадавх, туршлагыг нотлох мэдээлэл, баримт бичгээс шаардлагатайг сонгож, тендерийн хамт илгээх;

2.3.5. хуулийн 15.2, энэ журмын 2.3.4-т заасанд хамаарахгүй оролцогчийн ерөнхий шаардлага, чадавх, туршлагыг нотлох баримтыг "PDF" форматаар гаргацтай, тод хөрвүүлэх;

2.3.6. энэ журмын 2.3.5-д заасан нотлох баримт, тендерийн үнэ, тендерийн хүчинтэй байх хугацаа, санал болгосон үнийн хөнгөлөлт болон холбогдох бусад мэдээллийг цахим системийн холбогдох талбарт бүрэн оруулж, мэргэжлийн байгууллагын гаргасан зааварчилгааны дагуу тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх;

2.3.7. цахим системд тендер илгээхэд хуулийн этгээд бол түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн, эсхүл түүнийг итгэмжлэлээр төлөөлөх этгээдийн, иргэн бол тухайн иргэний тоон гарын үсгээр баталгаажуулах;

2.3.8. цахим системээр тендер илгээхэд үйлчилгээний хураамж төлөх;

2.3.9. шаардлагатай гэж үзвэл тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендертээ нэмэлт, өөрчлөлт оруулах.

2.4. Тендер шалгаруулалтын зарлал, урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.

2.5. Захиалагч цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас дараах журмаар ирүүлсэн тендер шалгаруулалт зарласнаас хойших мэдээллийг тендер хянан үзэхэд үндэслэл болгоно. Үүнд:

2.5.1. татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт. Уг тодорхойлолтыг оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим системээр дамжуулан авч цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбосон байх;

2.5.2. шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөртэй эсэх тодорхойлолт. Уг тодорхойлолтыг оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим системээр дамжуулан авч цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбосон байх;

2.5.3. авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, дээд боловсролын дипломын мэдээлэл, санхүүгийн тайлан зэрэг бодит цагийн горимоор дамжуулдаг, өдөр тутам өөрчлөгддөггүй мэдээлэл.

/Энэ заалтад СС-ын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/98 дугаар тушаалаар хасалт хийсэн/

2.6. Энэ журмын 2.5 дахь заалт хуулийн 4.1.6-д заасан гадаадын этгээдийн ирүүлсэн тендерт хамаарахгүй.

2.7. Захиалагч энэ журмын 2.2.4-т заасны дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулснаас бусад үндэслэлээр тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах бол энэ тухай цахим систем дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн "тодруулга" хэсэгт нийтэлж, тендер шалгаруулалтын баримт бичигт холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгана.

2.8. Захиалагчийн цахим системд оруулсан мэдэгдлийн талаар зурвасыг цахим системд бүртгүүлсэн аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, оролцогчийн бүртгэлтэй цахим шуудангийн хаягаар, эсхүл гар утасны зурвас болон харилцаа холбооны бусад хэлбэрээр илгээж мэдэгдэх ба аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, оролцогч тухайн цахим шууданг ашиглаж байгаа эсэхээс үл хамааран хүлээн авсанд тооцно.

2.9. Захиалагчийн шийдвэр, тендер шалгаруулалтын үр дүнг энэ журмын 2.2.5-д заасны дагуу цахим системээр оролцогчид нэгэн зэрэг мэдэгдсэн өдрөөс эхлэн хуулийн 30.1-д заасан гэрээг байгуулах хугацааг тоолно.

2.10. Захиалагч болон аж ахуй эрхлэгч, сонирхогч этгээд, оролцогчоос ажлын цаг дууссаны дараа, эсхүл амралтын өдөр цахим системд оруулсан баримт бичгийг холбогдох этгээд дараагийн ажлын өдөр хүлээн авсанд тооцно.

2.11. Оролцогч энэ журмын 2.3.1-д зааснаар гэрээг баталгаажуулаагүй бол түншлэл, эсхүл туслан гүйцэтгүүлэх гэрээ бүхий тендер ирүүлсэн оролцогч гэж үзэхгүй.

2.12. Оролцогчоос ирүүлсэн тендер энэ журмын 2.3.5-д заасан шаардлага хангаагүй бол тухайн баримт бичгийг үнэлгээнд харгалзан үзэхгүй.

2.13. Оролцогчоос ирүүлсэн тендер энэ журмын 2.3.6-д заасны дагуу цахим системийн холбогдох талбарт оруулсан мэдээлэлтэй зөрвөл цахим системийн мэдээллийг баримтална.

2.14. Тендерийг энэ журмын 2.3.7-д заасан этгээдээс өөр этгээдийн тоон гарын үсгээр баталгаажуулан цахим системд ирүүлснээс үл хамаарч тухайн аж ахуй эрхлэгчийг тендер шалгаруулалтад оролцсон гэж тооцно.

2.15. Хуулийн 22.7-д зааснаар тендерийн баталгааг цахим системээр дамжуулан ирүүлээгүй тендерийг нээхээс

татгалзана.

2.16.Оролцогч энэ журмын 2.5.1-д заасан тодорхойлолтыг цахим системд холбож ирүүлээгүй бол захиалагч тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтыг холбогдох мэдээллийн сангаас татан авч, тендер хянан үзэхэд үндэслэнэ.

/Энэ хэсгийг СС-ын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/98 дугаар тушаалаар нэмсэн/

2.17.Оролцогч энэ журмын 2.5.2-т заасан тодорхойлолтыг цахим системд холбож ирүүлээгүй бол захиалагч тендер нээсэн өдрийн байдлаар шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөртэй эсэх тодорхойлолтыг холбогдох мэдээллийн сангаас татан авч, тендер хянан үзэхэд үндэслэнэ.

/Энэ хэсгийг СС-ын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/98 дугаар тушаалаар нэмсэн/

2.18.Энэ журмын 2.5-д зааснаас бусад болон цахим системд холбогдоогүй мэдээллийг хуулийн 15.2-т заасан мэдээллийн санд байгаа олон нийтэд нээлттэй мэдээлэлд үндэслэн тендер хянан үзэж болно.

/Энэ хэсгийг СС-ын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/98 дугаар тушаалаар нэмсэн/

2.19.Энэ журмын 2.5-д заасан мэдээллийг цахим системээр дамжуулан татахад алдаа гарсан бол захиалагч уг асуудлаар мэргэжлийн байгууллагад хандана.

/Энэ хэсгийг СС-ын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/98 дугаар тушаалаар нэмсэн/

Гурав.Мэргэжлийн байгууллагын чиг үүрэг

3.1.Мэргэжлийн байгууллага Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д зааснаар цахим системийн мэдээлэл хариуцагч байх ба тус хуульд заасан үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.Мэргэжлийн байгууллага хуулийн 49.4-т зааснаас гадна цахим системтэй холбоотой дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1.цахим систем болон түүний бүрэлдэхүүн хэсгийн портал хуудсыг хөтлөх, бүртгэлийн тогтолцоог ханган ажиллах, цахим системийн хэвийн үйл ажиллагааг хариуцах;

3.2.2.баталгаа гаргагч, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч, бусад төрийн байгууллага, тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэгч байгууллага болон бусад шаардлагатай байгууллагатай гэрээ байгуулж ажиллах;

3.2.3.энэ журмын 3.2.2-т заасны дагуу байгуулсан гэрээний хэрэгжилтийг хянаж, хангаж ажиллах;

3.2.4.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон гомдол хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага, хууль, хяналтын байгууллагыг тухайн хяналт, шалгалтын хүрээнд хяналт тавих боломжоор хангах, байгууллагын хүсэлтэд үндэслэн цахим системд нэвтрэх эрх олгох;

3.2.5.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112.10-т зааснаар цахим системд байршуулсан баримт бичгийг шинжлэн судлах хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүсэлт, эсхүл захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн шүүгчийн захирамжид үндэслэн тухайн тендер шалгаруулалтын дугаар, зарлал, урилгын мэдээллийн дагуу цахим системд нэвтрэх эрх олгох;

3.2.6.тендер шалгаруулалттай холбоотойгоор цахим системд захиалагчаас оруулж буй мэдэгдэл, нэмэлт мэдээлэл, тодруулга, тендер шалгаруулалтын баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлт, гомдол хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой мэдээллийг оролцогчид цахим шуудан, эсхүл гар утасны зурвас болон харилцаа холбооны бусад хэлбэрээр дамжуулан хүргэх техникийн шийдлийг бий болгон ажиллах;

3.2.7.тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх, лавлагаа тодорхойлолт зэрэг нийтийн мэдээлэл солилцохоор гэрээ байгуулсан байгууллагуудыг цахим системд нэвтрэх, холбогдох мэдээллийг нийтлэх боломжоор хангах;

3.2.8.цахим системээр зохион байгуулж буй тендер шалгаруулалт, түүнд нийтлэгдэж буй мэдээлэлд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, хяналт тавих, илэрсэн алдаа, дутагдлыг арилгуулах тухай холбогдох байгууллагуудад шаардлага, мэдээлэл, зөвлөгөө хүргүүлэх;

3.2.9.захиалагч, аж ахуй эрхлэгч цахим системийн үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөөгүй бол мэргэжлийн байгууллага үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй;

3.2.10.цахим системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагаа, сургалт, сурталчилгаа, нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллахтай холбогдуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран цаг үеийн асуудлаар улирал тутам уулзалт зохион байгуулах;

3.2.11.цахим систем төрийн бусад системтэй харилцан өгөгдөл солилцох боломжтой бөгөөд үйл ажиллагааны дарааллын дагуу цахим системд оруулсан нэг төрлийн өгөгдөл бусад системд харилцан солилцох боломжтой байх системийн хөгжүүлэлт хийх.

3.3.Мэргэжлийн байгууллага хуулийн 8.2-т заасан жагсаалтад орсон барааг ерөнхий гэрээний аргын дагуу сонгон шалгаруулж, цахим дэлгүүрт байршуулан, тухайн барааг шууд худалдан авах боломжоор захиалагчийг хангаж болно.

Дөрөв.Аж ахуй эрхлэгчийн чиг үүрэг

4.1.Аж ахуй эрхлэгч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 35.2-т заасан үүргийг хүлээнэ.

4.2.Аж ахуй эрхлэгч цахим системд нэвтрэх эрх авсан ажилтны үйлдэл, эс үйлдэл, түүнд олгогдсон эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой хариуцлагыг хүлээнэ.

4.3.Аж ахуй эрхлэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарах аливаа хариуцлагыг аж ахуй эрхлэгч өөрөө хариуцна.

4.4.Аж ахуй эрхлэгч, түүнийг төлөөлөн цахим системд нэвтрэх эрх бүхий этгээд цахим системд нэвтрэх эрх, нууц үгийн нууцлалыг хадгалах ба нууцлалыг алдсан, мартсан тохиолдолд цахим системээр мэргэжлийн байгууллагад хүсэлт гаргаж, цахим шуудангаар хариуг хүлээж авна.

4.5.Аж ахуй эрхлэгч холбогдох цахим системээс дамжуулан авч буй өөрийн тендерт холбоотой мэдээлэл, өөрийн ирүүлсэн тендер, түүнд хавсаргасан аливаа баримт бичгийн үнэн зөв эсэхийг нягтлах, алдаатай тохиолдолд тендер хүлээж авах эцсийн хугацаанаас өмнө залруулах үүрэгтэй ба энэ үүргээ биелүүлээгүйтэй холбоотой хариуцлагыг дангаар хүлээнэ.

4.6.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

4.7.Оролцогч байгуулсан гэрээний гүйцэтгэлийн талаарх мэдээллийг нотлох баримтын хамт бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн хуваарийн дагуу цахим системд бүртгэнэ.

4.8.Энэ журмын 2.2.5-д заасны дагуу шалгарсан оролцогчийн тендерийн хүний эмзэг мэдээлэлд хамаарахгүй хэсэг, тендерийн талаар оролцогчоос өгсөн тодруулгатай танилцах бусад оролцогч нууц хадгалах тухай баталгааг цахим хэлбэрээр гаргана. Захиалагч шаардлагатай гэж үзсэн бол бичгээр гаргуулж болно.

4.9.Аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалтад оролцох сонирхол илэрхийлэх болон оролцоход хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлнө.

4.10.Хуулийн 22.7-д зааснаар тендер илгэхээс өмнө тендерийн баталгааг цахим системээр дамжуулан хүргүүлэхтэй холбоотой үүрэг, хариуцлагыг аж ахуй эрхлэгч хүлээнэ.

Тав.Захиалагчийн чиг үүрэг

5.1.Захиалагч хуулийн 48.4.9-д зааснаас бусад баримт бичгийг тендер шалгаруулалт зохион байгуулж дууссанаар, хуулийн 48.4.9-д заасан баримт бичгийг гэрээг дүгнэж бараа, ажил, үйлчилгээг хүлээн авснаар зохих журмын дагуу архивлан хадгална.

5.2.Хуулийн 48.4-т заасан тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хамаарах баримт бичгээс цахим хэлбэрээр үйлдсэн баримт бичгийг цахим хэлбэрээр тусгай тээгч (зөөврийн хатуу диск, оптик диск) дээр архивлан хадгална.

5.3.Оролцогч үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлтэй танилцах хүсэлт гаргасан тохиолдолд хуулийн 29.3-т зааснаар танилцуулна.

5.4.Захиалагч үнэлгээний хорооны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан дэвшилтэт технологи, программ хангамж ашиглаж болно.

5.5.Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч цахим системд байршуулна.

5.6.Гэрээний гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсэгт шаардлагатай гэж үзвэл үнэлгээний хорооны гишүүнийг байлцуулж болно.

5.7.Энэ журмын 5.5-д зааснаар байршуулсан гэрээг шүүх хууль бус гэж тогтоосон, эсхүл талууд гэрээ цуцалсан, гэрээнээс татгалзсан бол захиалагч холбогдох мэдээллийг тухай бүр цахим системд шинэчилнэ.

5.8.Захиалагч ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээг худалдан авахад тухай бүр захиалгын хуудас цахим системд илгээнэ.

5.9.Цахим дэлгүүрээс худалдан авах нэг удаагийн захиалгын хуудаст тусгагдах худалдан авалтын хэмжээ тухайн төсвийн жилд цахим дэлгүүрээс худалдан авах нийт бараа, үйлчилгээний төсвийн 50 хувиас хэтрэхгүй байна.

5.10.Тухайн төсвийн жилд цахим дэлгүүрээс нэг бараа, үйлчилгээг нэг удаа худалдан авахаар төлөвлөсөн бол энэ журмын 5.9-д заасныг баримтлахгүй.

/Энэ хэсэгт СС-ын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/98 дугаар тушаалаар өөрчлөлт оруулсан/

5.11.Энэ журмын 3.3-т зааснаар цахим дэлгүүрт байршсан барааг худалдан авах захиалгын нийт дүн 20,000,00.0 (хорин сая) төгрөгөөс ихгүй байна.

5.12.Цахим системээр зохион байгуулаагүй тендер шалгаруулалтад шалгарсан оролцогчийн тендерийн эмзэг мэдээлэлд хамаарахгүй хэсэг, тендерийн талаар оролцогчоос өгсөн тодруулга, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлтэй танилцах бусад оролцогч бичгээр захиалагчид хүсэлт гаргаж, нууц хадгалах тухай баталгааг бичгээр гаргана. Захиалагч хүсэлтийн дагуу хуулбар хувийг танилцуулж, холбогдох баримт бичигтэй танилцсан оролцогчийн тухай тэмдэглэл үйлдэж, гарын үсгээр баталгаажуулан тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хадгална.

5.13.Хуулийн 49.4.7-д заасан хураамжийн үлдсэн 70 хүртэл хувийг захиалагч худалдан авах ажиллагаатай холбоотой үйл ажиллагаанд зарцуулж болно.

/Энэ хэсгийг СС-ын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/98 дугаар тушаалаар нэмсэн/

5.14.Сангийн сайдын баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.18-д заасныг хэрэгжүүлэхдээ захиалагчийн хэрэгцээнд зориулагдсан эрчим хүч, уур, дулаан, ус, бохир усыг дэд бүтэц холбогдсон этгээдээс тогтоосон тарифын хүрээнд тогтмол зардлаар авахад цахим системээр төлөвлөхгүй.

/Энэ хэсгийг СС-ын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/98 дугаар тушаалаар нэмсэн/

Зургаа.Цахим системийн аюулгүй ажиллагаа

6.1.Цахим системийн үйл ажиллагаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

6.2.Мэргэжлийн байгууллага цахим систем, түүний аюулгүй ажиллагааны хэрэгжилтийг хангуулах дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

6.2.1.цахим систем нь төрөөс баримтлах харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэл, мэдээллийн аюулгүй байдлын стандартад нийцсэн байх;

6.2.2.цахим системийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор цахим системд байнгын хяналт тавих;

6.2.3.худалдан авах ажиллагааны хууль, журамд нийцүүлэн цахим системийн үйл ажиллагааны шинэчлэл, сайжруулалтыг тасралтгүй хийх;

6.2.4.цахим системд мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хоёр жил тутамд хийлгэх;

6.2.5.цахим системийн хөгжүүлэлт, аюулгүй байдлыг ханган ажиллахдаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр танилцуулж, холбогдох саналыг хэрэгжүүлж ажиллах;

6.2.6.системийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хоёр дэд бүтцэд суурилсан үндсэн, эсхүл үүлэн технологид суурилсан нөөц сервер тоног төхөөрөмжтэй байх.

6.3.Мэргэжлийн байгууллага цахим системийн ашиглалт, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дотоод журмыг баталж, хэрэгжүүлж болно.

Долоо.Бусад зүйл

7.1.Хуульд заасан гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн талаар мэдээллийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам"-д зааснаар цахим системээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

7.2.Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас цахим систем ажиллах боломжгүйгээс шалтгаалан сонирхогч этгээд тендер шалгаруулалтад оролцох боломжгүй болсноос үүдэн гарах аливаа хариуцлагыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн байгууллага, захиалагч хариуцахгүй.

7.3.Энэ журмын 7.2-д зааснаар цахим систем ажиллах боломжгүй болсон тохиолдолд мэргэжлийн байгууллага энэ тухай захиалагчид нэн даруй мэдэгдэж, тендерийн нээлтийг тодорхой хугацаагаар хойшлуулж, энэ тухай цахим системээр дамжуулан, боломжгүй бол харилцаа холбооны бусад хэрэгслээр нэгэн зэрэг мэдэгдэнэ.

7.4.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- оОо ---